

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 8 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ
8 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 8 дугаар сарын 23-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 64
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	65 - 278
1. <i>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нарын 6 гишүүн 2024.08.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	67 - 69
2. <i>“Улсын Их Хурлын гишүүний халдаагүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	69 - 70
3. <i>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нарын 6 гишүүн 2024.08.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцэслэн батлах/</i>	70 - 72
4. <i>“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	72 - 216
5. <i>Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах</i>	216 - 237
6. <i>Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	237 - 277
7. <i>Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/</i>	277
8. <i>Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	278

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
8 дугаар сарын 23-ны өдөр /Баасан гараг/-ийн хуралдааны
товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 64 гишүүн хүрэлцэн ирж, 50.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 04 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга, Э.Болормаа, Ж.Галбадрах, А.Ганбаатар, Ж.Ганбаатар, Д.Ганмаа, Д.Жаргалсайхан, Б.Пүрэвдорж, Б.Чойжилсүрэн;

Чөлөөтэй: С.Одонтуяа, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: М.Ганхүлэг, Г.Дамдинням, С.Лүндэг;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан – 01 минут, Н.Алтанишагай – 3 цаг 57 минут, С.Амарсайхан – 03 минут, Ц.Баатархүү – 31 минут, М.Бадамсүрэн – 1 цаг 28 минут, Д.Батбаяр – 1 цаг 51 минут, Р.Батболд – 02 минут, Н.Батсүмбэрэл – 1 цаг 03 минут, Б.Батцэцэг – 05 минут, Б.Баярбаатар – 14 минут, Ж.Баярмаа – 08 минут, Ж.Баясгалан – 04 минут, Ш.Бямбасүрэн – 19 минут, Д.Ганбат – 13 минут, Л.Гантөмөр – 19 минут, Ц.Даваасүрэн – 04 минут, Т.Доржханд – 03 минут, Б.Жавхлан – 3 цаг 00 минут, Б.Жаргалан – 19 минут, Ж.Золжаргал – 02 минут, Ц.Мөнхбат – 07 минут, П.Мөнхтулга – 4 цаг 53 минут, Н.Номтойбаяр – 28 минут, Э.Одбаяр – 31 минут, Б.Пунсалмаа – 1 цаг 00 минут, Д.Пүрэвдаваа – 01 минут, Р.Сэддорж – 02 минут, Ц.Туваан – 06 минут, Г.Тэмүүлэн – 09 минут, А.Ундраа – 16 минут, Г.Хосбаяр – 09 минут, Ж.Энхбаяр – 13 минут, Д.Энхтуяа – 14 минут, Р.Эрдэнэбүрэн – 4 цаг 17 минут.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нарын 6 гишүүн 2024.08.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооноос гаргасан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

“ИХ ХУРАЛДАЙ” ТАНХИМ

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 36
Бүгд: 90

60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын санал дэмжигдсэн тул хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Ёс зүй, дэгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байнгын хороодын асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 42
Бүгд: 92

54.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:15/

Уг асуудлыг 10 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нарын 6 гишүүн 2024.08.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцэслэн батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байнгын

хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Д.Амарбаясгалан: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 63

Татгалзсан: 33

Бүгд: 96

65.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 37

Бүгд: 97

61.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 31

Бүгд: 97

68.0 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /10:24/

Уг асуудлыг 10 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол

Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Нийслэлийн Засаг даргын орлогч Н.Мандуул, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын дарга З.Батбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга Д.Гантулга, Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, мөн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, Геологийн бодлогын газрын дарга Х.Санчигдорж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны

Хөдөлмөрийн бодлогын газрын дарга Б.Алимаа, мөн яамны Хүн амын хөгжлийн бодлогын газрын Хүүхэд, гэр бүлийн газрын дарга Н.Баярмаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын нэгдсэн бодлогын хэлтсийн дарга О.Энхмөнх, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын Орон сууц, санхүүжилтийн хэлтсийн дарга Э.Батболд, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны ерөнхий менежер Б.Гүнболд, Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх Ц.Эрдэнэбат, Б.Баттөмөр, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх П.Мөнхбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Б.Ганбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч Б.Төрбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Б.Нандингэрэл, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, О.Цогтгэрэл, С.Ганбаатар, З.Мэндсайхан, О.Амгаланбаатар, Л.Соронзонболд, М.Нарантуяа-Нара, Б.Уянга, Ц.Идэрбат, Д.Рэгдэл, С.Бямбацогт, Б.Түвшин, Д.Батлут, Дав.Цогтбаатар, Ц.Мөнхтуяа, Б.Заяабал, С.Эрдэнэболд, Ж.Золжаргал, Д.Ганбат, Д.Энхтуяа, Б.Бейсен нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Боловсролын сайд П.Наранбаяр, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Эрчим хүчний яамны Төрийн нарийн

бичгийн дарга Н.Тавинбэх, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы хуралдаанд Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Дэд Ерөнхийлөгч эрхэмсэг хатагтай Пани Ятодү /Pany Yathotou/ тэргүүтэй төлөөлөгчид зочилж байгааг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс талархал илэрхийлж, мэндчилгээ дэвшүүлэв.

Танхимын баруун хойд, зүүн хойд хэсэгт байрлуулсан дэлгэц дээр “THE STATE GREAT HURAL (PARLIAMENT) OF MONGOLIA WELCOMES H.E. Ms.PANY YATHOTOU, THE VICE PRESIDENT OF THE LAO PEOPLE’S DEMOCRATIC REPUBLIC” гэсэн үг гарч байв.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 13 цаг 07 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Х.Жангабыл, С.Эрдэнэбат, Д.Бум-Очир, Т.Аубакир, М.Нарантуяа-Нара, Г.Ганбаатар, О.Батнайрамдал, Х.Тэмүүжин, Р.Батболд, Ж.Баясгалан, Н.Батсүмбэрэл, М.Бадамсүрэн нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 14 цаг 11 минутаас хуралдааныг даргалав.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Р.Сэддорж, Д.Жаргалсайхан, Г.Лувсанжамц, Д.Рэгдэл, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Г.Уянгахишиг, Б.Энхбаяр /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтын 3 дахь дэд заалтын “улсын төсөвт тусган хэрэгжүүлэх” гэснийг “улсын төсвийн төсөлд тусган өргөн мэдүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 57
Бүгд: 112
49.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан, Тогтоолын төслийн 3 дахь заалтын “уул уурхай, говийн унаган байгаль, түүх, соёлын өв,” гэсний дараа “шинжлэх ухаан,” гэж “Аж үйлдвэрийн төрөлжсөн, ногоон эрчим хүчний” гэсний өмнө “Технологи,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 60
Бүгд: 112

46.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3. Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын бүлэг, зүйлийн нэрийн жагсаалт бүхий агуулга хэсгийг хасаж, “Өмнөтгөл” хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны
үйл ажиллагааны хөтөлбөр”

Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар олонхыг бүрдүүлсэн Монгол Ардын намаас Засгийн газрын бүрэлдэхүүнд Ардчилсан нам, ХҮН намыг урьж, хамтарсан Засгийн газрыг байгуулсан.

Засгийн газар хөгжлийн тулгамдсан асуудал, тулгарч байгаа сорилтуудыг илүү хурдан, үр дүнтэйгээр шийдвэрлэх, бүрэн эрхийнхээ хугацаанд бүтээлчээр, тогтвортой хамтран ажиллах зорилгоор “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” хамтарсан Засгийн газрын гэрээг байгуулсан. Тус гэрээг удирдлага болгон 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд дэвшүүлсэн Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын мөрийн хөтөлбөрт суурилсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулахдаа:

Үндэсний эв нэгдэл, үндэсний эрх ашгийг эрхэмлэж, эрх зүйт төрийн үндсэн зарчмуудыг удирдлага болгон;

Улсын эрх ашиг нэгдүгээрт, улс төрийн намын эрх ашиг хоёрдугаарт, эцэст нь хувийн эрх ашиг байх зарчмыг үнэт зүйлээ болгон;

“Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй, хурдтай шийдвэрлэхийг зорин;

Монгол Ардын намын мөрийн хөтөлбөрт туссан нийгмийн бодлогын шинэчлэл, бүсчилсэн хөгжлийн бодлого, авлигагүй төр, шударга ёсыг бэхжүүлэх цахим засаглал, эхлүүлсэн томоохон төсөл, арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зорилтууд, Ардчилсан намын мөрийн хөтөлбөрт туссан хүний хөгжил, хувийн өмчийн эрхийн хамгаалалт, технологи суурьтай мэдлэгийн эдийн засаг, бизнес, хөрөнгө оруулалтын орчин, эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулах, шударга төрийн зорилтууд, ХҮН намын мөрийн хөтөлбөрт туссан эрчим хүчний болон боловсролын салбарын шинэчлэл, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, төрийн худалдан авах ажиллагааны бодлогыг шинэчлэх, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах зорилтуудыг тэргүүлэх чиглэл болгон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бодлогын үндсэн 4 чиглэлийг тодорхойлж, тэдгээрийн хүрээнд тус бүр 4 зорилго, нийт 593 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгалаа.

Бүсүүдийг төрөлжүүлэн хөгжүүлж, бүс бүхэнд ялгаатай татварын бодлого хэрэгжүүлэх бөгөөд Хангайн бүсийг “Уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн, хот байгуулалтын дэд бүс”, Баруун бүсийг “Эрчим хүчний төрөлжсөн, байгалийн аялал жуулчлалын дэд бүс” болгон, Хойд бүсийг “Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” болгон, Говийн бүсийг “Аж үйлдвэрийн төрөлжсөн, ногоон эрчим

хүчний дэд бүс” болгон, Төвийн бүсийг “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” болгон, Зүүн бүсийг “Түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн, эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүс” болгон төрөлжүүлэн хөгжүүлнэ.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд дараах 14 мега төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөлөө:

1.“Гашуунсухайт-Ганцмод”, “Ханги-Мандал”, “Шивээхүрэн-Сэхээ” хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барина. Тус төслийг хэрэгжүүлснээр нийт экспортын хүчин чадал 40 сая тонноор буюу Гашуунсухайт-Ганцмод 20 сая тонн, Ханги-Мандал боомт 10 сая тонн, Шивээхүрэн-Сэхээ боомт 10 сая тонноор нэмэгдэж, экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэж, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэх, зорчигчид ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэнэ.

2.Тавантолгойн 450 мВт-ын дулааны цахилгаан станцыг барина. Тус төслийг хэрэгжүүлснээр жилд 3150.0 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, Оюутолгойн өсөн нэмэгдэх 2,242.5 сая кВт.ц хэрэглээ болон Тавантолгойн орд газрууд, бусад стратегийн ач холбогдолтой өмнөд бүсийн уул уурхайн төслийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг дотоодоос хангах боломж бүрдэнэ. “Оюутолгой” ХХК-ийн БНХАУ-аас импортолж байгаа 110-120 сая ам.долларын валютын урсгалыг зогсооно. Барилга угсралтын явцад давхардсан тоогоор 2000, ашиглалтад орсноор 300 байнгын ажлын байр шинээр бий болно.

3.Эрдэнэбүрэнгийн 90 мВт-ын усан цахилгаан станцын төслийг хэрэгжүүлнэ. Тус төслийг хэрэгжүүлснээр Жилд 366 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх ба баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг 2027 оноос эхлэн 100 хувь найдвартай, тасралтгүй хангах боломж бүрдэж, 52,000 ахуйн хэрэглэгчийг хангах эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болж, баруун аймгуудын 4,430 аж ахуйн нэгж, 5,400 орон сууц, 36,000 гаруй гэр хорооллын хэрэглэгчийг дотоодын цахилгаан эрчим хүчээр бүрэн хангана. ОХУ, БНХАУ-аас жил бүр импортоор авч байгаа 17.5 тэрбум төгрөгийг хэмнэнэ.

4.Эгийн голын 310 мВт-ын усан цахилгаан станц барина. Тус төслийг хэрэгжүүлснээр эрчим хүчний системийн найдвартай, тогтвортой, шуурхай ажиллагааг хангаж, системийн эх үүсвэрийн зохистой харьцааг бүрдүүлнэ. ОХУ-д жил бүр төлдөг 25 сая ам.долларын импортын төлбөрийг хэмнэнэ. Түүхий нүүрсний хэрэглээг жил бүр 438,7 мянган тонноор, хүлэмжийн хийн ялгаруулалтыг 709 мянган тонноор бууруулна. 5.7 тэрбум шоо метр цэвэр усны нөөц бүрдүүлж, Монгол Улсын усан хангамжийн аюулгүй байдлыг хангана.

5.Сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэрийг хөгжүүлнэ. Монгол Улс нь судалгаагаар 2,600 гВт сэргээгдэх эрчим хүчний нөөцтэй болох нь тогтоогдсон бөгөөд шинээр эх үүсвэрүүдийг бий болгох замаар өсөн нэмэгдэж байгаа дотоодын цахилгаан эрчим хүчний дутагдлыг нөхөх, бусад улс руу экспортлох боломжтой. Сэргээгдэх эрчим хүчний салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулснаар уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх боломж бүрдэж, хүлэмжийн хийн ялгарлыг

бууруулах, нүүрс хүчлийн хийн арилжаанд оролцож, нэмэлт орлого олох боломж нээгдэнэ.

6.Хэрлэн-Тоонот, Орхон-Онги ус дамжуулах хоолойг барих төслийг хэрэгжүүлнэ. Хэрлэн голын олон жилийн дундаж урсацын 5-9 хувийг битүү хоолойгоор дамжуулан Хэнтий, Чойр, Дорноговь, Өмнөговь аймгийн хүн ам, мал аж ахуй, үйлдвэр, уул уурхайн усны хэрэгцээг бүрэн хангана. Жилдээ 30 мян.тн хүлэмжийн хийг бууруулна. “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд усны асуудлыг шийдвэрлэж, цөлжилт, хуурайшилтыг сааруулна.

Онги гол болон Улаан нуурыг сэргээж, усны түвшин тогтворжиж, Онги голын дагууд оршин сууж байгаа 29.2 мянган хүн ам, 230 гаруй мянган толгой мал сүргийг гадаргын усаар хангах нөхцөл бүрдэнэ. Агаар, хөрсний чийгшил, газрын доорх усны тэжээгдэл нэмэгдэж, нуурын орчны бүсийн экосистем, биологийн олон янз байдал сэргэж, хөрсний элэгдэл эвдрэлд орох нөхцөл багасаж, цөлжилтийг бууруулна.

7.Эрэнцав-Чойбалсан-Баруун Урт-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр замыг барина. Тус төслийг хэрэгжүүлснээр худалдааны эргэлтийг нэмэгдүүлж, тээврийн зардлыг бууруулна.

8.Монгол, Францын хамтарсан Ураны төслийг хэрэгжүүлнэ. Төсөл хэрэгжиж, үйлдвэрлэл бүрэн хүчин чадлаараа ажилласнаар жилд 2,500 тонн ураныг олборлож экспортолно. Төсөл хэрэгжих хугацаанд улс, орон нутгийн төсөвт 1 тэрбум гаруй ам.долларын татвар төлнө. Үйлдвэрлэлийн туршилтын төсөл дээр үндсэн үйлдвэрлэлийн олборлолт эхлэхэд 1,000 гаруй ажлын байр бий болно. Улс, орон нутгийн хэмжээнд томоохон худалдан авалт, бизнесийн боломж нэмэгдэнэ. Монгол Улсад атомын цахилгаан станцыг барих суурь судалгааг хийнэ.

9.Нүүрс-хими, Кокс-химийн цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, боловсруулах үйлдвэрлэлийг нэг шат ахиулснаар экспортын орлогыг нэмэгдүүлэх, олон улсын түүхий эдийн үнээс хараат байдлыг бууруулах боломж бүрдэнэ.

Кокс-химийн үйлдвэрийн нүүрс баяжуулах үйлдвэрийн 1 дүгээр шатанд 10 сая тонн коксжих нүүрсийг угааж, 5.4 сая тонн баяжуулсан нүүрс, 3 сая тонн завсрын бүтээгдэхүүн (мидлинг) үйлдвэрлэнэ. 2.7 сая тонн баяжуулсан нүүрсийг боловсруулж, 2 сая тонн хатуу кокс, 107 МВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэнэ. Дотоодын хэрэглээнээс илүү гарсан 1.5 сая тонн коксын бүтээгдэхүүнийг экспортолно. “Алтанширээт” үйлдвэрлэл технологийн паркийг байгуулснаар 140 га талбайд төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэр, нүүрс угаах үйлдвэр, коксын үйлдвэр, төмрийн хүдрийн хорголжийн зэрэг дагалдах үйлдвэрүүд бүхий 500 мян.тн/жил ширэм үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр ашиглалтад орно.

10.Зэс боловсруулах цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр жилд 560 мянган тонн зэсийн баяжмал боловсруулж, 125 мянган тонн катодын зэс, 72 кг алт, 38.2 тонн мөнгөн гулдмай болон 182 мянган тонн элементийн хүхэр үйлдвэрлэж, 1.1 тэрбум ам.долларын борлуулалтын орлогыг бүрдүүлнэ. Катодын

зэсийн үйлдвэр нь дотоодын зэс утас, кабель, цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэх салбарыг хөгжүүлэхэд томоохон түлхэц үзүүлнэ. Үйлдвэрээс гарган авах 182 мянган тонн элементийн хүхэр нь химийн болон бордооны үйлдвэрлэлд өргөн ашиглагдах тул нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг нэмэгдүүлнэ.

11.Гангийн цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр дотоодын тасралтгүй нэмэгдэж байгаа ган арматур болон бусад ган бүтээгдэхүүний хэрэгцээг дотооддоо бүрэн хангах зорилтын хүрээнд 1.0 сая тонн ган бэлдэц, бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Гангийн үйлдвэрийг ашиглалтад оруулж эхний ээлжид 500 мянган тонн ширэм, 500 мянган тонн ган бэлдэц үйлдвэрлэж, ган бэлдцээс барилгын арматур, булан төмөр, төмөр утас зэрэг ган бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, дотоодын барилгын арматурын хэрэгцээг бүрэн хангана.

12.Газрын тос боловсруулах цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр жилд 1.5 сая тонн түүхий тосноос 1.3 сая тонн бүтээгдэхүүн гарган авч, дотоодын газрын тосны хэрэглээний 55 орчим хувийг бүрэн хангах, импортын хараат байдлыг бууруулах, шатахууны үнийг бие даан уян хатан зохицуулах боломж бүрдэнэ.

13.Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ. Тус төсөл хэрэгжсэнээр жилд гадаад орны алт цэвэршүүлэх үйлдвэрт цэвэршүүлж, мөнгөжүүлдэг алтны 70 хувийг дотооддоо цэвэршүүлэх боломж бүрдэнэ. Баяжуулсан алтны хувийг нэмэгдүүлж, олон улсын зах зээлд борлуулж, валютын орлогыг нэмэгдүүлэх боломжтой. Монгол Улс алтаа одоог хүртэл гадаад орнуудад цэвэршүүлж байгаа бөгөөд үйлдвэр ашиглалтад орсноор үүнтэй холбогдон гарах тээвэр, даатгал, хамгаалалтын зардлыг хэмнэнэ.

14.Үндэсний хиймэл дагуулыг хөөргөнө. Монгол орны нийт газар нутгийн 26.8 хувьд 4G сүлжээ нэвтэрсэн. Үлдсэн 73.2 хувь буюу орон нутгийн иргэд, малчин айл өрхийг шилэн кабелиар интернет сүлжээнд холбоход шаардлагатай 29.0 их наяд төгрөгийг хэмнэж, улс орны өнцөг булан бүрд интернетийн сүлжээ нэвтэрнэ. Байгалийн гамшиг, гэнэтийн аюул, ослын үед газрын сүлжээнд саад, доголдол гарсан тохиолдолд сансрын холбооны сүлжээ нь найдвартай холбооны сүлжээ болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	64
Татгалзсан:	49
Бүгд:	113

56.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 1.1.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.1.1.“20 минутын хот” буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын баримт бичгийг боловсруулж, түүнд суурилсан “Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040” болон бусад хот суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 45
Бүгд: 113
60.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “1.1.2. Эрчим хүчээр хангагдсан хот” зорилтод доор дурдсан агуулгатай 1.1.2.12 дахь заалт нэмэх:

“1.1.2.12.Багануурын дулааны станцын зуух, дулаан дамжуулах сүлжээг өргөтгөн шинэчилж, засварлана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 48
Бүгд: 113
57.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 1.1.3.5 дахь заалтын “татварын хөнгөлөлт” гэснийг “дэмжлэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 58
Бүгд: 113
48.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 53
Бүгд: 113
53.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Төслийн 1 дүгээр хавсралтын 1.1.3.5 дахь заалтын “татварын хөнгөлөлт” гэснийг “дэмжлэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 51
Бүгд: 113
54.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, С.Бямбацогт, Б.Жаргалан, Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “1.1.3.Гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулалт” зорилтод доор дурдсан агуулгатай 1.1.3.7 дахь заалт нэмэх:

“1.1.3.7.Гэр хорооллын бүсэд эрчим хүчний хэмнэлттэй, ногоон, пассив барилгын стандарт болон ногоон санхүүжилтийн шаардлага хангахуйц бие даасан инженерийн шийдэлтэй, загвар хорооллыг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын түншлэлд үндэслэн барьж байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 43
Бүгд: 113
61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 1.1.5.3 дахь заалтын “уялдаа холбоог хангаж,” гэсний дараа “зорчигч тээврийн логистик төвийн хамт” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 47
Бүгд: 113
58.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “1.2.1, 1.2.2 дахь зорилтуудын гарчгийн “Дагуул хотуудын” гэсний өмнө “Улсын зэрэглэлтэй болон” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 53
Бүгд: 113
53.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 1.2.1.5 дахь заалтыг “3.3.7.Шинжлэх ухаан, технологи, инновац” гэсэн зорилтод шилжүүлэх.

“1.2.1.5.Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборыг ашиглалтад оруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 46
Бүгд: 113
59.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “1.1.3.Хойд бүс-“Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” зорилтод доор дурдсан агуулгатай 1.3.3.6 дахь заалт нэмэх:

“1.3.3.6.Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн авто замыг барина.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 50
Бүгд: 113
55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “1.3.4.Говийн бүс-“Аж үйлдвэрийн төрөлжсөн, ногоон эрчим хүчний дэд бүс” зорилгод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“1.3.4.6.Даланзадгадад 50 мВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станцыг барина.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 43
Бүгд: 113
61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.4.3, 3.3.3.24, 3.3.3.25, 3.3.3.26, 3.3.3.31 дэх дараах заалтуудыг тус тус хасах:

“1.3.4.3.Говийн бүсэд нар, салхины тус бүр 100 МВт хүртэл хүчин чадалтай цахилгаан станц барина.

3.3.3.24.Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт нар, салхины нөөцийн давхцалын бүсүүдийг түшиглэн 3 ГВт-ын нар, салхины сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг барьж байгуулах, экспортлох төслүүдийг дэмжинэ.

3.3.3.25.Чойрт 100 МВт салхи, 40 МВт цэнэг хураагуурын төслийг хэрэгжүүлнэ.

3.3.3.26.Мандалговь 200 МВт нарны цахилгаан станц, 100 МВт цэнэг хураагуурын төслийг хэрэгжүүлнэ.

3.3.3.31.Мандалговийн 2,000 МВт нар-салхины эрчим хүчний паркийн төслийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 66
Бүгд: 113
41.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “1.4.2.Орон нутгийн хөгжлийн нийтлэг зорилт” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“1.4.2.7.Аймгийн төвүүд болон томоохон хот, суурин газрын агаарын бохирдлыг бууруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 43
Бүгд: 113
61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.1.Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“2.1.1.9.Өсвөр үеийн охид, хөвгүүдийн дунд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх, үе тэнгийн зөвлөгч бэлтгэх, тэднээр дамжуулан мэдээллийг өсвөр үеийнхэнд хүргэх, шаардлагатай үйлчилгээнд зуучлах нууцлалтай чатбот үйлчилгээг хөгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 43
Бүгд: 113
61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.1.Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“2.1.1.11.Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх үндэсний төлөвлөгөөг баталж, төр болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 40
Бүгд: 113
64.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1.1.21 дэх заалтын “стандартыг” гэсний дараа “албан байгууллага,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 41
Бүгд: 113
63.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1.1.23 дахь заалтын “байгуулна” гэснийг “хүртээмжтэй, тэгш боломжоор хангагдах нөхцөлийг бүрдүүлэн ажиллана.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 63

Бүгд: 113

44.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

20. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.1.Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого” зорилтод доор дурдсан агуулгатай 2.1.1.26 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“2.1.1.26.Төр, хувийн хэвшил, нийгмийн түншлэлийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамж, үйлчилгээний чанарыг сайжруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 45

Бүгд: 113

60.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21. Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.1.Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого” зорилтод доор дурдсан агуулгатай 2.1.1.30 дахь заалт нэмэх:

“2.1.1.30.Төрийн бүх шатны байгууллагууд залуу мэргэжилтнүүдийг дэмжих тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 56

Бүгд: 113

50.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22. Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.1.Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого” зорилтод доор дурдсан агуулгатай 2.1.1.31 дэх заалт нэмэх:

“2.1.1.31.Залуу гэр бүлд зориулсан урьдчилгаа төлбөр, хүүгийн таатай нөхцөл бүхий орон сууцны тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 45

Бүгд: 113

60.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23. Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.1.1.4.Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймагт дүүрэгт төр хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлд сэтгэл зүйн зөлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийг ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн нөхцөлийг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 53

Бүгд: 113

53.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.2.Хөдөлмөр эрхлэлт” зорилтод доор дурдсан агуулгатай 2.1.2.10 дахь заалт нэмэх:

“2.1.2.10.Хөдөлмөр, нийгмийн гурван талт оролцоонд тулгуурлан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тогтолцоог сайжруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 49

Бүгд: 113

56.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.2.Хөдөлмөр эрхлэлт” зорилтод доор дурдсан агуулгатай 2.1.2.11 дэх заалт нэмэх:

“2.1.2.11.Суралцангаа хөдөлмөрлөх/хөдөлмөрлөнгөө суралцах хосмог ажлын байрыг нэвтрүүлэхтэй уялдуулан дадлагажигчийн цалин хөлс, хөдөлмөрийн нөхцлийн талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72

Татгалзсан: 41

Бүгд: 113

63.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1.3.11 дэх дараах заалтыг хасах:

“2.1.3.11.Орлого багатай иргэдийн нэмэлт орлогын эх үүсвэрээс авах татварыг бодлогоор бууруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 59

Бүгд: 113

47.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.3.Нийгмийн баталгаа” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“2.1.3.17.Улс төрийн амлалтаар өрх, иргэнд халамжийн нийтлэг мөнгөн шилжүүлэг олгохгүй байхаар нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг өөрчилнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 49
Бүгд: 113
56.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2.3.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.2.3.2.Багшийн мэргэжил дээшлүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэн, багшлах эрх олгох хялбаршуулсан сургалтын зохицуулалт бий болгож, багш бус мэргэжилтэй шилдэг боловсон хүчнийг багшаар бэлтгэх замаар багшлах хүний нөөцийн чадавхыг сайжруулж, багшийн хомсдолыг бууруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 49
Бүгд: 113
56.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

29.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Ж.Баярмаа нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.2.4.Цахимжсан боловсрол” зорилтод доор дурдсан агуулгатай 2.2.4.5 дахь заалт нэмэх:

“2.2.4.5.Сургалтын байгууллагын интернэтийн дэд бүтцийг сайжруулах, хүүхэд бүрийг компьютержүүлэхэд санхүүгийн түрээсийн системийг нэвтрүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 44
Бүгд: 113
61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

30.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.3.2.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж” зорилтод доор дурдсан агуулгатай 2.3.2.8 дахь заалт нэмэх:

“2.3.2.8.Сэргээн засах тусламж, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдэд урт болон богино хугацаагаар, цогц

байдлаар, нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээг үзүүлж, чанар, аюулгүй байдлыг хангана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 42
Бүгд: 113
62.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 2.4.3.3 дахь заалтын “мастер төлөвлөгөөг” гэсний дараа “хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 50
Бүгд: 113
55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

32.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 2.4.3.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.4.3.5.Хот суурин газарт үерийн эсрдлийн үнэлгээг ерөнхий болон нарийвчилсан байдлаар хийж инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг боловсруулж үе шаттай хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 44
Бүгд: 113
61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.1.3.Банк, санхүү, даатгалын салбарын реформ” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“3.1.3.11.Хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжиж эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын стандартын дагуу баригдах амины орон сууцны ипотекийн зээл болон жижиг дунд үйлдвэрийн тогтвортой, ногоон зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор “Монголын ногоон санхүүгийн корпорац”-ыг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын түншлэлд үндэслэн байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 45
Бүгд: 113
60.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

34.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.2.1.Татвар, нийгмийн даатгалын реформ” зорилтод доор дурдсан агуулгатай 3.2.1.8 дахь заалт нэмэх:

“3.2.1.8.Хөдөө орон нутгаас Улаанбаатар хотыг чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулах, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор бүсийн ялгаатай татварын тогтолцоог бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65

Татгалзсан: 48

Бүгд: 113

57.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.2.2.Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин” зорилтод доор дурдсан агуулгатай 3.2.2.14 дэх заалт нэмэх:

“3.2.2.14.Төсвийн хөрөнгө оруулалтыг их өгөгдөлд суурилан төлөвлөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 47

Бүгд: 113

58.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

36.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.2.2.Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин” зорилтод доор дурдсан агуулгатай 3.2.2.15 дахь заалт нэмэх:

“3.2.2.15.Экспортын гол бүтээгдэхүүнүүдийн зах зээлд нэвтрэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний гадаад экспортыг нэг цонхны бодлогоор дэмжинэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 44

Бүгд: 113

61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1.1 дэх заалт, 3.3.1.7 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.1.1.Уул уурхайн салбарын түүхий эдийн боловсруулалтын түвшин болон хүнд үйлдвэрлэлийн хүчин чадлыг өсгөж, экспортын орлогыг нэмэгдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 47

Бүгд: 113

58.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1.2 дахь заалтын “Геологийн эрэл хайгуулын” гэснийг “Геологийн судалгаа, эрэл, хайгуулын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 44
Бүгд: 113
61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.1.3.Оюутолгойг түшиглэсэн зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 39 дүгээр саналыг гүйцээн боловсруулах чиглэлийг Байнгын хороонд өгөв.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1.4 дэх дараах заалтыг хасах:

“3.3.1.4.Оюутолгойтой дүйцэхүйц дараагийн стратегийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 57
Бүгд: 113
49.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1.6, 3.3.1.12 дахь заалтуудыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.1.6.Дорноговь аймагт дотоодын түүхий эдэд түшиглэсэн газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, олон улсын стандартын шаардлага хангасан авто бензин, түлшний тодорхой хувийг дотоодоосоо хангах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 41
Бүгд: 113
63.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.1.Уул уурхай” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.1.15 дахь заалт нэмэх:

“3.3.1.15.Стратегийн ач холбогдол бүхий Эрдэнэтийн зэс, молибдений ордын талбайн хил заагийн хүрээнд багтаж буй Оюут болон бусад хэсгүүдэд эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх, нөөцийг тогтоож, ашиглалтад бэлтгэх ажлыг эхлүүлэх, эрэл, хайгуулын ажилд дэвшилтэт техник, технологи, хиймэл оюун ухааныг нэвтрүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 75

Татгалзсан: 38

Бүгд: 113

66.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

43.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.1.Уул уурхай” зорилгод доор дурдсан агуулгатай 3.3.1.16 дахь заалт нэмэх:

“3.3.1.16.Нүүрс-химийн технологийг эзэмших, боловсон хүчнээ бэлтгэх, ирээдүйн томоохон төслийн техник, эдийн засгийн үзүүлэлтүүдийг тодорхойлох зорилгоор туршилт тохиргооны бага оврын үйлдвэр байгуулан хийн түлш, нийлэг материал, ус төрөгч гарган авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 47

Бүгд: 113

58.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

44.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилтын 3.3.2.18, 3.3.2.20 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.2.18.Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ, Ханги-Мандал, Бичигт-Зүүнхатавч боомтуудын хил дамнасан төмөр замуудыг барьж хөрш орны төмөр замтай холбоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 75

Татгалзсан: 38

Бүгд: 113

66.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

45.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилгод доор дурдсан агуулгатай 3.3.2.24 дэх заалт нэмэх:

“3.3.2.24.Эрэнцав-Чойбалсан-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр замыг барина.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 78

Татгалзсан: 35

Бүгд: 113
69.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

46.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр, логистик” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.2.25 дахь заалт нэмэх:

“3.3.2.25.Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудлыг 4D ангилалын болгон өргөтгөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 45
Бүгд: 113
60.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

47.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.2.26 дахь заалт нэмэх:

“3.3.2.26.Ханх-Хатгал чиглэлийн автозамыг барина.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 48
Бүгд: 113
57.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

48.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.3.3.Сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг нийгмийн үйлчилгээний байгууллагуудын барилга байгууламжийг пассив барилгын стандартад нийцүүлж, эрчим хүчний хэмнэлттэй технологит шилжүүлэх арга хэмжээ авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 44
Бүгд: 113
61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

49.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.3.Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.3.12 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“3.3.3.12.“10,000 нарны дээвэр” хөтөлбөрийг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын шугамаар хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73

Татгалзсан: 40
Бүгд: 113
64.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

50. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3.35 дахь дараах заалтыг хасах:

“3.3.3.35. Дархан УХУЦС 100 МВт төслийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 67
Бүгд: 113
40.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

51. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3.41 дэх дараах заалтыг “1.4.1. Шилжилт хөдөлгөөн” зорилтод шилжүүлэх:

“3.3.3.41. Төрийн байгууллагуудын эрхлэх асуудал, чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааны хамрах хүрээг нь харгалзан нийслэл Улаанбаатар хотоос үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээнд Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг холбогдох харьяа байгууллагуудын хамт Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 56
Бүгд: 113
50.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

52. Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3 дахь заалтын 3.3.3.37 дахь дэд заалтаас “Сонгино-Дархан” гэснийг хасаж доор дурдсан агуулгатай 3.3.3.42 дахь заалт нэмэх:

“3.3.3.42. Сонгино-Дархан чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж, эрчим хүчний найдвартай ажиллагааг дээшлүүлнэ” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 42
Бүгд: 113
62.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

53. Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.3. Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.3.43 дахь заалт нэмэх:

“3.3.3.43.Байгалийн хий дамжуулах хоолойн төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 75
Бүгд: 113
33.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

54.Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” гэсэн зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.2 дахь заалт нэмэх:

“3.3.4.2.Хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгохтой холбогдуулан зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, нөөц санг бүрдүүлж хоршооны гишүүн малчинд олгосон хөнгөлөлттэй зээлийн хүүгийн зөрүүг төрөөс хариуцна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 67
Бүгд: 113
40.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

55.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.4.4 дэх заалтын “экспортлоход анхаарна” гэснийг “экспортлоно” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 53
Бүгд: 113
53.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

56.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.29 дэх заалт нэмэх:

“3.3.4.29.Мал аж ахуй, газар тариалан, жимс, хүнсний ногоо тариалалтад дэмжлэг үзүүлэх зорилготой хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн түрээсийн аж ахуйн тогтолцоог бий болгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 43
Бүгд: 113
61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

57. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.30 дахь заалт нэмэх:

“3.3.4.30.Хоршоодод “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг байгуулах, хувьцаа эзэмших, хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлж, хоршооны үйл ажиллагааг дэмжих зорилготой “Малын эзэн-Үйлдвэрийн эзэн” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 41
Бүгд: 113

63.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

58. Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.31 дэх заалт нэмэх:

“3.3.4.31.Хөдөө аж ахуйн салбарын боловсон хүчин, залуу малчид, тариаланчдыг бэлтгэх зохистой бодлогыг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 75
Татгалзсан: 38
Бүгд: 113

66.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

59. Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.32 дахь заалт нэмэх:

“3.3.4.32.Сорт, сорилын төв, үрийн аж ахуйг дэмжиж, үрийн шинэчлэл хамгаалалтыг сайжруулан, гол нэр төрлийн тариалангийн үр үйлдвэрлэлд урамшуулал олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 49
Бүгд: 113

56.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

60. Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.33 заалт нэмэх:

“3.3.4.33.Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх, хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн нөөц бүрдүүлэх хүрээнд жил бүр 100.0 мян.тн хүнсний улаан буудайн нөөц бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 45
Бүгд: 113
60.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

61.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.5.Дөрвөн улирлын аялал жуулчлал” зорилгод доор дурдсан агуулгатай 3.3.5.12 дахь заалт нэмэх:

“3.3.5.12.Дундговь аймгийн Цагаан суварга орчмын палеонтологийн нөөцөд тулгуурлан аялал жуулчлалын тусгай бүсийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 43
Бүгд: 113
61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

62.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.6.Соёлын бүтээлч үйлдвэрлэл” зорилтын гарчгийг “3.3.6.Соёл урлаг, соёлын өв уламжлал, соёлын бүтээлч үйлвэрлэл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 51
Бүгд: 113
54.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

63.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.6.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.6.4.Түүхэн дурсгалт барилга байгууламжийг сэргээн засварлах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, “Соёлын биет өвийг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 42
Бүгд: 113
62.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

64.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.7.1 дэх заалтын “Шинжлэх ухаан” гэсний өмнө “Шинжлэх ухаан, технологийн арга хэмжээний зардлыг ДНБ-ий 1 хувьд хүргэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 43
Бүгд: 113
61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

65.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.7.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.7.7.Үндэсний эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн сангийн MORI платформыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, мэдлэгийн Data center байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 47
Бүгд: 113
58.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

66.Улсын Их Хурлын гишүүн А.Ундраагийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.4.2.Уур амьсгалын өөрчлөлт” зорилтод доор дурдсан агуулгатай 3.4.2.9 дэх заалт нэмэх:

“3.4.2.9.Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд хот, суурин газруудад яндангүй бүс байгуулж эрчим хүч, усны ухаалаг хэрэглээтэй амины орон сууцны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 49
Бүгд: 113
56.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

67.Улсын Их Хурлын гишүүн А.Ундраагийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.4.3.7 дахь заалтын “үйл ажиллагааг дэмжин” гэсний дараа “, Үндэсний ногоон барилгын үнэлгээний систем нэвтрүүлж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 49
Бүгд: 113
56.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

68.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.4.3.Ногоон эдийн засаг, ногоон хөгжлийн загвар” зорилтод доор дурдсан агуулгатай 3.4.3.11 дэх заалт нэмэх:

“3.4.3.11.Орхон-Онги, Хэрлэн-Гоонот ус дамжуулах хоолойг барина.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 49
Бүгд: 113
56.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

69.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.1.1.15 дахь дараах заалтыг хасах:

“4.1.1.15.Монгол Улсын Үндсэн хууль, хууль, хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн байгууллагын захиалгаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах, Улсын Их Хурлын хяналт шалгалтын үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх чиг үүрэг бүхий Хууль судлалын институтыг байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 58
Бүгд: 113
48.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

70.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.1.1.17 дахь дараах заалтыг хасах:

“4.1.1.17.Үйлдвэрлэлийг өргөжүүлэх замаар хоригдлын ажлын байрыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг сайжруулан, улсын төсвийн ачааллыг бууруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 57
Бүгд: 113
49.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Б.Хэрлэн, Б.Мөнхсоёл нарын “дэмжсэн” 69 дүгээр санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Б.Хэрлэн, Б.Мөнхсоёл нарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 40
Бүгд: 113
64.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: 69.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.1.1.15 дахь дараах заалтыг хасах:

“4.1.1.15.Монгол Улсын Үндсэн хууль, хууль, хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн байгууллагын захиалгаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах, Улсын Их Хурлын хяналт шалгалтын үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх чиг үүрэг бүхий Хууль судлалын институтыг байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 44
Бүгд: 113

61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын “дэмжсэн” 70 дугаар санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 52
Бүгд: 113

54.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: 70.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.1.1.17 дахь дараах заалтыг хасах:

“4.1.1.17.Үйлдвэрлэлийг өргөжүүлэх замаар хоригдлын ажлын байрыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг сайжруулан, улсын төсвийн ачааллыг бууруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 54
Бүгд: 113

52.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

71.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.1.1.18 дахь дараах заалтыг хасах:

“4.1.1.18.Хорих ял эдлүүлэх орчин, нөхцөлийг сайжруулах зорилгоор "Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага"-ын цогцолбор барилгыг ашиглалтад оруулж хүний эрхийг хангана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 55
Бүгд: 113

51.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

72.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.1.2.Хэвлэлийн эрх чөлөө” зорилтод доор дурдсан агуулгатай 4.1.2.2 дахь заалт нэмэх:

“4.1.2.2.Олон нийтийн радио, телевизийн бие даасан байдлыг хангах, хариуцлагатай, хараат бус, иргэдийг соён гэгээрүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн нийтлэлийн бодлоготой болгох чиглэлээр эрх зүйн орчныг шинэтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 43

Бүгд: 113

61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

73.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.1.3.Иргэний нийгэм, хувийн хэвшил, төрийн түншлэл, хамтын ажиллагаа” зорилтод доор дурдсан агуулгатай 4.1.3.4 дэх заалт нэмэх:

“4.1.3.4.Тендэрийн үнэлгээнд төсөл хөрөнгө оруулалтуудын шууд дам нөлөөлөл, хүртээмж нэмэх, нийгмийн үнэлгээ хийх эрх зүйн орчин бий болгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 73

Бүгд: 113

35.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

74.Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.1.3.Иргэний нийгэм, хувийн хэвшил, төрийн түншлэл, хамтын ажиллагаа” зорилтод доор дурдсан агуулгатай 4.1.3.5 дахь заалт нэмэх:

“4.1.3.5.Иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог баталгаажуулан бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцооны тодорхой шалгуур үзүүлэлт бүхий нийтлэг журмыг баталж, төрийн байгууллагуудын ил тод байдлын түвшинг жил бүр үйлчилгээг хүртэгч төрийн бус байгууллага, иргэдээр үнэлүүлж индексжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 56

Бүгд: 113

50.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

75.Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.1.3.Иргэний нийгэм, хувийн хэвшил, төрийн түншлэл, хамтын ажиллагаа” зорилтод доор дурдсан агуулгатай 4.1.3.6 дахь заалт нэмэх:

“4.1.3.6.Иргэний нийгмийн байгууллагууд болон сайн дурынхны нийгэм-эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг үндэсний тооцооны аргачлалаар үнэлдэг албан

ёсны статистикийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 52
Бүгд: 113
54.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

76.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.1.5.Парламентын засаглал ба эрх мэдлийн хяналт, тэнцэл” зорилтын гарчиг болон 4.1.5.1 дэх дараах заалтыг хасаж, 4.1.5.2 дахь заалтыг “4.1.1.Хүний эрх” зорилтын 4.1.1.6 дахь заалт болгон шилжүүлж, дугаарлалтыг өөрчлөх:

“4.1.5.1.Улс орны хөгжлийн амин чухал асуудлаар үндэсний зөвшилцөлд хүрч, төрийн залгамж чанар, бодлогын тогтвортой байдлыг хангах бөгөөд улс төрийн намуудыг нийтийн эрх ашгийн төлөө үйлчилдэг бодлогын институт болгох эрх зүйн орчныг бүрдүүлж, хатуу гишүүнчлэлээс татгалзаж, санхүүжилтийг ил тод болгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 53
Бүгд: 113
53.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

77.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.1.6.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.6.5.Хууль зүйн дэд бүтцийг хөгжүүлэх, бэхжүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 50
Бүгд: 113
55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

78.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.1.2.“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 49
Бүгд: 112
56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

79.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.3 дахь заалтын “Авлига” гэсний өмнө “Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааг үргэлжлүүлж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 53
Бүгд: 112
52.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

80.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.4 дэх заалтыг хасах:

“4.2.1.4.Авлигаас олсон орлогыг хураан авч, тухайн орлогыг гэмт хэргийн хохирлыг барагдуулах, хууль сахиулах байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх болон нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 47
Бүгд: 112
58.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

81.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.1.Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах үйл ажиллагаа” гэсэн зорилтод доор дурдсан агуулгатай 4.2.1.8 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“4.2.1.8.Улс төр дэх мөнгөний нөлөөллийг бууруулж, сонгогчдын саналыг худалдан авах аливаа ажиллагааг зогсооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 49
Бүгд: 111
55.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

82.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.15 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.1.15.Тагнуулын үйл ажиллагаа болон нууц мөрдөн шалгах ажиллагааны зааг ялгааг тодорхой болгож, эрх зүйн орчныг тус тусын хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 43
Бүгд: 111
61.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

83. Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.3.1. Чадахуйн зарчимд суурилсан оновчтой бүтэц бүхий төрийн албыг бэхжүүлж, төрийн албан хаагчийн бүтээмжийг нэмэгдүүлэн, төрийн албаны чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг боловсронгуй болгож, төрийн захиргааны албан хаагчдын тоог зохистой хэмжээнд хүргэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 49
Бүгд: 111
55.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

84. Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.6 дахь заалтын “эвлэлдэн нэгдэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 71
Бүгд: 111
36.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, С.Лүндэг нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, С.Лүндэг нарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 67
Бүгд: 111
39.6 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

85. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.11 дэх дараах заалтыг хасах:

“4.2.3.11. Төрийн албан хаагчдын цахим мэдээллийг өөрт нь нээлттэй болгох замаар төрийн албан хаагчийн иж бүрэн цахим платформыг хөгжүүлж, мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдлыг сайжруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 48
Бүгд: 111
56.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

86.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“4.2.3.12.Хууль сахиулагчдын мэргэшил, нийгэм, эдийн засгийн баталгааг сайжруулж, хууль сахиулагч болон хууль сахиулах албаны эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль, эрх зүйн орчныг бий болгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 51

Бүгд: 111

54.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

87.Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” зорилтод доор дурдсан агуулгатай 4.2.3.13 дахь заалт нэмэх:

“4.2.3.13.Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулж, ёс зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 49

Бүгд: 111

55.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

88.Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” зорилтод доор дурдсан агуулгатай 4.2.3.14 дэх заалт нэмэх:

“4.2.3.14.“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” /2024-2030 он/ дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлж, ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэх соёлыг хэвшүүлж, нийгмийн ёс суртахууны үнэт зүйл бүхий сэтгэл зүйг төлөвшүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 58

Бүгд: 111

47.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

89.Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” зорилтод доор дурдсан агуулгатай 4.2.3.15 дахь заалт нэмэх:

“4.2.3.15.Төрийн албаны ёс зүйн индекс, ёс зүйн дэд бүтцийг олон улсын туршлагад суурилан хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 54

Бүгд: 111

51.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

90. Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.4.Орон нутгийн засаглалын бие даасан байдал” зорилтод доор дурдсан агуулгатай 4.2.4.1 дэх заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“4.2.4.1.Орон нутгийн засаглалын бие даасан байдлыг бэхжүүлэх хүрээнд орон нутгийн босоо удирдлагатай байгууллагуудын томилгооны асуудлыг орон нутагт нь шилжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 67

Бүгд: 111

39.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

91. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.4.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.4.3.Хот байгуулалт, барилга, газрын талаарх холбогдох хуулийн уялдааг сайжруулж, төлөвлөлтөд суурилсан хот байгуулалтын тогтолцоог бий болгон, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрлийг олгож, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлагыг чангатгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 51

Бүгд: 111

54.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

92. Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.4.Орон нутгийн засаглалын бие даасан байдал” зорилтод доор дурдсан агуулгатай 4.2.4.4 дэх заалт нэмэх:

“4.2.4.4.Хороо, багийн хэмжээнд хэрэгжүүлэх тохижилтын жижиг төслүүдийг иргэдийн бүлэг, хөршийн холбоогоор гүйцэтгүүлэх боломжийг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 53

Бүгд: 111

52.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

93.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.3.1.“E-Mongolia”-блок чейн-Цахим засаглал” зорилтод доор дурдан агуулгатай 4.3.1.6 дахь заалт нэмэх:

“4.3.1.6.Засгийн газрын тусгай сангуудын санхүүжилт, сонгон шалгаруулалтыг цахимжуулж ил тод болгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 51
Бүгд: 111

54.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

94.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.4.1.3 дахь заалтын “ёс суртахууны доголдол,” гэснийг хасаж, 4.4.1.4 дэх заалтын “ёс зүйтэй” гэснийг “хариуцлагатай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 49
Бүгд: 111

55.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

95.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.4.1.6, 4.4.1.7, 4.4.1.8, 4.4.1.9, 4.4.1.10, 4.4.1.11 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.4.1.6.Хилийн цэргийн байгуулалтыг хөгжүүлэх, мэргэшсэн хилчин, технологид суурилсан хил хамгаалах албыг бэхжүүлэн, зэвсэглэл, инженер, дохиолол хамгаалалт, радио релейн болон хяналтын систем, цэргийн холбоо, техник, нисгэгчгүй нисэх хэрэгсэл, тусгай хэрэгслээр бүрэн хангаж, хилийн цэргийн нисэх анги байгуулан, нисдэг тэрэг, нисэх онгоц ашиглах замаар хилийн аюулгүй байдлыг хангах, хилийн дэглэмийн гэрээг хэрэгжүүлнэ.

4.4.1.7.Хилийн боомтын сэргэлтийн бодлоготой уялдуулан авто зам, төмөр зам бүхий боомтуудад шалган нэвтрүүлэх анги байгуулж, боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, ухаалаг цахим гарц, дохиолол хяналт, хамгаалалтын нэгдсэн систем, тоног төхөөрөмжөөр хангана.

4.4.1.8.Хилийн цэргийн анги, салбарын албаны барилга, орон сууцыг шинэчилж, хилчдийн алба хаах, амьдрах нөхцөлийг сайжруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 53
Бүгд: 110

51.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

96.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.4.2.4 дэх дараах заалтыг хасах:

“4.4.2.4.Гадаад бодлогын үзэл баримтлалыг сансар судлал, шинжлэх ухаан, технологийн салбар дахь дэлхийн чиг хандлагатай нийцүүлэн шинэчилнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 45

Татгалзсан: 65

Бүгд: 110

40.9 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 67

Бүгд: 110

39.1 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 57

Бүгд: 110

48.2 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

97.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.4.2.15 дахь заалтын “дээшлүүлэх шаардлага улам нэмэгдэж байна” гэснийг “дээшлүүлнэ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 53

Бүгд: 110

51.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

98.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.4.3.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.4.3.7.“ЭХ ОРНЫ ДУУДЛАГА-ЭР ЦЭРГИЙН АЛБА”-ны хүрээнд батлан хамгаалах үйл хэргийг иргэдэд сурталчилж, хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлж, цэргийн сургалтын тогтолцоонд шинэчлэл хийж, цэргийн албаны төрлийг нэмэгдүүлэх замаар Зэвсэгт хүчин, алба хаагчийн олон нийтийн дэмжлэг, нэр хүндийг дээшлүүлнэ.” өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 46

Бүгд: 108

57.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

99. Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “Эрсдэлийн удирдлага” гэсэн бүлгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, “4.4.Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм” гэсэн хэсэгт 4.4.5 дахь зорилт болгон шилжүүлж, 4.4.4 дэх зорилтын гарчгийн “, эрсдэлийн удирдлага” гэснийг хасах:

“4.4.5.Эрсдэлийн удирдлага

4.4.5.1.Геополитикийн тогтворгүй байдал, цар тахлын үеийн болон дараах эдийн засгийн хямрал, эрчим хүчний дутагдал, тээвэр логистикийн доголдол, хиймэл оюун ухаан, кибер аюулгүй байдал ба дэвшилтэт технологийн хурдацтай шилжилтийн тодорхой бус байдал, санхүүгийн эх үүсвэрийн хүрэлцээгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, байгаль, цаг уурын нөлөөлөл болон бусад эрсдэлийг даван туулах, хариу бэлтгэл арга хэмжээг шуурхай авах зорилгоор холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах, төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангасан эрсдэлийн удирдлагын цогц бодлого, төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.

4.4.5.2.Эрсдэлийг урьдчилан илрүүлэх, үнэлэх, эрэмбэлэх, хариу арга хэмжээ авах, хэрэгжилтэд үнэлгээ хийх системийг хөгжүүлж, эрсдэлийн удирдлагын шинэчлэлийг эхлүүлнэ.

4.4.5.3.Хамтрагч, түншлэгч талууд болон олон нийтэд мэдээллийг түргэн шуурхай хүргэх, солилцох нөхцөлийг бүрдүүлж, хамтын итгэлцлийг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлага, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэх хүрээнд гадаад болон олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

4.4.5.4.Эрсдэлийн удирдлагын үе шат бүрд иргэн, хуулийн этгээдийн оролцоог хангаж, урамшуулах бодлогыг дэмжинэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 61

Татгалзсан: 47

Бүгд: 108

56.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

100.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.4.4.10 дахь заалтын “Гамшгийн зураглал, эрсдэлийн мэдээллийн сан, гамшгийн эрсдэл хуваалцах механизмыг хөгжүүлнэ.” гэснийг “гамшгийн зураглал, байгаль орчин, уур амьсгалын эрсдэлийн мэдээллийн сан, гамшгийн эрсдэл хуваалцах механизмыг хөгжүүлж, олон нийтэд нээлттэй болгоно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 50
Бүгд: 108

53.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

101.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтад “Үр дүн” баганад “Зах зээл дэх төрийн оролцоог бууруулах” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2023” гэж, “Суурь түвшин” баганад “76.2 %” гэж, Зорилтот түвшний “2025 он” баганад “77%” гэж, “2026 он” баганад “78%” гэж, “2027 он” баганад “79%” гэж, “2028 он” баганад “80%” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “ҮСХ” гэж, “Мэдээлэл цуглуулах арга” баганад “Статистик мэдээ” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жилд нэг удаа” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 49
Бүгд: 108

54.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

102.Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтад 13 дахь мөр буюу “Үр дүн” баганад “Ёс зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ёс зүйн хороо, дэд хороодын чадавхын үнэлгээ” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2024” гэж, “Суурь түвшин” баганад “0” гэж, Зорилтот түвшний “2025 он” баганад “20” гэж, “2026 он” баганад “30” гэж, “2027 он” баганад “40” гэж, “2028 он” баганад “50” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Ёс зүйн хороо, дэд хорооны тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Ёс зүйн хороо, дэд хорооны чадавхын судалгаа” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жилд нэг удаа” гэж, 14 дэх мөр буюу “Үр дүн” баганад “Ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэх соёлыг хэвшүүлж, нийгмийн ёс суртахууныг төлөвшүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ёс зүйн зөрчлийн бууралт, нийгмийн нөлөөллийн үнэлгээ” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2024” гэж, “Суурь түвшин” баганад “Батлагдсан хөтөлбөр” гэж, Зорилтот түвшний “2025 он” баганад “30” гэж, “2026 он” баганад “50” гэж, “2027 он” баганад “75” гэж, “2028 он” баганад “85” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Олон эх үүсвэр” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил бүр” гэж, 15 дахь мөр буюу “Үр дүн” баганад “Төрийн албаны ёс зүйн индекс, ёс зүйн дэд бүтцийг олон улсын туршлагад суурилан хэрэгжүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ёс зүйн үзүүлэлт” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2024” гэж, “Суурь түвшин” баганад “0” гэж, Зорилтот түвшний “2025 он” баганад “10” гэж, “2026 он” баганад “15” гэж, “2027 он” баганад “25” гэж, “2028 он” баганад “35” гэж, “Мэдээллийн эх сурвалж”

баганад “Төрийн албаны олон улсын индекс (InCiSE)-ийн ёс зүйн (INT) үзүүлэлт” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Үндэсний үзүүлэлтийн судалгаа” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жилд нэг удаа” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 56
Бүгд: 108
48.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 53
Бүгд: 108
50.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Төслийн 2 дугаар хавсралтад 13 дахь мөр буюу “Үр дүн” баганад “Ёс зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ёс зүйн хороо, дэд хороодын чадавхын үнэлгээ” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2024” гэж, “Суурь түвшин” баганад “0” гэж, Зорилтот түвшний “2025 он” баганад “20” гэж, “2026 он” баганад “30” гэж, “2027 он” баганад “40” гэж, “2028 он” баганад “50” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Ёс зүйн хороо, дэд хорооны тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Ёс зүйн хороо, дэд хорооны чадавхын судалгаа” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жилд нэг удаа” гэж, 14 дэх мөр буюу “Үр дүн” баганад “Ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэх соёлыг хэвшүүлж, нийгмийн ёс суртахууныг төлөвшүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ёс зүйн зөрчлийн бууралт, нийгмийн нөлөөллийн үнэлгээ” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2024” гэж, “Суурь түвшин” баганад “Батлагдсан хөтөлбөр” гэж, Зорилтот түвшний “2025 он” баганад “30” гэж, “2026 он” баганад “50” гэж, “2027 он” баганад “75” гэж, “2028 он” баганад “85” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Олон эх үүсвэр” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил бүр” гэж, 15 дахь мөр буюу “Үр дүн” баганад “Төрийн албаны ёс зүйн индекс, ёс зүйн дэд бүтцийг олон улсын туршлагад суурилан хэрэгжүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ёс зүйн үзүүлэлт” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2024” гэж, “Суурь түвшин” баганад “0” гэж, Зорилтот түвшний “2025 он” баганад “10” гэж, “2026 он” баганад “15” гэж, “2027 он” баганад “25” гэж, “2028 он” баганад “35” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Төрийн албаны олон улсын индекс (InCiSE)-ийн ёс зүйн (INT) үзүүлэлт” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Үндэсний үзүүлэлтийн судалгаа” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жилд нэг удаа” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 47
Бүгд: 108
56.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

103. Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтад “олон улсын ур чадварын үзүүлэлт” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 51
Бүгд: 108
52.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

104. Ажлын хэсгийн гаргасан, Зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан тогтоолын төслийн болон хавсралтын нэр томъёог жигдлэх, бүлэг, зүйл, хэсэг, заалт, дэд заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 42
Бүгд: 108
61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

НАЙРУУЛГЫН САНАЛ:

Д.Амарбаясгалан: 1. Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтын 3 дахь дэд заалтын “мэдэгдэл” гэснийг “мэдэгдлийн” гэж, “төлөвлөгөө” гэснийг “төлөвлөгөөний” гэж, 3 дахь заалтын “төрөлжсөн,” гэснийг “төрөлжсөн бүс бөгөөд” гэж тохиолдол бүрд, тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “реформ” гэснийг “шинэчлэл” гэж, “реформыг” гэснийг “шинэчлэлийг” гэж тохиолдол бүрд, 1.3.6.1 дэх заалтын “Алтай овоо” гэснийг “Алтан овоо” гэж, 2.1.1.7 дахь заалтын “гэр бүл, хүүхэд хөгжил, хамгааллын” гэснийг “, гэр бүлийн” гэж, 2.1.1.12 дахь заалтын “хөгжил, нийгмийн” гэснийг “хөгжлийн болон нийгмийн” гэж, 2.2.1.4 дэх заалтын “тохируулгад” гэснийг “тохируулгат” гэж, 2.2.1.9 дэх заалтын “чиглэнэ” гэснийг “чиглүүлнэ” гэж, 2.2.1.13 дахь заалтын “төгсдөг” гэснийг “төгсөх” гэж, 3.2.2.5 дахь заалтын “хүч” гэснийг “хүчний” гэж, 3.2.2.9, 3.2.2.10 дахь заалтын “баталж,” гэснийг “батлуулж” гэж, 3.2.2.10 дахь заалтын “саад тотгорыг” гэснийг “саадыг” гэж, 3.3.5.10 дахь заалтын “марс гарагт” гэснийг “марс гарагтай” гэж, 3.3.6.7 дахь заалтын “концепцоор” гэснийг “агуулгаар” гэж, 4.1.1.3 дахь заалтын “мөрдөн хавчигддаг” гэснийг “мөрдөн хавчигддаггүй байх” гэж, 4.1.2.1 дэх заалтын “ёс зүй” гэснийг “ёс зүйг баримтлан” гэж, 4.3.2.4 дэх заалтын “IoT” гэснийг “юмсын интернэт” гэж тус тус өөрчлөх.

2. Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.1.4.4 дэх заалтын “хөдөлгөөн” гэсний өмнө “замын” гэж, 2.1.1.29 дэх заалтын “хөтөлбөрт” гэсний өмнө “сургалтын” гэж, 2.1.4.2 дахь заалтын “шигшээ” гэсний өмнө “үндэсний” гэж, 2.2.1.6 дахь заалтын “эдийн засгийн”

гэсний дараа “хувьд” гэж, 3.2.2.5 дахь заалтын “төлбөрөөс” гэсний өмнө “ажлын байрны” гэж, 3.4.1.1 дэх заалтын “төрхийг” гэсний өмнө “унаган” гэж, 4.2.1.12 дахь заалтын “камерын” гэсний дараа “хяналтын” гэж, 4.3.1.3 дахь заалтын “зэрэг бүх салбарт” гэснийг “болон бусад салбарт” гэж, 4.4.2.1 дэх заалтын “суурь” гэсний өмнө “гадаад бодлогын” гэж тус тус нэмэх.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2.1.7 дахь заалтын “дээд зэргээр” гэснийг, 2.2.4.2 дахь заалтын “дигитал” гэснийг, 3.1.1.3 дахь заалтын “Монгол Улсын Үндсэн хуульд заасан” гэснийг, 3.2.2.2 дахь заалтын “багц” гэснийг, 3.2.2.4 дэх заалтын “цахим” гэснийг, 3.3.4.4 дэх заалтын “ялангуяа” гэснийг, 4.3.2.5 дахь заалтын “аливаа” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 48

Бүгд: 108

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин найруулгын саналтай холбогдуулан үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Байнгын хороо найруулгын саналыг гүйцээн боловсруулахдаа Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжиний саналыг анхаарахыг чиглэл болгов.

Хоёр.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дахь заалтыг хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 45

Татгалзсан: 63

Бүгд: 108

41.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, О.Батнайрамдал нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, О.Батнайрамдал нарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 56

Бүгд: 108

48.1 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Г.Уянгахишиг нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Г.Уянгахишиг нарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 57
Бүгд: 108
47.2 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 1.1.3.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.3.2.Цэвэрлэх байгууламжийн тархмал дэд төвүүдийг шинээр байгуулах, бие даасан, бага оврын ариун цэврийн байгууламжийн хэрэглээг бодлогоор дэмжих замаар нүхэн жорлонгийн тоог 2 дахин бууруулж, хөрсний бохирдлыг бууруулна.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 59
Бүгд: 108
45.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “1.1.3.Гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулалт” зорилтод доор дурдсан агуулгатай 1.1.3.7 дахь заалт нэмэх:

“1.1.3.7.Эрчим хүчний хэмнэлтийг бий болгох, нийслэлийн орон сууцны дулаан алдагдлыг бууруулах зорилгоор нэг удаа орон сууцны дулаалгын ажлыг хийнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 88
Бүгд: 108
18.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 79

Бүгд: 108
26.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “1.3.5.Төвийн бүс- “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс”” гэсэн зорилтын гарчгийг “1.3.5.Төвийн бүс-“Эрчимжсэн хөдөө аж ахуй, аж үйлдвэржилт, эрчим хүчний дэд бүс”” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 95
Бүгд: 108
12.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.5.3 дахь дараах заалтыг хасах:

“1.3.5.3.Шүрэнгийн усан цахилгаан станц барина” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 80
Бүгд: 108
25.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайханы гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “1.3.5.Төвийн бүс-“Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” гэсэн зорилтод доор дурдсан агуулгатай 1.3.5.7 дахь заалт нэмэх:

“1.3.5.7.Дарханы арьс ширний үйлдвэрийг барьж дуусгана.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 68
Бүгд: 108
37.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.1.Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого” зорилтын “Хүүхэд” хэсэгт доор дурдсан агуулгатай 2.1.1.9 дэх заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“2.1.1.9.Хичээлээс гадуурх үйл ажиллагаа буюу хүүхэд хөгжүүлэх секц, дугуйлан, сургалтын төвүүд, түүний багш нарт санхүүжилтийн болон байр, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 91

Бүгд: 108

15.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

8.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1.1.19 дэх заалтын ”инфляц” гэснийг “өмнөх оны инфляцын жилийн дундаж болон” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33

Татгалзсан: 75

Бүгд: 108

30.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

9.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1.2.6 дахь заалтын “цалин хөлсийг” гэсний дараа “жил бүр” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 83

Бүгд: 108

23.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

10.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.2.Хөдөлмөр эрхлэлт” зорилтод доор дурдсан агуулгатай 2.1.2.2 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“2.1.2.2.Хөдөлмөрийн зах зээлд эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрийг хангасан цалин хөлсний тогтолцоог бий болгоно.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 68

Бүгд: 108

37.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

11.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.2.1.Тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол” хэсэгт доор дурдсан агуулгатай 2.2.1.20 дахь заалт нэмэх:

“2.2.1.20.Хүүхэд хөгжлийн STEAM боловсрол олгох ордныг дүүргүүдэд байгуулна.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 65

Бүгд: 108
39.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

12.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.2.1.Тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол” зорилтод доор дурдсан агуулгатай 2.2.1.21 дэх заалт нэмэх:

“2.2.1.21.Үндэсний цөөнхийн бага, дунд боловсрол эзэмших эрхийг хангах “Хос хэл”-ний бодлого, арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 78
Бүгд: 108
27.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаярын “дэмжсэн” 11, 12 дугаар санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 51
Бүгд: 99
48.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, М.Нарантуяа-Нара нарын “дэмжсэн” 11 дүгээр санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, М.Нарантуяа-Нара нарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 48
Бүгд: 99
51.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: 11.Төслийн 1 дүгээр хавсралтын “2.2.1.Тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол” хэсэгт доор дурдсан агуулгатай 2.2.1.20 дахь заалт нэмэх:

“2.2.1.20.Хүүхэд хөгжлийн STEAM боловсрол олгох ордныг дүүргүүдэд байгуулна.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 48
Бүгд: 99

51.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаярын “дэмжсэн” 12 дугаар санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 48
Бүгд: 99

51.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 12 дугаар саналыг гүйцээн боловсруулах чиглэлийг Байнгын хороонд өгөв.

13.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2.4.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.2.4.1.Боловсролын бодлого, санхүүжилт, хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хүн ам, орон зайн их өгөгдөлд тулгуурласан хиймэл оюун ухаан ашиглах замаар боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүн, үр ашгийг сайжруулна.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 36
Бүгд: 99

63.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

14.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, О.Саранчулуун нарын гаргасан, Төслийн 2.3.4.3 дахь заалтын “эрүүл мэндийн ажилтны” гэсний дараа “цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулж” гэж нэмж, “алслагдсан” гэснийг хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 44
Бүгд: 99

55.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

15.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “2.4.1.Баялагтаа эзэн Монгол” зорилгод доор дурдсан агуулгатай 2.4.1.9 дэх заалт нэмэх:

“2.4.1.9.Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг Засгийн газартай байгуулсан аж ахуйн нэгжүүд, уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн үйлчлэлд хамруулна.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 45

Бүгд: 99

54.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

16. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 2.4.2.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.4.2.7. Үл хөдлөх салбарын хамтын хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 60

Бүгд: 103

41.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

17. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.2.1. Гатвар, нийгмийн даатгалын реформ” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“3.2.1.8. “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг шинэчилнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 47

Бүгд: 104

54.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

18. Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.1. Уул уурхай” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.1.17, 3.3.1.18 дахь заалт нэмэх:

“3.3.1.17. Эрдэнэтийн овооны Оюут ордын нөөцийг тооцоолон, ТЭЗҮ-ийг эцэслэж, ашиглалтад оруулахад бэлэн болгоно.”

“3.3.1.18. Эрдэнэтийн стратегийн ордын талбайн эрэл хайгуулын ажлын хүрээнд хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологи ашиглан дахин шинэ стратегийн орд нээж, ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг эхлүүлнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 42

Бүгд: 104

59.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

19. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилтын 3.3.1.13, 3.3.2.17 дахь дараах заалтуудыг хасах:

“3.3.1.13. “Сайншанд-Баруун-Урт-Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлнэ.”

“3.3.2.17. “Сайншанд-Баруун-Урт-Хөөт” чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 45

Бүгд: 104

56.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

20. Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабылын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” гэсэн заалтад доор дурдсан агуулгатай 3.3.2.20 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“3.3.2.20. Даянгийн боомтыг хатуу хучилттай авто замаар холбох бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33

Татгалзсан: 71

Бүгд: 104

31.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

21. Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн, Л.Энх-Амгалан, Д.Батлут, Б.Бат-Эрдэнэ, Д.Үүрийнтуяа нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.2.27 дахь заалт нэмэх:

“3.3.2.27. Хутаг-Өндөр сумаас Бага илэнхийн хилийн боомт хүртэл 146 км хатуу хучилттай авто замыг барина.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 83

Бүгд: 104

20.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 78

Бүгд: 104

25.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

22.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн, Л.Энх-Амгалан, Д.Батлут, Б.Бат-Эрдэнэ, Д.Үүрийнтуяа нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.2.28 дахь заалт нэмэх:

“3.3.2.28.Эрдэнэт хотын доторх авто замын барилга угсралт, шинэчлэлт, өргөтгөл, их засварын ажлыг гүйцэтгэнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33

Татгалзсан: 72

Бүгд: 105

31.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 74

Бүгд: 105

29.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

23.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн, Л.Энх-Амгалан, Д.Батлут, Б.Бат-Эрдэнэ, Д.Үүрийнтуяа нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.2.29 дэх заалт нэмэх:

“3.3.2.29.Мөрөн-Их-Уул-Рашаант-Өлзийт-Хайрхан-Тэрхийн цагаан нуур босоо чиглэлийн хатуу хучилттай авто замыг барьж дуусгана.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 67

Бүгд: 105

36.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.3.Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” гэсэн зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.3.44 дэх заалт нэмж, 3.3.3.30 дахь заалтаас “Чойр-Сайншанд чиглэлийн 220 кВ,” гэснийг, 3.3.3.37 дахь заалтаас “Тавантолгойн ДЦС-Оюутолгой,” гэснийг тус тус хасах:

“3.3.3.44.Тавантолгой-Оюутолгой чиглэлийн 220кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, Чойр-Сайншанд чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг тус тус барина.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 57

Бүгд: 105

45.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3.38 дахь дараах заалтыг хасах:

“3.3.3.38.Аймгийн төвүүд, сум суурин газруудын дулаан хангамжийн дэд бүтцийг сайжруулах, үр ашиг өндөртэй нүүрс, сэргээгдэх эрчим хүчний технологийг ашигласан станцуудыг байгуулах суурь судалгааг хийх, төслүүдийг эхлүүлнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 57

Бүгд: 105

45.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

26.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн, Л.Энх-Амгалан, Д.Батлут, Б.Бат-Эрдэнэ, Д.Үүрийнтуяа нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.3.Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.3.45 дахь заалт нэмэх:

“3.3.3.45.Мөрөн хотод 50 мВт-аас доошгүй хүчин чадалтай дулааны цахилгаан станц байгуулах бэлтгэл ажлыг хангана.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 65
Бүгд: 105

38.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

27. Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн, Л.Энх-Амгалан, Д.Батлут, Б.Бат-Эрдэнэ, Д.Үүрийнтуяа нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.3.Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.3.46 дахь заалт нэмэх:

“3.3.3.46.Эрдэнэт хотын цахилгаан хангамжийг сайжруулахад шаардлагатай 35 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барина.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 65
Бүгд: 105

38.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

28. Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.3.Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.3.47 дахь заалт нэмэх:

“3.3.3.47.Эрчим хүчний салбарт реформ хийж, салбарын эрх зүйн орчныг сайжруулах ажлын хүрээнд Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулиуд болон холбогдох хууль тогтоомжийг шинэчилнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 83
Бүгд: 105

21.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

29. Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.3 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“3.3.4.3.Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, хоршооны загвар төслүүдийг бэлтгэх, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий сургагч багш нарыг бэлтгэх, сургалт зохион байгуулна.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 70
Бүгд: 105

33.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

30. Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” гэсэн зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.7 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“3.3.4.7.Бэлчээрийг зохистой ашилах, хамгаалах үүднээс малчдын өвөлжөө, хаваржааны доорх газрын хоорондын доод зай хэмжээг, мөн гүний худгийн цооног хоорондын доод зай хэмжээг тогтоох, дээрх газруудыг эзэмших, ашиглах эрхийг бусдад шилжүүлэхийг хориглох, арилжихыг хориглох, зөвхөн үр хүүхэддээ өвлүүлдэг байх эрх зүйн өөрчлөлт оруулна.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 56

Бүгд: 105

46.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

31. Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.4.1.1 дэх заалтын “тусгай хамгаалалттай газар нутгийг өргөтгөн,” гэснийг “тусгай хамгаалалттай газар нутгийн” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 45

Татгалзсан: 60

Бүгд: 105

42.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

32. Улсын Их Хурлын гишүүн А.Ундраагийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” гэсэн зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.29 дэх заалт нэмэх:

“3.3.4.29.Малчдад эрчим хүчний хэмнэлттэй өвлийн жишиг сууцны загвар түгээж, мэдлэг олгоно.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 57

Бүгд: 105

45.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

33. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.1.1.2 дахь дараах заалтыг хасах:

“4.1.1.2.“Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний II хөтөлбөр” батлуулж, хэрэгжүүлнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 50

Бүгд: 105

52.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

34. Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарагийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.1.4. Авлигаас олсон орлогыг хураан авч, тухайн орлогыг хүүхэд хамгаалах сан, хүүхдийн эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэн зарцуулна.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 48

Бүгд: 105

54.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

35. Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.1. Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах үйл ажиллагаа” зорилтод доор дурдсан агуулгатай 4.2.1.8 дахь заалт нэмэх:

“4.2.1.8. Авлигатай тэмцэх газрын салбарыг 21 аймагт байгуулна.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 38

Бүгд: 105

63.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

36. Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.13 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.1.13. Нууц мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн орчныг хүний эрхийг дээдлэх зарчимд тулгуурлан тодорхой болгоно.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, О.Номинчимэг нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 36 дугаар саналыг гүйцээн боловсруулах чиглэлийг Байнгын хороонд өгөв.

37. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3. Төрийн албаны реформ” зорилтыг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.3. Төрийн албаны шинэчлэл

4.2.3.1. Хөгжлийн бодлого, чиг үүргийн шинжилгээнд тулгуурласан захиргааны оновчтой, уян хатан, үр дүнтэй, үр ашигтай төрийн албаны бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний төрлийг оновчилж, чадахуйн зарчимд суурилсан чадварлаг, цомхон, төрийн албыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн албан хаагчийн ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үнэлгээний менежментийг сайжруулан, төрийн захиргааны албан хаагчдын тоог үе шаттайгаар зохистой хэмжээнд хүргэнэ.

4.2.3.2. Хяналт шалгалт, хүний нөөцийн аудитын тогтолцоог оновчтой бүрдүүлж, хууль, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээг гүйцэтгэл, үр дүнд суурилан үнэн зөв, бодитой хийж, олон улсын үнэлгээнд нийцүүлнэ.

4.2.3.3. Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг үргэлжлүүлэн эрчимжүүлж, төрийн мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн халах, иргэн, хуулийн этгээд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй авах нөхцөлийг бүрдүүлнэ.

4.2.3.4. Эрх мэдлийн төвлөрөл үүсгэсэн хууль тогтоомжийг өөрчилж, хөгжлийн чиг хандлага, бүсчилсэн хөгжилд нийцүүлэн, төрийн албаны хууль тогтоомжийн шинэтгэлийг эрчимжүүлнэ.

4.2.3.5. Төрийн албанд ёс зүйн төлөвшлийг бэхжүүлж, ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг бий болгох, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг төрийн бүх шатны байгууллагад хэрэгжүүлэх, төрийн албаны чадамжид суурилсан хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд ёс зүйн хэм хэмжээ, шалгуур үзүүлэлтийг суурь болгоно.

4.2.3.6. Төрийн албан хаагчийг улс төр, удирдлагын хууль бус шийдвэр, аливаа дарамт шахалт, улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх зарчмыг хангах, эвлэлдэн нэгдэж, эрх ашгаа хамтран хамгаалах боломжийг бүрдүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгон, тогтвортой ажиллах нөхцөлөөр хангана.

4.2.3.7. Төрийн албаны хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, чадавхыг бэхжүүлэх, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх, хөгжүүлэх тогтолцоог сайжруулж, төрийн албанд таваас дээш жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн гурван жилд нь “маш сайн” үнэлэгдсэн төрийн албан хаагчийг гадаад улс орны болон ахисан түвшний сургалтад хамруулах чиглэл баримтална.

4.2.3.8. Төрийн албаны сургалтын байгууллагын бүтэц, төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлж, сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.

4.2.3.9. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны зохистой бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, төрийн албан хаагчийг адил, тэгш боломжоор хангана.

4.2.3.10.Төрийн албаны нэгдсэн тоо бүртгэлийг чанаржуулж, цахим мэдээллийг албан хаагчдад өөрт нь нээлттэй болгох замаар төрийн албан хаагчийн иж бүрэн цахим платформийг хөгжүүлэн, мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдлыг хангана.

4.2.3.11.Төрийн албанд сэтгэлгээ, дүн шинжилгээ хийх, боловсруулах, монгол хэлийг ярианы болон бичгийн өндөр ур чадвартай иргэнийг сонгон шалгаруулах хэлбэр, эрх зүйн орчныг шинэчилнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 38
Бүгд: 105

63.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

38.Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.3.5.Төрийн албаны ёс зүйн зарчмуудад үндэслэсэн суурь шалгуур үзүүлэлтийг боловсруулж, төрийн албаны чадамжид суурилсан хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг үнэлж дүгнэнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 55
Бүгд: 105

47.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

39.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.3.8.Төрийн албаны сургалтын байгууллагын хөтөлбөрийг төрийн албаны шинэчлэлд нийцүүлж, сургалтын байгууллагын чадавхыг бэхжүүлнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 64
Бүгд: 105

39.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

40.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.3.9.Төрийн албан хаагчдын цалин хөлс, ниймгийн баталгааны зохистой бодлого баримтлан, орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлнэ. Төрийн албанаас эрт тэтгэвэрт гарч буй иргэдэд хөдөлмөрлөх, бичил, жижиг, дунд бизнес эрхлэх, орлого олох,

баялаг бүтээх боломжийг бүрдүүлнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 48

Бүгд: 105

54.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

41. Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.3.10.Төрийн албаны нэгдсэн тоо бүртгэлийг чанаржуулж, мэдээллийн ил тод, үнэн зөв, бүрэн бүтэн байдалд хяналт тавих нөхцөлийг хангасан төрийн албаны хүний нөөцийн иж бүрэн цахим платформыг хөгжүүлэн, өгөгдөлд суурилсан хүний нөөцийн удирдлагын бодлогыг оновчтой, шинжлэх ухаанч байдлаар зөв төлөвлөн хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.”

42. Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.11 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.3.11.Төрийн албанд сэтгэлгээний болон дүн шинжилгээ хийх, асуудлыг оновчтой, шуурхай шийдвэрлэх өндөр ур чадвартай иргэнийг сонгон шалгаруулах аргыг нэвтрүүлж, эрх зүйн орчныг шинэчилнэ.”

-Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг дээрх 41, 42 дугаар саналаа татаж авч байгаагаа мэдэгдэв.

43. Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.4.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.4.1.Хотын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг харгалзан боловсруулан батлуулж, үүнтэй уялдуулан төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, зарцуулалтын бодлогыг хэрэгжүүлнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 76

Бүгд: 105

27.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

44. Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.4.Орон нутгийн засаглалын бие даасан байдал” зорилтод доор дурдсан агуулгатай 4.2.4.5 дахь заалт нэмэх:

“4.2.4.5.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хуулийг боловсронгуй болгох замаар боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хүн амын тоотой уялдуулан хүртээмжтэй

хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 58
Бүгд: 105
44.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Тав. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Э.Золзаяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 18 цаг 59 минутаас хуралдааныг даргалав.

Нэр дэвшигчийн талаарх танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг нар танилцуулав.

Нэр дэвшигчээс болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, С.Эрдэнэбат, О.Алтангэрэл, П.Сайнзориг, Д.Ганбат, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Э.Золзаяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 19 цаг 55 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүд Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчидтэй танилцлаа.

Уг асуудлыг 19 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Р.Ринчинбазар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, мөн газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Мөнхтөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Г.Лувсанжамц, М.Нарантуяа-Нара, Д.Энхтуяа, Б.Жаргалан, Х.Баасанжаргал, Б.Мөнхсоёл, Б.Батбаатар, Б.Пунсалмаа, Б.Түвшин, Д.Пүрэвдаваа нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Сангийн сайд Б.Жавхлан, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа, М.Нарантуяа-Нара, Г.Тэмүүлэн нар үг хэлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ч.Анар, А.Ариунзаяа, Д.Батбаяр, Р.Батболд, Э.Болормаа, П.Ганзориг, Х.Ганхуяг, П.Мөнхтулга, Д.Пүрэвдаваа, Б.Пунсалмаа, Б.Түвшин, Б.Уянга, Дав.Цогтбаатар, Ж.Чинбүрэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн 3 дахь заалтын “орлогын хэмжээ” гэснийг “орлогын доод хэмжээ” гэж, 9 дэх заалтын “санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ” гэснийг “хуваарилах зардлын дээд хэмжээ” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 39
Бүгд: 108
63.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн 4 дэх заалт буюу “Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ” 2025 онд “32,992.0” гэснийг “31,901.6” гэж, 2026 онд “35,849.5” гэснийг “34,967.8” гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2025 онд “34.7” гэснийг “33.6” гэж, 2026 онд “34.2” гэснийг “33.4” гэж, үзүүлэлтийн 5 дахь заалт буюу “Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл” 2025 онд “-2,990.7” гэснийг “-1,900.3” гэж, 2026 онд “-2,975.9” гэснийг “-2,094.1” гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2025 онд “-3.1” гэснийг “-2.0” гэж, 2026 онд “-2.8” гэснийг “-2.0” гэж, үзүүлэлтийн 6 дахь заалт буюу “Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ” 2025 онд “28,101.0” гэснийг “27,010.6” гэж, 2026 онд “30,779.5” гэснийг “29,897.8” гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2025 онд “29.6” гэснийг “28.4” гэж, 2026 онд “29.4” гэснийг “28.6” гэж, үзүүлэлтийн 7 дахь заалт буюу “Нэгдсэн төсвийн суурь тэнцэл” 2025 онд “1,900.3” гэснийг “2,990.7” гэж, 2026 онд “2,094.1” гэснийг “2,975.9” гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2025 онд “2.0” гэснийг “3.1” гэж, 2026 онд “2.0” гэснийг “2.8” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 40
Бүгд: 108
63.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**1.ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ
САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:**

Нэг.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: 1. Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ч.Анар, А.Ариунзаяа, Д.Батбаяр, Р.Батболд, Э.Болормаа, П.Ганзориг, Х.Ганхуяг, П.Мөнхтулга, Д.Пүрэвдаваа, Б.Пунсалмаа, Б.Түвшин, Б.Уянга, Дав.Цогтбаатар, Ж.Чинбүрэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 37
Бүгд: 108
65.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд “, 6.5 дахь хэсгийн “нэмэгдүүлэх, 6.4-т заасан хугацааг сунгахыг” гэснийг “нэмэгдүүлэхийг” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 51
Бүгд: 108
52.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд “19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “2025” гэснийг “2024” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 45
Бүгд: 108
58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлд “19.9 дэх хэсгийн “Энэ хуулийн 6.1.2-т” гэснийг “Энэ хуульд” гэж тус тус” гэж нэмэх.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 4 дүгээр саналыг гүйцээн боловсруулах чиглэлийг Байнгын хороонд өгөв.

Хоёр.Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, Г.Тэмүүлэн нарын гаргасан, Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн үг хэлж, Сангийн сайд Б.Жавхлан тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 57
Бүгд: 108
47.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээс Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг 2024 оны 8 дугаар сарын 26-ны өдөр /Даваа гараг/-ийн 10.00 цаг хүртэл завсарлага авах тухай мэдэгдэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэгт 2024 оны 8 дугаар сарын 26-ны өдөр /Даваа гараг/-ийн 10.00 цаг хүртэл завсарлага өгөв. /22.04/

Долоо.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгээс Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг 2024 оны 8 дугаар сарын 26-ны өдөр /Даваа гараг/-ийн 10.00 цаг хүртэл завсарлага авах тухай мэдэгдэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэгт 2024 оны 8 дугаар сарын 26-ны өдөр /Даваа гараг/-ийн 10.00 цаг хүртэл завсарлага өгөв. /22.05/

Найм.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгээс Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг 2024 оны 8 дугаар сарын 26-ны өдөр /Даваа гараг/-ийн 10.00 цаг хүртэл завсарлага авах тухай мэдэгдэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэгт 2024 оны 8 дугаар сарын 26-ны өдөр /Даваа гараг/-ийн 10.00 цаг хүртэл завсарлага өгөв. /22.06/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 8 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 12 цаг 03 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 112 гишүүн ирж, 88.9 хувийн ирцтэйгээр 22 цаг 07 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 8 дугаар сарын 23-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
10 цаг 04 минут

ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Баасан гарагийн Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна.

Ирц 33 хувьтай явж байна.

Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 6.2-т нэгдсэн хуралдаан долоо хоног бүрийн Пүрэв, Баасан гарагт өглөө 10.00 цагаас 13.00 цаг, 14.00 цагаас 18.00 цагт хуралдана гээд хуульчлагдсан байгаа.

Гишүүд 09.00 цагаас эхлээд ирцэд орох хуулийн заалттай.

Тийм учраас хуралдаан цагтаа эхэлж байх хуулиар хүлээсэн үүрэгтэй байдаг.

Ингээд ирцэд ирээгүй байгаа гишүүдийн нэрсийг дуудъя.

Жуковын Алдаржавхлан, Норовын Алтанхуяг, Наранцэцэгийн Алтаншагай, Сайнбуянгийн Амарсайхан, Хүрэлбаатарын Баасанжаргал, Цэндийн Баатархүү, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Энхтайваны Бат-Амгалан, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Далайн Батбаяр, Ринчиндоржийн Батболд, Дамбын Батлут, Нацагдоржийн Батсүмбэрэл, Халтмаагийн Баттулга, Батмөнхийн Батцэцэг, Пүрэвийн Батчимэг, Баярмагнайн Баярбаатар, Жудагийн Баярмаа, Жадамбаагийн Баясгалан, Хөххүүгийн Болормаа, Энхбатын

Болормаа, Хүрэлбаатарын Булгантуяа, Шинэбаярын Бямбасүрэн, Сандагийн Бямбацогт, Жанчивын Галбадрах, Амгаланбаатарын Ганбаатар, Жамбалын Ганбаатар, Дашдондогийн Ганбат, Даваасамбуугийн Ганмаа, Лувсаннъямын Гантөмөр, Мөнгөнцогийн Ганхүлэг, Цэрэнпилийн Даваасүрэн, Гонгорын Дамдинням, Тогмидын Доржханд, Болдын Жавхлан, Батбаярын Жаргалан, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Батжаргалын Заяабал, Жаргалсайханы Золжаргал, Сүрэнжавын Лүндэг, Цагаанхүүгийн Мөнхбат, Тогтмолын Мөнхсайхан, Пүрэвбаатарын Мөнхтулга, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Бадрахын Найдлаа, Одсүрэнгийн Номинчимэг, Нямтайширын Номтойбаяр, Эрдэнэбилэгийн Одбаяр, Салдангийн Одонтуяа, Бадамдоржийн Пунсалмаа, Даваахүүгийн Пүрэвдаваа, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Ренчинбямбын Сэддорж, Цэвэгдоржийн Туваан, Буяагийн Тулга, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Ганзоригийн Тэмүүлэн, Бадарчийн Түвшин, Агваанлуvsангийн Ундраа, Гончигдоржийн Уянгахишиг, Ганбатын Хосбаяр, Даваагийн Цогтбаатар, Дамдины Цогтбаатар, Баттогтохын Чойжилсүрэн, Жадамбын Энхбаяр, Доржзовдын Энхтуяа, Сүхбаатарын Эрдэнэболд, Равжихын Эрдэнэбүрэн, Доржсүрэнгийн Үүрийнтуяа.

Гишүүд хуралдаандаа ирэхийг хүсье.

Гадаадад Засгийн газрын шийдвэрээр болон олон улсын байгууллагын шугамаар ажиллаж байгаа гишүүдийн нэрс. Чөлөө хүссэн гишүүдийн нэрс ирсэн байна.

Халтмаагийн Баттулга, Д.Ганмаа, А.Ганбаатар, Ж.Ганбаатар, Ж.Галбадрах, Б.Чойжилсүрэн нар чөлөө хүссэн байна.

Орон нутагт Энхбатын Болормаа гишүүн ажиллах чөлөөтэй, Д.Үүрийнтуяа гишүүн орон нутагт ажиллах чөлөөтэй.

Эмнэлгийн чөлөөтэй Гонгорын Дамдинням, Сүрэнжавын Лүндэг нар эмнэлгийн чөлөөтэй байгаа юм байна.

Ингээд чуулганы хуралдааны ирц 50.8 хувьтай болж ирц хүрсэн байна.

2024 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр хуралдаанаар дараах 8 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хоёрдугаарт, “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй дэд хорооны

бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Гуравдугаарт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батална.

Дөрөвдүгээрт, Улсын Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулна.

Тавдугаарт, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Зургадугаарт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Долдугаарт, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийнэ.

Наймдугаарт, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

**Нэг. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд
нэмэлт оруулах тухай хуулийн төсөл**
/Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нарын 6 гишүүн
2024.08.14-ний өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. Анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Чулуунбилэгийн Лодойсамбуу танилцуулна.

Индэрт урьж байна.

Ч.Лодойсамбуу: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Н.Батсүмбэрэл, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Д.Цогтбаатар, Д.Энхтуяа нараас 2024 оны 8 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Ёс зүй, дэгийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Ёс зүй, дэгийн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их

Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт болон зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасны дагуу хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооны

санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Одоо Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. /алх цохив/

Асуултаа асуух дарааллаар М.Нарантуяа-Нара гишүүн асуулт асууна.

М.Нарантуяа-Нара: Би дараагийн юу төсөв дээр. Төсөв дээр асуух асуулт байгаа юм. Одоо асуучих юм уу?

Д.Амарбаясгалан: Энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуулт асууна.

М.Нарантуяа-Нара: Тэгвэл би дараагийн хүнд шилжүүлчихье.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу жагсаалт гарч байгаа. Асуултаа асууна.

Б.Батбаатар: Бид түрүүчийн хуралдаанаар дэгийн тухай хуулийг хэлэлцэж байхад дэгийн асуудал дээр нэмэлтээр Улсын Их Хурлын тухай хуульд бас зарим нэг өөрчлөлт оруулахаар ажлын хэсэг байгуулагдах тухай ярьсан.

Их Хурлын дарга, Ерөнхий нарийн бичгийн дарга дэгийн тухай хууль дээр тайлбар өгөөд Их Хурлын дарга бас Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах, намуудыг бүлэгтэй болгох

чиглэлээр ямар боломж, яаж ажиллах боломж байна вэ гэдэг дээр ажлын хэсэг байгуулья гэсэн.

Тэгээд тэр тухайгаа ажлын хэсэг байгуулж өгөөсэй л гэж хүсэж байна.

Энэ дэгийн заалт дээр дэмжиж байна. Оруулж ирсэн зүйлийг.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Тийм ээ.

Жаргалсайханы Золжаргал гишүүн асуултаа асууна.

Ж.Золжаргал: Дэгийн тухай хуулийн оруулж ирсэн заалтыг бол дэмжиж байгаа. Асуулт байхгүй байна.

Д.Амарбаясгалан: Ринчиндоржийн Батболд гишүүн асуулт асууна. Алга байна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулахаар байгаа.

Ирц хэдэн хувьтай байна. 69.8 хувьтай байна.

Тэгэхээр Байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал

хураалтыг явуулна. Санал хураалт. /алх цохив/

Энэ санал уншигдахгүй байна. Хүчингүй болгоё дахиж санал хураалт эхлүүлбэ. Уншсан уу? Дахиж санал хураалт явуулъя. Хүчингүй болгоё гээд микрофонд хэлчихсэн байгаа.

Санал хураалтад 90 гишүүн оролцсоноос 54 гишүүн дэмжиж, 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Ёс зүй, дэгийн байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Хоёр. “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэх асуудал. Хоёр. “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулна.

Индэрт урьж байна.

О.Номинчимэг: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт заасныг үндэслэн “Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг

боловсруулж, Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийг Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатарыг тус дэд хорооны бүрэлдэхүүнд оруулахыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 64.7 хувийн саналаар дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад оролцсон 92 гишүүнээс 50 гишүүн дэмжиж, 54.3 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

Тогтоолын төсөл батлагдлаа.

Тогтоолын төслийг уншиж танилцуулья.

Монгол Улсын Их Хурлын тогтоол.

“Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийг Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатарыг тус дэд хорооны гишүүнээр баталсугай.

2.Энэ тогтоол баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Гурав. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл
/Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нарын 6 гишүүн
2024.08.14-ний өдөр өргөн мэдүүлсэн,
эцэслэн батлах/

Хэлэлцэх асуудал. Гурав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батална.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-т “...долоо хоногийн Баасан гарагийн 10.00 цагт нэгдсэн хуралдаанаар

хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Хуралдааны ирц хуулийн төсөл эцэслэн батлах шаардлага хангахаар бол бусад өдөр, цагт хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулж болно.” гэж заасны дагуу Ёс зүй, дэгийн байнгын хорооны хуулийн төслийн эцэслэн батлуулах хувилбарыг бэлтгэж, эцэслэн батлуулахад бэлэн болсон байна.

Одоо төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т “...нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно.” гэж заасан байгаа.

Тэгэхээр нийт гишүүдийн олонх гэдэг чинь 64 гишүүн дэмжсэнээр санал хураалт хүчинтэй болно.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Горимын санал гаргая.

Улсын Их Хурлын гишүүн Дүгэрийн Рэгдэл горимын санал.

Д.Рэгдэл: Төхөөрөмж ажиллахгүй байна.

Тийм учраас санал хураалтыг хүчингүй болгоод дахиж явуулах саналтай байна.

Д.Амарбаясгалан: Улс Улсын Их Хурлын гишүүн Дүгэрийн Рэгдэлийн гаргасан горимын саналын дагуу саяын хураагдсан саналыг хүчингүй болгож, шинээр санал хураалт явуулах тухай санал хураалт явуулъя.

Хүчингүй болгох санал хураалт. /алх цохив/

97 гишүүнээс 60 гишүүн дэмжсэнээр түрүүчийн явуулсан санал хураалт хүчингүй боллоо.

Үндсэн санал хураалт. Эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

64 гишүүн дэмжиж байж хүчинтэй болно. Санал. /алх цохив/

66 гишүүн дэмжиж, санал хураалт дэмжигдлээ.

Энэ төхөөрөмж дээр бас алдаа гарч байна. Сая бас дэмжиж санал өгсөн гишүүд маань протоколд дэмжсэнээр бүртгүүлэх хүсэлтээ Хурал зохион байгуулах хэлтэст ирүүлж болно. Санал дэмжигдлээ. /алх цохив/

Санал хураалтад 97 гишүүн оролцож, 66 гишүүн дэмжигдсэнээр санал дэмжигдсэн байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль тогтоолын эцсийн найруулгатай танилцаж, ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу Ёс зүй, дэгийн байнгын хороо хуулийн төслийн эцсийн найруулгын хувилбарыг бэлтгэж танилцуулахад бэлэн болсон байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Хэлэлцэх асуудал. Дөрөв.

Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах тухай.

Хууль зүйн байнгын хорооноос оруулж ирэх ёстой асуудал.

Хууль зүйн байнгын хорооны хурал хараахан дуусаагүй байна.

Тийм учраас хэлэлцэх асуудлыг алгасаад тавдугаар асуудалд орёе.

**Дөрөв. “Монгол Улсын Засгийн газрын
2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”**

Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна.

Индэрт урья.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы

нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тус Байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39, 63 дугаар зүйлд заасан журмын дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна.

**Нэг.АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ
БЭЛТГЭСЭН ТАЛААРХ
МЭДЭЭЛЭЛ**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 38 дугаар захирамжаар дээрх тогтоолын төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнээр ахлуулан гишүүдэд

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, Д.Жаргалсайхан, Г.Лувсанжамц, Д.Рэгдэл, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Г.Уянгахишиг, Б.Энхбаяр нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан болно.

Тогтоолын төсөл иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын **D-Parliament** цахим системээр дамжуулан олон нийтээс тухайн төсөлтэй холбогдуулан санал авахад нэр бүхий иргэдээс 4 санал ирүүлснийг ажлын хэсэгт танилцуулсан болно.

Ажлын хэсэгт Улсын Их Хурлын 21 гишүүнээс 148 санал, Мэдээлэл, холбооны операторуудын ассоциаци, Монголын оюуны өмч хамгаалах холбоо төрийн бус байгууллага болон холбогдох яамдаас 45 санал ирүүлсэн болно.

Ажлын хэсэг тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэхдээ дээрх саналуудыг болон Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит бус чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын 51 гишүүнээс давхардсан тоогоор нийт 146 санал гарсныг судлан үзэж, 72 зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлтгэн Байнгын хорооны хуралдаанд оролцож хэлэлцүүлсэн болно.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллын үндэслэл, шаардлага, хамрагдах хүрээ:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын урт дунд хугацааны бодлогын баримт бичиг болон Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн үнэт зүйлс, үндсэн зарчим тэргүүтэй тэргүүлэх бодлого, зорилготой уялдуулан дараах агуулгын хүрээнд зарчмын зөрүүтэй саналын томъёололыг боловсруулан боловсруулсан болно. Үүнд:

1.Тогтоолын төсвийн хавсралтын өмнөтгөл хэсэгт тусгагдсан танилцуулгын шинжтэй өнөөгийн нөхцөл байдал болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээний давхардуулан дурдсан зарим арга хэмжээг хасаж, өмнөтгөл хэсгийг бүхэлд нь өөрчлөн найруулах.

2.Төслийн 1, 2 дугаар хавсралтын талаар Улсын Их Хурлын гишүүд төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн саналыг бодлогын баримт бичигт нийцсэн байдал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах боломжтой эсэхийг нь харгалзан үзэж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах шаардлагатай зарим төсөл арга хэмжээг нэмж тусгах.

3.Өргөн мэдүүлсэн төслийн зарим зорилт, арга хэмжээнд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах, найруулгын шинжтэй засвар хийх зэрэг хүрээг хамарч байгаа болно.

Хоёр.БУСАД БАЙНГЫН ХОРООНООС ИРҮҮЛСЭН САНАЛ, ДҮГНЭЛТ:

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39, 63 дугаар зүйлд заасан журмын дагуу бусад Байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 20, 21-ний өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг

явуулж дараах санал, дүгнэлтийг ирүүлснийг танилцуулж байна.

1/Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал дүгнэлт:

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан.

Тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй нийт 12 санал гарсан бөгөөд саналын томъёоллоор нэг бүрчлэн хэлэлцэж санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан, авалгүйгээр нь бүлэглэн бэлтгэж, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын санал, дүгнэлтийг хамт Байнгын хороонд ирүүлсэн.

2/Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт:

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан байна.

Тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй 3 саналаар санал хураалт явуулахад зарчмын зөрүүтэй саналуудын хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, зарчмын зөрүүтэй саналын томъёолол санал, дүгнэлтийн хамт Байнгын хороонд ирүүлсэн.

3/Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт:

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал уур амьсгал, байгаль, цаг уурт дасан зохицсон, тэсвэр чадвартай нутгийн шилмэл малаар малын үржлийн ажлыг явуулах, бүс нутгуудыг тодорхойлж, хөрөнгө, санхүүжилтийг хөтөлбөрт тусгах, газар тариалангийн бүс нутагтай уялдуулж эрчимжсэн мал аж ахуй эрхлэх, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, малчдаа орлогожуулж, өвс тэжээлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтыг анхаарах, “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг дэмжих чиглэлд зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хүүгийн зөрүү олгох асуудлыг хэлэлцүүлгийн түвшинд анхаарах, Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр өнөөдрийг хүртэл хэрэгжүүлж байгаа “Шинэ хоршоо” хөдөлгөөний үйл ажиллагаа, зээл олголтод үнэлгээ хийх, цаашид уг арга хэмжээг улам сайжруулах, Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар өнгөрсөн хугацаанд хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөрүүдэд үнэлэлт дүгнэлт өгөх, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар малчдыг малжуулах, даатгалын үйлчилгээг малчдад хүргэх, хамруулах боломжийг судалж хэрэгжүүлэх зэрэг саналуудыг илэрхийлсэн болно.

Тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй 10 саналаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, зарчмын зөрүүтэй саналын томьёоллын санал, дүгнэлтийн хамт Байнгын хороонд ирүүлсэн болно.

4/Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын байнгын хорооны санал,
дүгнэлт:

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10 дахь хэсэгт заасан эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийг баримтлан 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу хэлэлцсэн байна.

Төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

5/Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал,
дүгнэлт:

Ёс зүй, дэгийн байнгын хороо өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 63.9 дэх хэсэгт заасны дагуу 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа “Монгол Улсын Засгийн газраас 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их

Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн байна.

Тус Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар төслийн 4 дүгээр заалтад “4.2.3.12.Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянаж шийдвэрлэх, менежментийг сайжруулах, ёс зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.”, “4.2.3.13.Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030 он/ дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлж, ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэх соёлыг дэвшүүлж, нийгмийн ёс суртахууны үнэт зүйл бүхий сэтгэл зүйг төлөвшүүлнэ.”, “4.2.3.14.Төрийн албаны ёс зүйн индекс, ёс зүйн дэд бүтцийг олон улсын туршлагад суурилан хэрэгжүүлнэ.” гэж тус тус нэмэх талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргасан бөгөөд олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналын томьёололыг санал, дүгнэлтийн хамт Байнгын хороонд ирүүлсэн.

6/Инновац, цахим бодлогын байнгын
хорооны санал, дүгнэлт:

Инновац, цахим бодлогын байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.9 дэх

хэсэгт заасны дагуу Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралдаанаар гаргасан санал, дүгнэлтийг Байнгын хороонд ирүүлсэн болно.

7/Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт:

Нийгмийн бодлогын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсэгт заасан эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39.3 дахь хэсгийг баримтлан 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар “Монгол Улсын Засгийн газраас 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан байна.

Тус Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүний зорчих дэд бүтцийн хэсэгт бүх аж ахуйн нэгжүүдээс гадна албан байгууллагуудыг хамруулахад анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ орчны бохирдлын асуудал нь салбар дундын асуудал тул бүх салбарын чиглэлд тусгах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен сумын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, автомашины асуудлыг тодорхой тусгаж, эмч, эмнэлгийн ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэхэд анхаарах талаар тус тус санал илэрхийлсэн байна.

Тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй нийт 16 санал гарсан бөгөөд

саналын томьёоллын нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлтгэж, зарчмын зөрүүтэй саналын томьёоллын санал, дүгнэлтийг санал, дүгнэлтийн хамт Байнгын хороонд ирүүлсэн.

8/Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт:

Төсвийн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан байна.

Тус Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэтийн авто замыг барих төслийг Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргасан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.16 дахь хэсэгт заасны дагуу санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналын томьёололыг санал, дүгнэлтийн хамт Байнгын хороонд ирүүлсэн.

9/Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт:

Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10 дахь хэсэгт заасан эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39.3 дахь хэсгийг

баримтлан 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Г.Уянгахишиг, Б.Бат-Эрдэнэ, С.Эрдэнэболд нарын гишүүд зарчмын зөрүүтэй 4 саналын томьёолол гаргасныг олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлтгэж, зарчмын зөрүүтэй саналын томьёололыг санал, дүгнэлтийн хамт Байнгын хороонд ирүүлсэн.

10/Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт:

Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин экспортын гол бүтээгдэхүүнүүдийн зах зээлд нэвтрэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний гадаад экспортыг нэг цонхны бодлогоор дэмжих талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж Эрдэнэтийн овооны Оюут ордын нөөцийг тооцоолон, ТЭЗҮ-ийг эцэслэж, ашиглалтад оруулахад бэлэн болгох, Эрдэнэтийн стратегийн ордын талбайн эрэл хайгуулын ажлын хүрээнд хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологи ашиглан шинэ стратегийн орд нээж, ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг эхлүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг эрчим хүчний салбарт шинэчлэл хийж, салбарын эрх зүйн орчныг сайжруулах ажлын хүрээнд Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулиуд болон холбогдох хууль тогтоомжийг шинэчлэх, Сонгино-Дарханы чиглэлийн 220 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг

барьж, эрчим хүчний найдвартай ажиллагааг дээшлүүлэх талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг санал, дүгнэлтийн хамт Байнгын хороонд ирүүлсэн болно.

Гурав.ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛАХ ҮЕД:

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр, Ц.Сандаг-Очир нарын ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томьёоллын талаар асуулт асууж, саналаа илэрхийлсэн болно.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс боловсруулсан 72, Байнгын хорооноос ирүүлсэн 54, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Б.Жаргалан, Г.Лувсанжамц, Ж.Баярмаа, Б.Хэрлэн, О.Номинчимэг, С.Зулпхар, М.Бадамсүрэн, Л.Мөнхбаатар, Л.Энх-Амгалан, Д.Батлут, Б.Бат-Эрдэнэ, Ц.Даваасүрэн, Д.Үүрийнтуяа, Ж.Бат-Эрдэнэ нараас гаргасан 37, нийт 63 зарчмын зөрүүтэй саналаас 152 зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явууллаа.

Ажлын хэсэг болон бусад Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллийг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд
ээ,

“Монгол Улсын Засгийн газраас 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёололыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа.
Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулья.

Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Монгол Улсын Ерөнхий сайд, Лувсаннъямын Гантөмөр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд, Сайнбуянгийн Амарсайхан Монгол Улсын Шадар сайд, Тогмидын Доржханд Монгол Улсын Шадар сайд, Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Эрдэнэбилэгийн Одбаяр Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээ Үндэсний хорооны дарга, Буяагийн Тулга Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, Равжихын Эрдэнэбүрэн Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга, Батмөнхийн Батцэцэг Гадаад харилцааны сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Оюунсайханы Алтангэрэл Хууль зүй, дотоод хэргийн сайд, Салдангийн Одонтуяа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Сандагийн Бямбацогт Батлан хамгаалахын сайд, Жадамбын Батсуурь Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Пүрэвсүрэнгийн Наранбаяр Боловсролын сайд, Борхүүгийн Дэлгэрсайхан Зам, тээврийн

сайд, Чинбатын Номин Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Цэвэгдоржийн Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд, Жадамбын Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Цэндийн Баатархүү Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Тогтмолын Мөнхсайхан Эрүүл мэндийн сайд.

Ажлын хэсгийн бусад гишүүд.

Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нэргүйн Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дагвадоржийн Ганхуяг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Эрхэмбаярын Баттулга Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сүхбаатарын Төмөрхүү Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ханджавын Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лханаажавын Мөнхтүшиг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сандагдоржийн Батболд Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Адъяасүрэнгийн Даваажаргал Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Сандагийн Магнайсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвасүрэнгийн Мөнхзул Гэр бүл,

хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Пушаагийн Алтан-Од Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нансалын Тавинбэх Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дагвадоржийн Очирбат Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дорждэмбэрэлийн Цолмон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Нямандэлэгийн Мандуул Нийслэлийн Засаг даргын орлогч, Шаравын Мөнхцэрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга, Лхагвасүрэнгийн Балчинлуvsан Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Даваасамбуугийн Эрдэнэбаяр Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Зинаамядарын Батбаяр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын дарга, Ганзоригийн Эрдэнэбулган Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Доржпаламын Гантулга Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга, Пүрэвдоржийн Оюунаа Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Сүхбаатарын Сүхбат Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга, Мэлтэсчойн Мэндбаяр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга, Болдбаатарын Анхбаяр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны

бодлогын газрын дарга, Хүрэлбаатарын Санчигдорж Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологийн бодлогын газрын дарга, Баасансүрэнгийн Алимаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга, Нарантуяагийн Баярмаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын газрын Хүүхэд, гэр бүлийн газрын дарга, Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ганбаатарын Энхтүвшин Эрчим хүчний яамны бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги төлөвлөлтийн хэлтсийн дарга, Пүрэвийн Оюунцэцэг Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Отгонтогтохын Энхмөнх Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын нэгдсэн бодлогын хэлтсийн дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Бодлого, төсөөллийн хэлтсийн дарга, Очиржанцангийн Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга, Эрдэнэбатын Батболд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын Орон сууц, санхүүжилтийн хэлтсийн дарга, Баатарын Гүнболд Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны ерөнхий менежер, Цэвээндоржийн Эрдэнэбат Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын зөвлөх, Батсуурийн Баттөмөр Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх, Пэрэнлэйн Мөнхбат Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх, Мижиддоржийн Санжаадорж Сангийн

яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Булгаагийн Ганбат Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх, Бат-Эрдэмийн Төрбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 9.1.17-д Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүн бүр асуулт асууж, үг хэлэх эрхтэй гэж заасан.

Иймд Засгийн газрын гишүүн болон холбогдох бусад албан тушаалтнаас, түүнчлэн Байнгын хорооноос санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүдэд нэрээ өгье. /алх цохив/

Очирбатын Амгаланбаатар гишүүнээр тасаллаа.

Нийт 20 гишүүн асуулт асууна.

Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар асуултаа асууя.

Н.Наранбаатар: Гишүүддээ энэ өглөөний мэнд хүргэе. Хоёр, гурван асуулт асууя.

Нэгдүгээрт, “Орон нутгийн бие даасан байдал”. Тухайлбал, төсвийн эрх

мэдэл, томилгооны эрх мэдэл гээд үүнтэй холбоотойгоор ирэх 4 жилд ер нь хууль эрх зүйн ямар өөрчлөлтүүдийг хийхээр үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бэ гэдэг нэг асуудал.

Хоёрт нь, “Бүсчилсэн хөгжил” бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тэргүүн эгнээний зорилт байгаа.

Тийм учраас бүсчилсэн хөгжлийг амилуулахад хууль эрх зүйн орчны өөрчлөлтүүдийг зайлшгүй хийх шаардлагатай байгаа юм. Тухайлах юм бол энэ Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль гэх мэтчилэн. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль гээд олон хууль эрх зүйн орчны өөрчлөлт хийж байж бүс чинь цаашаагаа удирдлагатай, төсөвтэй, зөвлөлтэй байж цаашаагаа явах юм.

Тийм учраас бүсчилсэн хөгжлөө амилуулж цааш нь бодит ажил болгоход ямар хууль эрх зүйн орчны өөрчлөлтүүдийг хийхээр энд тусгагдаад байгаа вэ гэсэн асуулт байна.

Дараа нь “Шинэ сэргэлт”-ийн бодлогын 6 том зорилтын хамгийн эхнийх нь энэ “Боомтын сэргэлт” байгаа юм.

Тэгэхээр Монгол Улс 2022 оноос эхлээд боомтын албатай болоод Хилийн тухай хуульд ороод явчихсан. Хилийн тухай хуульд нэг заалт л явж байгаа. Боомтын захиргаатай байна гээд.

Тэгэхээр цаашдаа бид энэ боомтоо хөгжүүлэх, төлөвлөх, бүтээн байгуулах, өргөтгөхөд зайлшгүй боомтын бие даасан хуультай байх шаардлагатай гэж үзэж

байгаа юм. Хуучин энэ Боомтын хууль байсан.

Тэгэхээр үйл ажиллагааны хөтөлбөрт боомтыг цааш нь хөгжүүлэхэд хууль эрх зүйн ямар өөрчлөлтүүд байхаар тусгаж байгаа вэ? Боомтын тухай хуулиа эргэж дахиж боловсруулж батлуулах уу гэдэг ийм асуудал байна.

Дараа нь тойргийн гишүүний хувьд Өмнөговь аймгийн төвд 50 мегаваттын дулааны цахилгаан станц барих гэдэг санал өгсөн.

Мөн Даланзадгад хотод Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн харьяа сургуулийн бүтээн байгуулалтыг хийх гэсэн санал өгсөн.

Мөн Даланзадгадын “Говь гурван сайхан” нисэх онгоцны буудлыг 4D буюу олон улсын зэрэглэлтэй болгох гэсэн ийм саналууд өгсөн.

Тэгээд энэ ямар байдлаар тусгагдаж хөтөлбөрт орж явж байгаа вэ гэсэн ийм хэдэн асуудал байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Хууль зүйн шинэтгэл Оюунсайханы Алтангэрэл сайд хариулъя.

О.Алтангэрэл: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Засгийн газрын үйл ажиллагаа мөрийн хөтөлбөрт дурдагдсанаар хүний эрх, эрх чөлөөний талаар нэлээн олон зүйлүүд оруулсан байгаа. Энд:

- Хэвлэлийн эрх чөлөө, жагсаал цуглааны журмын тухай хууль зэрэг олон чиглэлээр хүний эрх

чөлөөний чиглэлээр шинэтгэл хийнэ.

Мөн үүнээс дутахгүйгээр ач холбогдол өгч оруулсан хэсэг бол энэ авлигатай тэмцэх үйл ажиллагааны чиглэл байгаа.

▷ “5Ш” ажиллагааг үргэлжлүүлнэ.

▷ Авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.

▷ Хүний эрхийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.

▷ Авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

Дээрээс нь “Монгол Улсад эрх зүйн шинэтгэл II хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.

Үүнээс гадна хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно гэдэг ийм агуулгатай хөтөлбөр, заалтууд тусгагдсан байгаа.

Д.Амарбаясгалан: Бусад асуудалд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал сайд хариулна.

Н.Учрал: Н.Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Тэр бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулаад засаг захиргааны нутаг дэвсгэрийн нэгж, түүний хуваарьт өөрчлөлт оруулах асуудал яг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орох нь бас зохимжгүй.

Тийм учраас бид нэгэнт бүсчилсэн хөгжлийн бодлогыг тухайлан авч үзэж байгаа учраас 3 намын хамтарсан Засгийн газрын гэрээнд энэ бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулаад засаг захиргаа, нэгжийн хуваарьт өөч өөрчлөлт оруулж гүйцэтгэх эрх мэдлийн зарим томилгоог орон нутгийн удирдлагад шилжүүлнэ гэдэг ийм шийдвэр дээр хамтарсан Засгийн газрын гэрээн дээр тусгагдсан.

Тэгээд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бүсчилсэн хөгжлийн хүрээнд энэ бие даасан эдийн засаг бүхий дагуул хотуудыг хөгжүүлэх, дээрээс нь Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулах уу? Ням-Осорын Учрал сайдын микрофоныг өгье. Гүйцээж хариулъя.

Н.Учрал: Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийг хэрэгжүүлнэ.

2026 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжих энэ хууль дээр орон нутгийн шинж чанартай, улсын зэрэглэлтэй хотуудыг байгуулах асуудал суусан.

Тийм учраас энэ хуулийг хэрэгжих бэлтгэл ажлыг хангуулна.

Орон нутгийн бие даасан байдлыг хангуулахад энэ хууль өөрөө бүхэлдээ том өөрчлөлтийг авчирна гэж ойлгож байгаа.

Тийм учраас Засгийн газар дээр энэ бүсчилсэн хөгжлийн асуудлыг эрхэлсэн Шадар сайд ажиллаж байна.

Тэгэхээр Шадар сайдын дэргэд бүсийн хөгжлийг дэмжих чиглэлээр

бүтэц ажиллаж, цаашдаа бүсүүдийн интеграцыг хангуулах чиглэлээр бодлогоо боловсруулж ажиллана.

Д.Амарбаясгалан: Тийм. Дулааны станц Баттогтохын Чойжилсүрэн сайд хаана байна. Эрчим хүчний яамнаас хүн байна уу? Нансалын Тавинбэх. Төрийн нарийн бичгийн дарга хариулъя.

Индэр дээрээс 2 дугаар микрофон.

Н.Тавинбэх: Н.Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Өмнөговь аймгийн цахилгаан дулааны эрчим хүчний хэрэглээг хангах зориулалттай.

Байнгын хороод дээр гишүүдээс гарсан Даланзадгадад 50 мегаваттын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих санал дэмжигдсэн. Яам бас дэмжиж байгаа.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Үйл ажиллагааны хөтөлбөрөөс заавал тодруулах зүйлс байна. Тэр нь жишээ нь одоо бид чинь улс орон сайн сайхан больё, хөгжиж дэвшье л гэвэл мэдээж гаднаас орж ирдэг, гаднаас олдог мөнгө маань аль сувгаараа яаж нэмэгдэж, хасагдах вэ гэдэг л хамгийн чухал байх.

Тэгэхээр гол валют орж ирдэг 3 суваг байдаг.

- Экспорт,
- Гадаадын хөрөнгө оруулалт,
- Зээл.

Өнгөрсөн цаг хугацаанд бид энэ 3-аас дандаа тэр “зээл” гэдэг зүйлийг нь түлхүү ашиглаад, яаж экспортоо, тэр тусмаа тэр уул уурхайн бус гэж байгаа экспортоо яаж нэмэгдүүлэх вэ гэдэг дээр нэг тийм уриа лоозонгийн шинжтэй явдаг.

Тэгээд л гарч ирсэн засаг бүхэн, гарч ирсэн сайд бүхэн сайхан сайхан зүйл ярьж байдаг. Эцсийн үр дүн нь байдаггүй нэг ийм л зүйл байдаг.

Тэр “гадаадын хөрөнгө оруулалт” гэдэг зүйл яг юу болж байна вэ.

Тэгэхээр тэр гадаадын хөрөнгө оруулалтын чиг хандлага нь яаж байна? Одоо Оюу Толгойн хөрөнгө оруулалт багасчихаар үүн дээр ямар бодлого чиглэл барьж байна? Тодорхой тоон үзүүлэлтүүд юу байна вэ? Энэ дээр нэг мэдээлэл өгөөч.

Тэр экспорт, тэр тусмаа уур уурхайн бус экспорт энэ үйл ажиллагааны хөтөлбөр дээр яг тодорхой тоон хэмжүүрүүд яаж тавигдаж байгаа вэ? Энэ дээр мэдээлэл өгөөч ээ.

Залгаад Ц.Туваан сайдаас нэг асуулт байгаа юм.

Ер нь “уул уурхайн хайгуул” дээр яг ямар бодлого барих гэж байгаа вэ? Үйл ажиллагааны төлөвлөгөө, олон зүйл дээрээ яаж орж байгаа юм.

Бид яг үнэндээ валют олно л гэдэг. Явсаар явсаар бүгдээрээ тэгээд уул уурхай дээр тулж очоод байдаг асуудал байдаг.

Өнгөрсөн цаг хугацаанд “уул уурхайн хайгуул” гэдэг зүйлийг дээр дооргүй ярьсаар байгаад бүгдээрээ

хаагаад хаячихсан нэг ийм л нөхцөл байдалтай.

Сүүлийн хэдэн жил ч юм хайгуул хийгдсэнгүй. Энэ дээр ер нь ямар бодлого барих юм?

Үүний нөгөө талд чинь бас орон нутгийн иргэдийн эрх ашиг, орон нутгийн иргэдэд өгөөж гээд олон зүйл бас яригддаг.

Тэгэхээр энэ зөрчилтэй зүйлс дээрээ яг ямар бодлого, бодлогын гарц шийдэл энэ дээр харж байгаа вэ? Хэрхэн яаж үүнийг даван туулах гэж бодож байгаа вэ? Эдгээр асуудлууд дээр тодруулга өгөөч.

Д.Амарбаясгалан: Хариулъя. Ц.Туваан сайд.

Ц.Туваан: О.Цогтгэрэл бүлгийн даргын асуултад хариулъя.

Ер нь энэ удаагийн Засгийн газар дээр хуучин Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам гэж оруулж ирж байгаа.

Тэгээд энэ бол аж үйлдвэрийн асуудлыг нэг номерт тавьж, нэмүү өртөг шингээж, ажлын байр бий болгох гэдэг тал руу нь зорьж ажиллаж байгаа.

Мөн энэ эрдэс баялгийн салбар маань өөрөө тодорхой дарааллаар явагддаг. Энэ дарааллын хамгийн эхэнд таны саяын хэлсэн энэ геологи, хайгуулын ажил байдаг.

Геологио эхэлж хийж нөөцөө олж тогтоогоод дараагаар нь олборлолт, ашиглалт, дараагаар нь үйлдвэрлэлийн асуудал явагддаг учраас энэ дээр онцгой анхаарал тавьж ажиллана. Засгийн газрын

үйл ажиллагааны хөтөлбөрт тодорхой заалтууд орсон байгаа.

Тодорхой хэлэх юм бол энэ хайгуулын асуудал дээр бид бүхэн байнга энэ уламжлалт, яг өрөм тавьж хайгуул хийхээс гадна орчин үеийн, ялангуяа энэ Австрали, Канад гээд уул уурхай өндөр хөгжсөн улсуудад хэрэглэдэг агаарын соронзон геофизикийн аргаар хайгуул хийх ажлыг сүүлийн 2 жил улсын төсөв дээр тавьж анхаарч ирсэн.

Тэгэхээр энэ асуудлуудыг нэлээн цааш нь үргэлжлүүлж явуулна гэсэн ийм бодлого барьж байгаа.

Уул уурхай дээрээ ерөөсөө л хариуцлагатай уул уурхай буюу бүх оролцогч тал нь харилцан ашигтай байх гэдэг. Өөрөөр хэлбэл энэ дотор орон нутгийн иргэд, орон нутгийн удирдлага ч гэсэн бас уул уурхайгаа ашиглуулж байгаа бол эрх ашгаа хангуулах асуудлыг бас нэн тэргүүнд тавьж ажиллана гэсэн ийм бодлогыг барьж ажиллана.

Д.Амарбаясгалан: Тодруулга. Одонгийн Цогтгэрэл гишүүн.

Тэргүүн Шадар сайд Л.Гантөмөр хариулъя.

Дэг нэлээн өөрчлөгдсөн юм байна гэж ойлголоо. Уг нь ажлын хэсэг гараад, Их Хурлын ажлын хэсэг гараад ажилласан. 100 гаруй санал хураалт өнөөдөр явуулах байх.

Тэр ажлын хэсгээс асуух цаг хугацаа нь хэзээ байдаг юм бол? Дэгээ одоо манай Тамгын газрынхан сайн хараарай.

Л.Гантөмөр: О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Ер нь бид экспорт гэх юм бол уурхай дээр 90 хувьтай байгаа шүү дээ.

Тэгээд одоо бид нарын эхний алхам бол уул уурхайн бүтээгдэхүүнийг дахин боловсруулах, уул уурхай дээр түшиглэсэн аж үйлдвэрийг бий болгох гэдэг Ц.Туваан сайдын хариулт бол бидний эхний стратеги байгаа юм.

Дараагийнх нь, “уул уурхайн бус бүтээгдэхүүн”. Түүн дотор аялал жуулчлал байгаа.

Уул уурхайн бус бүтээгдэхүүнийг бид өндөр технологи руу шилжүүлж байж зах зээлд гаргах юм билээ. Ингэхийн тулд бидний хамгийн түрүүнд хийх ажил бол энэ инновац, нөгөөдөх нь шинжлэх ухааны парк.

Тэгэхээр бид шинжлэх ухааны.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт тодруулга. Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Тэр уул уурхайн хайгуул дээр Ц.Туваан сайд улсын төсвөөс уул уурхайн хайгуул хийнэ гээд Та хэлчих шиг боллоо.

Энэ чинь ер нь тийм зарчим, бодлого, чиглэл нь тэр их эрсдэлтэй салбар луу улсын төсвөөс хөрөнгө оруулна гэдэг саяын тэр яриа чинь хэр зэрэг. Одоо өнгөрсөн хугацаанд хэчнээн мөнгө төгрөг түүнд төсөвлөгдөж явсан юм, ирээдүйд яаж төсөвлөгдөж явах юм? Энэ чинь өөрөө бодлого, чиглэлийн хувьд жоохон тийм алдаатай л юм шиг л сонсогдох юм.

Та үүн дээрээ нэг тайлбар өгөөч.

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт. Цэвэгдоржийн Туваан сайд.

Ц.Туваан: Тодруулж хариулъя.

Өнгөрсөн 2 жилийн хугацаанд улсын төсвөөс нийтдээ 30 гаруй, 30 гаруй, нийтдээ 60 гаруй тэрбум төгрөгийн төсвийг яг энэ хайгуулын. Тухайлах юм бол энэ агаарын соронзон геофизикийн аргаар хайгуул хийх зүйл дээр тавьж өгсөн.

Мөн тэр геологийн салбарыг урдаа тавьж, тэргүүлэх эгнээндээ явуулахын тулд бид хууль эрх зүйн орчин, ялангуяа хайгуулын лиценз олгох асуудал, хууль эрх зүйн асуудлыг нээж өгөх тал дээр ажиллана.

Мөн яамны бодлого, энэ асуудлыг хариуцсан агентлагийн бодлого дээр нэлээн томоохон шинэчлэлт хийж уул уурхайн салбарын анхдагч хэсэг болсон геологийн хайгуулын салбараа бодлогоор, хүн хүчний хувьд ч тэр, бусад бодлогын асуудлын хувьд ч тэр өргөжүүлж ажиллана гэдгийг танд хэлье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Чуулганы танхимд хүндэт зочин ирсэн байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Өнөөдөр Монгол Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы хуралдаанд Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын дэд Ерөнхийлөгч эрхэмсэг хатагтай Пани Ятодү /Pany Yathotou/ тэргүүтэй төлөөлөгчид зочилж байна. /алга ташив/

Та бүхэнд ээ Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс Монгол

Улсад тавтай морилно уу хэмээн чин сэтгэлээсээ мэндчилж байна. /алга ташив/

Монгол Улс Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улстай эртний түүхэн улбаатай найрсаг дотно харилцаатай төдийгүй Монгол Улсын Их Хурал, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Үндэсний Ассамблей хоорондын харилцаа, хамтын ажиллагаа өнгөрсөн хугацаанд идэвхтэй сайн хөгжиж ирсэн.

Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Үндэсний ассамблей Монгол Улсын Их Хуралд хоёр улсын харилцааны найрамдлын бэлгэ тэмдэг болгон улаан модоор хийсэн сандал, ширээ зэрэг тавилгыг 2003 онд бэлэглэж байсан.

Эдгээр тавилгыг Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн танхимд өнөөг хүртэл ашиглаж байгааг Та бүхэн мэднэ.

Монгол Улсын Их Хурлын гишүүдийн тоо 126 болон нэмэгдсэнтэй холбогдуулан нэмж 50 ширхэг улаан модон сандал, ширээ, холбогдох бусад тавилгыг хийлгэх асуудлыг Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын тал найрсагаар хүлээн авч тусалж дэмжсэнд талархалтай байгаагаа илэрхийлж байна. /алга ташив/

Монгол Улсын Их Хурлын зүгээс Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Үндэсний Ассамблейн ордонд зориулж дэвсгэр хивс 2023 оны 11 дүгээр сард бэлэглэж хоёр орны найрсаг харилцааг бэхжүүлж байсан.

Цаашид хоёр улсын харилцаа бүхий салбарт улам өргөжин хөгжинө гэдэгт итгэлтэй байна.

Эрхэм хүндэт Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын дэд Ерөнхийлөгч хатагтай Пани Ятодү Танд болон хамт олонд дахин талархал илэрхийлж, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Амжилт хүсье. Та бүхэндээ. /алга ташив/

Ингээд чуулганы хуралдаан үргэлжилье.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Би энэ үйл ажиллагааны хөтөлбөрт нэг санал оруулаад долоо хоног хөөцөлдлөө.

Байнгын хороодын дарга нар болон холбогдох хүмүүст нь бүгдэд нь учирлалаа.

Санал нь мега төслийн 13-д Оюу Толгойг түшиглэсэн зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ гэж байгаа юм.

Үүний оронд Монгол орны зэсийн ордуудыг түшиглэж зэсийн баяжмал хайлуулах, зэс болон бусад дагалдах элементийг цэвэршүүлэх гэж оруулаад өгөөч ээ л гэж би долоо хоног гуйлаа, учирлалаа.

Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр бас энэ саналууд ирсэн. Тэгээд дамжуулсан.

Өнөөдөр энэ бол Та бүхэн Ц.Туваан сайдын яам аа. Эрдэс баялгийн яам өнөөдөр Оюу Толгойд барьцаалагдсан яам биш л юм бол, энэ

засаг төрийн бодлого дээрээ, төрийн бодлогын бичиг баримт дээрээ үндэсний компаниудаа яагаад ялгаварлаж байгаа юм бэ?

5 төсөл явж байгаа шүү дээ. Бусад 4-ийг нь дэмжихгүй. Төр өнөөдөр ганцхан Оюу Толгойг түшиглэнэ гэж орсон байна.

Монгол орны зэсийн ордууд дотор чинь “Оюу Толгой” орж байгаа. Тэр нь орж байгаа шүү дээ. Яагаад ялгаж байгаа юм?

Энэ бол та нар Үндсэн хуулийг зөрчиж байна гэж ойлгож байна. Үндсэн хуулийн цэцэд очно энэ.

Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1-д “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны онцлогт тохируулж эдийн засгаа хөгжүүлнэ.”

2-т нь, “...төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хамгаална.”

3-т нь, “...өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.”

Одоо өнөөдөр. Би ямар нэгэн нэр хэлээгүй шүү дээ. 5 том төслөөс ганцхан “Оюу Толгой” дээр түшиглэж зэс хайлуулах үйлдвэр барина гээд төр дискриминац^[ялгаварлан гадуурхалт] хийчихлээ. Энэ дээр болж байгаа юм уу?

Өнөөдөр үүнийг хэрвээ барих юм бол. Одоо өнөөдөр “Оюу Толгой” дээр. Би Оюу Толгойн эсрэг биш.

Хэзээ ч гадаадын хөрөнгө оруулалтын эсрэг биш.

Зүгээр Монголд ашигтай юу, үндэсний компаниудыг яагаад ялгаварлан гадуурхаж байгаа юм бэ л гэж асууж байгаа.

Өнөөдөр энэ утгаараа “Оюу Толгой” нэг секундэд 964 литр ус хэрэглэдэг. Тонн ус секундэд хэрэглэхэд 40 литр ус л дутуу.

Өнөөдөр энэ үйлдвэр баригдаад эхэлбэл хэдэн арваар нэмэгдэнэ шүү дээ.

ТЭЗҮ байхгүй. “Оюу Толгой” дээр ТЭЗҮ байхгүй шүү дээ. Гарчиг тавиад л паналдуулаад л одоо ханалаа шүү дээ.

Өнөөдөр бие даасан хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргах боломжийг Улсын Их Хурал хааж байна гэсэн үг.

Зэс хайлах, цэвэршүүлэх үйлдвэр барихын тулд байршил, усан хангамж, эрчим хүч, байгаль орчны нөлөөлөл, суурьшлын бүс гээд олон асуудлуудыг ярих ёстой байтал өнөөдөр зүгээр л шууд хааж байгаа. “Оюу Толгой” дээр барь.

Ямар том лобби вэ. Үүнийгээ эргэж харах боломж байна уу л гэж гуйсан. Би ямар нэгэн нэр томьёо хэлээгүй.

Бор-Өндөр дээр, Шанд дээр, Говьсүмбэр дээр олон удаа энэ төслүүд явж байгаа. Яагаад тэднийг өнөөдөр Их Хурал дээр ямар ч ТЭЗҮ-гүй мөртөө “Оюу Толгой” дээрээ.

Говийн усыг ашиглаад түүрэм болж байгаа шүү дээ. Энэ байршлийг нь би өнөөдөр бие даасан хөндлөнгийн

шинжээчид дүгнэж ярих эрх боломжийг нь Их Хурал өгөөч ээ.

Томьёоллын би маш тодорхой гаргалгаа хэлж байна шүү дээ. “Монгол орны зэсийг нь баяжуулах ордуудыг түшиглэн” гэж үг оруулаад өгөөч л гэж байгаа юм.

Өнөөдөр үндэсний үйлдвэрлэгчдээ хамгаалдаггүй юм гэхэд битгий гадуурхаач ээ. Өнөөдөр “Оюу Толгой” хөлсний алуурчин нийтлэлчид намайг үйлдвэрлэгчдийн, бизнес эрхлэгчдийн эсрэг болгочихсон л доо. Үгүй, үгүй, үгүй,

Монголд ашигтай юу, үндэсний бизнесменүүдээ хамгаалаач ээ л гэж би олон жил, 20 жил ярьж байна.

Дээр нь нэмээд өнөөдөр “Оюу Толгой” л зэсийн хайлуулах үйлдвэр дээр хөрөнгө босгоно, бусад нь босохгүй гэж төрийн баримтдаа тусгаж байгаатай утга нэг болчихлоо.

Өнөөдөр Монгол оронд 9.9 тэрбум тонн хүдрийн баяжмал байгаа. Бусдыг нь яагаад гадуурхаж байгаа юм бэ? Үүнийг эргэж харах боломж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Лувсаннъямын Гантөмөр хариулна.

Л.Гантөмөр: Баярлалаа.

Тэгэхээр Засгийн газар яг С.Ганбаатар гишүүнтэй адилхан бодолтой байгаа.

Яг ийм төслийг бид өргөн барьсан. Их Хурлын ажлын хэсэг зөвхөн “Оюу

Толгой” гэж хязгаарлаж байгаагаа татаж авах хэрэгтэй шүү.

Боломж бололцоо зөндөө байгаа. Тийм учраас бид оруулж ирэхдээ энэ төслүүдийн 10 дээр “зэс боловсруулах цогцолбор байгуулна” гээд оруулаад ирчихсэн.

Гэтэл үүнийг зөвхөн “Оюу Толгойн зэс хайлуулах үйлдвэр” гэдгээр томьёолж өөрчлөх юм бол бид нарыг ганц төсөл рүү шахаж байгаа юм шиг болно.

Тийм учраас ажлын хэсэг дээр энэ саналаа өөрчлөөд Их Хурал дээр санал хураалгахдаа бараг энэ саналаа яг хуучин байснаар нь оруулъя гэдэг байдлаар өөрчилж өгөөрэй гэж хүсмээр байна.

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт Цэвэгдоржийн Туваан сайд.

Дараа нь Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, ажлын хэсгийн дарга Ж.Бат-Эрдэнэ гишүүн хариулна.

Ц.Туваан: Өчигдөр Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж яг энэ асуудлыг ярьсан.

Тэгээд ажлын хэсгээс орж ирсэн саналууд байгаа.

Тэгээд сая энэ тараагдсан материалыг манай С.Ганбаатар Байнгын хороон дарга бас харчхаарай.

Үүний 10 дээр нь “зэс боловсруулах цогцолборыг ашиглалтад оруулна” гэж оруулсан байгаа. Тодорхой байршил заагаагүй.

Тэр 13-ыг бас ярьж байна. Түүн дээр “Оюу Толгой” гэсэн үг орсон

байсан. Үүнийг бас “Оюу Толгой” гэдэг үгийг нь аваад, тодорхой компанийн нэр заалгүйгээр шинээр 10, 13 хоёрыг шинэчилж томьёолоод оруулж ирсэн байгаа гэдгийг тодруулж хэлье.

Тэгэхээр Аж үйлдвэржилтийн байнгын хорооны дарга, С.Ганбаатар даргын асуудал тодорхой хэмжээнд орсон.

Үүнийг бас дахин оруулж ирэх энэ асуудал бол Их Хурлын болон ажлын хэсгийн бүрэн эрхэд байгаа байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн хариулна.

Ж.Бат-Эрдэнэ: Л.Гантөмөр сайд ерөнхийдөө хариулчихлаа даа.

Энэ 10 дээр “зэс боловсруулах цогцолборыг ашиглалтад оруулна” гэж байгаа шүү дээ. Ингээд орчихсон байгаа. Нэг.

Хоёрдугаарт, яг таны хэлбэрээр орох боломж нь дэгийн тухай хуулиараа орж ирээгүй юм. Хоёр.

Гуравдугаарт, С.Ганбаатар дарга аа, С.Ганбаатар гишүүн ээ, С.Ганбаатар Үйлдвэржилтийн байнгын хорооны дарга аа.

Таны олон жил ярьсан яриаг чинь одоо өнөөдөр Улсын Их Хурлаас боломжийг тань олгоод Үйлдвэржилтийн байнгын хорооны, мэргэжлийн Байнгын хорооны дарга болгосон шүү дээ.

Танд одоо энэ Үйлдвэржилтийн байнгын хорооныхоо бодлогын хүрээнд бодлогоо гаргах даргалж байгаагийн

хувьд танд асар том боломж бол байгаа шүү дээ.

Та хэрвээ яг энэ үг, үсгээр нь оруулаад ирсэн бол бид дэмжээд явчих л байсан шүү дээ.

Танд бодлого чинь байгаа. Шулуухан хэлэхэд та.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар тодруулга.

С.Ганбаатар: Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээрээ энэ асуудлыг оруулсан.

Тэгээд Оюу Толгойн сонирхлын группүүдээ дийлэхгүй байна.

Тэгээд танд учирлаад ярьсан. Албан ёсоор хандсан.

Дээр нь нэмээд 13-ын ард. Та нар юмаа уншаарай. 13-ын ард, “Оюу Толгой” гэдгийн ард, нэрийг нь сольсон ч гэсэн ард нь “алт цэвэршүүлэхэд 70 хувийг нь дотооддоо цэвэршүүлэх” гээд яг Оюу Толгойд зориулсан хүрэх үр дүнгээ бичсэн байгаа.

Та нар тэр 10-ыг хар. 10 дээр “зэс боловсруулах цогцолбор” гэсний ард 560 тонн гээд Эрдэнэтийн яг лобби ороод ирчихсэн явж байгаа.

Эрдэнэтийн хагас дутуу тэр төсөл дотор маш олон. Одоо хүхрийн хүчил маш аюултай түвшинд гаргана гэдэг тийм томьёоллууд орчихсон байгаа.

Асуудлуудаа уншиж, асуудлууд дээрээ нэлээн гярхай ажиллах шаардлагатай байна. Ажлын хэсэг дээр

би анхаарал тавь. Одоо энэ асуудал шийдэгдэнэ гэж би ойлгож байна шүү.

Д.Амарбаясгалан: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн нэмж хариулья.

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн хэлэлцүүлэг дээр асуудлаа бас дахиж гаргаж ирээд л, одоо энд бас даргын хэмжээнд, яг санал хураалтын хүрээнд яг энэ асуудал дээрээ асуудал дэвшүүлээд тэгээд дараагийн хуралдаанаар орох ийм боломж нээлттэй.

Тэгэхдээ энэ чинь хүндрэлтэй шүү. Батлагдах боломж нь байхгүй шүү.

Хамгийн гол нь танд асар том боломж байсныг Та ашигласангүй шүү дээ. Мэргэжлийн Байнгын хороо чинь хэрвээ ингээд лобби нь автагдчихаж байгаа бол мэргэжлийн Байнгын хороо чинь, таны ахалсан мэргэжлийн Байнгын хороо чинь бодлого нь эсвэл зөв яваад наадхыг чинь дэмжихгүй байна.

Эсвэл тэр буруу тийшээгээ хандаад явж байна. Түүн дээрээ өөрөө анхаараад ажиллаач ээ л гэж би хэлмээр байна.

Ажлын хэсэг рүү оруулж ирсэн бол дэмжихээр байлаа.

Д.Амарбаясгалан: Нэмэлт тодруулга. Нэг удаа тодруулж болно. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулга. 1 минут.

С.Ганбаатар: Энэ мэдээжийн асуудлыг Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр тас гэдрэгээ савж унана гэдэг дээр би ичихийн дээдээр ичиж байгаа.

Одоо Монголын ард түмний өмнө энэ асуудлаа бас Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр ямар процесс, ямар протокол явсан бэ гэдгийг илэрхийлнэ.

“Captured state” гэдэг тийм нэр томъёо байдаг юм шүү.

“Барьцаалагдсан төр” гэдэг шиг.

20 жил өнөөдөр үүнийг ярьж байгаа бид. Ингээд бэрхшээлүүдээ шийдэхийн төлөө бас хандаж ажиллана.

Д.Амарбаясгалан: Загджавын Мэндсайхан гишүүн асуултаа асууя.

3.Мэндсайхан: Энэ “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гээд Засгийн газрын хөтөлбөрт тусгаад өгчихсөн байгаа.

Тэгэхээр одоо энэ зээл чинь орон нутагт цаашаа бас олгогдохгүй байна.

Тэгэхээр “Зээлийн батлан даалтын сан”-гийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх тал дээр Засгийн газар ямар асуудлыг энэ дээр тусгаж өгч байгаа юм?

Энэ өөрийн хөрөнгөө нэмэгдүүлээгүй тохиолдолд энэ зээл ингээд малчдын хувьд хүндрэлтэй болоод зогсох нь.

Нөгөө талдаа хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих одоо энэ үндэсний “Цагаан алт” хөтөлбөр гэж батлагдсан байгаа.

Нэг талдаа бид хөдөө шинэ хоршоогоороо малчдын тогтвортой мал аж ахуй эрхлэлтийг дэмжээд байдаг. Нөгөө талдаа хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих бодлого маань хаягдаад байгаа.

Тэгэхээр энэ хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих “Цагаан алт” хөтөлбөр дээрээ энэ “Зээлийн батлан даалтын сан”-г уяж өгөх, баталгааг нь гаргаж өгөх, хөнгөн үйлдвэрүүддээ бүс орон нутагт энэ хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд “Зээлийн батлан даалтын сан”-г ямар хэлбэрээр явуулах дэмжлэг үзүүлэхээр яг энэ шинэ хоршоо шиг холбож өгч болохгүй юу? Засгийн газар.

Хоёрдугаарт, үйлдвэр, технологийн паркуудыг байгуулна гэж байгаа. Ажил хэрэг болоод явж байгаа нь ганцхан баруун бүсэд байгаа.

Гэтэл эрх зүйн орчноороо энэ дээр ямар нэгэн татварын ялгаатай бодлого байхгүй. Зөвхөн бид үйлдвэр, технологийн паркийг төсвийн хөрөнгөөр байгуулаад өгч байгаа.

Тэгэхээр энэ дээр цаашаа бүс нутаг руу үйлдвэрлэлийг хөгжүүлэх дээр татварын ямар бодлого явуулах гээд байгаа юм бэ?

Гурав дахь нь бүс нутаг. Одоо ялангуяа баруун бүсийг эрчим хүчний тэргүүлэгч чиглэлтэй гээд тодорхойлчихсон. Дулааны асуудал хаягдаад байна. Бүс нутагт орон сууцжуулах, бүс нутгийн ялгааг арилгах, тэр нүүдэл суудал, түгжрэл, утааг шийдэхэд чинь гол нь орон сууцжуулах асуудал байгаа.

Тэгэхээр энэ дэд бүтцийн асуудал хаягдаад байна гэдэг саналыг олон удаа оруулсан. Тэгээд дулааны асуудал ерөөсөө дэмжигдэхгүй байна.

Энэ дээр Эрчим хүчний яамнаас хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Хариулъя. Сангийн сайд байна. уу?

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбын Энхбаяр хариулна.

Ж.Энхбаяр: Хоршоодын хөдөлгөөн улс орны хэмжээнд өрнөж байна.

Малчид маань маш сайн зохион байгуулалтад орж төсөл, хөтөлбөрөө арилжааны банкнуудад идэвхтэй танилцуулж байна.

2024 оны төсөвт батлагдсан 500.0 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэр үндсэндээ ингээд бүрэн ашиглагдаад дуусаж байна.

Сангийн яам, Монголбанкттайгаа Хөдөө аж ахуйн яам зөвшилцөөд дахин шинэ эх үүсвэрийг гаргаж зээлийг үргэлжлүүлэх асуудал үндсэндээ өнөө маргаашгүй шийдэгдэх байх.

Тэгээд энэ бололцоог ашиглаад хоршоод маань төсөл, хөтөлбөрөө арилжааны банкнууддаа идэвхтэй өгөөд хорших тэр хөдөлгөөнөө цааш нь эрчимжүүлээрэй гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Үүнтэй холбоотойгоор “Зээлийн батлан даалтын сан”-гийн дүрмийн санг 50.0 тэрбумаар нэмэгдүүлэх ийм тооцоог гаргаж 2025 оны төсөвт тусгахаар өгсөн байгаа.

Одоо байгаа эх үүсвэрээрээ бид он дуустал энэ хэмжээний санхүүжилтийг зээлийн батлан даалтыг нь хийгээд явчих бололцоотой байгаа.

Хөнгөн үйлдвэрийн асуудал дээр “Цагаан алт” хөтөлбөр Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан.

Мөн үүн дээр 300.0 тэрбум төгрөгийн эх үүсвэр гарсан. Одоо энэ ажил яг эхлэхээр бэлтгэл ажил хангагдаж байна.

300.0 тэрбум төгрөгийн хүрээнд ноос, ноолуур, арьс ширний салбарт үйлдвэрлэлийн чадавхыг нэмэгдүүлэх, эргэлтийн хөрөнгө болон хөрөнгө оруулалтад зориулсан ийм зээлүүд явагдана.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулах хүн байна уу? Сангийн яам.

Энэ “Зээлийн батлан даалтын сан”-гийн хөрөнгийн нэмэгдлийн асуудлыг Сангийн яам ер нь дангаараа шийддэг.

Тэгэхээр энэ дээр Сангийн яамнаас хэн хариулах вэ? Б.Жавхлан сайд хааччихсан юм. Б.Жавхлан сайдыг дуудаарай. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр явагдаж байна шүү. Яригдаж, хэлэлцүүлэгдэж байна.

Загджавын Мэндсайхан гишүүн тодруулга.

З.Мэндсайхан: Дулааны асуудал дээрээ хариулт авъя.

Хоёрдугаарт, “Зээлийн батлан даалтын сан”-г 50.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлнэ гэж төсөвлөж байна гэж байна. Энэ чинь ерөөсөө л 50.0 тэрбумын зээл гараад зогсоно л гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр нөгөө хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих тэр бодлого чинь

хэрэгжихэд энэ хангалттай эх үүсвэр болж өгөхгүй.

500.0 тэрбумыг ирэх жил гаргахаар, 300.0 тэрбумыг гаргахаар төлөвлөсөн гэж байна. Энэ дээр ямар ч зээлийн талаасаа батлан даалтын сангаасаа баталгаа алга байна шүү дээ.

Тэгэхээр наад зээл чинь ингээд цаасан дээр мөрөөдөл болоод үлдэх байхгүй юу.

Тэгэхээр энэ эх үүсвэр талаа шийдэхээсээ илүүтэй батлан даалтын талаар эхний ээлжид авч хэрэгжүүлмээр байна. 50.0 тэрбум гэдэг бол хангалттай биш.

Ийм учраас наад зээлүүд чинь эх үүсвэрүүд чинь гарахгүй.

Тэгэхээр энэ “Зээлийн батлан даалтын сан” талдаа та нар анхаарч өгөөч ээ. Ингэж байж бүс нутаг руу бид тэр үйлдвэрлэлийг чинь хөгжүүлэх бодлого чинь явна шүү дээ.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулах хүн байгаа юу?

З.Мэндсайхан гишүүн ээ, наадах чинь ийм асуудал үүсчхээд байгаа юм билээ.

Хөтөлбөр хэрэгжиж эхлээд Сангийн яам, Хөдөө аж ахуйн яам, Монголбанк гурав арилжааны банкнуудтайгаа 500.0 тэрбумын гэрээ хийсэн. Гэрээ 500.0 тэрбумдаа хүрсэн. Одоо нэмэлт гэрээгээ шинэчлэх процесс явагдаж байгаа юм билээ.

Тэгэхээр нэг дэх учир шалтгаан энэ дээр байна.

Тэгэхээр Засгийн газар үүнийг яаралтай зохион байгуулж, хүлээлт өндөртэй байгаа төслөө хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулах нь зөв байх гэж бодож байна.

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Ж.Бат-Эрдэнэ: Би асуулт биш. Нэг санал хэлчихье гээд байсан юм.

Ажлын хэсгийн даргын хувьд төрийн албаны реформ, төрийн албаны шинэчлэлтэй холбоотой. Урьд нь энэ асуудлыг хэлэлцэж байх үед хэлэх гээд багтаагүй юм.

Тэгээд сая ажлын хэсэг дээр бид нэлээн том бүлгээр нь өөрчлөлт оруулаад ирсэн. Тэгээд Төрийн байгуулалтын байнгын хороон дээр энэ маань дэмжигдээгүй өөрчлөгдсөн. Хуучнаараа орж ирж байгаа юм.

Тэгэхээр би юу хэлэх гээд байна гэхээр одоо энэ төрийн албан дээрээ нэлээн том реформ хийнэ шүү. Энэ дээр ер нь ямаршуу реформ хийх юм бэ гэдэг асуултыг давхар асуучихъя.

Хэрэг эрхлэх газрын дарга хариулах болов уу гэж бодож байна.

Одоо бид төрийн алба дээр нэлээн том шинэчлэл хийхгүй бол болохоо больчихоод байна. Зүгээр л нэг цомхотгоно гэдэг асуудлаар хамаг асуудлыг хаагаад л байдаг.

Гэтэл энэ чинь хуулийн дагуу явж байгаа тангараг өргөсөн төрийн албан хаагч шүү дээ. Нэг.

Хоёрдугаарт, улс төрийн төрийн албан хаагч дээрээ бид ер нь ямар арга

хэмжээ авч байгаа вэ? Улс төрчид дээрээ, улс төрийн алба дээрээ, сайд нар дээрээ.

Бид жишээ нь сайд нарын хүрээнд давхар дээлтэй ингээд сайд нар маань орж л байна. Энд тодорхой хэмжээний хариуцлага байх хэрэгтэй. Их Хуралтай холбоотой асуудлууд, Их Хурлын гишүүдтэй холбоотой асуудлууд. Ер нь бол.

Тэгээд үүнийг эргээд буцаад дээрээс нь хөөгөөд ирэхээр явж явж байгаад нөгөө сонгуультай холбоотой асуудал, улс төрийн намуудтай холбоотой асуудал, Сонгуулийн хуульдаа гар хүрэх шаардлагатай болчихоод байна.

Сая өнгөрсөн сонгуулиар бид чинь яалаа. Нэлээн том мөнгөний сонгууль.

Ер нь яах вэ, бүсчилсэн хөгжил гэдгийг би хоёр гараараа дэмждэг хүн. Бүсчилсэн хөгжил маань зөв байсан. Гэхдээ тэрэн дээрээ бид тэр зардал мөнгөтэй холбоотой асуудал дээр нь өөрчлөлт хийж чадалгүйгээр орчихсон. Энэ хамгийн том алдаа боллоо шүү дээ. Асар том мөнгөний сонгууль боллоо.

Тэгэхээр улс төрийн албан хаагчид дээрээ бид хариуцлага тооцохгүйгээр төрийн захиргааны албан хаагчид, төрийн тусгай, тэгээд төрийн үйлчилгээний албан хаагчдаа л бид чангалаад тэд нар дээрээ л мушгиад байгаа болохоос биш яг улс төрийн албан хаагчид дээрээ ямар хариуцлага тооцож байна гэдэг асуудал чинь сул болчихоод байна шүү дээ.

Тийм болохоор төрийн албатай холбоотой асуудлууд, ёс зүйтэй холбоотой асуудлууд, дагалдсан энэ хуулиудтай холбоотой асуудлууд, ер нь бүхэлд нь нэлээн том шинэчлэл хийх шаардлага гараад байгаа юм.

Ер нь яах вэ, ажлын хэсэг дээр нэлээн яригдаад томхон хэмжээнд өөрчлөлт оруулъя гэж ярьсан маань ингээд буцаад хэвэндээ орж ирлээ.

Тэгээд цаашдаа мэдээж Засгийн газар энэ дээрээ өөрчлөлт хийх, хуульдаа бүр.

Би хэлээд байгаа юм. Таазанд тулсан бүх шаардлагуудыг оруулж ирсэн ийм хуулийн өөрчлөлтийг оруулж ирээч ээ гэсэн ийм л асуулт, ийм санал байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал хариулья.

Н.Учрал: Төрийн албан дээр нэлээдгүй шинэчлэл хийх шаардлага үүссэн.

Жишээ нь, **Public service**, энэ **CV service** гээд байгаа чинь яг ангилж өгөхгүй бол өнөөдөр төрийн албан хаагчдын тоо 226 мянгад хүрчихлээ гэж яриад байгаа. Яг үүнээс бараг төрийн үйлчилгээний албан хаагч үүний чинь 67 хувь байхгүй юу. Жишээ нь, 53 мянга гаруй төрийн үйлчилгээний албан хаагч нар байгаа.

Тэгэхээр төрийн жинхэнэ албыг хааж байгаа энэ төрийн захиргааны албан хаагч нар бол ерөөсөө л 21 мянга гаруй л байгаа шүү дээ. Энэ чинь ер нь 10 хувь бараг хүрэхтэй үгүйтэй.

Тэгэхээр үүнийг нэг ийм том саванд хийчхээд энэ бол нийт төрийн алба юм аа, 226 мянга юм аа гээд ингэж үзээд байвал цаашдаа энэ төрийн албан дээр шинэчлэл хийхэд маш их бэрхшээлтэй.

Тийм учраас Төрийн албаны хууль дээр мэдээж нэлээн үндэсний зөвшилцлийн хэмжээнд ажиллах ёстой.

Тийм ч учраас бид төрийн албыг илүү хурдан шуурхай ажиллах, ялангуяа ийм техникал ур чадварыг заавал хүн хийх шаардлага бол өнөөдөр яг энэ технологийн хувьслын үед байхгүй болчихлоо шүү дээ.

Тийм учраас нийтийн алба, төрийн албаа хуулиар нь ангилаад, ийм техникийн, гүйцэтгэлийн түвшинд ажиллаж байгаа албан хаагчдыг илүү технологи суурьтай байх, хүнээс хамааралгүй байх шийдэл рүү явуулахад төр аяндаа төрийн бүтээмж нэмэгдэнэ.

Тийм ч учраас өчигдөр Төрийн байгуулалтын байнгын хороон дээр орж ирсэн санал дээр Засгийн газраас орж ирсэн энэ зорилтуудыг тусгаад өгөөч ээ. Үүн дээр одоо бид энэ тэр **“DME”** [Design, Monitoring and Evaluation] гэж хэлээд байгаа. Дизайн хийгээд, мониторинг хийгээд үнэлдэг.

Ингээд үр дүнгээ хэмжихэд яг энэ концепц нь яг хоорондоо нэгдэж байх ёстой.

Тийм ч учраас бид цаашдаа төрийн албан дээр нийтийн албыг ангилна.

Хоёрт, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын хуулийг хэрэгжүүлнэ. Үүний хүрээнд төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоо руу шилжүүлнэ.

Ингээд энэ салбарын хяналтууд ч гэсэн мэргэжлийн холбоо орж ирж ажиллах ёстой.

Тэгэхээр мэргэжлийн холбоогоороо дамжуулаад энэ экспертүүд, эрдэмтэн, судлаачдын оролцоог төрийн албанд хангуулахгүй бол тэр салбартаа мэргэшсэн экспертүүдийг заавал нэг яамны мэргэжилтэн болгож суулгах гээд байдаг энэ тогтолцооноос гарах ёстой.

Тийм ч учраас өчигдөр Засгийн газар 8 төрлийн 54 үзүүлэлтээр нэгдсэн **“big data”** дээр шийдвэр гаргах бололцоог сайд нарт олгож байгаа.

Үүний үндсэн дээр бид **“их өгөгдөл”** дээр суурилсан шийдвэр гаргаснаар бүтээмж хоёр дахин нэмэгдэнэ.

Цаасны хэмнэлтийг хүртэл 10 дугаар сарын 01-нээс авхуулаад цахимаар бичиг солилцох. Үүний тусламжтайгаар төр өөрт байгаа тэр **158 terabyte** гээд байгаа мэдээллийг ашигладаг болох, шийдвэр гаргалт, төрийн шийдвэр өөрөө байгаа онох тогтолцоог бүрдүүлэхэд төрийн албан хаагч нарын бэлэн байдлыг хангуулахын тулд үүнийг үндэсний хэмжээнд хийнэ.

Тийм учраас Төрийн байгуулалтын байнгын хороон дээр энэ саналуудыг дэмжсэнд гишүүдэд талархаж байгаа.

Д.Амарбаясгалан: Очирбатын Амгаланбаатар гишүүн асуулт асууя.

О.Амгаланбаатар: Та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе.

Энэ “Боомтын шинэчлэл” тээвэр, ложистикийн 3.3.2.8-д “Наран Сэвстэйн боомтыг сэргээж, нээнэ” гэсэн ийм заалт байна.

Тэгээд энэ дээр одоо мэдээж энэ боомтыг нээхэд Алтай хот хүртэл засмал зам тавьж таарна.

Тэгэхээр үүнийг яаж оруулах юм? Санал хураалгахдаа гэдэг юм уу, энэ дээр тэр засмал замынх нь асуудлыг нэмж санал хураалгах юм уу? Энэ дээр Их Хурлын дарга анхаармаар юм шиг байна. Энэ зам тавигдахгүйгээр энэ боомт нээгдэхгүй

Тийм учраас үүнийг оруулмаар юм шиг байна гэж хэлэх байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, нэг асуух зүйл байна. “Их Хурлын гишүүн бол ард түмний элч төлөөлөгч” гээд байгаа юм.

Тэгэхээр монголчууд ярьдаг. “Хэлэх үг элчийн аманд” гээд.

Тэгэхээр Их Хурлын гишүүд бол ард түмний хэлэх үгийг дамжуулж байгаа. Одоо тэр бүгдийнхээ төлөөлөл.

Тийм учраас би бас энэ хөдөөгийн ард иргэд маань, ялангуяа малчид маань бид нарын малын гаралтай түүхий эдийг үнэтэй болгож өгөөч ээ л гэж хүсэлт тавиад байгаа юм.

Малын гаралтай түүхий эдийг үнэтэй болгож өгөөч ээ, бид нарын орлогыг нэмэгдүүлж өгөөч ээ л гэж гол хүсэлт маань тэр.

Түүнээс биш бид зээл авъя гэдэг хүсэлт бол нэгдүгээрх асуудал нь биш.

Би Байнгын хорооны хурал дээр Ж.Энхбаяр сайдад хэлсэн.

Өнгөрсөн 20 жилийнхээ энэ хөдөө орон нутагт хэрэгжсэн бүх төсөл, зээл, энэ хоршоодод өгсөн мөнгөн дээрээ нэг үнэлгээ хийгээдхээч ээ гэж хүсэлт тавьсан байгаа. Энэ үнэлгээ хэзээ хийж дуусах вэ гэдгийг бол асууя. Хийгдсэн бол ямархуу хэмжээний юм байна вэ?

Говь-Алтай аймгийн хувьд. Энэ амьдрал мэддэг хүний хувьд та хэдэд, бас энэ гишүүдэд хэлэхэд Говь-Алтай аймагт 2009-2012 онд яг өнөөдрийн энэ хоршоонд өгч байгаа зээл шиг ийм зүйл Говь-Алтайд хэрэгжсэн.

Энэ хугацаанд 65 иргэнд нийтдээ 1.1 тэрбум төгрөгийн зээл олгогдсон байдаг юм. 15, 20 сая гэх зэргээр.

Энэ бол мөн л одоо ингээд өнөөдрийн энэ хэрэгжиж байгааг 12 жилийн өмнө хэрэгжүүлж байсан гэсэн үг. Бараг 13 жилийн өмнө.

Энэ маань өнөөдөр Говь-Алтай аймгийн төсөв бүрдүүлэх хамгийн асуудал болчихдог. Нөгөө хүмүүс нь мөнгөө буцааж төлөөгүй. Говь-Алтай аймгаар нийтдээ 40 гаруй иргэн шүүхийн шатад энэ мөнгийг төлөхгүй. Аймгийн Засаг даргын үүдэн дээр нөгөөдүүл нь очерлочихсон сууж байдаг. Үгүй ээ, энэ зээлээ төлөхгүй байна. Хойшлуулж өгөөч ээ. Та нэг бичиг хийгээд өгчхөөч ээ гэдэг ийм асуудлууд байж байдаг юм.

Тэгэхээр өнөөдөр яг 5 жилийн дараа Монголын бүх малчдад ийм асуудал үүсэх гээд байгаа юм.

Одоо Монголын ард түмэн бүгдээрээ л энэ интернэт орчинд ярьдаг шүү дээ. Үгүй ээ, энэ дээгүүрээ бүгд хуваагаад идээд байна. Та нар энэ ЖДҮ-ээс, энэ боловсролын сангаас, тэр шинжлэх ухааны сангаас бүгдээрээ аваад

идчихлээ гээд ингээд байхаар нь хэдүүлээ бүгдээрээ хуваагаад аваад идчихсэн шүү дээ гэж хэлээд та нар нэг ч үйлдвэр барихгүйгээр зээл өгөөд зээлийн ахуйд хөдөөгийн ард иргэдийг оруулах гээд байна.

Хөдөөгийн ард иргэд үйлдвэр бариад өгөөч ээ. Бид нарын малын гаралтай түүхий эдийг үнэтэй болгоод өгөөч ээ л гэж хүсэлт тавьж байгаа болохоос биш бид 50.0 сая төгрөг авъя гэж нэг нь ч хүсэлт тавихгүй байгаа юм.

Тийм учраас энэ шинэ хоршооныхоо бодлогыг үйлдвэр барих тал руу оруулахгүй бол 9 үндсэн өрх нийлээд 450.0 сая төгрөг аваад, 450.0 сая төгрөгөөр баригддаг үйлдвэр гэж хэзээ ч байхгүй.

Энэ бол ард иргэдийг 5 жилийн дараа бүгдээрээ өрний хавханд оруулаад. Одоо миний энэ гар дээр бүх энэ Говь-Алтай аймгийн аудитын дүгнэлт, шүүхийн шийдвэрүүд байж байна.

Тэгэхээр 5 жилийн дараа Монголын энэ 200 гаруй малчин ард иргэд бүгдээрээ өрний хавханд орох гээд ийм зүйл рүү ингэж түлхэж болохгүй. Ийм учраас үүн дээрээ та хэд маань энэ үйлдвэртэй холбох юмнуудаа. Тэр З.Мэндсайханы тэр “Цагаан алт” хөтөлбөртэй, яаж бүгдээрээ нийлж томоохон хэмжээний үйлдвэр бий болох вэ гэдэг тал дээр Хөдөө аж ахуйн яам бодлогоо чиглүүлж явахгүй бол болохгүй нь гэж хэлэх байна.

Д.Амарбаясгалан: Маш олон зүйл хольж хутгаж ойлгоод асуугаад байх шиг байна.

Хүнс, хөдөө аж ахуйн сайд ялгаа заагийг нь гаргаж зөв тайлбарлаж өгөх нь зөв байх. Хариулт өгье.

Ж.Энхбаяр: О.Амгаланбаатар гишүүний асуултад хариулъя.

Энэ малчдаа хоршоолуулах нь өөрөө малын түүхий эдийг үнэтэй болгох гол бодлогын суурь нь байгаа юм. Хоршсон малчин үйлдвэртэйгээ хэрхэн холбох вэ. Хоршсон малчин өөрөө үйлдвэрлэлийн анхан шатны түүхий эдийг гол бэлтгэх анхны нэгж нь байгаа юм.

Тэгэхээр энэ малчдаа бид эдийн засгийн харилцаанд оруулъя. Эдийн засгийнх нь боловсролыг нэлээн сайжруулах, сургах, бэлтгэх гээд энэ зээл маань өөрөө 14 төрлийн чиглэлээр олгогдож байгаа.

Нэгдүгээрт, малчид маань хоршоод энэ авсан эх үүсвэрээрээ малаа чанаржуулна, малынхаа тэжээлийг тарьдаг болно, хадан тэжээлээ хамтдаа авдаг болох, малаа эрүүлжүүлэх, мал угаалга, мал эрүүлжүүлэх ажлуудаа хамтраад хийдэг гэх мэтийн нөгөө үйлдвэрлэлд нийлүүлдэг түүхий эдийнхээ гарцыг сайжруулах, чанарыг сайжруулах, тэгээд зохион байгуулалтынхаа ийм анхны нэгжээ бий болгож байгаа нь өөрөө цаашид хөдөө аж ахуйн биржтэйгээ холбогдох, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлтэйгээ холбогдох ийм гол бололцоог л нээж байгаа юм.

Мэдээж зөвхөн малчиддаа анхаараад байгаа юм биш шүү дээ. Малчдаа анхан шатаа бэлдье, хоршоожуулъя. Нөгөө талд нь энэ “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд энэ арьс шир, ноос, ноолуурынхаа салбарын

үйлдвэрүүдээ босгоод ирье гэдэг л хоёр том бодлого зэрэг явж байгаа юм.

Тэгэхээр хэрэгжээд дөнгөж хэдхэн сар өнгөрч байна. Мониторинг хийх болоогүй. Жилийн эцсээр гарна.

Эхний санхүүжилт 500.0 тэрбум төгрөгийн ажил. Малчид маань маш талархалтайгаар, зохион байгуулалттайгаар идэвхтэй хамрагдаж байна. Дахин шинэ эх үүсвэрийг нэмж байна. Зэрэгцээд хөнгөн үйлдвэрээ босгох бодлогууд нь орж ирж байна. “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд.

Ингээд энэ чинь цогц явж байгаа ажил шүү дээ. Малчин хөнгөн үйлдвэр хоёрын холбоос.

Тэгээд оны эцэс гэхэд нэгдсэн үр дүнгүүдийг, эхний үр дүнгүүдийг танилцуулах бололцоо үүснэ.

Д.Амарбаясгалан: Очирбатын Амгаланбаатар гишүүн тодруулга.

О.Амгаланбаатар: Тэгээд Ж.Энхбаяр сайд ер нь итгэлтэй байгаа юм байна.

Тэгээд 4 жилийн дараа малын гаралтай түүхий эд буюу нөгөө хонины нэхий жалганд хаягдахгүй ээ, асуудалгүй ээ, мал махны үнэ нэмэгдэнэ ээ, арьс шир үнэгүйдлээс гаргаж чадна аа гэдэгтээ итгэлтэй байгаа юм байна гэж ойлголоо.

Тэгээд Та бүгд маань энэ хөтөлбөрөө үр дүнтэй хэрэгжүүлээрэй. Битгий ард түмнийг ингээд 20 жил хуурсан шигээ дахиад хуураарай гэж л хэлье дээ.

Та хэдийн ам ажлын зөрүүгээ арилгахгүй бол яг үнэндээ хэлэхэд энэ

худлаа амлаад юу ч хийдэггүй энэ зүйлээс чинь болоод ард түмэн туйлдаад дууссан.

Сүүлийн 8 жил лав Говь-Алтай аймгийнхан сум болгон засмал замтай болно гэж бараг ирсэн гишүүн болгонд нь сүү өргөсөөр байгаад одоо нэг ч сум нь засмал замгүй л ингээд 8 жил болчихсон байгаатай адилхан ингээд утаа болоод арилав гэж л хэлье дээ.

Д.Амарбаясгалан:

Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд:

Мөрийн хөтөлбөрт олон боомтын ангиллын дээшлүүлж эдийн засгийг дэмжихээр тусгасан байна.

Тэгэхээр энэ олон боомтуудаар орж ирж байгаа импортын хүнсний барааны аюулгүй байдлыг шинжилдэг лабораториудын асуудлыг ер нь яаж тусгаж байгаа вэ гэдэг нэг ийм асуулт байгаад байна. Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт, нийгмийн даатгалын хуримтлалын санг иргэн бүрт бүрдүүлж бий болгож байгаа. Одоогийн байдлаар бид нийгмийн даатгалынхаа орлогыг тухайн жилдээ зарлагадаад явж байгаа юм.

Тэгэхээр ирэх 4 жилийн хугацаанд жилийн нийгмийн даатгалын зарлагын хэдэн хувийг ер нь энэ хуримтлалын сангаар бүрдүүлэхээр тооцоолж байна вэ? Ямар нэгэн зорилт байна уу гэж хоёрдугаар асуултыг асуумаар байна.

Мөн мөрийн хөтөлбөрт боловсролтой холбоотойгоор их дээд сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор сургууль,

хотхонуудыг байгуулна гээд тусгасан байна.

Гэтэл Дорнод аймагт Монгол Улсын Их Сургуулийн хотхоны техник, эдийн засгийн үндэслэл нь хийгдчихсэн, газрын зөвшөөрөл, бүх асуудлууд нь шийдэгдчихсэн ийм төсөл байдаг юм билээ. Энэ асуудал энэ мөрийн хөтөлбөрийн хугацаанд хэрэгжих үү гэж Боловсролын сайдаас асуумаар байна.

Дөрөвдүгээр асуудал. Хувийн секторынхны гол бэрхшээл юу байна вэ гэхээр мэргэшсэн ажиллах хүчин олдохгүй байна гэдэг асуудал яригдаж байгаа. Гэтэл аймаг бүрт насан туршийн боловсролын төвүүд байдаг юм байна.

Тэгэхээр хэрвээ энэ хувийн сектор “Насан туршийн суралцахуйн төв”-тэй хамтраад хүмүүсийг дахин мэргэшүүлэх ажлуудыг сайн зохион байгуулж чадвал бас энэ ажиллах хүчний асуудлыг шийдвэрлэх боломжтой юм болов уу? Энэ тал дээр Боловсролын сайд маань юу бодож байдаг юм болоо? Ялангуяа энэ аймгийн энэ “Насан туршийн энэ суралцахуйн төв” нь өөрөө төсвийн хувьд нэлээн хязгаарлагдмал, дэд бүтцийн хангамж муутай байгууллага байдаг юм билээ.

Тэгээд Барилга, хот байгуулалттай холбоотойгоор 3.4.3 дээр эрчим хүч, ус, бохирын хувьд бие даасан байгальд ээлтэй зөөврийн орон сууцны технологийг судална гээд заачихсан байх юм.

Энэ орон сууц гэхээсээ илүүтэй амины орон сууцны технологийн судалгааг хийгээд тэгээд жишиг загварын жагсаалт гаргаж иргэддээ хүргэх тал руу нь илүү ажиллах нь зөв юм биш үү гэж

Барилга, хот байгуулалтын сайдаас асуумаар байна.

Хөтөлбөрийн 4.4.2 дээр эдийн засгийн хамтын ажиллагааны бүсүүдийг хөрш орны төлөвлөлттэй уялдуулна гэж заажээ. Энд аль аль бүсийн тухай яригдаж байна вэ гэж ийм асуултуудыг асуумаар байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Боловсролын сайд П.Наранбаяр сайд хариулт өгье.

П.Наранбаяр: Баярлалаа.

Тэгэхээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.4 дээр төрийн өмчийн зарим их сургууль, политехник коллежийг түшиглэн техникийн болон дээд боловсролын шаталсан тогтолцоо бүхий сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор их сургууль, төрөлжсөн коллежийг бүсүүдэд хотхон хэлбэрээр хөгжүүлнэ гээд заачихсан.

Тэгэхээрээ бүх бүсүүд орчихсон учраас Дорнодын зүүн бүсэд байгуулагдана гэж ойлгож болно.

Насан туршийн энэ боловсролын асуудал. Ялангуяа манай мөрийн үйл ажиллагааны хөтөлбөрийн тэр юун дээр байгаа. Эдийн засгийн 2.2.6 дээр туссан энэ хэлбэрээрээ байгаа. Өөрөөр хэлэх юм бол хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн иргэдийг ажиллангаа суралцах, суралцангаа хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэн хосмог ажлын байрны сургалтыг бүрэн нэвтрүүлнэ гэсэн ийм байдлаар орсон. Үүнийг хэрэгжүүлнэ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хот байгуулалт, барилга, орон

сууцжуулалтын сайд Ж.Батсуурь хариулъя.

Ж.Батсуурь: Гурван намын мөрийн хөтөлбөрт

- ▶ Монгол Ардын намын мөрийн хөтөлбөрт “100 мянган айлын орон сууц”,
- ▶ Ардчилсан намын мөрийн хөтөлбөрт “105 мянган айл”,
- ▶ ХҮН намын мөрийн хөтөлбөрт бас “Орон сууцын чанар, төрлийг сайжруулна” гэж орсон байгаа.

Үүнтэй холбогдуулаад бид “дагуул хот”, “шинэ хотууд” гэж том орон сууцууд явж байгаагаас гадна Монгол Улс маш том газар нутагтай.

Тийм учраас сумдын айлын амьдралын түвшин, аймгийн амьдарч байгаа Улаанбаатарт орж байгаа хүмүүсийн амьдралын түвшин, чанарыг л ойртуулна гэж ингэж үзэж байгаа юм.

Тийм учраас хашаандаа сайхан амьдрах гэхээр хашаанд сайхан амьдарна гэдэг бол өөрөө халаалт дулаантай, ариутгах татуургатай. Дээр нь ажлын байр нь нэмэлттэй байгаа юм. Нийтийн орон сууцад амьдрахад зүгээр л өөрөө боловсон.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя.

Ж.Батсуурь: Тийм учраас бид бүхэн сум, аймагт байгаа амины орон сууцад халаалт дулаан оруулах асуудал. Мөн тэнд дулааны хэмнэлттэй орон сууцуудыг барих. Мөн энэ пассив хаус

гээд орчин цагийн технологийн шаардлага хангасан орон сууцуудад хөнгөлөлт өгөх. Мөн тэрийг зээлийн болон хөнгөлөлттэй зээлээр дэмжих ийм хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэж үзэж байгаа.

Д.Амарбаясгалан:

Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд хариулт өгье.

Л.Энх-Амгалан: Их Хурлын дарга минут сунгаад өгөх үү? Ганц минутад хариулах жаахан хүндрэлтэй байна.

Д.Амарбаясгалан: 2 минут өглөө.

Л.Энх-Амгалан: Тэгэхээр их том асуудал хөндөж Л.Соронзонболд гишүүн тавьсан учраас.

Ер нь бид нийгмийн даатгалынхаа сан, нийгмийн даатгалыг дагасан энэ 4 сангийнхаа асуудлыг тогтолцооны хувьд эргэж харахгүй бол улс төржсөн шийдвэр гараад нийгмийн даатгалын сан дээр ямар хохирол учруулсан бэ гэдэг нэг тооцоо судалгаагаа би Их Хуралд танилцуулъя гэж бодож байгаа.

Одоо энэ тэтгэврийн насыг нөхөн тооцсон шийдвэрээс гарсан, малчдын насыг, тэтгэврийн насыг наашлуулснаас болсон. 7 жилийг 5 жил болсноос үүссэн нийгмийн даатгалын сан дээр үүсэж байгаа энэ ачааллыг бид зайлшгүйгээр засаж залруулах ёстой.

Одоо ирэх жилээс авхуулаад манай нийгмийн даатгалын сан чинь бараг үндсэндээ алдагдал нь 2 их наяд төгрөгийн алдагдал хүлээх ийм бодитой эрсдэл бид нарын өмнө нүүрлэхээд байна шүү дээ.

Тэгэхээр нийгмийн даатгалын мөнгө бид нарын төсвийн мөнгө биш. Энэ бол одоо яг нийгмийн даатгуулагчдын төлж байгаа мөнгө учраас энэ санд эрсдэл үүсэх, аливаа тийм улс төрийн ийм эрсдэлтэй шийдвэрийг би дахиж ерөөсөө гаргаж болохгүй гэж бодож байгаа.

Тийм ч учраас Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр энэ дээр бас нэлээн томоохон ийм тогтолцооны шинж чанартай заалтууд орсон.

Тэгэхээр мэдээж энэ жилээс авхуулаад нийгмийн даатгалын багц хуулиар иргэдийн даатгуулагчдын дансанд 2 хувь даатгуулагч, ажил олгогчдын төлж байгаа шимтгэлийн 2 хувийг бид байршуулж байгаа. Удахгүй бид иргэддээ бас үүнийг зарлана.

Таны дансан дээр хэдэн төгрөгийн үлдэгдэл байна вэ гэдэг. Энэ жилээс эхэлж энэ хуримтлал үүсэж байна.

Тэгэхээр одоо энэ оны төгсгөлөөр даатгалын тэтгэврийн нөөц сан гэж хэлье дээ. Энэ дээр 240 орчим тэрбум төгрөг төвлөрөх ийм санхүүгийн бололцоо гарч ирж байна.

2028 онд энэ сан үндсэндээ 2 их наядын бас ийм нөөц сантай болох ийм сан байгаа.

Тэгэхээр хуримтлалын санг бид давхар байгуулсан. Ингээд хуримтлалын сангийн санхүүжилт, тэтгэврийн сангийн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж 1 минут. Гүйцээж хариулья.

Л.Энх-Амгалан: Тэгэхээр хуримтлалын сангийн эх үүсвэр байгалийн баялгаас иргэддээ нэрийн дансанд нь байршуулах, эрүүл мэнд, боловсрол, орон сууцын чиглэлээр зарцуулах том бодлогууд хэрэгжинэ.

Засгийн газрын хамгийн том хэрэгжүүлэх бодлого бол энэ орон сууцын бодлого.

Тийм учраас орон сууцын бодлогыг бид яг гэр бүлд суурилсан, гэр бүлийн өрхөд суурилсан, иргэдэд зориулсан яг ямар гэр бүлийн ямар орон сууцын бүтээгдэхүүнүүд гаргах юм, тэрийг яг ямар санхүүжилтийн тогтолцоогоор хийх вэ вэ гэдгийг илүү хуримтлалын сан, тэтгэврийн нэрийн дансан дээр хуримтлагдсан энэ сангаар хийх санхүүжилтийн том тогтолцооны асуудлуудыг бид хийхээр төлөвлөж байгаа гэдгийг би онцолж хэлье гэж бодож байна.

Ер нь тэгээд нийгмийн даатгалыг дагасан ажилгүйдлийн даатгал, ингээд үйлдвэрлэлийн ослын даатгал гээд цаг үеэсээ хоцорчихсон даатгалын тогтолцоонуудтай байна. Өнгөрсөн 30 жил хоцорсон тогтолцоотой явсан байна.

Тийм учраас бид энэ ажил олгогч нарт илүү ээлтэй, даатгал төлж байгаа хүмүүстээ илүү ээлтэй даатгалын ийм тогтолцоонуудыг л.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Б.Тулга сайд. Боомтын сайд нэмж хариулья.

Б.Тулга: Та бүгдийн энэ өдрийн амар амгаланг эрье. Л.Соронзонболд гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр Монгол Улсын боомтуудаар яг импортолж байгаа

хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, лабораторийн чиглэлээр асууж байна.

Тэгэхээр өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа нийтдээ Монгол Улсын хэмжээнд 6 лаборатори ажиллаж байгаа. Энэ 6 лаборатори дээр нэмээд Боомтын цогцолборыг энэ ондоо ашиглалтад оруулж байгаа 3 боомт дээр бүтээн байгуулалтын ажил явж байгаа.

Тэгэхээр энд бас нэмэгдэж энэ 3 дээр орно гэсэн үг.

Ер нь бид энэ боомтын цогцолборын бүтээн байгуулалтыг хийхдээ хүнсний бүтээгдэхүүн, мөн барилгын материалын лабораторийг цогцолбор дотор нь шингээж тусгаж дандаа хийж байгаа.

Тэгэхээр шинээр баригдаж байгаа бүх боомтууд дээр бараа материал, хүнсний бүтээгдэхүүний лабораториуд давхар ашиглалтад ороод явна гэдгийг энд хариулмаар байна.

О.Амгаланбаатар гишүүн бас өмнө нь асуусан. Энэ Наран Сэвстэйн боомтыг нээх заалтыг оруулсан гээд.

Тэгэхээр боомтуудыг нээхдээ бүс нутгийн “Таван цагариг”.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут өгье. Нэмж хариулъя.

Б.Тулга: Бүс нутгийн “Таван цагариг” зорилт. Энэ хүрээндээ боомтуудыг холбож байж боомтын цогцолборыг, боомтыг нээх асуудлыг давхар уялдуулж шийдэж байгаа гэдгийг энэ ташрамд хэлье.

Тэгэхээр Наран Сэвстэйн боомтын эрх зүйн орчныг тодорхой болгож

нээгээд замыг үүнтэй цуг шийдэж явна гэдгийг хэлмээр байна.

Өмнө Н.Наранбаатар гишүүн асуусан.

Ер нь энэ боомтын эрх зүйн орчин, Хилийн тухай хуульд явж байгаа нэг заалтаар, нэг бүлгээр явж байгааг цаашид бие даасан хуультай болгох. Энэ хүрээндээ боомтуудын газрын менежмент, төслүүдийн хөрөнгө оруулалт, боомтыг цаашдаа эдийн засгийн хөдөлгүүр болгох энэ чиглэлд нь эрх зүйн шинэчлэл хийх шаардлага байгаа.

Үүнийг Улсын Их Хурал руу өргөн барихаар бид бэлдэж байгаа гэдгийг энэ ташрамд хэлье.

Д.Амарбаясгалан: Мөнхтөрийн Нарантуяа.

Л.Соронзонболд гишүүн.
Тодруулга 1 минут.

Л.Соронзонболд: Боловсролын сайдаас тодруулах гэсэн юм. Энэ нөгөө “Насан туршийн суралцахуйн төв” маань өөрөө ингээд төсөв их багатай, хангамж багатай ийм байгууллага байдаг юм билээ. Гэтэл зорилго нь аягүй том байгаад байдаг.

Тэгэхээр энэ талаар ямар ажил хийх гэж байгаа вэ гэж асуусан.

Нөгөө талаар эдийн засгийн хамтын ажиллагааны бүсүүдийг хөрш орны төлөвлөлттэй уялдуулна гэж заасан байна. Энэ ямар бүсийн тухай ярьж байна вэ гэж асуусан.

Д.Амарбаясгал: Нэмж хариулъя. П.Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Насан туршийн боловсролын асуудал үнэхээрийн манай яаман дээр өнөөдөр хэлтэс нь байгуулагдсан. Шинээр ажил юмнуудаа жигдэлж байгаа.

Тэгэхээр насан туршийн боловсролын асуудал дээр төсөв мөнгийг нь нэмэх асуудал дээр анхаарч ажиллая.

Хөрш орнуудтай харилцах бүс гэсэн үү. Дахин та тэрийгээ тодруулаад яаж болох уу?

Бид энэ 4 жилд энэ насан туршийн боловсрол дээр хамтын санхүүжилтийг бий болгохоор энэ арга хэмжээг тусгачихсан байгаа.

Д.Амарбаясгалан: Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр хариулна. Нэмж.

Л.Гантөмөр: Тийм. Эдийн засаг эдийн засгийн хамтын ажиллагааны бүсүүдийг хөрш орнуудын төлөвлөлттэй харилцан уялдуулна гэж байгаа юм.

Эрээний хил, Замын-Үүдийг хэлж байгаа юм.

Тэгээд өнгөрсөн жилийн 4 сард Эрээн-Замын-Үүдийн чөлөөт бүсийн төлөвлөлтийг нь хамтад нь хийе гэдэг шийдвэрийг Хятадын тал гаргачихсан. Манай тал ч гэсэн энэ дээр ажиллаж байгаа.

Ер нь дундын худалдааны бүсийг бид хөгжүүлж чадсанаар яг бодитойгоор боомт маань босож ирэх юм билээ. Тэгэхгүй бол одоо ямар асуудал үүсэж байгаа вэ гэхээр Эрээн талаас бид зөвхөн

Орос руу явдаг ачааг л зөөдөг ийм л боомт болж хувирах нь байна шүү.

Яг хоёр улсын хоорондын худалдаа нэвтрэлт дээрээ анхаарахгүй бол энэ нэвтрэлт чинь яваандаа байхгүй болох нь байна шүү гэдэг ийм зүйл хөндөгддөг юм билээ.

Тийм учраас энэ төлөвлөлтийг Замын-Үүд дээр хийж байгаа гэж ингэж ойлгоорой.

Д.Амарбаясгалан: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуултаа асууна.

М.Нарантуяа-Нара: Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе.

Хүний хөгжлийн бодлого гээд 2 дугаар хэсэгт заасан байгаа. 2.1.1.9 дээр. Цалинтай эцэг, эх нийгмийн хамгааллын бодлогыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгоно гээд заасан байгаа.

Энэ дээр ээжүүдийн хамрах хүрээг хэдээс хэдэн насны хүүхэдтэй ээжүүдийг гэж зааж оруулсан байгаа вэ? Жишээлбэл, хүүхэдтэй ээж, аавууд насан туршдаа л ээж, аав байдаг. Тийм ээ.

Тэгэхээр энд “цалинтай эцэг, эх” гээд оруулсан байна. Үүнийг тодруулмаар байна.

Дээрээс нь олон улсын жишигт нийцүүлнэ гээд заачихсан байна. Жишээлбэл, миний амьдарч байсан Япон Улсад “цалинтай ээж”-ийн дүн бол тухайн хүний цалингийн 67.0 хувьтай тэнцэхүйц ийм дүн байдаг.

Жишээлбэл, 3 сая төгрөгийн цалинтай хүн бол 67.0 хувь гэхээр 2 сая төгрөгийн цалинтай ээжийн цалин авдаг байх нь.

Манай Монголд одоо ингээд 2024 оны 5 дугаар сарын 01-нээс авхуулаад хөдөлмөр хөлсний доод хэмжээг 660.0 мянган төгрөгөөр шинэчлээд тогтоочихсон байна. Үүнтэй дүйцүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн байгаа юу?

Дээрээс нь “цалинтай эцэг” гэж яг ямар хүнийг оруулсан бэ? Өрх толгойлсон эцэг юм уу? Эсвэл гэр бүлийн нялх хүүхэдтэй бас эцэг хүнийг давхар оруулсан байна уу гэдэг дээр тодруулмаар байна.

Хоёрдугаарт, нь эрүүл мэндтэй холбоотой.

Ер нь энэ хөтөлбөр дээр хүүхдийн эрүүл мэндтэй холбоотой асуудлыг ерөөсөө нарийвчлан шигтгэж өгөөгүй байна. Эрүүл мэнд гэсэн хэсэг дээр ч алга байна. Хүний хөгжлийн бодлого дээр ч эрүүл мэнд алга байна.

Хүүхдийн хамгийн нэгдүгээр чухал зүйл бол эрүүл мэнд.

Эрүүл байж сурах, хөгжих, хамгаалуулах дараа дараагийн хэрэгцээ шаардлага үүсдэг.

Эрүүл мэндийн яамны сайд хэлэхдээ 4-өөс 5 жилийн хугацаанд бид зорилт тавиад эх орондоо эмчилж чадахгүй хүүхдүүдийн асуудлыг эмчилдэг болгох ийм зорилт тавин ажиллана гэсэн.

Тэгвэл энэ 4-өөс 5 жилийн хугацаанд эмчлэгдэх боломжгүй байгаа, өнөөдөр гадаад улсад гэхэд олон нийтээсээ хандив гуйгаад байж байгаа 10 гаруй хүүхдүүд байж байна.

Эдгээр хүүхдүүдийн асуудлыг 4-өөс 5 жилийн хугацаанд яаж шийдэх вэ? Хүүхдээ наад захын эрүүл мэндээр хамгаалж чадахгүй. Ингээд төсөв дээр маш олон төрлийн хэчнээн их наяд төгрөг барилга, байгууламжид яваад байгаа юм. Бүр гаргахад маш ээдрээтэй.

Тэгсэн мөртөө яг өнөөдөр монгол хүүхдүүд эмнэлэг дээрээ очерлоод. Нөгөө Эх, хүүхдийн үндэсний төв чинь очер нь буцлаад эхэлчихсэн ийм төрх байдалтай байгаа.

Тэгээд үүн дээр ямар арга хэмжээ авах юм бэ?

Ингээд нөгөө “Хүүхдийн төлөө сан” гээд байгаа. Энэ “Хүүхдийн төлөө сан”-д 18.0 тэрбум төгрөг цуглачихсан байна гээд байдаг.

Энэ “Хүүхдийн төлөө сан”-гийн зарцуулах тухай хууль нь Засгийн газрын тусгай сангаар тогтоогдчихсон байдаг. Тэгсэн мөртөө энэ нь нөгөө хуулиасаа давсан журмаар нийтдээ 8 бүлэг, 89 зүйл бүхий журмаар хязгаарлагдчихсан.

Энд уг нь өөрөө хүүхэд, хүүхдийн хөгжил, хүүхэд хамгаалал, оролцоог дэмжих зориулалттай гэхихсэн. Хүүхэд хамгаалалд хамгийн түрүүнд хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах асуудал багтана гэж би хувьдаа ойлгоод байна.

Тэгэхээр энэ асуудлыг яах вэ? Эдгээр дээр хариулт авмаар байна.

Д.Амарбаясгалан: Хариулъя. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд. Цалинтай ээж хөтөлбөрийн талаар.

Л.Энх-Амгалан: Одоо бид М.Нарантуяа-Нара гишүүн ээ, түрүүн бид

Байнгын хороон дээрээ нэлээн сайн ярьсан.

Ерөнхийдөө бид яагаад энэ гэр бүлийн яамыг байгуулсан юм бэ гэдэг асуудал байгаа юм.

Энэ Засгийн газар томоохон бодлогын нэг бол хүний хөгжлийн бодлого байна.

Хүний хөгжлийн бодлогыг бид хэрэгжүүлэхдээ өмнө гарсан нэг ийм хавтгайрсан халамж, нийгмийн хамгааллын үр дүнгүй том бодлогуудаа бас нэг цэгцлэх ёстой юм байна гэж харж байгаа.

Тэгэхээр цалинтай ээж ч гэсэн бараг яг цагаа тулбал хавтгайрсан халамжийн бас нэг хэлбэр шүү дээ.

Яг өнөөдөр эзнээ олсон одоо 1 хүүхэдтэй ээжийн асуудал, 2 хүүхэдтэй ээжийн асуудал, 3 хүүхэдтэй ээжийн асуудал, 5 хүүхэдтэй ээжийн асуудал, гэр бүлийн асуудал гээд их өөр өөр байдаг.

Бусад улсуудад Та Японы жишээ хандаж ярьж байх шиг байна. Бусад улсуудын ер нь энэ нийгмийн хамгааллын бодлогууд дандаа нөхцөлтэй байдаг юм байна. Дандаа нөхцөлтэй байдаг.

Тийм учраас одоо бид энэ эмийн хөнгөлөлт өгвөл бүх ахмадуудад өгчихдөг, цалинтай ээж гэвэл бүх ээж нарт өгчихдөг гээд. Гэх мэтчилнээр энэ асуудлуудыг энэ тогтолцооны гажуудлуудаа бид нэг эргэж засах ийм зайлшгүй шаардлага байгаа юм.

Одоо цаашдаа ч гэсэн бид энэ цалинтай ээжийг яг хэнд өгөх юм, хэдэн хүүхэдтэй хүнд өгөх юм, ямар хэлбэрээр

өгөх юм, хэзээ өгөх юм, зориулалт нь яг юу байх юм бэ гэдэг асуудлуудыг ч гэсэн ойрын хугацаанд бид их тодорхой болгоёл гэж харж байгаа.

Одоо жишээ нь түрүүн Та асуугаад байх шиг байна. Ээж, аав хоёрт нь зэрэг өгөх юм уу гэж. Үгүй. Энэ бол төрсөн ээжүүдэд хүүхдээ харахад нь өгдөг тэтгэлэг.

Нөгөө талаасаа нөгөө өрх толгойлсон эцгүүд байгаа шүү дээ. Тэр эцгүүдэд өгч байгаа ийм тэтгэлгүүд байгаа юм.

Өчигдөр Туркийн гэр бүлийн сайдтай уулзлаа. Турк ч гэсэн энэ гэр бүлийн бодлогуудыг явуулахад тухайн гэр бүл яг ямар онцлогтой гэр бүл байна. Гишүүд нь яг хэдэн гишүүдтэй байдаг юм. Тэр гишүүдийнх нь эрэлт хэрэгцээ, хөгжлийн асуудлууд нь яг юу байдаг юм бэ гэдгийгээ тодорхойлж байж нийгмийн үйлчилгээнүүдээ явуулдаг юм.

Одоо цөмөөрөө цаашаа нийгмийн халамж гэж ярихаа больё. Халамжийг цөмөөрөө зогсооё. Тийм ээ.

Тийм учраас цаашдаа бид яг иргэн хүний гэр бүлд суурилсан, гэр бүлийн эрэлт хэрэгцээн дээр суурилсан ийм л хүн рүүгээ чиглэсэн нийгмийн хамгааллын бодлого буюу нийгмийн үйлчилгээнийхээ тогтолцоонуудыг бий болгож тарифжуулах. **Нэгдүгээрт.**

Хоёрдугаарт, санхүүжилтийн асуудал руу нь хийх.

Гуравдугаарт, тэр хүртээмжийн тогтолцоог хийх ийм зүйл рүүгээ л бид ер нь анхаарлаа хандуулах нь зүйтэй юм байна л гэж харж байгаа шүү дээ. М.Нарантуяа-Нара гишүүн ээ. Тийм.

Д.Амарбаясгалан: Тогтмолын Мөнхсайхан сайд нэмж хариулъя. Эрүүл мэндийн сайд.

Т.Мөнхсайхан: М.Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр яг бүгдийг нь хүүхэд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд гээд салгаад оруулах юм бол энэ жоохон утгагүй зүйл болно.

Тийм учраас энэ дээр Монгол Улсад оношлогдох, эмчлэгдэх боломжгүй өвчнийг богино хугацаанд технологийг нэвтрүүлж, хүний нөөцийг сургаж эмчилдэг болгоно гэдэг өргөн агуулгаараа орчихсон байж байгаа.

Энэ маань цаашаа задраад явахаараа хүүхэд, эмэгтэйчүүд гээд тус бүрдээ задраад явна.

Гэхдээ өнөөдрийн нөхцөл байдалд бид өмнө нь гадагшаа яваад эмчлүүлээд ирсэн хүүхдүүдийн 5 хувийг “Эрүүл мэндийн дэмжих сан”-гаас даадаг байсан бол өнөөдрийн байдлаар 50 хүртэлх хувийг “Эрүүл мэндийн дэмжих сан”-гаас даадаг энэ тогтолцоо бий болчихсон байгаа.

Гэхдээ энэ хугацаанд бид ер нь цаашдаа хүүхдүүдээ өвдсөнийх нь дараа гадагшаа яаж эмчлүүлэх вэ гэдэг бодлого баримтлах юм уу, хүүхдүүдээ яаж өвдүүлэхгүй байх вэ гэдэг бодлогыг баримталж жирэмсэн байхад эхийн хэвлийд байх.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя. 1 минут.

Т.Мөнхсайхан: Эхийн хэвлийд байхаас нь авхуулаад ээжид нь эрүүл мэндийн боловсрол олгох, дөнгөж төрсөн нярайд эрт илрүүлэг, скринингийг ямар түвшинд хийж хэрэгжүүлэх ёстой вэ гээд энэ бүх үйл ажиллагаанууд маань одоо хэрэгжээд эхэлж байгаа.

Тэгэхээр бид цаашдаа ер нь бодлогоо хүүхдүүдээ яаж өвдүүлэхгүй байх вэ гэдэг рүү чиглэсэн нэгдүгээрт бодлого явах ёстой.

Хоёрдугаарт, өвдсөн тохиолдолд хэрхэн яаж эрт илрүүлэх вэ гэдэг бодлого явах ёстой.

Гуравдугаарт, бид бүх төрлийн өвчнийг эх орондоо эмчилдэг энэ бодлого, үйл ажиллагаанууд руугаа онцгой анхаарах ёстой.

Энэ ч утгаараа бид ер нь гадагшаа явж эмчлүүлээд байгаа энэ 26 нэр төрлийн өвчнийг Монголдоо эмчилдэг болгох талаар 12 нэр төрлийн багийг нь бид энэ 9 сардаа багтаагаад явуулах төлөвлөгөө маань гарчихсан. 11 сард энэ шаардлагатай тоног, төхөөрөмжүүдийн нийлүүлэлтийг хийхээр энэ төлөвлөгөөнүүд маань гарчихсан.

Гэх мэтчилэн бидний ажил эхэлчихсэн. Богино хугацаанд Монголдоо бүх төрлийн тусламж, үйлчилгээг үзүүлдэг болох бодлого маань эхнээсээ биеллээ олоод эхэлчихсэн гэж ойлгож болно. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууна. Алга байна.

Болдын Уянга гишүүн асуултаа асууна.

Б.Уянга: Та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Надад нийт гурван асуулт байна. Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр.

Эхний асуултыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал сайдаас асууя.

Төрийн өмчийн үйл уурхайн компаниудын засаглал, үйл ажиллагааны цар хүрээний асуудлууд чухлаар тавигдсаар ирсэн.

Тэгээд энэ дээр 2024-2028 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр ямар ямар үйл ажиллагаа тусгагдсан байгаа вэ? Ер нь юуг баримталж байна вэ гэдэг дээр Н.Учрал сайдаас асууя.

Боловсролын сайд, П.Наранбаяр сайдаас хөтөлбөрийн 2.2-т “Эрдэм боловсролтой Монгол хүн” гэсэн хэсэгт байгаа.

Яг энэ агуулгаар хоёр асуултыг асуумаар байна.

Нэг нь, боловсролд бүх хүүхэд, залуучуудыг тэгш хамруулна гээд. Ер нь хөтөлбөрийг бүхэлд нь агуулгаар нь дэмжиж байгаа.

Гэхдээ албан боловсролын сургалтад хамрагдах боломжгүй тийм суралцагчид Монгол Улсад их байдаг. Тэгэхээр энд орсноор Боловсролын чөлөөт бүсийг байгуулна гэдгээр орсон байна.

Тэгэхээр “чөлөөт бүс” гэдэг нь яг хэрэгжиж байсан агуулга үргэлжлээд явж байна уу? Боловсролын яам бодлогынхоо хүрээнд чөлөөт бүсэд яг юу юуг хамруулах, ямар төлөвлөлтүүд

нарийвчилж тусах вэ? Дараа нь төлөвлөгөөнд. Үүнийг асуумаар байна.

Хоёрт нь, мэдлэг чадвартай мэргэжилтэн бэлдэнэ гэж байгаа юм.

Тэгэхээр бид Засгийн газрынхаа мөрийн хөтөлбөрт 14 мега аж үйлдвэржилтийн том том төслүүдийг оруулаад явсан.

Яах вэ, манайд инженерийн мэргэжлийг сонгож байгаа суралцагчид нэлээд буураад их удаж байна. Ер нь нэлээдгүй хэдэн жил болсон.

Тэгэхээр магадгүй энэ 14 мега төсөлтэй хамааралтайгаар Та энэ хөтөлбөрт тусгаснаар дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлтийн хувийг эрэлттэй нийцүүлнэ гэсэн агуулгадаа юу юуг ер нь хамруулж байна вэ?

Дараа нь Засгийн газрын яг нарийвчилсан төлөвлөгөөг гарахад ямар ажлуудыг төлөвлөж байна вэ? Ийм хоёр асуултыг танаас асууя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Н.Учрал сайд. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга.

Н.Учрал: Б.Уянга гишүүний асуултад хариулъя.

Төрийн бүтээмжийг өсгөнө гэдэг бол ер нь төрийн өмч хөрөнгийн үр ашгийг өсгөхөөс эхлэх юм билээ.

Яагаад гэхээр сая сүүлийн судалгааг харахад Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар нэг төрийн өмчит 99 компани, хуулийн этгээд байна гэсэн ийм статистик байна.

Гэтэл 99 компанийн нийт өмч бараг 64 их наядад хүрсэн. Энэ чинь бараг манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүнтэй дүйцэж очиж байгаа гэсэн үг.

Тэгэхээр улсаараа үйлдвэрлэсэн, худалдсан, үйлчилсэн бүх дүнтэй бараг зэрэгцэж очиж байна гэдэг бол төр их өмчтэй байна.

Тэгээд өмчтэй байгаа мөртөө үүний чинь ерөөсөө Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэт үйлдвэрийг хасаад тооцох юм бол бараг 96 компанийнх нь хөрөнгийн өгөөж нь 0.4 хувьтай.

Ийм байдалтайгаар цаашдаа төр өөрийнхөө өмчийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нь нэмэгдүүлнэ гэж байхгүй.

Тийм учраас ерөөсөө гуравхан сонголт байгаа.

Энэ компаниудыг нэгтгэх үү, эсвэл татан буулгах уу, эсвэл хөрөнгийн зах дээр хувьцаа гаргах уу л гэдэг ийм сонголт.

Тийм учраас засаглал сайжруулах ажил эндээс эхэлнэ. Тийм учраас бид цаашдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хууль, төрийн болон орон нутгийн өмчийн компанийнх нь тусдаа хуулийг нь оруулж ирээд зохицуулах ёстой.

Түрүүн Үндэсний баялгийн сан дээр бас олон гишүүд асууж байна.

Үндэсний баялгийн сангийн орлого гол бүрдүүлж байгаа байгууллага бол “Эрдэнэс Монгол нэгдэл” юм гээд бид хуульчилж өгсөн.

Гэтэл “Эрдэнэс Монгол нэгдэл” дотор энэ төрийн өмчит үйлдвэрийн газрын статустай байгаа Эрдэнэт үйлдвэр, Монрос эд нар багтдаггүй.

Тэгэхээр бид үүнийг шинэ хуулиар нь компани болгож оруулж ирээд, нөгөө 34 хувийг нь хуримтлалын санд бүрдүүлдэг. Цаашлаад иргэн болгонд нээсэн гэсэн хуримтлалын дансаараа дамжуулаад орон сууц, эрүүл мэнд, боловсрол зарцуулах боломжийг нь нээхгүй бол яг өнөөдөр Үндэсний баялгийн сангийн хуулийг хэрэгжүүлэх гэхээр гол орлого бүрдүүлээд байгаа. Жишээ нь, гол гол компаниуд нь энэ Компанийн хуулиар зохицуулагдахгүй. Төрийн өмчит үйлдвэрийн газар гээд яваад байгаа.

Тийм учраас бид төрийн өмчит компанийн энэ засаглалыг сайжруулах чиглэлээр үйл ажиллагааг нь ил тод болгоно. Бүх процессыг нь цахимжуулна. Хүний оролцоогүй хиймэл оюун ухаан түшиглэсэн худалдан авалттай болгоно.

Ингээд хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг нь яг орчин үеийн жишигт нийцүүлээд, шударга, ил тод болгох ёстой.

Ингээд худалдан авалтыг ч гэсэн өнөөдөр хүний хамааралгүй болгох ажлуудыг хийнэ.

Тэгэхээр нөөцийг зөв хуваарилах, төлөвлөх буюу түүн дээр нь үндэслэсэн гүйцэтгэлийг хэмжих ийм л шинжлэх ухаанч гаргалгаа руугаа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт болсон уу? Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд.

Д.Амарбаясгалан: Уучлаарай. П.Наранбаяр сайд нэмж хариулах юм байна.

П.Наранбаяр: Б.Уянга гишүүний асуултад хариулья.

Тэгэхээрээ тэр чөлөөт бүс. Боловсролын чөлөөт бүс гэсэн нэг ойлголт туссан байгаа юм. Тэр бол өнөөгийн байж байгаа яг энэ үндэсний хөтөлбөрт заасан ийм хатуу зүйл биш. Энэ дээр ялангуяа Германы “Штайнер” /Rudolf Steiner/ гэх мэт. Тийм ээ.

Энэ “алтернатив боловсрол”-ыг анх боловсролын системд оруулж ирсэн ийм хүмүүст, тусгай хэрэгцээтэй байгаа, мөн илүү авьяаслаг эд нар ийм хүүхдэд зориулсан бас сургалтыг зөвшөөрч байна гэсэн үг.

Ер нь 11 мянга орчим ийм тусгай хэрэгцээтэй хүүхэд байгаа. Эндээс бас хувьсах зардлыг нь шууд 3 дахин нэмэгдүүлэх бодлогыг барьж ирсэн учраас ер нь 80 гаруй хувь нь өнгөрсөн хичээлийн жилд сургалтад хамрагдсан байгаа.

Энэ хамрагдалтыг бид нэмэгдүүлэх ийм бодлогыг барина.

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт өгье. 1 минут.

П.Наранбаяр: Түүний зэрэгцээ бас цахим сургалтад хамруулах. Мөн тусгай хэрэгцээнд нь зориулсан ганцаарчилсан сургалт гэх мэт бүх сургалтуудыг явуулна.

Түүний зэрэгцээ гадаадад байгаа Монголчуудад зориулсан “diaspora” сургалтын журмыг гаргаж дэмжих ажлыг хийнэ.

Эрэлттэй мэргэжлүүдийн тухайд өнөөдөр тэргүүлэх эрэлттэй мэргэжлээр нь жишээлбэл 15 жил тасралтгүй ажилласан багшийн хүүхдийг эрэлттэй мэргэжлээр Боловсролын зээлийн сангаас буцдаггүй тэтгэлэг олгож байгаа. Цаашдаа ч гэсэн олгож эхэлнэ.

Ялангуяа инженерийн чиглэлээр бид боловсон хүчин бэлдэхэд онцгой анхаарч ажиллаж байгаа. Тухайлах юм бол Хөшигийн хөндийд олон улсын инженерийн сургуулийг байгуулж, тэндээ жилдээ 2 мянга гаруй инженерийг нэмж бэлтгэх ажил явагдана. КООСЕН сургалтыг бас.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Гурван асуулт байгаа. Хоёр нь хөдөө аж ахуйн салбартай холбоотой. Нэг нь бүсийн асуудалтай холбоотой.

Хөдөө аж ахуйтай холбоотой асуудал дээр ер нь хөдөө аж ахуйн салбар дээр хийгдэж байгаа байгаа одоо нөхцөл байдлыг сайжруулах, тэр гишүүдийн ярьж байгаа, иргэд, малчдын хүсэж байгаа орлогыг нэмэгдүүлэх хүрээнд “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт” гэдэг хоёр хөтөлбөр өнгөрсөн парламентаар батлагдаад нэлээн амжилттай явж байгаа.

Эхнээсээ “Цагаан алт” нь гэхэд ирэх оноос хэрэгжиж эхлэхээр явж байгаа. “Шинэ хоршоо” хөтөлбөрийн хүрээнд энэ жилийн эх үүсвэр нь 500 тэрбумаараа одоогоор дууссан. Ирэх

жилийнх нь дахиад 500 тэрбумын эх үүсвэр он гараад дахиад тавигдаад ингээд явна гэсэн ийм чигтэй байгаа.

Тэгэхээр дээр яах вэ, гишүүд асуултаа асуучихсан учраас ер нь энэ гурван хөтөлбөрийг яагаад ч салгаж ойлгож боломгүй юм билээ. Яг малчид, хоршоод, тэр цагаан алт, тэр хүнсний хувьсгалын бэлтгэлүүдийг л хангаж байдаг ийм л кластер системийг л улс орон даяар хөгжүүлэх ийм том юм явж байгаа гэж ингэж харж байгаа.

Эх үүсвэртэй холбоотой асуудал дээр ер нь зүгээр яах вэ, аймаг, сумд ажиллаж байсан хүний хувьд төрийн албаныхны өмнө нэг зовлон байдаг. Энэ нь юу вэ гэхээр сумдын Засаг даргын Тамгын газруудад “хоршооны зээл” гэж нэг юм олгож эхэлсэн. Энэ бол одоо төрийн албан хаагч нэг бодлын банкны ажилтан юм шиг. Сая О.Амгаланбаатар гишүүний хэлж байгаа. Зээлээ олгосныхоо дараа шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажилтан юм шиг.

Магадгүй нэг сум тойроод ах дүү, худ ураг гээд ингээд холбоо сүлбээг нь ярих юм бол эргээд хуулийн байгууллагын хаалга татах ч магадгүй нэг иймэрхүү хүндрэлтэй юмнууд байгаад байдаг.

Тэгэхээр энэ хоршооныхоо эх үүсвэрийг ер нь нэг болгоод, арилжааны банкаар дамжаад явдаг болчихвол хаана хаана амар юм.

Тэгэхээр би үүнийг анхан шатад ажиллаж байгаа манай нөхдүүд бас хэлж байгаа учраас.

Хоёр дахь нь, малчид руу хандсан малын индексжүүлсэн даатгалын асуудлыг өнгөрсөн парламент дээр

Байгаль орчны байнгын хороон дээр, хөдөө аж ахуйн байнгын хороон дээр ажлын хэсэг гаргаад зогсчихсон байгаа.

Одоо өнөөдөр ингээд өнгөрсөн зудын хохирол гээд 17 тэрбум төгрөгийг 9 сарын 15-наас олгож эхлэх гэж байх шиг байна.

Тэгэхээр цаашдаа индексжүүлсэн даатгал, ер нь хөдөө аж ахуйн салбарын даатгалын асуудал дээр Засгийн газар ямар байр суурьтай байх юм бэ гэдэг нэг ийм асуудал.

Гурав дахь нь, бүстэй холбоотой. Би Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга байгаа учраас асууя.

Ялангуяа Улаанбаатар-Чойбалсан чиглэлийн тэр тамын 50 гэж яригдаад байдаг энэ замын эх үүсвэр өнгөрсөн төсөв дээр батлагдсан. Одоо болтол яг яах гээд байгаа нь мэдэгдэхгүй. Хийх гээд ч байгаа юм шиг, хийхгүй ч юм шиг, бүр орхигдчихсон ч юм шиг. Нэмээд Булганы 30 километрийн асуудал байгаа.

Тэгэхээр дээр Дорнодынхон, энэ замаар зорчдог олон хүмүүс асуултын хариуг чих тавин анхаарч байгаа.

Тийм учраас Төрийн нарийн бичгийн дарга бүр нэг тодорхой хариулт өгөөд. Хэзээ эхлэх, эхлэхгүйг нь хэлээд өгөөч ээ гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд 2 дугаар индрээс хариулт өгнө.

С.Батболд: Ц.Идэрбат гишүүний асуултад хариулъя.

Хэнтий аймгаас Чойбалсан явж байгаа замын 50 километр. Улсын төсөв дээр төсөв нь батлагдаагүй. Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжих төслийн хүрээнд хийгдэхээр батлагдсан байгаа.

Нийтдээ төсөвт өртөг нь 59.0 тэрбум төгрөг.

Дэлхийн банкны нийтдээ 316 километр замыг бид 4 багц болгож хувааж зарлаж байгаа. Эхний багцууд зарлагдчихсан.

Яг таны асуусан энэ замын тендерийг зарлахаар Дэлхийн банканд бид зөвшөөрөл хүсчихсэн байж байгаа.

Ирэх долоо хоногт Дэлхийн банкны яг дэд бүтэц хариуцсан Монгол дахь төлөөлөгч өөрчлөгдсөн. Газар дээр нь ажиллаад бид нарт чиглэл өгөх тэр тендерээ зарлана.

Бодит ажил энэ жил хийгдэж амжихгүй. Тендер зарлаад, дүгнээд, гэрээ байгуулаад ирэх оны хавар ажил эхлэхээр байгаа.

Д.Амарбаясгалан: Тодруулга. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асууна.

Ц.Идэрбат: Тийм. Хөдөө аж ахуйн тэр индексжүүлсэн даатгалын асуудлаар тэр сумдын Засаг даргын Тамгын газрынхан банкны ажил хийгээд байгаа, шүүхийн шийдвэрийн ажил хийгээд байгаа энэ тогтолцоо энэ шинэ хоршоотойгоо яаж уялдуулах талаар.

С.Батболд Төрийн нарийн бичгийн даргад. Хэрвээ шаардлагатай бол. Маргааш бид орон нутаг руу ажиллана.

Яамныхантай хамт газар дээр нь ажиллахад бэлэн байна. Хэрвээ орон нутгийн зүгээс, бүсийн зүгээс энэ ажил дээр ойлгомжгүй зүйл байгаа, тодорхой шийдлүүд хүлээгдэж байгаа бол газар дээр нь ажиллаад явах саналыг би яамны Төрийн нарийн бичгийн даргад тавьж байна гэдгээ тодотгож хэлье.

Д.Амарбаясгалан: Дүгэрийн Рэгдэл гишүүн асуулт асууна.

Д.Рэгдэл: Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе. Хоёр асуулт байгаа юм. Эрчим хүчтэй холбоотой байгаа юм.

Нэгдүгээрт, 14 том төслийн хүрээнд “Эгийн голын 310 мегаваттын цахилгаан станцыг барина” гэдэг асуудлыг томъёолж оруулж ирж байгаад их баяртай байгаа.

Тэгэхээр станц барих угаасаа их цаанаа том асуудал дагуулаад байгаа. Оросын Холбооны Улсын Засгийн газраас Нэгдсэн Үндэстний Байгууллагад асуудал тавьсан. ЮНЕСКО-д асуудал тавиад Байгаль нуурын эко системд энэ цахилгаан станц нөлөөлөх юм гэдэг үндэслэлээр тавиад ингээд Дэлхийн өвийн хороо бас хориг тавьчихсан ийм л асуудал.

Тэгэхээр одоо үүнийг цааш нь явуулахдаа Оросын эрдэмтдээс Засгийн газартаа санал боловсруулсан хүмүүстэй нь, эрдэмтэдтэй нь ажиллах ийм л асуудал байгаа юм.

Тэгэхээр би бол тэр эрдэмтдийг нь олсон. Шинжлэх ухааны академийн зүгээс бид Монголд хоёр удаа авчраад, Орост хоёр удаа очиж ярилцлага хийгээд.

Тэгээд эцсийн дүндээ юу гэхээр Франц бол Орост хамаагүй ээ. Бид Орос,

Монгол хоёр улсын эрдэмтэд нийлж байгаад хамтарсан ажлын хэсэг гаргаад энэ асуудлыг судалж үзээд явахад ер нь бид дэмжихэд бэлэн байгаа шүү гэсэн ийм байр суурьтай байдаг юм.

Тийм учраас энэ асуудлыг үйл ажиллагааны хөтөлбөрийг нь дагасан төлөвлөгөөнд сайн тусгаж өгөөд, мөнгө төгрөгийг нь суулгачихвал цаашаа явна.

Үүнийг дагаж орж ирж байгаа бас Шүрэнгийн цахилгаан станц байгаа юм.

Энэ дээр би санал гаргаад хэдийн хэд ч байлаа даа. Хасагдчихсан байна. Төрийн байгуулалтын байнгын хороон дээр.

Шүрэнгийн цахилгаан станц, Эгийн голын цахилгаан станц хоёрыг зэрэг яривал Орос хэзээ ч дэмжихгүй гэдэг бол ерөөсөө ойлгомжтой. Энэ хоёулаа Сэлэнгийн бассейн дээр баригдах станцууд.

Тийм учраас энэ Шүрэнгийн цахилгаан станцыг хасъя гэж оруулаад, ажлын хэсгээс хасах саналыг дэмжээд явуулсан байхад Төрийн байгуулалтын байнгын хороо ямар үндэслэлээр Шүрэнгийн цахилгаан станц барих заалтыг буцааж оруулсан юм бол гэж асууж байгаа юм. Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт бол энэ хөтөлбөрийн 3.3.3.7-д ураны нөөцтэй нь түшиглэн атомын эрчим хүчийг хөгжүүлж, атомын цахилгаан станц байгуулах суурь судалгааг хийнэ гэсэн нэг заалт байгаа юм.

Тэгэхээр зэрэг ажлын хэсэг дээр яриад, санал оруулаад суурь судалгааг хийж дуусгана гэсэн найруулгыг нь жаахан өөрчилж гэсэн санал ороод

Төрийн байгуул байгуулалтын байнгын хороо бас дэмжээд явсан.

Гэтэл би одоо энэ дотор бас Төрийн байгуулалтын байнгын хороон дээр дэмжсэн, эсвэл дэмжээгүй саналууд энэ дотор үүнийг олж харахгүй байгаа юм.

Ерөөсөө энэ суурь судалгааг хийж дуусгах ёстой. Энэ 4 жилд. Тэгэхгүй бол цаашаа атомын цахилгаан станц барих асуудал чинь нөгөө МАГАТЭ-гийн зөвлөмжийн дагуу үндсэндээ 10 гаруй нөхцөлийг биелүүлэх болдог.

Тэгээд суурь судалгааг Монголчууд энэ экспертүүдийнхээ өөрийн, үндэсний экспертүүд, судлаачдынхаа хүчээр 4 жилд хийгээд дуусгачих бүрэн боломжтой байгаа юм.

Тийм учраас энэ 3.3.7-г хэрвээ би олж хараагүй байж мэднэ. Дэмжсэнд ч олж харсангүй, дэмжээгүйд ч олж харсангүй. Энэ яагаад яригдаагүй юм бол гэсэн хоёр дахь асуулт. Жижиг асуулт байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ц.Туваан сайд хариулья.

Ц.Туваан: Д.Рэгдэл гишүүний асуултад хариулья.

Яг энэ атомын цахилгаан станцын асуудал өчигдөр Төрийн байгуулалтын байнгын хороон дээр яригдсан. Найруулгаар орж ирсэн. Сая хамгийн сүүлийн тэр “дуусгана”, “хийнэ” гэдэг дээр бас нэг найруулгаар явчхаж болох байх.

Яг энэ тодорхой улс, нэр заалгүйгээр найруулж, ерөнхий байдлаар

оруулж ирж “дуусгана” гэсэн асуудлыг дэмжих боломжтой.

Тэгэхээр та Байнгын хороон дээр зарчмын саналаа гаргаад найруулгаар асуудал орчхож болно.

Д.Амарбаясгалан: Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Л.Гантөмөр нэмэлт хариулт өгье.

Л.Гантөмөр: Д.Рэгдэл гуай яг зөв ярьж байна.

Ингээд ажлын хэсэг дээр гарсан 104 саналыг тойрч ярихыг би гишүүдээсээ хүсээд байгаа юм. Ингэж байж ажил хэрэгч болно.

Яагаад санал байна, яагаад алга болов гэдэг асуудлыг бүгдээрээ ярих хэрэгтэй. Жишээлбэл, Шүрэнгийн станц Байнгын хороон дээр дэмжигдээгүй шалтгаан бол аль аль нь байж байг гэж байгаа юм. Тийм.

Энэ бол хэлэлцээр. Бид Эгийн голтойгоо үлдэх ёстой. Тэгэхдээ аль альныг нь зорилт болгож дэвшүүлж байж аль нэг нь үлдэнэ гэдэг байдлаар жишээлбэл Байнгын хороо Шүрэнгийн станцыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дотор үлдээе гэж шийдсэн байгаа.

Д.Амарбаясгалан: Сандагийн Бямбацогт гишүүн. Уучлаарай. Дүгэрийн Рэгдэл гишүүн. Тодруулга 1 минут.

Д.Рэгдэл: Ер нь энэ хоёр станцыг. Би Л.Гантөмөр сайдын санааг ойлголоо.

Энэ бол бас зөв зүйтэй л яригдаж байгаа юм байна.

Зүгээр яг бодит амьдрал дээр бид энэ хоёр станцыг Оростой л, Оросуудтай л ярьж байж барих эсэхээ шийдэх юм.

Энэ хоёрыг зэрэг тавьчих юм бол Орос ярихгүй байх магадлал их өндөр. Би зөндөө Оросуудтай ярьдаг учраас үүнийг хэлж байгаа юм. Тэгээд бас бодолцоно биз дээ.

Д.Амарбаясгалан: Сандагийн Бямбацогт гишүүн асуулт асууя.

С.Бямбацогт: Эрчим хүчтэй холбоотой асуудал бас нэлээн тодотгож ярихгүй бол олны анхаарал татсан сэдэв болоод байна л даа.

Эрчим хүчний үнэ чөлөөлнө гээд зарлаж байгаа. Үүнтэй холбоотойгоор эрчим хүч бүх бараа, бүтээгдэхүүний суурь үнэд нөлөөлдөг.

Тэгээд дээр бид Засгийн газрынхаа мөрийн хөтөлбөр дээр нэлээн тодорхой тусгаж өгөхгүй бол бас нэлээн болгоомжлол бий болж байгаа юм.

Ер нь эрчим хүчний нийлүүлэлтийг яаж нэмэгдүүлэх вэ, эрчим хүч үйлдвэрлэе борлуулъя гэж байгаа иргэн, аж ахуйн нэгж хөрөнгө оруулъя гэсэн хүмүүсийг яаж дэмжих вэ, өрсөлдөөнийг яаж дэмжих вэ. Энэ рүү чиглэсэн бодлогоо нэлээн тусгаад. Үүнийгээ жоохон түрүүлж яриад явбал яасан юм бэ.

Урьд нь би Зам, тээврийн сайд хийж байхдаа агаарын тээврийн либералчлал, үнэ чөлөөлөх асуудлыг хөндсөн.

Улаанбаатар, Сөүлийн хооронд Монголоос, Солонгосоос ганц ганцхан

онгоц нисдэг байсан чөлөөтэй нисдэг болсон.

Үүний үр дүнд Сөүл, Улаанбаатарын билет нь 3 сая байж байгаад 1 сая болж хямдарч байсан.

Үе үеийн засгийн газрууд барилгын материалын салбарт Монгол Улс ганцхан цементийн үйлдвэртэй. Цемент нь өндөр үнэтэй байсан. Олон цементийн үйлдвэр баригдсан. 5 үйлдвэртэй болсон. Өнөөдөр цемент урьд нь 700 мянга байсан бол 250 мянга болж бараг 3 дахин хямдарч байна.

Иймэрхүү байдлаар бид өрсөлдөөнийг дэмжээд, нийлүүлэлтийг нэмэгдүүлээд явах юм үнэ өсдөггүй. Үнэ буурдаг.

Тийм болохоор эрчим хүчний салбарт яаж өрсөлдөөнийг дэмжих вэ, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх вэ? Энэ дээр нэг жоохон бодмоор байна л даа.

Тэгэхээр үүнийгээ эхэлж л жоохон ярьж явахгүй бол эрчим хүчний либералчлал, эрчим хүчний үнэ чөлөөлнө гээд явчхаар иргэд, аж ахуйн нэгжид айдастай л болох гээд байна.

Тийм болохоор эрчим хүч үйлдвэрлэе гэж байгаа аж ахуйн нэгжүүдээ чөлөөтэй үйлдвэрлэ. Бүх тусгай зөвшөөрөл нь хүнд сурталгүй өгнө. Эрчим хүч борлуулъя гэж байгаа аж ахуйн нэгжүүдээ бүх төрлийн татвараас чөлөөлнө, хөнгөлнө. Тодорхой хугацаанд.

Үүнийгээ зарлаад явчих юм бол энэ хэмжээгээрээ эрчим хүчний үнийг тийм үү, тодорхой тогтвортой барих бололцоо бүрдэх байх.

Өнөөдөр бидний Оросын Холбооны Улсаас нэг киловатт эрчим хүчийг 400 орчим төгрөгөөр авч байгаа. Хятадаас нэг киловатт эрчим хүчийг 500 төгрөгөөр авч байгаа.

Усан цахилгаан станц маань нэг киловатт эрчим хүчийг 50 төгрөгөөр үйлдвэрлэж байгаа. Дулааны цахилгаан станцууд маань нэг киловатт эрчим хүчийг 200 орчим төгрөгөөр үйлдвэрлэж байгаа.

Тэгээд иргэн, аж ахуйн нэгжүүдээ 200 орчим төгрөгөөр нийлүүлж байгаа. Импортоор авсан дээр алдагдалтай ийм байж байгаа.

Мөн сэргээгдэх эрчим хүч, нарны, салхины эх үүсвэр 600 төгрөг байгаа. Маш өндөр үнэтэй.

Тийм болохоор бид эрчим хүчний нийлүүлэлтийг, үйлдвэрлэгчдийг яаж татвараас хөнгөлөх юм, чөлөөлөх юм, яаж хүнд сурталгүй үйлдвэржилт нийлүүлэлтийг дэмжих юм. Үүнийгээ жоохон түлхүү яриад, энэ дээр жоохон түлхүү анхаарчих юм бол иргэд, аж ахуйн нэгж айгаад байгаа үнэ өсчих вий гэж тийм үү, болгоомжилж байгаа болгоомжлол нь бага болчих юм биш үү. Энэ рүү бас нэг бодлогоо жоохон түлхүү яривал яасан юм бэ гэсэн нэгдүгээр асуудал байгаа.

Хоёрдугаарт нь, сая бас замын асуудал ярьж байна. Манай зарим гишүүд.

Зам дээр ч ялгаа байхгүй. Өнгөрсөн 100 жилийн хугацаанд бид 100 сумаа замтай болгосон. 330 сумаас.

2024 онд бид 40 сумыг замтай болгох эх үүсвэр тавьсан.

Одоо Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тодорхойгүй тусчихсан байна гэж шүүмжилж байна. О.Амгаланбаатар гишүүн.

Үүнийг жоохон тодорхой болгоод тусгая. Тодорхой зорилттой. Хэмжигдэхүйц, гарт баригдахуйц, нүдэнд харагдахуйц тавьцгаая.

Ирэх 4 жилийн хугацаанд ерөөсөө л 100 сум л замтай болгоё л доо. 330 сумаасаа 200 замтай. 100 жил 100 сум замтай болсон бол одоо бид 4 жилийн хугацаанд 100 сум замтай болгоё. Ийм тодорхой зорилт тавьж болохгүй юу?

Ингэх юм бол тодорхой асуудал шийдэх бололцоотой. Одоо жишээ нь баруун аймгууд байж байна. Баруун аймгуудад ихэнх сумууд нь замгүй байж байгаа. Ихэнх аймгийн сумууд нь. Үүнийг шийдэх бололцоотой. Энэ дээр нэлээн тодорхой.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Та хэд чинь Засаг дээрээ ер нь ярилцаагүй юу? Тэргүүн Шадар сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд Л.Гантөмөр хариулья.

Л.Гантөмөр: С.Бямбацогт сайд Байнгын хорооны хурал дээр бараг бүтэн суусан. С.Бямбацогт сайд нэг санал гаргасан. Өөрөөр санал гаргаагүй.

Тэгэхээр та мэдэж байгаа. Ажлын хэсгээсээ түлхүү асуух хэрэгтэй. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Засгийн газар дээр эрчим хүчний шилжилтийн асуудал дээр Т.Доржханд Шадар сайдаар ахлуулаад ажил эхэлж байгаа.

Тэгээд ажлын хүрээнд С.Бямбацогт сайд саналаа хэлсэн байх гэж харж байна.

Сумын замын тухайд ийм л зарчим байгаа шүү дээ. Бүсийн хөгжлөө эхлээд томьёолъё. Бүсийн хөгжлөө томьёолчих юм бол бүсэд хөгжилд нөлөө үзүүлэх сумдын зураг гараад ирнэ.

Тэгэхээр тэр сумууд дээрээ ач холбогдол өгсөн хөрөнгө оруулалтыг хэдүүлээ үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд тусгаад явъя гэсэн ийм л зарчим яригдаж байгаа.

Д.Амарбаясгалан: Шадар сайд Т.Доржханд хариулт өгье.

Т.Доржханд: Баярлалаа. Яг энэ асуудал дээр С.Бямбацогт гишүүнтэй санал нэг байгаа юм.

Эрчим хүчний салбар. Хамгийн их манлайлж явах ёстой салбар маань хамгийн хойно хоцроод. Тэгээд үр дүнд нь бусад бүтээн байгуулалтуудаа уячхаад байгаа хязгаарлагч хүчин зүйл болчихоод байгаа байхгүй юу.

Тэгээд энэ юунаас болоод байна гэхээр ерөөсөө л зах зээлийн системдээ ороогүй. Зах зээлд шилжээгүй, үр ашиг байхгүй. Тэгээд төрийн монопол үүсчихсэн. Үр дүнд нь хязгаарлалт хийгддэг болчихсон. Эрчим хүчний хомсдолд ордог болчихсон.

Гэтэл Монгол Улс асар их эрчим хүчний нөөцтэй юм. Зөвхөн газрын дээр биш бас газрын дээрх сэргээгдэх эрчим хүчний нөөц хангалттай их байгаа.

Одоо бараг хөрөнгө оруулах боломжтой дэлхийн 200 улсын эхний 5-д орж байгаа.

Хэн хөрөнгө оруулах юм бэ гэхээр хувийн сектор байхгүй юу. Гэтэл тэр хувийн секторын тэр боломжуудыг нь хязгаарлачихсан 34 жилийг өөрчилье л гэж байгаа юм.

Тийм болохоор яг энэ татварын ямар өөрчлөлтүүд хийх юм бэ. Хөнгөлөлттэй орчин.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн 1 дүгээр микрофон.

Б.Тэлмүүн: Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн. С.Бямбацогт гишүүний асуултад хариулья.

Татварын бодлогоор эрчим хүчний салбарт маш олон төрлийн хөнгөлөлт, чөлөөлт байгаа.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын нэг том зорилт бол энэ “Эрчим хүчний сэргэлт” байгаа.

Үүнтэй холбоотойгоор сүүлийн 3 жилийн хугацаанд эрчим хүчний салбарт хамгийн олон төрлийн хөнгөвчлөлтийн хуулиуд батлагдсан байдаг.

Тухайлах юм бол 2022 оны 4 сарын 29-ний өдрийн хуулиар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулаад дулаан, цахилгаан үйлдвэрлэх төслийн үйл ажиллагааны орлогын татварыг эхний 3 жил 90 хувь, дараагийн 3 жил 50 хувиар хөнгөлөх хууль батлагдаад хэрэгжиж байгаа.

Өөрөөр хэлэх юм бол эрчим хүчний төслүүдийн орлогын албан татвар 1 хувь болсон.

2023 оны 7 сарын 07-ны өдөр баталсан хуулиар цахилгаан эрчим хүчний 5 мегаваттаас дээш, эсвэл дулааны эрчим хүчний 1.5 мегаваттаас дээш төслүүдийн төслийн үндсэн хөрөнгө.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулт 1 минут.

Б.Тэлмүүн: Төслийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх импортын тоног төхөөрөмжийн гаалийн албан татварыг чөлөөлөөд НӨАТ-ын татвар төлөх хугацааг 4 хүртэл жилийн хугацаатай хойшлуулах гээд.

Эрчим хүчний төслүүд бүтээн байгуулалтын шатанд гааль, татварын хөнгөлөлтүүд. Үйл ажиллагаа явуулсны дараа орлогын татварын хөнгөлөлт байгаа.

Дээрээс нь үйлдвэр, технологийн паркийн эрчим хүчний төслүүдийг нэмээд газрын төлбөр, үл хөдлөх хөрөнгийн татвараас бүрэн чөлөөлөгдөөд явдаг ийм татварын таатай орчин өнөөдөр үйлчилж байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй байх. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: С.Бямбацогт сайд тодруулга. 1 минут.

С.Бямбацогт: Засгийн газар өргөн бариад Их Хурлын ажлын хэсэг ажиллаад бас жоохон тодорхой болчих болов уу гэхээр тодорхой болоогүй болохоор асууж байгаа шүү. Их Хурлын гишүүнийхээ хувьд асууж байгаа.

Тэгэхээр замын асуудал дээр сая хариулт гарсангүй.

100 сум л замтай болгочихмоор байна. Очсон газар болгон зам нэхэж байгаа.

Намайг сая явж байхад ерөөсөө замтай болгож өгнө биз ээ л гэж явсан. Баруун аймгуудын Ховд бүх сумаа замтай болгочихсон. Увс ганцхан сум замтай. Говь-Алтай нэг ч сум замгүй. Завхан аймаг 18 сум замгүй байгаа.

Баруун бүс гэхэд ядаж 24 сумыг. Тийм үү. Тэр Завхан, Говь-Алтай, Увсыг замтай болгох ёстой. Үүнийг тодорхой оруулмаар байна.

Яг ийм байдлаар байдлаар 100 жилд 100 сум замтай биш, 2024 онд ганцхан жилд 40 сум замтай болох ажил эхэлсэн. Үүнтэй адилхан бид хичээгээд зүтгэх юм бол 100 сумын замтай болох бололцоо байгаа.

Үүнийг жоохон тодорхой тусгачихмаар байна. Энэ дээр ажлын хэсэг хариулаад өгөөч.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд бас индэр дээрээс Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр хэлэлцэж байх үед хариулсан шүү дээ.

Ер нь энэ ирэх 2025, 2026 онд зам, дэд бүтэц, дулаан хангамжийн асуудлыг бүрэн шийдвэрлэхийн төлөө Засгийн газраас улсын төсвийн бодлогыг боловсруулж оруулж ирж өргөн барина гэдгээ илэрхийлсэн.

Тэгэхээр замын асуудал, эрчим хүч, дэд бүтэц, дулаан хангамжийн асуудал дээр манай салбарын сайд нар, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж байгаа ажлын хэсэг бас дээр онцгой анхаарч ажиллах нь зүйтэй.

С.Бямбацогт гишүүний хэлж байгаа санал 100 хувь бодитой санал.

XXI зуунд хүн ам суурьшсан бүс нутгийг хатуу хучилттай авто замаар холбоогүй байна. Холбох ажил удааширна гэдэг бол бас учир дутагдалтай зүйл.

Тийм учраас Засгийн газар хөтөлбөр боловсруулж байгаа. Ирэх оны төсөв боловсруулж байгаа. Ажлын хэсгүүд энэ дээр онцгой анхаарч ажиллах ёстой гэдгийг хэлье.

Улсын Их Хурлын гишүүдийн ирцтэй холбоотойгоор хэвлэл мэдээллийн байгууллагад буруу ойлголт яваад байх шиг байна.

Өнөөдөр Улсын Их Хурлын чуулганд 126 гишүүнээс ирвэл зохих 116 гишүүн байгаа. 116 гишүүнээс одоогийн байдлаар чуулганы танхимд 107 гишүүн ирцэд бүртгэгдсэн байна.

Тийм учраас ямар нэгэн шалтгаангүйгээр өнөөдрийн чуулганы хуралдааныг тасалсан Улсын Их Хурлын гишүүдийн нэрсийн жагсаалтыг Тамгын газраас албан ёсоор, хэвлэл мэдээллийн байгууллагад хүргүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Тэгэхгүй бол Улсын Их Хурлын нэр хүнд Улсын Их Хурлын ирцдээ ирсэн ажлаа хийж байгаа гишүүдийн нэр хүндэд халдаж болохгүй.

Дараагийн хүн асуултаа асууя. Банзрагчийн Түвшин гишүүн асуултаа асууя.

Б.Түвшин: Та бүхэндээ өдрийн мэндийг хүргэе.

Тэгээд Засгийн газрын мөрийн хөтөлбөрт зэс боловсруулах үйлдвэр, гангийн үйлдвэр, газрын тос боловсруулах цогцолбор, алт цэвэршүүлэх, үндэсний хиймэл дагуул гээд олон том том төсөл, хөтөлбөрүүд орж ирсэн.

Яг энэ эдийн засгийн тооцоо, судалгаа нь цаанаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг өөрчлөөд нэлээн маргаан өрнүүлж байгаа.

Нөгөө талаасаа энэ томоохон үйлдвэрийн төслүүдийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байгааг ойлгож байгаа.

Тэгээд бид нарын сэтгэлгээ хаашаа яваад байна вэ гэхээр үүнийг л их хэмжээний хөрөнгө оруулалт, мөнгө шаардагдах учраас Засгийн газар хийнэ л гэдэг дээр л төвлөрчхөөд л, одоо Засгийн газрын өр зээл авах хэмжээг нэмэгдүүлэх гээд байх шиг байна.

Яах вэ нэг талаасаа төсөв, санхүү дээр яригдана биз. Нөгөө талаасаа ерөөсөө томоохон хэмжээний хөрөнгө оруулалтыг гадаад, дотоодын иргэдээс оруулахад нь эрх зүйн орчныг нь сайжруулах ямар ямар бодлого тавигдаж байна вэ?

Ямар ч байсан хөдөлмөр эрхлэлтийн бодлогууд дээр юу тавигдаж байна вэ гэхээр маш бага хэмжээний ажлын байрыг бий болгож байгаа жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг л татвар, эдийн засгийн бодлогоор дэмжинэ гээд байж байгаа.

Үүний цаана ямар логик явж байна вэ гэхээр иргэд нь жижиг, дундыг

хийгээд төр нь томоохон төслөө хэрэгжүүлдэг гэдэг логик яваад байдаг.

Гэтэл бид дотоодын нийт бүтээгдэхүүнээ өсгөх замаар Засгийн газрынхаа ч зээлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтаа ч дэмжих боломжтой учраас энэ дээр ямархуу хэмжээний хөрөнгө оруулалтын бодлогууд тавигдах вэ? Цаашдаа үүнийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар хийх юм бол Засгийн газрын зээл өсөхгүйгээр эдийн засагт үр өгөөжтэй байх юм биш үү?

Энэ дээр Л.Гантөмөр сайдыг хариулж өгөөч ээ гэж хүсэж байна.

Хоёр дахь нь, тэр нийгмийн даатгалын реформын тухай асуудал. Би Л.Энх-Амгалан сайдаас асууя.

Ер нь нийгмийн даатгалын асуудал бизнес эрхлэгчдийн талд нэг талдаа толгойны өвчин болчихсон. Ямар ч нийгмийн даатгалд хамааралгүй бүх ажил, гүйлгээнээс шимтгэл авдаг болчихсон.

Нөгөө талдаа шинэчлэлийг сайжруулна гээд байгаа мөртөө иргэн бүрт хуримтлалын данс явуулна гээд байгаа юм.

Иргэн болгон хуримтлалын төлсөн мөнгөө авдаг тогтолцоо биш шүү дээ. Энэ Нийгмийн даатгал чинь. Тодорхой хэмжээний суурийг нь бүх хүмүүсээс авчхаад, бас тодорхой хэмжээний нийгмийн асуудлыг шийдэхийн тулд хүн болгон хуримтлалын дансаараа авахгүй шүү дээ. Тодорхой хэмжээнээс дээш төлсөн дүн бол хуримтлалаараа авч болно уу гэхээс.

Тэгж байж бид зарим нэг халамжийн шинж чанартай асуудлыг

нийгмийн даатгалаараа шийдэхгүй бол хүн болгон төлсөн мөнгөө хувийн дансаараа, нэрийн дансаараа авчихна гэдэг бол өөрөө нийгмийн даатгалын тогтолцоо, философитой жоохон зөрчилдөөд байгаа учраас үүнийг нэг тайлбарлаад өгөөч ээ гэж хэлэх гээд байгаа юм.

Дөрөв дэх нь, тэр “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” гэж байгаа. Энэ бол ерөнхийдөө хөдөлмөр зохион байгуулалт, тэр тусмаа нүүдлийн мал аж ахуй дээр эдийн засгийн эргэлтэд оруулах, хамтрах тухай ийм төсөл, хөтөлбөрүүд явж байх шиг байна.

Энэ үр ашгийн тооцоо гэж асууя гэж байсан. Түрүүн тооцоолол хийгээгүй гэх шиг боллоо. Ямар хэмжээний зардал гараад одоо төсвийн тодотголд хэд сууж байгаа вэ?

Ер нь энэ малчдын чиглэлийн асуудал дээр хамгийн чухал асуудал нь малчдаас татах логистикийн системийн л асуудал байж байгаа шүү дээ.

Мал болон малын дагавар дайвар бүтээгдэхүүнүүдийг татах.

Тэгэхээр энэ хөтөлбөрийн 3.3.4.29 дээр малчдаас мал, мах болон түүнтэй холбогдох дайвар, дагавар бүтээгдэхүүнийг татан авах логистикийн тогтолцоог бий болгоно гэж мөрийн хөтөлбөрт нэмээд өгөөч ээ гэдэг ийм санал байна.

Тав дахь асуудал нь, С.Бямбацогт сайдтай санал нэг байгаа. Энэ замуудыг тодорхой болгооч. Ялангуяа баруун аймгуудын сумууд ихэнх нь зам байхгүй. Ялангуяа олон улсын байгууллагын төсөл, тусламжаар хэрэгжиж байгаа замууд нь сумын төвүүдээрээ дайрчих

юм бол ядаж нэг сум, суурин газрынхаа замыг холбочих асуудал шийдэгдчих юм.

Тэгэхээр ядаж энэ удаагийн хөтөлбөр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Л.Гантөмөр сайд эхний асуултад хариулья.

Л.Гантөмөр: Томоохон төслүүдийг Засгийн газар санхүүжүүлэхийн тулд өрийн таазыг нэмж байна гэсэн ийм буруу мэдээллийг гишүүд хүртэл хавтгай тараагаад байна. Одоо үүнийгээ зогсоомор байна. Өрийн тааз чинь ерөөсөө хөдлөөгүй ээ. 60.0 хувь хэвээрээ байгаа.

Тэгэхээр өр нэмэгдэхгүй. Үүнийг Засгийн газар хариуцлагатай хэлж байгаа.

Өрийг бууруулах бодлогыг хатуу баримтална.

Энэ томоохон төслүүдийг бид яаж хэрэгжүүлэх гэж байгаа вэ гэхээр яг Б.Түвшин гишүүний хэлдгээр гадна, дотнын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлнэ.

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжих юм. Энэ төслүүдийн санхүүжилтийн зөв схемийг бид зөв гаргаж ирж чадах юм бол явна гэдгийг л Та бүхэн минь ойлгооч гэж байгаа юм.

Нөгөө талдаа ер нь урсгал зардал тулчихсан байгаа шүү.

Одоо гишүүд энэ үйл ажиллагааны хөтөлбөрт баахан санал оруулаад, үүнийхээ дагуу баахан байгууллага байгуулаад, баахан зардал гаргая гэвэл тэр бол худлаа шүү.

Урсгал зардал үндсэндээ тулчихсан. Бид тогтвортой байдлын хуулиар урсгал зардал чинь өөрөө дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувийн ашигтайгаар гарах ёстой гээд их хатуу хууль оруулж байгаа шүү дээ.

Тэгэхээр урсгал зардал бидний хүсэж байгаа шиг нэмэгдэхгүй.

Тийм учраас урсгал зардал ер нь их тогтвортой байх юм байна. Том төслүүдийг хөрөнгө оруулалтаар шийдэх юм байна. Уул уурхайн дэд бүтэц дээрээ онцгой анхаарах юм байна гээд ингээд нэг нэгдсэн ойлголттой болоод өгмөөр байна.

Ийм гуравхан зүйлийг л ойлгочих юм бол бүгдээрээ ямар хэмжээнд амьдрах гэж байгаагаа ерөнхийдөө ойлгоод авчих юм.

Тэгэхгүй бол асуудал шийдэх мөнгө байхгүй шүү.

Тэгэхээр жижиг асуудлаа тэвчээд бүсийн хэмжээнд бодож сэтгэж гаргалгаа гаргаж явъя гэдэг ийм л зүйлийг л одоо бид уг нь үйл ажиллагааны хөтөлбөртөө оруулж ирж Та бүхнээр дэмжүүлэхийг л зорьж байгаа шүү дээ.

Д.Амарбаясгалан:

Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд хариулья. Нийгмийн даатгалын тогтолцоо.

Л.Энх-Амгалан:

Б.Түвшин гишүүн ээ, ийм байгаа шүү.

Та нөгөө хуримтлалын сан, тэтгэврийн нөөц сан хоёрыг жаахан холиод байх шиг байна.

Бид хоё сантай болж байгаа шүү дээ. Хоёр сантай.

Хуримтлалын сан баялгийн эх үүсвэрээс буюу уул уурхайн компаниудын ногдол ашгаас орж ирж байгаа эх үүсвэр гэсэн үг.

Одоогийн байдлаар сая сонгуулийн өмнө энэ сан байгуулагдаад 500 орчим тэрбум төгрөгийн эх үүсвэр шийдэгдэж, үүнийг ипотекийн зээлд урьдчилж зарах ийм шийдлүүд гарсан байгаа. Энэ бол хуримтлалын сан.

Энэ жилээс нийгмийн даатгал төлж байгаа иргэдийн нэрийн данс дээр данс нээгээд төлсөн тэр нийгмийн даатгалынх нь шимтгэлийн 2 хувийг бид мөнгөн хуримтлал болгож эхэлсэн. Мөнгөн хуримтлал.

Одоо 10 сард манай иргэд данс дээрээ өөрийнхөө бодит хуримтлалыг харах боломжууд удахгүй нээгдэх гэж байна.

Тэгэхээр энэ сан маань оны төгсгөлд нийт.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут. Гүйцээж хариулья.

Л.Энх-Амгалан: Энэ сан маань оны төгсгөлд 240.0 тэрбум төгрөг. 2028 он гэхэд энэ сан маань 2.1 их наядын санхүүгийн эх үүсвэр төвлөрөх ийм хуримтлалын сан байхгүй юу.

Иргэд хуримтлуулсан 2 хувиа өвлүүлэх, ямар нэгэн амь насны эрсдэл гарвал үр хүүхдүүддээ өвлүүлэх, орон сууцын зориулалтаар ашиглах ийм боломжуудыг бид хууль эрх зүйн хувьд нээгээд өгсөн гэж ойлгож болно. Нээгээд өгсөн гэж.

Тэгэхээр Монгол Улс цаашдаа ер нь олон давхарт тэтгэврийн тогтолцоо руу л алхаж байна л гэж ойлгож болно. Одоо удахгүй бид Улсын Их Хурал дээр хувийн тэтгэврийн даатгалын хуулийг өргөн барих гэж байна.

Ингээд суурь тэтгэвэр, тэтгэврийн нөөц сангаас хуримтлуулж байгаа хуримтлал, дахиад дээрээс нь хувийн тэтгэврийн санд хуримтлал авах ийм олон эх үүсвэрээс тэтгэвэр авах ийм тогтолцоог л бид бий болгохыг зорьж байна гэж ойлгож болно.

Д.Амарбаясгалан: Гурав дахь асуулт чинь хэнээс асуучихлаа. Б.Түвшин гишүүн. Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Сантай холбоотой асуудал тийм биз.

Эх үүсвэрийн асуудал байсан уу? Тийм үү.

Д.Амарбаясгалан: Хоршоо, “Цагаан алт” хөтөлбөр зэрэг хөтөлбөрүүдийн хоорондын эдийн засгийн тооцоо, уялдаа холбоо гэдэг асуулт явсан. Тийм ээ.

Тийм. Тэгээд ложистикийн тогтолцоог бүрдүүлэх тал дээр гэж асуусан байгаа.

Ж.Энхбаяр: Зорилго бол нэгдүгээрт тус тусдаа байгаа малчдаа хоршоолоод нэг дэд бүтцийг үүсгэхийе.

Тэгээд малчны хотхоноос гарч байгаа тэр мах, сүү, арьс шир, ноос ноолуур, тэр бүтээгдэхүүнийг хөдөө аж ахуйн бирж дээрээ мэдээллийг нь зангидчихъя.

Биржээрээ дамжуулаад хөнгөн хүнсний үйлдвэрүүдтэйгээ холбочихъё гэдэг л ерөнхий ийм бодлогын ажил явж байгаа.

Тэгээд түүний эх үүсвэр болж малчдаа хорших, малчид үйлдвэрлэлийн чанар, стандартад нийцсэн түүхий эдийг хэрхэн бэлдэх вэ, нөгөө талаар цаг уурын өөрчлөлтөд хэрхэн дасан зохицох, тэр эрсдэлийг даван туулах чадавхыг нэмэгдүүлэхийн тулд тэр тэжээлээ хэрхэн тарих вэ, хөдөлмөрөө хэрхэн хорших вэ гэх мэтийн. Энэ зээл маань өөрөө 14 нэр төрлийн ийм төсөл, хөтөлбөрийн орон зайд л зээл олгож байгаа шүү дээ.

Нөгөө талдаа үйлдвэрүүдээ босгоод ирж байна. Хооронд нь холбох хөдөө аж ахуйн биржийнхээ систем, сүлжээг нээлттэй болгоод эхэлж байна.

Одоо ноолуур, махны мэдээлэл бүрэн орсон. Одоо энэ намар үр тарианы мэдээллийг холбох гэж байна.

Ер нь бүхэлдээ “Ухаалаг хөдөө аж ахуй” гэсэн нэгдсэн платформын доор

- ухаалаг малчин,
- ухаалаг тариаланч,
- ухаалаг ногоочин,
- бирж,
- үйлдвэрүүд

гэсэн ийм систем холбогдоод олон нийтэд нээлттэй болоод ирэх байх.

Д.Амарбаясгалан: Дамбын Батлут гишүүн асуултаа асууя.

Д.Батлут: Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй танилцсан.

Монгол төр хүний хөгжлийн бодлогоо нэн тэргүүнд тавьж байж том зургаараа хөгжих ёстой. Хүнээ хөгжүүлсэн улс орон л хөгжлийн өндөр түвшинд хүрдэг.

Гэхдээ өнгөрсөн хугацаанд төрөөс оруулж байгаа хөрөнгө оруулалт орон нутаг болгонд, хүн болгонд ижил тэгш хүрсэн. Тэгсний үндсэн дээр хот хөдөөгийн ялгаа гэдэг зүйл том ялгаралыг бий болгочхож.

Одоо хөдөө сумдад нийгмийн олон талт үйлчилгээ авах боломж хомс болсон байна. Яагаад гэвэл тэнд багш нар байхгүй байна. Эмч нар алга болсон.

Хүнээ эмчлүүлэх гэж аймгийн төв рүү явдаг болсон. Сум битгий хэл аймгийн төвд зарим сургуулиуд багшлах хүний нөөц байхгүй болж эхэлсэн.

Төрийн албанд ажилладаг албан хаагч нар байхгүй болчихсон.

Тэгээд энэ юунаас шалтгаалж байгаа вэ гэхээр төрийн хөрөнгө оруулалт нь иргэн бүрт ижил тэгш хүрэх тэр боломжийг олгоогүйгээс, сум, орон нутаг руу чиглэсэн томоохон бодлогын хөрөнгө оруулалт хийгээгүйгээс тэнд ажиллаж амьдрах орчин, нөхцөл сайжраагүйгээс, тэнд ажиллаж байгаа хүмүүсийн нийгмийн баталгааг хангаагүйгээс л энэ асуудал үүсэж байгаа юм.

Харин магадгүй өнгөрсөн хугацаанд энэ хөрөнгө оруулалтад дандаа төвлөрлийг бий болгосон ийм л хөрөнгө оруулалт байсан.

Өнөөдөр ч гэсэн төвлөрлийг бий болгох хөрөнгө оруулалтууд ихэвчлэн тавигдсан байна.

Би тэгээд улс төрчдөд Засгийн газар, Их Хурлыг бас уриалах гээд байгаа юм.

Одоо улсын төсвийн хөрөнгө оруулалтуудыг улсаа хөгжүүлбэ гээд хөдөө сумаасаа эхэлбэ л дээ. Тэнд ажиллаж амьдарч байгаа хүмүүсийн амьдрах боломжийг бүрдүүлбэ. Тэнд Улаанбаатар хотод, төв суурин газарт авч байгаа тийм нийгмийн үйлчилгээг авдаг нөхцөл байдлыг бүртүүлбэ.

Ингэж байж бид нарын төвлөрөл гэж яриад байгаа, түгжрэл гэж яриад байгаа зүйл чинь саарна шүү дээ. Ингэж байж бид зах хязгаар нутагтаа хүмүүс ажиллаж амьдрах боломжийг бүрдүүлнэ. Тэр утгаараа бүс нутаг, орон нутаг хөгжих боломж нь бүрдэнэ гэж харж байгаа.

Магадгүй цаашлаад ярих юм бол Монгол Улсын халдашгүй байдалтай ч холбоотой байхыг үгүйсгэхгүй. Бид өргөн дэлгэр уудам нутагтай.

Тэгэхээр би Байнгын хороон дээрээс хариулт авах гээд чадаагүй. Ямар бодлогууд хэрэгжүүлэх юм бэ? Ямар бодлогууд хэрэгжүүлэх юм?

Өнгөрсөн цаг хугацаанд 100 сургууль, цэцэрлэг ч гэдэг юм уу, эсвэл нэг тоо тавигдаад явагддаг юм. Тэр хаачдаг вэ гэхээр дарга нарын тойрог руу явчихдаг. Тийм л дүр зурагтай өнгөрсөн.

Тэгээд нэг ёсондоо тэр тойрогт амьдарч байгаа хүмүүс азтай ч гэмээр юм шиг. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

бол иргэн хүн бүрт жигд, тэгш, хүртээмжтэй л хүрдэг байх ёстой юм.

Тэгэхээр хүний хөгжил, тэр дундаа хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах боломжийг бүрдүүлэх, нийгмийн үйлчилгээг авах тэр боломжийг бүрдүүлэх тал дээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр ямар бодлого, ямар шийдлүүдийг гаргах гэж байгаа юм бэ? Надад тодорхой тоо баримттай хариулж өгөөч ээ гэж хүсэж байна. Тодруулна дарга аа. Сүүлд нь.

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Н.Учрал сайд хариулна.

Н.Учрал: Д.Батлут гишүүний асуултад хариулъя.

Энэ удаагийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр ер нь төвлөрлийг задлахад, эрх мэдлийн төвлөрлийг арилгахад л гол чиглэлээ зориулж байна гэж ойлгож болно.

Жишээ нь, нийслэлийн их, бага тойрог 770 га газар дээр төвлөрчихсөн. Улс орныхоо 0.2 хувь дээр хүн амынх нь тал нь амьдарч байгаа энэ төвлөрлийг бодитойгоор задлахгүйгээр цаашаа урагшлах замгүй болсон.

Тийм ч учраас бид Засгийн газрыг, яам, агентлагуудыг, төрийн байгууллагуудыг бүхэлд нь Улаанбаатар хотоос гаргах ийм бодлогын хүрээнд. Үүнд хүрэх дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр энэ төсвийн тодотголд шаардлагатай ТЭЗҮ боловсруулах. Одоо тэр **“PMС”** [project management consultancies]-тэй холбоотой зардлуудыг нь тавьсан.

Тэгэхээр үнэхээр Улаанбаатар хотоос бид гүүрэн байгууламжийг

байгуулаад, цаашаа тэр хос туннелээр яг тэр Номтын ам руу холбовол цаана нь Засгийн газрын бүх яамдууд, агентлагууд нүүхэд энэ чинь бараг 80 орчим мянган метр квадрат байр байгуулагдах юм байна.

Түүний дэргэд төрийн албан хаагч нарыг орон сууцжуулах бодлогын хүрээнд бид орон сууцны бодлогыг тэнд хэрэгжүүлснээрээ энэ төвлөрөл саарах юм байна гэж үзэж байгаа.

Дээрээс нь өнгөрсөн хугацаанд 76 жижиг мажоритар тогтолцоо бол яг Д.Батлут гишүүний хэлж байгаа шиг ерөөсөө илүү нөлөө бүхий, илүү олон сонгогдсон ч гэдгээсээ юм уу, ерөөсөө л өөрийнхөө тойрог дээр шаардлагагүй газар шаардлагагүй төсөв, хөрөнгө оруулалт тавьдаг байсан.

Түүнээсээ болоод хүн очоогүй газар хоосон байр бариад үр дүнд хүрдэггүй юм гэдгийг өнгөрсөн хугацаа харуулсан.

Тийм учраас ерөөсөө л энэ төсвийг ухаалгаар төлөвлөх хүрээнд хотын хөгжлийн 2040 оны төлөвлөгөөг нь гаргаад **“20 минутын стандарт”** гэж юу байх юм бэ. Үүнийг нь төсөв ухаалгаар төлөвлөдөг болгоё гэж байгаа юм.

Дээрээс нь бүсчилсэн хөгжлийн бодлого Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 бүлгийн нэг нь.

Тэгэхээр бүсчилсэн хөгжил цэвэр интеграц. Энэ интеграц уялдаа холбоо сайжрахгүйгээр цаашдаа урагшлахгүй учраас боомтын сэргэлттэй холбогдуулаад ч гэсэн бид экспортоо нэмэгдүүлээд цаашлаад эдийн засагт хэлэх юм бол яг хүнийхээ хөгжил рүү зориулах үүднээсээ 4 бүлгийн нэг **“Хүний**

Хөгжлийн бодлого” юм гэдгийг тусгаж өгсөн.

Тийм ч учраас түрүүн байгалийн баялагтай холбогдуулж байгаа 34 хувийг үнэхээр хуримтлалын санд төвлөрүүлээд иргэнд эзэмшүүлээд эхэлсэн энэ бодлого амжилттай хэрэгжвэл үүнийг нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах чиглэлээр, орон сууцжуулах, эрүүл мэндийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх, дээрээс нь боловсролын тэгш боломжийг улс орныхоо хэмжээнд тэгш олгох үүднээсээ энэ 4 бодлого хоорондоо уялдаж байгаа.

Тэгэхээр 15 төсөл гэдэг чинь ерөөсөө л эдийн засгаа тэлэх, эдийн засгийн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дамбын Батлут гишүүн нэмэлт тодруулга.

Д.Батлут: Яах вэ, тэгээд цахимжих зүйлүүд байх байх.

Тэгэхдээ хөрс суурин дээрээс нь тэр орон нутгийн онцлогт тохирсон тодорхой шийдлүүд гарах нь илүү зохимжтой.

Тэнд хүүхдүүд сурч байгаа. Монголын ирээдүй хойч болсон хүүхдүүд сурч байна. Тэнд хүүхдүүд төрж байгаа. Бас Монголын ирээдүй болсон хүүхдүүд байна. Монголчууд тэнд ажиллаж амьдарч байгаа. Эрүүл мэндийн асуудал нь чухал уу. Чухал байгаа.

Яах вэ, Үндэсний баялгийн сангийн тухай хууль өнгөрсөн Их Хурлаар батлагдаад, түүгээр иргэд маань бас харилцах данстай болоод орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх тэр боломжууд бүрдэж байгаа.

Тэгвэл төр өөрсдөө хийх ёстой юмаа л хийчихмээр байгаа байхгүй юу. Тэр дэд бүтцийг нь татъя л даа. Суманд. Тэр уурын зуухыг нь дулааны станц болгочихъё.

Тэр бол нэг их тийм өндөр үнэтэй зардал орохгүй. Магадгүй төр, хувийн хэвшлийн түншлэлээр ч хийчих боломжтой гэж хардаг.

Энэ мэтчилэнгээс олон зүйлийг санаачилж бүх сум дээр анхаарлаа хандуулж ажиллах цаг нь болчихжээ гэж харж байгаа юм.

Дээрээс нь тэр орон нутагт ажиллаж байгаа хүмүүсийн цалин хөлсийг яах юм бэ? Одоо бид орон нутагт 80 хувь нэмэгдүүлнэ гээд. Тэрийг нь орон нутгийн эрх мэдэлд шилжүүлчхэж байгаа. Тэр төсөв төвлөрүүлдэггүй сум, аймгууд яаж тэрийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тодруулга болсон байгаа. Хариулт байхгүй. Үг хэлсэн. Тийм ээ. Хариулах юм уу? Н.Учрал сайд.

Даваагийн Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Өдрийн мэнд.

Би Засгийн газраас ирүүлсэн Ерөнхий сайдын гарын үсэгтэй бичгийг би өөрөө буруу ойлгоод байна гэж бодоод байсан нь зөв юм байна.

Тогтоолын төсөл. 2024-2028 оны хооронд Засгийн газрын Их Хурлаар батлуулах мөрийн хөтөлбөрийн тогтоолын төсөл.

Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр нь тодорхойгүй баахан асуудал дээр бид нэлээн олон хуулийн өөрчлөлт хийх гээд гаргалгаануудыг нь Их Хурал хайгаад суугаад байгаа юм.

Үүнийг ингэхгүйгээр эхлээд Их Хурал өөрөө Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 2028 он хүртэл тодорхойгүй байгаа бүх асуудлуудыг нь тодорхой болгуулаад үүний араас хуулиуд руугаа орсон бол илүү оновчтой болох байсан болов уу гэж бодоод байгаа юм.

Тэгээд үүнтэй холбогдуулаад манай урдаа барих хуульчид гэж яригдаад байгаа Б.Энхбаяр гишүүн хүртэл тендерийн хууль дээр гаргалгаа ч олж чадахгүй байна. Баахан нүх сүв, цоорхойг нь олж хараад, тэгээд магадгүй араас нь баахан хулгай хийх боломжийг бүрдүүлж өгөх гэж байгаа Улсын Их Хурал болж харагдаад байна гэдгийг нь бид холбогдох Байнгын хороод дээр маш их ярилцсан.

Тэгэхээр Их Хурал өөрөө түрүүлээд Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг нь батлаад, Батлахдаа тодорхойгүй байгаа маш олон асуудлуудыг тодорхой болгосны дараа холбогдох хуулийн төслүүд. Одоо юу гэдэг юм Төсвийн тухай хууль, Тендерийн тухай хууль, Тогтвортой байдлын тухай хууль гээд маш олон хуулиудаа ярих хэрэгтэй байна гэж би хараад байна. Их Хурлын дарга аа.

Хоёрдугаарт, дахиад Ж.Энхбаяр сайд руугаа. Ж.Энхбаяр сайд руу биш ээ, Хөдөө аж ахуйн яам, тэгээд бодлого руу хандсан юм л ярих гээд байгаа юм.

Д.Батлут гишүүн яриад байгаа, Б.Түвшин гишүүн яриад байгаа, З.Мэндсайхан гишүүн яриад байгаа.

Бид Улаанбаатар хот улс болох гээд байна. Малчид руугаа чиглэсэн, алс хязгаар нутаг руугаа чиглэсэн бодлого ерөөсөө явуулахгүй, дөрвөн уулын дунд байгаа асуудлаа шийдэхийн тулд одоо энэ Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр гээд байгаа тодорхойгүй асуудлыг тойроод хэд хоног.

Миний орсон Байнгын хороо, ажлын хэсэг бүгдээрээ л яг үүнийг яриад байгаа юм.

Малчид руугаа чиглэсэн бодлого алга гээд. Тэгээд үүнийг ярихаар “Цагаан алт” хөтөлбөр, эсвэл “Шинэ хоршоо” хөдөлгөөн гэдэг юм яриад байгаа юм.

“Шинэ хоршоо” нөгөө зээл олгох байсан. Олгоод дуусчихсан. Эх үүсвэр байхгүй.

“Цагаан алт” гэдэг нь эрчимжсэн мал аж ахуй, эсвэл нэг сүүтэй үнээ, эсвэл нэг махтай үхэр л ярих гээд байх шиг байгаа юм.

Яг хөдөө малчдад чиглэсэн, малын гаралтай түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн болгоход чиглэсэн, үйлдвэр барихад чиглэсэн бодлого ерөөсөө тодорхой юм байхгүй байна. Үүнийг тодорхой болгож өгөхгүй бол бид энэ төвлөрөл чинь энд шийдэгдэхгүйгээр л өсөөд байх боломжтой.

Бид Монгол Улс биш, Улаанбаатар хот улс болох гээд байна л гэдгийг дахин дахин анхааруулж хэлмээр байна.

Тэгээд Ж.Энхбаяр сайдад, энэ Хөдөө аж ахуйн яамныхан орж ирээд манай Байнгын хороо, Төсвийн байнгын хороон дээр санагдаж байна. Саналаа хэлэхээр Та ёстой зөв юм яриад байна. Зөв юм байна. Танаас орж бараг л туршлага судалъя л гээд салсан.

Жишээлэхэд манай ноосон бордооны үйлдвэр. Үүнийг бүр 21 аймагт барих хэмжээний бодлогыг оруулж ирээд. Энэ үйлдвэрийг хэн барих нь чухал биш байна. Хэн эзэмших нь чухал биш байна.

Бид ноосоороо эцсийн бүтээгдэхүүн хийгээд экспортод гаргаж чадах юм бол малчид өөрөө.

Жишээлэхэд надад Өвөрхангай аймгаас нэг хүн өөрөө яг уулзалт дээр ирээд хэлж байсан юм. Ноос үнэтэй болчих юм бол бид ядахдаа хүүхдийнхээ сургалтын төлбөрт нэмэрлэмээр байна гээд байгаа юм. Энэ чиглэлд та нар нэг тодорхой бодлого боловсруулж оруулж ирж болох уу л гэж. Ийм л хоёр зүйл байна. Нэг нь санал юм. Нэг нь асуулт юм.

Д.Амарбаясгалан: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбаагийн Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: “Шинэ хоршоо” хөдөлгөөн бол урьд өмнө байгаагүй малчид руу чиглэсэн маш том бодлогын арга хэмжээ шүү дээ.

5 их наядын хөтөлбөр. Жил болгон 500, 500 тэрбум төгрөгийн эх үүсвэрээр хоршсон малчдынхаа үйл ажиллагааг дэмжинэ.

Зүгээр малчдад мөнгө өгөөд орхиж байгаа зүйл биш шүү дээ.

Үүнийгээ сая таны яриад байгаа тэр “Цагаан алт” гэж бодлогын хүрээнд хөнгөн хүнсний үйлдвэрүүдээ босгож ирье гэж байгаа.

Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг хоёр том бааз суурь бэлдэж байгаа. Нэг нь малчид. Нэг нь тариаланчид.

Энэ хоёрыгоо нэг нь “Хүнсний хувьсгал”-аараа тариаланчдаа дэмжээд гаргаад ирнэ. “Шинэ хоршоо” хөдөлгөөнөөрөө малчдаа дэмжээд гаргаад ирнэ.

Үүний зангилгаа нь тэр хөнгөн үйлдвэрийг дэмжих “Цагаан алт” хөтөлбөр шүү дээ.

Нэг ийм зүйл байгаа юм л даа. Бид яг өнөөдөр ноолуурынхаа 70-аас 80 хувийг угааж, 10 орчим хувийг нь самнаж, 20 орчим хувьд нь бэлэн бүтээгдэхүүн хийж чадаж байгаа. Монгол Улс.

Ноосныхоо 75 хувийг угааж, 25 хувь нь бэлэн бүтээгдэхүүнтэй.

Арьс, ширний түүхий эдийнхээ 30 хувийг л дөнгөж бэлтгэж чадаж байгаа.

Тэгэхээр энэ боловсруулалтынхаа түвшинг л энэ хөтөлбөрийн хүрээнд эрс дээшлүүлье. Үүнийг эрс дээшлүүлэхийн тулд анхан шат, тэр малчдаа зохион байгуулалт буюу түүхий эдийн бэлтгэлийн баазаа сайхан дэмжээд өгье. Дунд нь хөдөө аж ахуйн биржүүд нь идэвхтэй ажиллаад өгье гэсэн ийм цогц бодлого шүү дээ.

Ингээд дагуулаад нөгөө өвс, тэжээлийн нөөц нэмэгдүүлэх, бүсчилсэн тэр тэжээлийн баазуудыг бий болгох, таримлын үр, сортыг сайжруулах, тэгээд

тэр бэлчээрийн даацын асуудал дээр том бодлогын өөрчлөлтүүд орох энэ хөтөлбөр маш сайн.

Ялангуяа саяын хэлдэг таны тэр ноостой холбоотой 3.3.4.4-д ноос боловсруулах үйлдвэрүүдээ сэргээе. Ноосон эдлэл, бүтээгдэхүүн, ялангуяа шинэ бүтээгдэхүүн болох ноосон бордоо, ноосоор хийсэн барилгын дулаалга үйлдвэрлэх бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг онцгой анхаарна гэж оруулж ирж байгаа юм.

Ноос маань зөвхөн ноосон эдлэл биш. Барилгын материал болж хувирч байна. Мөн маш сайн чанарын бордоо болж хувирч байгаа.

Тэгэхээр энэ сайн бүх жишээнүүдийг дэмжье гэдгээрээ бүр зорилт болгож оруулж байгаа.

Тэгээд итгэлтэй байж болно. Ямар ч байсан 4 жил малчид руугаа чиглэсэн хөдөө аж ахуйн салбарыг дэмжих томоохон бодлого амжилттай хэрэгжинэ.

Яагаад гэвэл төвлөрлийг сааруулахын тулд хийж байгаа бас том ажил шүү дээ. Хөдөө хөгжүүлж байж л төвлөрч саарна. Тэгэхгүй бол хотоосоо бид гарч чадахгүй.

Энэ бодлогын хүрээнд хөдөөгөө хүн ажиллах, амьдрах, бизнес эрхлэх орлоготой байх бололцоо бүрдүүлэх энэ бодлогууд чинь л чиглээд байгаа юм л даа. Тэгж байж төвлөрлөөс, хотоос орон нутаг руу шилжих ажлыг бүх талаар урамшуулж байгаа ийм том хөшүүрэг юм шүү. Давхар бас.

Д.Амарбаясгалан: Хариулт болсон уу? Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнхтуяа: Баярлалаа. Миний асуух асуулт мэдээж Боловсролын сайд П.Наранбаяраас 6 асуулт асууна.

Нэгдүгээр асуудал нь, ирэх 4 жилд багш, ажилчдын үндсэн цалинг хэдэн хувиар нэмж, хэдэн төгрөг болгох вэ? Энэ тал дээр сайд ямар бодолтой, бодлого барьж байна вэ гэдгийг асууя.

Хоёрдугаарт, салбарын багш, ажилчдын тэр орон сууцын асуудал дээр П.Наранбаяр сайд ямар бодолтой явж байна. Яг юу хэрэгжүүлэх юм. Тийм ээ. Мөрийн хөтөлбөр дээр орсон ямар асуудал дээр нь багш, ажилчдынхаа орон сууцын асуудлыг шийдэх боломж, гаргалгаа байна вэ гэдгийг П.Наранбаяр сайд дотроо бодож байгаа юм байгаа байх.

Гуравдугаар асуудал. Нөгөө Монголын багш нарын 7, 8 дугаар их хурлын шийдвэр багш нарын 70-аас 80, бараг 90 хувь нь багш нарын тэтгэврийн насны асуудал байгаа. Энэ дээр та бас ямар бодлого барьж ажиллах вэ?

Тэтгэврийн насыг эрэгтэй 55, эмэгтэй 50. Хүсвэл гэж байгаа юм. Тийм. Хүсвэл гарах боломж, нөхцөл, хуулийн гаргалгааг Та хийж чадах уу?

Дөрөвдүгээр асуудал. Боловсролын салбарын багш, ажилчдын хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийх үү? Үүнийг ерөөсөө хийхгүй орхигдуулаад яваад байгаа.

Тавдугаар асуудал. Салбарын багш, ажилчдын мэргэжлээс шалтгаалах өвчлөл гэдэг асуудал ерөөсөө орхигдчихсон.

Сүүлийн үед багш нар маш их хавдраар өвчилж байна. Энэ тал дээр Та анхаарч ажиллаарай. Сайдын хувьд.

Сүүлийн асуулт. Ирэх 4 жилд цэцэрлэг, сургуулийн анги, бүлэг дүүргэлтийг 30-аас хэтрүүлэхгүй байх энэ бодлогыг барьж ажилла гэдгийг маш олон багш нар санал хүсэлтээ ирүүлээд байгаа. Энэ дээр Та бас ямар бодлого барьж ажиллах вэ?

Ер нь хотод 50-иас дээш хүүхэдтэй ангиуд маш их хичээллэж байгаа шүү дээ. Энэ дээр танд ирсэн тоо баримт юу байна аа? Үүнийг асууж байна.

Д.Амарбаясгалан: П.Наранбаяр сайд. Боловсролын сайд хариулт өгье.

П.Наранбаяр: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт багш нарын цалин хөлсний бүтцийн судалгааг хийж, цалинг үе шаттай нэмэгдүүлэх бодлого тусчихсан байгаа. 2024 онд батлагдсан “Багшийн гурван тулгуурт бодлого”-д мөн багшийн хөлсийг нэмэгдүүлэх арга хэмжээг тусгасан.

Ер нь үе шаттай нэмэгдүүлж, улсын дунджид хүргэнэ гэсэн байгаа.

2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчийн цалингийн сүлжээг шинэчлэн тогтоогоод өнөөдөр сургуулийн өмнөх боловсролын багшийн үндсэн цалин 1.6 сая, ерөнхий боловсролын багшийн үндсэн цалин 1.5 сая төгрөгт хүрсэн нь 2020 онтой харьцуулахад хоёр дахин өсчхөөд байгаа ийм үзүүлэлт.

Мөн “Багшийн гурван тулгуурт бодлого” дээр багшийн нийгмийн халамж, хангамжийг сайжруулах иж

бүрэн бодлого тусгасан. Засгийн газрын тогтоол гарсан байгаа.

Энэ дээр багшийн ажлын үнэлэмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон нийтэд нөлөөллийн ажлыг зохион байгуулах. Мөн багшид орон сууцын дэмжлэг үзүүлэх гэх зэрэг олон бодлогууд туссан байгаа.

Тэтгэврийн насны тухайд 50-иас 55 нас. Өөрсдөө хүссэн тохиолдолд гэсэн. Үүнийг Та хэлж байна. Ер нь яах вэ, өнөөдөр багшийн хомсдол хүчтэй тавигдаж байгаа ийм үед тэтгэвэрт эрт гаргах нь тэр болгон зохимжгүй болов уу гэсэн ийм бодол байдаг.

Ер нь багшийн ажил чинь хамгийн сайхан мэргэжлийн нэг шүү дээ.

Тэгэхээр зэрэг үүнийгээ хүнд хортой гэж ярих нь бас жоохон учир дутагдалтай болов уу гэж боддог.

Харин хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, мэргэжлийн хүчний асуудлыг судлах учиртай.

Цэцэрлэг, сургуулийн хүртээмж. Цэцэрлэг, сургуулийн тэр бүлэг дүүргэлтийн асуудал Засгийн газрын түрүүн дурдсан тогтоолоор “Багшийн гурван тулгуурт бодлого”-ыг баталсан энэ тогтоолынхоо 3.1.11-д “...нэг багшид ногдох суралцагчийн тоог үе шаттайгаар бууруулж, улсын дунжийг 20 суралцагчид хүргэнэ.” гээд заачихсан байгаа.

Бидний хийсэн судалгаагаар 1, 2 дугаар ангид 45-аас дээш хүүхэдтэй ийм бүлгийн тоо улс орон даяар харахад 1, 2 дугаар ангидаа 97 орчим байна.

Тэгэхээр энэ бүлгүүдэд туслах багшийг оруулж ажиллуулах. Өөрөөр хэлбэл Багшийн хөгжлийн хуулийн 8.4-т энэ заачихсан заалтыг бас хэрэгжүүлэх ийм шаардлага зүй ёсоор урган гарч байгаа.

Ингэснээр багшийн ачааллыг их хөнгөлнө.

Мөн манай Байнгын хорооны гишүүдийг би сайдын хувиар хүлээж авч уулзаж байх үед Ц.Мөнхтуяа гишүүн танаас энэ санал гарч байсан. Үүнийг би ажил хэрэгчээр хүлээн авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Одоо Сангийн сайдтай хамтарсан орон тооны жишиг дээд хязгаарыг тогтоох нэг ийм тушаалын төсөл.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь нэмж хариулья.

Ж.Батсуурь: Ж.Мөнхтуяа гишүүний асуултад хариулья.

Сая Н.Учрал сайд маш тодорхой хариулсан. Засгийн газрын барьж байгаа бодлого бол төвлөрлийг сааруулах.

Сая Д.Батлут гишүүн ч асууж байна. Орон нутгийг ажлын байраар хангах, орон сууцжуулах гээд.

Зөвхөн багш гэлтгүй бид

- ▶ миний анхны байр,
- ▶ миний түрээсийн орон сууц,
- ▶ миний амины орон сууц,
- ▶ миний сонголт орон нутаг,
- ▶ миний сонголт нийтийн алба

гэсэн ийм орон сууцын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

Тэгээд энд яах вэ гэхээр мэдээж ипотекийн зээлийн хөнгөлөлт, урьдчилгаа төлбөрийн хөнгөлөлт. Мөн юу гэдэг юм орон нутагтаа амьдрах юм бол түрээсээ төлөх замаар орон сууцынхаа төлбөрийг хийж, тэр нь түрээслэх замаар өөрийн өмчлөл болох. Мөн өмчлөл болохгүйгээр тэнд ажиллаж байх хугацаандаа түрээслэх.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулья. Минут өгье.

Ж.Батсуурь: Тэгэхээр хамгийн гол зүйл бол төвлөрлийг сааруулах, орон нутагт амьдарч байгаа хүн, багш гэлтгүйгээр энэ олон боломжуудыг хангаж ажиллаж болох юм байна.

Тийм учраас хамгийн гол нь цалинд нь таарсан, орлогод нь таарсан орон сууцын бүх боломжуудаар хангах ийм л бодлогыг энэ төрлүүд дээр дэмжин ажиллах болно гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Ц.Мөнхтуяа гишүүн тодруулга.

Ц.Мөнхтуяа: П.Наранбаяр сайд яг тоо, судалгаатай юм хэлсэнгүй. Тоймтой мөрийн хөтөлбөр дээр нэг тодорхой биш юмнууд яваад байгаа шүү дээ.

Тэгэхээр дээр Та нэлээн нарийн тооцоо, судалгаа гаргах хэрэгтэй байх. Сайдын хувьд, салбарын сайдын хувьд.

50, 55 бол эрт гарч болохгүй ээ. Багшийн дутагдалтай байна гэж ярьж

байгаа чинь өөрөө аягүй буруу ярьж байна шүү.

Багш нар эрүүл мэндийн хувьд бас их асуудалтай байгаа учраас эртхэн тэтгэвэрт гаръя. Тэтгэвэрт гараад нэг жил болохгүй өөд болцгоож байна шүү дээ. Ачаалал маш хүнд байна. Үүнийг хүнд хортой гэхээсээ илүү ачааллыг нь аягүй сайн нарийн судлахгүй бол зүгээр л нэг бүдэг бадаг юм яриад л, ингэж болохгүй, тэгж болохгүй гээд яваад байж болохгүй гэж бодож байна. Хүний амьдрал, амь настай холбоотой асуудал бас яригдаж байгаа шүү. Энэ дээр.

Зарим багш нар самбарынхаа өмнө харваад өнгөрч байгаа ч тохиолдол гарч байгаа шүү дээ. Энэ дээр П.Наранбаяр сайд өөрөө мэдээлэлтэй байгаа байх гэж бодож байна.

Тэгээд тэр 44-өөс дээш хүүхэд дээр туслах багш ажиллуулна гээд байсан шүү дээ.

Тэгэхээр энэ дээр дахиад нэг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Минут дууссан байна. П.Наранбаяр сайд нэмж хариулах уу? Нэмэлт хариулт.

П.Наранбаяр: Тэгэхээр Ц.Мөнхтуяа гишүүн ээ, ер нь багш ингээд богино наслаад. Ийм юм би танаас юу яаж байна. Анх сонсож байна. Урт сайхан насалж олон шавиараа тойрон хүрээлүүлсэн зөндөө л багшийг би мэднэ.

Тохиолдлууд байгаа байх аа. Гэхдээ багшийн мэргэжил гэдэг бол хамгийн бахархам сайхан мэргэжил байдаг. Энэ мэргэжлийг та ингэж бас яаж болохгүй байх аа.

Зүгээр юуны хувьд тэр 97 багшийн асуудал л яригдаж байгаа юм. Тэр багшийн хомсдол чинь 4200-гаар яригдаж байгаа.

Гэхдээ энэ туслах багш чинь тэтгэвэртээ суучихсан, мөн өөрөө ажиллах сонирхолтой ийм хүмүүсийг түлхүү авч ажиллуулна. Энэ чинь ядахдаа гэрийн даалгаврыг нь шалгаж өгөөд ангид нь нэмэр болоод байвал маш их ачааллыг бас үүрэлцэх ийм хүмүүс байхгүй юу.

Тэгэхээр ер нь боловсролын салбарын хомсдолын асуудлыг бид шийдвэрлэхдээ багшлах эрхийг тийм хялбаршуулсан журмаар олгох, гадаад дотоодын нэртэй сургуульд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт боллоо. Батжаргалын Заяабал гишүүн асуултаа асууя.

Байж байгаарай. 13.00 цаг болсон байна.

Үдээс өмнөх хуралдааныг үргэлжлүүлнэ. Өнөөдөр олон асуулт, олон санал хураалттай байгаа. Хуралдаан үргэлжилнэ. /алх цохив/

Б.Заяабал гишүүн асуултаа асууя.

Б.Заяабал: Баярлалаа. Өнөөдөр би Эдийн засаг, хөгжлийн яам болон Эрчим хүчний яамнаас хоёр асуулт асуух гээд байгаа юм.

Тэгэхээр бид бүгдээрээ хоёр сарын өмнө иргэд, сонгогчидтойгоо уулзаж намын мөрийн хөтөлбөрүүдийг танилцуулж, саналыг нь авч, бүгдээрээ сонгогдож орж ирсэн.

Бид нарт бас ярьж хэлж байсан, танилцуулж байсан мөрийн хөтөлбөрүүдийн биелэлтийг хангаж чадна гэж бидэнд итгэж өнөөдөр Их Хуралд суулгаж байгаа гэж ингэж ойлгож байгаа.

Энэ дагуу өнөөдөр гурван намын мөрийн хөтөлбөрүүдийг нэгтгэсэн ийм Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг манай Засгийн газар маань боловсруулж оруулж ирж байна.

Өнгөрсөн 2020-2024 оны Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 250 орчим арга хэмжээ төлөвлөж орж ирж байсан бол энэ удаагийн Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагаа 590 орчим үйл ажиллагаануудыг тусгаж орж ирж байна.

Хамгийн гол нь энэ 4 жил хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнд иргэдийн маань амьдрал дээшилсэн байх ёстой. Энэ бодлогын хэрэгжилтийн үр дүнд Монголчууд бүгдээрээ өнөөдрийн байгаа түвшнээсээ өссөн байх ёстой. Энэ бол энэ 4 жилийн бид нарын боловсруулж ярилцаж байгаа хөтөлбөрийн үр дүн байх ёстой юм. Энэ агуулгаар нь би асуулт асуух гээд байгаа юм.

Нэгдүгээрт нь, Монголчууд бид 3.5 саяулаа бид амьдарч байна. Өрхийн хувьд 950 орчим мянган өрх байгаа гэж үзэж байгаа.

Саяхан энэ оны эхээр Дэлхийн банк, Үндэсний статистикийн газрын хамтарсан судалгаа гарсан байгаа.

Энэ дээр Монгол Улсын ядуурлын түвшин 27 хувьтай гээд. Тэр дундаа манай баруун бүсийн ядуурлын түвшин 36.5 хувьтай. Ядуурлын түвшнээс

түвшинд амьдарч байна гэсэн ийм судалгаа гарсан байгаа юм.

Тэгэхээр Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг манай Засгийн газрынхан маань боловсруулж оруулж ирэхдээ мэдээж энэ судалгаануудыг хийсэн байх.

Бид нарын ярьдаг зүйл байгаа шүү дээ. Чинээлэг дундаж давхаргын нийгмийг бий болгоно л гэж яриад байгаа.

Өнөөдөр Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг боловсруулахын тулд бас статистик мэдээлэл судалгаанууд дээр нэлээдгүй ажилласан байх гэж бодож байгаа юм.

Тэр агуулгаараа би асуух гээд байгаа юм. Өнөөдөр яг нийт өрхийн хэдэн хувь нь чинээлэг давхаргад амьдарч байна вэ? Нийт өрхийн хэдэн хувь нь чинээлэг дундаж давхаргад байна вэ? Нийт өрхийн хэдэн хувь нь дундаж давхаргад байна вэ?

Ядуурлын түвшинд амьдарч байгаа хувь хэмжээг би сая хэлчихлээ.

Тэгэхээр энэ дээр өнөөдрийн түвшин ямар байна вэ?

4 жилийн дараа энэ түвшин маань яаж өөрчлөгдөх юм бэ? Орлогын тэгш бус хуваарилалтыг зохицуулалт хийсний үр дүнд чинээлэг давхаргын хэмжээ нь хэд болох юм? Чинээлэг дундаж давхаргын хэмжээ нь хэд болох юм? Дундаж давхаргын хэмжээ хэд болох юм? Айл өрхүүд дээр ирж байгаа өөрчлөлт нь хэр зэрэг байх юм бэ гэдэг дээр тодорхой мэдээлэл өгөөч ээ.

Мэдээж амьдралын түвшин дээшлэхийн цаана орлогын асуудал яригдана. Өрхийн орлогын бүтцийг аваад үзэх юм бол цалин хөдөлмөрийн орлого нь хэдээр нэмэгдэх юм? Өрхийн өөрийнх нь үйлдвэрлэлийн орлого хэдээр нэмэгдэх юм гэсэн ийм тооцоо судалгааг бас хэлж өгөөч ээ гэдэг ийм нэгдүгээр асуулт байна.

Хоёрдугаарт нь, эрчим хүчний салбарынхнаас асуухад Монгол Улс асар их хэмжээний сэргээгдэх эрчим хүчний нөөцтэй. Үүнийгээ бид мөнгө болгох цаг болсон. Үүнтэй холбоотой ямар бодлогын арга хэмжээнүүд явж байна вэ?

Өнөөдөр сэргээгдэх баялгаа бид баялаг болгоод экспортлоод асар их хэмжээний орлого олох боломж байна.

Дээрээс нь айл өрх болгон өнөөдөр эрчим хүчийг хэрэглэгч биш, эрчим хүчийг үйлдвэрлэгч, сүлжээндээ нийлүүлдэг, эргээд орлого олох ийм боломж байгаа юм. Энэ дээр ямар бодлогуудыг ойрын хугацаанд хэрэгжүүлэхээр зорьж байгаа вэ? Энэ асуудалд хариулж өгөөч.

Д.Амарбаясгалан: Л.Гантөмөр сайд хариулах уу? Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр хариулъя.

Л.Гантөмөр: Б.Заяабал гишүүний асуултад хариулъя.

Ер нь Монголын дотоодын нийт бүтээгдэхүүнийг дорвитой нэмэгдүүлэхгүйгээр бид одоо энэ “ядуурал” гэдэг үгнээс салахгүй юм билээ. Ядууралыг алга болгоод ядуурал гэдгээ одоо юу гэдэг юм багасгая гэх юм бол эдийн засгаа л өсгөх хэрэгтэй.

Тийм учраас бид энэ 4 жилийн хугацаанд эдийн засгаа тууштай өсгөнө гэдэг ийм л бодлогыг хамгийн түрүүнд баримталж байгаа.

Нөгөө талдаа ядуурлыг тооцоолдог матриксын хувьд олон улсын бодолтын аргаар жишээлбэл баруун бүсийн ядуурал багасахааргүй байгаа байхгүй юу.

Яагаад гэвэл тэр туулж очиж байгаа зам, төрийн үйлчилгээ авч байгаа хүртээмж. Нэг үгээр хэлбэл алслагдах тусмаа ядуурал байна гэж үзээд байгаа юм.

Тэгэхээр бид нэг зүйлийг их тодорхой хэлээд байгаа юм.

Орлого талаа хоёр дахин нэмэгдүүлнэ. Нэг үгээр хэлбэл өнөөдрийн орлогын түвшнээр ядуу гэж тооцогдож байгаа 27 хувь бол 4 жилийн дараа хоёр дахин буурсан байх ёстой. Энэ бол одоо бид нарын зорилго.

Үүнийгээ одоо бүр жижиглээд яг аль хэсэгт нь ямар анхаарал тавих вэ, аль хэсгийнхээ орлого ямар замаар хэрхэн нэмэгдэх вэ гэдэг нь ХҮН намын яаман дээр их тодорхой төсөл, хөтөлбөрүүдийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөр болоод бусад олон улсын байгууллагуудтай нийлээд тооцооллын аргуудаа нэгтгээд ингээд явж байгаа ийм л зүйл байгаа.

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт. Б.Заяабал гишүүн хариулт болов уу? Тодруулга.

Б.Заяабал: Тийм. Тэгэхээр манай төрийн бодлого яг иргэд рүүгээ, өрх рүүгээ чиглэсэн ийм бодлого л явах ёстой л доо.

Өнөөдрийн бид Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтот түвшин гээд баахан олон улсын ийм судалгааны байгууллагуудаас гаргадаг зорилтот түвшнүүдийг бид тавьчхаад сууж байгаа юм.

Гэтэл яг хөдөө суманд ажиллаж амьдарч байгаа өрхийн хувьд ямар өөрчлөлт орох юм, малчин өрхийн хувьд ямар өөрчлөлт орох юм, аав ээж нь төрийн албан хаагч хийдэг энэ өрхөд ямар өөрчлөлт орох юм.

Өрхийн орлогын хэмжээ нь цалин, хөдөлмөрийн хөлсөөр нэмэгдэх юм уу, эсвэл үйл ажиллагаа, бизнесийг нь дэмжих замаар үйл ажиллагааны орлогуудыг нэмэгдэх юм уу гэдэг ийм том бодлогуудыг бид тодорхойлох ёстой л доо.

Халамжийн хавтгайралтай холбоотой ажил эрхэлж байгаа хүмүүсийн чинь тоо буураад байна шүү дээ.

Тэгэхээр эдийн засгийг өсгөхийн тулд энэ талын бодлого хамгийн чухал юм гэдгийг л би тодруулж хэлж өгөөч ээ л гэдгийг л асуугаад байгаа юм.

Өрх болгоны тоогоор нь хэлж өгөөч ээ гэдэг л ийм асуулт асуугаад байгаа юм.

Х.Булгантуяа: Л.Гантөмөр сайд нэмж хариулах уу?

Л.Гантөмөр: Тийм. Б.Заяабал гишүүнтэй санал нэг байна. Ер нь санал нэг байгаа.

Юу вэ гэхээр бид ажил эрхэлдэг хүнийхээ тоог л харж явах хэрэгтэй. Яг

өнөөдөр Монголын хамгийн том асуудал юу вэ гэхээр ажил эрхэлж болох хүнийх нь 62 хувь нь ажил эрхлээд, үлдсэн бараг 40 хувь нь ажилгүй байгаа гэсэн бүрдгэлтэй байгаа юм.

Тэгэхээр энэ хүмүүс ажилтай байх. Ер нь хүн тогтвортой ажилтай байх, тэр нь эдийн засгийн өсөлт нь байнга ингээд оролцоотой байх гол нөхцөл бол үйлдвэр юм билээ л дээ.

Тэгээд Монголын эдийн засгийн хамгийн сул тал бол ерөөсөө үйлдвэрлэл байхгүй гэдэг дээр л оршоод байгаа юм. Худалдаа, үйлчилгээ.

Одоо сургууль төгссөн хүүхдүүд үйлчилгээний салбарт л нэг ажлын байр олдож байна шүү дээ.

Тийм учраас энэ Засгийн газрын бодлогын хамгийн чухал зүйл бол уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл дээр онцгой ач холбогдол өгнө. Ингэхийн тулд эрчим хүчний либералчлал буюу эрчим хүчнийхээ үйлдвэрлэл дээр онцгой анхаарна гэсэн энэ бодлогын үр дагавраар.../минут дуусав/

Х.Булгантуяа: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Баярлалаа. Ихэнх саналуудаа Байнгын хороод дээр хэлчихсэн учраас тодорхой гурван зүйл байна.

Нэг. Ажлын хэсгийн даргад хандаад Засгийн газрын энэ бодлого, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт орж байгаа үг болгон, нэр томьёо болгоны цаана ажлууд байгаа. Тэр ажлуудтай уялдсан төсөв байгаа. Түүнийг хэрэгжүүлэх үр дүнгийн зорилт байгаа.

Тийм учраас хоёрдмол энэ утгатай үгнүүд маш их байна.

Хоёрдугаарт, гадаад үг хэллэг зарим газар гамгүй орсон зүйлс байгаа. Энэ дээр Монгол хэлний зөвлөлөөр дараагийн хэлэлцүүлгийн өмнө энэ хөтөлбөрөө бас нэг хянуулбал зүгээр байна гэдэг ийм техникийн чанартай санааг хэлж байгаа юм.

Хоёрт нь, Т.Мөнхсайхан сайд, Эрүүл мэндийн сайд руу хандаж хэлж байна. Асууж байна.

Түрүүн Н.Учрал сайд хэллээ. Одоо энэ том том төсөл хөтөлбөрүүд, мега төсөл хөтөлбөрүүд, энэ төлөвлөж байгаа зүйлүүд маань эцсийн эцэст явж явж Үндсэн хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй орчинд иргэн амьдрах эрхийн талаар байгаа. Хүн рүүгээ чиглэсэн бодлого байгаа гэж хэлж байгаа.

Тэгэхээр яг өнөөдрийн байдлаар яг энэ хамтарсан Засгийн газрын өмнөх судалгаагаар жишээлбэл өвчлөлийн индекс ер нь ямар байна? Одоо ингээд өнөөдөр гэхэд Төв аймгийн Бүрэн сум, Сэлэнгийн Зүүнхараа дээр хоёр насанд хүрээгүй хүүхдийн хандивын хорт хавдрын аян явж байх жишээтэй. Энэ бол тоо томшгүй явж байгаа. Сүүлийн жилүүдэд хүүхдүүдийн дундах энэ аймшигтай өвчлөл хэрээс хэтэрсэн байгаа. Жилдээ хэдэн сая доллар жишээлбэл гадагшаагаар урсаж байдаг юм.

Тэгэхээр Т.Мөнхсайхан сайдаас асуух гээд байгаа санаа нь болохоор таны Эрүүл мэндийн сайдын хувьд энэ хүн амынхаа эрүүл, аюулгүй байдлын төлөө бодлого чинь Засгийн газрын мөрийн хөтөлбөрт бүрэн тусаж чадсан уу? Тэр холбогдох төсвүүд нь бүрэн орж чадсан

уу? Энэ дээр яг тодорхой санаа оноо байгаа юу гэж асуумаар байна.

Дараагийн гурав дахь асуулт Ж.Энхбаяр сайд руу чиглэж байгаа.

Төвлөрлийг сааруулах гэдэг концепц яваад байгаа. Тэгээд сонсох нь Та энэ Дархан-Уул аймаг руу яамаа нүүлгэе гэж байна. Тэгээд холбогдох хөдөө аж ахуйн сургуулиа нүүлгэе гэж байна. Институцүүдээ нүүлгэе гэж ярьж байгаа.

Тэгээд энэ яг бодитоороо түгжрэлийг сааруулах ямар судалгаа байгаа юм бэ? Энд ложистикийн хувьд ямар хугацаа шаардлагатай, ямар хөрөнгө шаардлагатай. Энэ чинь хөтөлбөр дээр хэр зэрэг оновчлолтой орсон юм бэ?

Тэр Үрчээний Энхтайван гээд судлаач залуу түгжрэлийг сааруулах гэхээсээ илүүтэйгээр байгаа газар орондоо, одоо тэр байгаа хүмүүст нь амьдралынх нь хүрэлцээтэй зүйлийг, хэв маягийг нь маш хурдан бодлогын хэмжээнд шинэчлэх ёстой гэж жишээлбэл хэлээд байх жишээний.

Тэгэхээр Ерөнхийлөгч бас сүүлийн үед төрийн байгууллагуудыг Хархорин руу нүүлгэнэ ч гэдэг юм уу, энд яг ийм нэгдсэн уялдаатай концепц, судалгаа байна уу гэдэг асуултуудыг асууя.

Тэгээд Т.Мөнхсайхан сайд Та тэр Солонгос болон бусад орон руу жилдээ урсаж байгаа долларын урсгал, эрүүл мэндийн зардал, эмчилгээ үйлчилгээтэй холбоотой долларын урсгал хэт болж байгаа талаар мэдээллийг бас өгөхгүй юу. Баярлалаа.

Х.Булгантуяа: Эхний асуултад Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан хариулья.

Т.Мөнхсайхан: Манай улсад өвчлөл жил болгон нэмэгдэж байгаа. Үүний шалтгаан бид өнгөрсөн хугацаанд илүү их эмнэлгийн тусламж, үйлчилгээ буюу өвдсөнийх нь дараа эмчлэх бодлого барьж ирсний уршиг байгаа.

Тийм учраас бид цаашдаа яаж ард иргэдээ өвчин тусгахгүй байх вэ. Туссан тохиолдолд яаж эрт илрүүлж оношлох вэ. Сургуульд суурилсан эрт илрүүлгийн тогтолцоог яаж оновчтой зөв хийх вэ гэдэг бодлого.

Дараагийн гол асуудал бол Монголд эмчлэгдэхгүй байгаа өвчлөлийг яаж Монголд эмчлэх вэ гэдэг. Энэ дотор хорт хавдар нэлээн тэргүүлэх байр суурь эзэлж байна л даа.

Өнөөдөр Монголд яг хорт хавдраар өвчлөлтэй онош нь тогтоогдсон 28 мянган хүн байна. Ингээд жилдээ 4500 орчим хүн хорт хавдраар буюу нийт нас баралтын 30-аас 35 хувийг хорт хавдрын улмаас нас баралд эзэлж байна.

Тэгэхээр бид цаашдаа энэ хорт хавдар дээр үүсгээд байгаа шалтгаан болгон дээр нь бид бодлогуудыг хэрэгжүүлэх ёстой. Жишээ нь, бид элэгний хорт хавдар гэхэд үүний гол шалтгаан Б, Ц, Д вирусийн халдвар, энэ архидалтын асуудлаас гол шалтгаан байгаа.

Тэгэхээр бид энэ халдварын тархалтыг бид яаж зогсоох ёстой юм. Ард иргэдээ энэ халдвар авсан тохиолдолд хавдар үүсэх эрсдэлтэй гэдгийг ойлгуулж, яаж хянах юм бэ.

Одоо ходоодны хавдар гэхэд гол шалтгаан хеликобактери болон чанаргүй хоол хүнстэй холбоотойгоор ходоодны хавдар үүсэж байна.

Тэгэхээр бид энэ шалтгаануудыг яаж арилгаж, хүнсний чанарыг яаж сайжруулах юм, хеликобактерийн тархалтыг яаж зогсоох юм гэдэг бодлогууд чухал байна.

Дээрээс нь эд нарыг бид яаж оновчтой бага зардлаар эрт илрүүлгийг оношилж чаддаг болгох вэ гэдэг бодлого чухал байна.

Ингээд дараад нь бид өнөөдөр Монголд үүсээд байгаа Монголд эмчлэгдэхгүй байгаа, гадагшаа явж эмчлүүлснээсээ болоод үүсээд байгаа ядууралд бид хэрхэн яаж өөрчлөлт хийх ёстой юм бэ гэдэг энэ бодлогууд чухал байгаа.

Энэ дээр бид ер нь яамны шинэ бүтцэд гадагшаа явж эмчлүүлж байгаа урсгалыг зогсох ийм нэгжүүдийг шинээр бий болгож ажиллаж байгаа. Шинэ мэргэжилтэн бий болж байгаа. Энэ дээр бид Монголоос гадагшаа явж эмчлүүлж байгаа, Солонгос, Япон, Турк, Энэтхэг улсуудыг явж эмчлүүлж байгаа улсуудыг яаж хяналтдаа байлгаж тусламж, үйлчилгээг нь илүү их ойртуулах вэ гэдэг энэ бодлогын ажлууд маань хийгдээд явж байгаа.

Өнөөдрийн байдлаар зөвхөн Солонгос Улс руу явж байгаа валютын урсгал гэхэд зүгээр Солонгос талаас хийгдсэн судалгаануудыг харахаар 700 орчим тэрбум төгрөгийн урсгал эрүүл мэндийн талаас гарч байна гэдэг ийм тоо баримт, судалгаанууд байгаа.

Манай талаас хийгдсэн судалгаанууд маш их бага гараад байгаа.

Бид үүнийг яг бодитойгоор энэ тоонуудыг тодорхой болгож, энэ дээр дорвитой, бодитой арга хэмжээ авахын тулд гадаадад эмчлүүлэгчдийг дэмжих нэгжийн асуудлыг бид тодорхой болгож, гол эмчлүүлж байгаа түрүүний хэлсэн.../минут дуусав/

Х.Булгантуяа: Т.Мөнхсайхан сайдын. Хоёр дахь хэсэг нь та Ж.Энхбаяр сайдаас асуугаад байсан уу? С.Эрдэнэболд гишүүн ээ. Ж.Энхбаяр сайдаас.

Тэгээд араас нь тодруулчхаарай. С.Эрдэнэболд гишүүн.

Ж.Энхбаяр: Мөрийн хөтөлбөрт Хүнс, хөдөө аж ахуйн яам болон салбар байгууллагуудыг орон нутагт шилжүүлэх ийм зорилт тавигдсан байгаа.

Үнэхээр төвлөрөл өөрөө Монгол Улсын их том сорилт болоод байгаа. Тэгээд төвлөрлийг сааруулахын тулд хөдөөгийн хөгжлийн асуудал нэгдүгээрт тавигдах ёстой. Тэнд хүн ажиллаж амьдрах, орлоготой байх тэр бололцоог хангах ёстой.

Нийслэл Улаанбаатар хотод төвлөрлийг сааруулах гол боломж нь төвийн бүс байгаа. Дархан, Сэлэнгэ, Төв аймаг.

Нөгөө талаар энэ бүс нутаг маань Монгол Улсын газар тариалангийн гол цөм нутаг, хөнгөн хүнсний үйлдвэрийн гол цөм нутаг. Харьцангуй дэд бүтэц, хүн ажиллаж амьдрах харьцангуй нөхцөл бололцоо нь хангагдсан.

Иймд ковидоос авсан их томоохон сургамж байдаг. Хэрвээ ковидын цар.../минут дуусав/

Х.Булгантуяа: С.Эрдэнэболд гишүүн нэмж тодруулах уу? Ж.Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Ковидын сургамж байгаа юм. Ковид хэрвээ ахиад 3 сарын хугацаанд цар тахал үргэлжилсэн бол Монгол Улс картын бараанд орохоос ийм аргагүй нөхцөл байдал тогтоогдож байсан.

Иймд яаралтайгаар хүнсний аюулгүй байдлыг хангахын тулд хөдөө аж ахуйн эрчимжсэн бүсүүдийг яаралтай хөгжүүлэх. Түүн дээрээ тулгуурласан хөнгөн хүнсний үйлдвэрийнхээ салбарыг яаралтай босгож ирэх нь Монгол Улсын хойшилшгүй зорилт байгаа.

Тэр зорилтын хүрээнд энэ төвийн бүсийн хөгжлийн асуудал. Үүнийгээ дагуулаад төвлөрлийг сааруулахад гол шингээгч бүс нутаг нь төвийн бүс гэж үзэж байгаа.

Ийм ч учраас Засгийн газраас авхуулаад ер нь бусад яам, Тамгын газрыг ер нь төвийн бүс Төв аймаг руу шилжүүлэх ийм том зорилт энэ хөтөлбөрт, тодотголд тусаж байгаа.

Тэгээд эхний улс төрийнх нь шийдэл, эхний мөс зүсэлт Хүнс, хөдөө аж ахуйн яам хийж Дархан, Сэлэнгийн бүс нутагт шилжин ажиллахад бид бэлэн байгаа.

Х.Булгантуяа: С.Эрдэнэболд гишүүн тодруулъя.

С.Эрдэнэболд: Т.Мөнхсайхан сайдаас би яг товчхон дахиад асуухад шүү дээ.

Таны бодож байгаа зүйлүүд, таны төлөвлөж байгаа зүйлүүд Монголын ард түмний амь нас, эрүүл мэнд, хувь тавилантай шууд холбоотой сэдэв байхгүй юу.

Тийм учраас таны ингээд бодоод байгаа зүйлүүд чинь яг хөтөлбөрт бүрэн дуусаж чадсан уу? Гол нь одоо нөгөө багаж төхөөрөмж шүү дээ. Та өөрөө мэс засалч хүн. Яг ингээд бүх юм чинь бэлэн байж явна шүү дээ.

Яг энэ хөтөлбөрт хангалттай тусаж чадсан уу? Хэрвээ тусаж чадаагүй зүйлүүд байгаа бол одоо л хэлж авахгүй бол энэ чинь ингээд нэг батлагдаад цаашаагаа явчихна шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр үүнийгээ Та илэрхийлээрэй гэдгээ хэлэх гээд байгаа юм.

Хоёрдугаарт, Ж.Энхбаяр сайдтай холбоотойгоор тодруулаад дахиад нэг юм асуухад энэ дээр арай өөр хүн хариулж магадгүй.

“Шинэ Зуунмод” гээд яваад байдаг. Манай Төв аймгийн төв чинь ер нь аймгийн төв хэвээрээ байх юм уу, эсвэл хотын тэлтээс болоод манай Төв аймгийн төв байхгүй болчих юм биш үү гэдэг хүмүүсийн ийм асуулт яваад байгаа. Энэ дээр нэг тодорхой хариулт өгчихгүй юу. Баярлалаа.

Х.Булгантуяа: Т.Мөнхсайхан сайд нэмж хариулъя.

Т.Мөнхсайхан: Энэ үйл ажиллагааны хөтөлбөрт ер нь тусгах

ёстой зүйлүүд үндсэн том агуулгаараа тусчихсан байгаа гэж ойлгож болно.

Гэхдээ манай эрүүл мэндийн салбарын нийт санхүүжилтийг ярих юм бол өнөөдөр дотоодын нийт бүтээгдэхүүний 2.8 орчим хувийг эрүүл мэндийн салбарт зарцуулж байгаа юм.

Тэгэхээр цаашид энэ төсвийн. Ер нь дотоодын нийт бүтээгдэхүүний 6-аас доошгүй хувийг эрүүл мэндийн салбарт зарцуулж байж бидний өнөөдрийн энэ яриад байгаа тулгамдсан асуудлууд маань шийдэгдэх боломж бүрдэнэ. Олон улсын дундаж нь доод тал нь 6 байдаг.

Тэгэхээр өнөөдрийн байгаа 2.8-ыг бид 6 руу аваачиж байж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, цаад өвчний сэргийлэлтийн ажлууд маань их үр өгөөжтэй хийгдэх ийм боломжууд байгаа гэж харж байгаа.

Х.Булгантуяа: Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууя. Хариулахаар байна уу? Н.Учрал сайд.

Н.Учрал: Улаанбаатар хотын энэ их ачаалал, төвлөрлийг Төв аймаг руу гэхээсээ илүү төвийн бүс рүү тэлэх ийм л бодлогыг барьж байгаа.

Тийм ч учраас “Шинэ Зуунмод хот”-ын эрх зүйн байдлын хуулийг баталсан. Ингээд “Шинэ Зуунмод хот” бол бие даасан хот болж хөгжинө.

Гэхдээ одоогийн Төв аймаг мэдээж аймгийнхаа статустайгаараа үлдэлгүй яах вэ. Гэхдээ хот тосгоны энэ батлагдсан хуулиар 2026 оны 01 сарын 01-нээс энэ аймгийн төвүүдийг орон нутгийн зэрэглэлтэй хот болгож хөгжүүлж байгаа юм.

Тэгэхээр нөгөө бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулах. Дээрээс нь “улсын зэрэглэлтэй хот”, “орон нутгийн зэрэглэлтэй хот” гээд ийм хоёр статус байгаагийн гол зорилго “улсын зэрэглэлтэй хот” чинь дэргэдээ “дагуул хот”-ыг чиглэл чиглэлээр нь хөгжүүлж болох ийм боломжийг бас нээсэн.

Дээрээс нь энэ удаагийн төсөв дээр яг хамгийн их чухал зүйл бол энэ ялгаатай татварын бодлого.

Тэгэхээр ямар нэгэн татварын хөшүүрэг хэрэглэхгүйгээр хүнийг тэнд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх хэцүү.

Тэгэхээр хүн яаж авчрах вэ, тэнд яаж зах зээл нэмэгдүүлэх вэ.../минут дуусав/

Х.Булгантуяа: Н.Учрал сайдад хариулт нэмэлт минут өгье.

Н.Учрал: Тийм. Тэгэхээр бид Улаанбаатар хотын түгжрэл, төвлөрлийг Төв аймаг ачааллыг нь хуваалцах гэж байна. Төвийн бүс ачааллыг нь хуваалцах гэж байна гэж ойлгож болно.

Энэ ч утгаараа жишээ нь Ж.Энхбаяр сайд бас манлайлаад ер нь Засгийн газрын зүгээс энэ Хүнс, хөдөө аж ахуйн яамыг, энэ салбарыг яг төвийн бүстэй үйл ажиллагаа явуулах бололцоогоор нь хангая. Ингэж байж тэнд хүн оршин тогтнох гэдэг утгаараа тэр бусад үйлчилгээн дээр явуулья гэж.

Түрүүн бас Т.Мөнхсайхан сайдаас асуугаад байна. Яагаад энэ Засгийн газар 15 төсөл яриад байгаа юм бэ гэдэг чинь ерөөсөө л энэ эдийн засгаа тэлье, экспортын орлогоо нэмэгдүүлье. Ингэж байж эрүүл мэндийн үйлчилгээ, боловсролын үйлчилгээнд зарцуулах

хөрөнгө оруулалт нэмэгдэхгүй бол нөгөө “хөнжлийнхөө хэрээр хөлөө жийнэ” гэж үг байгаа шүү дээ.

Түүнээс биш Т.Мөнхсайхан сайдын бодож байгаа, санаж байгаа бүх зүйл энэ 4 жилийн хөтөлбөрт сууна гэж угаасаа байхгүй шүү дээ.

Эдийн засаг тэлэхгүйгээр, өсөлт нэмэгдэхгүйгээр эрүүл мэндийн үйлчилгээг хүн бүрд тэгш хүртээмжтэй хүргэх бэрхшээлтэй учраас энэ төслүүдийг явуулахад дэмжлэг үзүүлээч ээ л гэж Их Хурлын гишүүдээс хүсэж байгаа.

Х.Булгантуяа: Манай сайд нар маш сайн тодорхой хариулна шүү.

Сая С.Эрдэнэболд гишүүн маш тодорхой асуусан шүү дээ.

Яг хэдэн төгрөг гадаадад эмчилгээнд зарцуулаад байна вэ? Үүнийг багасгахын тулд яг юу хийж байна вэ гээд.

Өнгөрсөн онд Эрүүл мэндийг дэмжих сангийн үйлчлэх хүрээг нь жишээлбэл өргөжүүлээд, шинэ техник, технологи нэвтрүүлэхтэй холбоотой зардлыг дэмжих сангаас зарцуулдаг болох. Та бүхэн маань, сайд нар маань асуудлуудаа анхаараад.

Манай Их Хурлын гишүүд бүх юм нь туссан байгаа даа гээд санаа зовж асууж байгаа учраас Та бүхэн хэрвээ тусаагүй үлдсэн зүйлүүд байвал одоо л түүнийгээ тусгаж авах ёстой шүү дээ.

Тийм учраас асууж байгаа гэдгийг ойлгоорой.

Жаргалсайханы Золжаргал
гишүүн.

Ж.Золжаргал: Баярлалаа. Хоёр асуулт байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.1.2.Үндэсний баялгийн сангийн нэгээс доошгүй хувийг инновац, технологийн салбарт зориулж эдийн засгийн салбаруудын бүтээмжийг дэмжинэ гэсэн.

Тэгэхээр Үндэсний баялгийн сангийн нэг хувь гэдэг нь юуны нэг хувь бэ гээд Сангийн сайдаас асуугаад. Хөгжлийн сангийн нэг хувь гэдэг мэдээлэл авсан.

Хөгжлийн сан гэдэг нь Баялгийн сангийн хуулиар тухайн жилийн төсөв ашигтай гараад, түүний дараа ашигт малтмалын үнэ хүлээлтээс давсан үнээр зарагдсан бол зөрүүгийнх нь талаар нь санхүүжих ийм сан.

Тэгэхээр одоо бид нарын оруулж ирж байгаа энэ төсөв дээр том төслүүд ирэх 4 жилд хэрэгжүүлэх нь. Тийм болохоор миний ойлгож байгаагаар ер нь жил болгон төсөв алдагдалтай гарах юм шиг байна.

Ямар ч байсан энэ төслийг дагаж орж ирсэн Баялгийн сангийн төсвийн тухай хууль дээр хоёр сан байгаад, Хөгжлийн сангийн төсөв бол байхгүй байгаа.

Тэгэхээр иймэрхүү байдлаар явах магадлалтай харагдаад байна.

Тэгэхээр энэ заалт маань ер нь хэрэгжих боломжтой юм болов уу? Хэзээ энэ заалтыг хэрэгжих тэр санхүүгийн эх

үүсвэр гарч ирэх бол гэдэг асуултыг нэгдүгээрт нь асууя.

Хоёрдугаарт нь, соёлын бодлоготой холбоотой нэг асуулт байгаа.

1.5 дээр, 3.3.5, 6, 7 гээд. Энэ “Соёлын бүтээлч үйлдвэрлэл”, “Монгол брэнд”. Тэгээд гадаадын жуулчдыг татах, Монгол орны нэр хүндийг олон улсад гаргах гээд арга хэмжээнүүд хийгдэж байгаа.

Үнэхээр ажиглагдаж байгаа. Урлаг соёлын наадмын. Тэгэхдээ энд нэг орхигдоод байгаа зүйл нь Монголын биет соёлын өв, археологийн олдворуудын хэрэглээ, хамгаалалт. Тэгээд нэмэх судалгааны ажлууд ингээд ер нь нэлээн орхигдоод байгаа нь харагдаад байгаа.

Зүгээр ганц хоёрхон жишээ хэлэхэд мэргэжлийн судлаач байтугай аялагч хүний үүднээс ингээд харахаар одоо энд тэнд очоод хадны зураг энэ тэр юм харахаар ингээд “10-ын В-гийн Болдоо” гээд биччихсэн тийм хамгаалалтын асуудал аягүй серъёзны харагдаж байна.

Манай хойд талын Чингис хаан музейн 3 давхарт Хүннүгийн маш олон ийм сүүлийн үед олдсон мундаг олдворууд байдаг. Тэр булшин дээр Архангай аймагт байдаг хайгуулын үеэр нь бас ингээд ороод гарахаар төсөв байдаггүй. Тэгээд л нэг ийм олон улсын байгууллагуудтай хамтардаг, хүмүүсээс гуйдаг. Олон жилийн өмнөөс ядаж гуйж явсан нөхцөл одоо болтол нэг их өөрчлөгдөхгүй байгаа ийм зураг харагдаж байгаа.

Тэгэхээр энэ дээр яагаад санаа зовж байна гэхээр нэгдүгээрт хамгийн өндөр үнэ цэнтэй соёлын өв, нөгөө

соёлын том байгууламж барихаас арав дахин бага зардлаар хайгуул хийгээд. Тэр нь бүр хэчнээн олон мөнгөөр илэрхийлсэн ч асар үнэтэй ийм үр ашигтай байхаар энэ зүйлдээ анхаармаар байгаа юм.

Хоёрдугаарт нь, сургуулиудын харьяаны хүрээлэнгүүд бас нөгөө Боловсролын яамнаасаа Эдийн засаг руу явчихсан. Шинжлэх ухааны академийн харьяа археологи дээр ямар төсөв тавигдаж байгаа юм бол. Энэ талаар ер нь энэ дээр тодорхой зүйл харагдахгүй байна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр.

Тэгэхээр үндсэн санаа нь соёлын арга хэмжээнүүд, бүтээн байгуулалтуудаас маш бага зардлаар тэр бүх бүтээн байгуулалтуудыг хэдэн арав дахин нугалсан их эдийн засгийн болоод түүхийн тусгаар улсын оюуны дархлаатай холбоотой салбар энэ дээрээ жоохон анхаарал хандуулаасай.

Ажлын хэсэг хэрвээ боломжтой бол энэ асуудлыг авч үзээсэй гэж хүсэж байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Ж.Золжаргал гишүүний асуултад Б.Жавхлан сайд байхгүй бол эхлээд Н.Учрал сайд хариулах уу? Баялгийн сантай холбоотой хэсгийг.

Н.Учрал: Ж.Золжаргал гишүүний асуултад хариулья.

“Үндэсний баялгийн сан” өнгөрсөн парламентад баталсан хуулийн дагуу “Ирээдүйн өв сан”, “Хуримтлалын сан”, “Хөгжлийн сан”-гаас бүрдэж байгаа.

Тэгэхээр таны яг хэлсний дагуу Ирээдүйн өв сан бол одоо нөгөө роялти, АМНАТ-ын орлогоос “Тогтворжуулалтын сан” болон “Орон нутгийн хөгжлийн сан”-д хуваарилаад тэр үлдэх хэсгийнх нь 65.0 хувийн орлогыг төвлөрүүлдэг ийм сан.

Тэгэхээр үүний мэдээж Ирээдүйн өв сангийн нэгээс доошгүй хувь инновац, технологид зарцуулагдана гэдгийг Засгийн газрын хөтөлбөрт заасан.

Тэгэхдээ энэ бол зөвхөн Ирээдүйн өв сан гэсэн ойлголт бас биш. Яагаад гэхээр Үндэсний баялгийн сан өөрөө гурван сангаас бүрдэж байгаа.

Тэгэхээр Хөгжлийн сан ч гэсэн хэрвээ төсвийн тэнцэл ашигтай гарсан тохиолдолд тухайн жилийн орлогын 50.0 хувийг төвлөрүүлж байгаа.

Тэгээд үүний ч гэсэн нэг хувь нь инновац, технологид зарцуулагдах ийм л зорилгыг агуулж байна.

Яагаад гэхээр 2024 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрт ч гэсэн гурван нам гурвуулаа, мөн парламентад суудалтай эвсэл, энэ Иргэний Зориг нам ч гэсэн яг энэ инновац, технологийн салбарт Баялгийн сангийн орлогыг бүрдүүлэх чиглэлийн зорилтуудыг бас тусгасан.

Ингээд мэдээж Үндэсний баялгийн санг орлоготой байлгахын тулд бид жишээ нь Хуримтлалын сан гэхэд л өнөөдөр яг тэр Эрдэнэт, Монрос хоёр төрийн өмчит үйлдвэрийн газар гээд төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн хуулиар зохицуулагдаж байгаа мөртөө тэр 34 хувийг нь одоо тэр Хуримтлалын сан дээр төвлөрүүлээгүй байхад бид өнгөрсөн хугацаанд иргэдэд

хувьцааны ногдол ашиг тараасан. Дээрээс нь 500.0 тэрбум төгрөг хуримтлуулсан.

Тэгэхээр энэ орлого угаасаа давж биелэх бололцоотой.

Тийм учраас энэ Засгийн газрын хэрэгжүүлэх гээд байгаа 15 төсөл дээр жишээ нь зөвхөн одоо энэ хил холболтуудыг л бид урагшлуулахад. Одоо зөвхөн Гашуунсухайт-Ганцмод гэсэн хил холболтыг хийхэд л зүгээр 2 жилийн дотор нүүрсний экспорт 30 сая тонн нэмэгдэх бололцоотой байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ Засгийн газрын төслүүдээ урагшлуулъя. Тэгээд үүнтэй холбогдуулаад өөрөө нөөцөө зөв хуваарилъя.

Тийм учраас ашигтай, орлоготой байгаа тохиолдолд инновац, технологийн салбарт зарцуулъя.

Дээрээс нь цаашлаад энэ төслүүдийг хэрэгжүүлэх үүднээсээ хувийн хэвшлээ дэмжих хүрээнд жишээ нь аж үйлдвэр, технологийн паркуудаа хөгжүүлъя. Үүн дээр хувийн хэвшлүүдийн оролцоог хангуулъя. Тэгээд уул уурхайн бүтээгдэхүүнийг дахин боловсруулах чиглэлээр ажиллая. Ингээд нэмүү өртөг үлдээе.

Энэ бол тэр чигээрээ технологийг дэмжсэн, инновацыг дэмжсэн бодлого, үйл ажиллагаа байх юм байна.

Үүний үр дүнд нэмүү өртөг улсад үлдэх юм байна. Тэгж байж макро эдийн засгийн өсөлт чинь тэр өрхийн амьжиргаа руу орох юм байна гэдэг зорилтоор л бид Засгийн газрын хөтөлбөр дээр энэ 15 төслийг урагшлуулж өгөөч ээ.

Тэгээд тэр холбогдох хуулиудад өөрчлөлт оруулж байя. Хугацаа бага байна гэдэг ийм л зүйлийг хэлээд байгаа юм.

Х.Булгантуяа: Л.Гантөмөр сайд нэмж хариулъя.

Л.Гантөмөр: Ер нь тэгээд шинжлэх ухаан, боловсролдоо мөнгө зараагүй улс орон шорондоо асар их мөнгө зарна гэдгийг манай улс их бодит байдлаар харуулж байгаа.

Тийм учраас шинжлэх ухаан, технологидоо энэ 4 жил асар их мөнгө зарна.

Зарсан хэмжээгээрээ бид үйлдвэртэй болно.

Тэгээд харамсалтай нь яах вэ, бид Засгийн газар аль нэг салбар дээр нь тэдэн хувийг зарна гэж үйл ажиллагааны хөтөлбөр болоод бусад зүйл дээр оруулж ирэхэд өрөөсгөл байгаа юм.

Тийм учраас ажлын хэсэг дээр их сайн ажилласан байна лээ. Ажлын хэсэг Д.Рэгдэл гуай санал гаргасан байх. Ажлын хэсэг дээр маш тодорхой дүнг шинжлэх ухаан, инновацын технологийн салбартаа, энэ чиглэлдээ зарна шүү гээд санал гараад дэмжигдчихсэн байна лээ.

Өчигдөр Төрийн байгуулалтын байнгын хороогоор дэмжсэн.

Энэ дээр Ж.Золжаргал гишүүн Монголын технологи болоод өндөр технологи, улс орныхоо хөгжилд санаа тавьж байгаа хүмүүс энэ саналуудаа уншиж байгаад.../минут дуусав/

Х.Булгантуяа: Соёлын өвтэй холбоотойгоор Ч.Номин сайд асуултад хариулья.

Ч.Номин: Сайн байна уу? Ж.Золжаргал гишүүний асуултад хариулья.

Нэгдүгээрт, соёлын өвийг хадгалж хамгаалахдаа ер нь 6 чиглэлээр явдаг.

- ▶ Судална,
- ▶ Бүрдгэнэ,
- ▶ Хадгална,
- ▶ Хамгаална,
- ▶ Сурталчилна, таниулна,
- ▶ Түгээн дэлгэрүүлнэ гээд явдаг.

Тэгэхээр яах вэ, манай улсын хувьд Соёлын өвийн тухай хууль маань бүрэн өнөөдрийн байдлаар үүнийг хэрэгжүүлж чадахгүй байгаа.

Тэгэхээр манайх яг өнгөрсөн жилийн хугацаанд соёлын өвийн багц хуулийн судалгааг хийж байгаа. Бид ирэх намрын чуулганаар багц хуулиа өргөн барихаар төлөвлөж байгаа.

Тэгэхдээ ер нь соёлын биет бус өвийг хэлэхэд хоёр төрлийн өв байгаа.

“Хөдлөх өв”, “үл хөдлөх өв” гэж байгаа.

“Хөдлөх өв”-ийн хувьд бид нарын бүртгэл, тооллого. Цаашлаад хамгаалалт, сэргээн засварлалтууд нэлээн сайн хэмжээнд хийгддэг болсон.

Та Чингис хааны музейг ярьж байна. Чингис хааны музейд 10 мянга гаруй үзмэрүүд байдаг. Үүний 90 гаруй хувь нь оригинал үзмэрүүд. Бусад нь дандаа **AR**[Augmented Reality], **VR**[Virtual Reality]

гэсэн хүүхдүүдийн боловсролын хөтөлбөртэй уясан олон хөтөлбөрүүд байдаг.

Х.Булгантуяа: Нэмж минут авах уу? Ч.Номин сайд нэмж хариулья.

Ч.Номин: Ингээд боловсролын хөтөлбөрүүдтэй уялдуулсан олон арга зүй дээр суурилсан зүйлүүд байгаа.

Би тантай санал нэг байгаа зүйл бол бид археологи, палеонтологийнхоо чиглэлээр малтлагуудыг илүү их хийх хэрэгтэй, судалгаа шинжилгээ хийх хэрэгтэй гэдгээр санал нэг байна.

Бидний хувьд өнөөдрийн байдлаар жилд ойролцоогоор 10-аас 20 байгууллагууд зөвшөөрөл авч палеонтологи, археологийн судалгаанууд хийдэг.

Тэгээд хүрээндээ олдворуудыг олж, гаргаж ирдэг.

Олон улсын түвшинд Монголын өвүүд тархсан байдаг. Үүнийг бид бүхэн Монголдоо буцаан төвлөрүүлэх. Олон улсдаа мөн энэ өвүүд маань Монгол Улсыг сурталчлан таниулах ажлууд хийгдэж байгаа. Энэ ч хүрээндээ бид Америк Улсаас палеонтологийнхоо олдворуудыг авсан. Цаашлаад Францаас авах гэх мэтчилэн ажлууд хийж байгаа.

Таны хэлсэн үл хөдлөх өв дээр Монгол хүмүүсийн хувьд бас үл хүндэтгэлтэй хандах, өвийн эх төрөх, бүрэн бүтэн байдалд халдах асуудал орж байгаа.

Үүнийг бид энэ өвийн тухай багц хуулийнхаа хүрээнд авч хэрэгжүүлж, одоо дээр илүү анхаарч ажиллах болно.

Юун дээр бүрэн орсон байгаа шүү.
Хөтөлбөр дээр бол.../минут дуусав/

Х.Булгантуяа: Хөтөлбөр дээр
бүрэн орсон байгаа гээд тэгж байна.

Дараагийн гишүүн Дашдондогийн
Ганбат гишүүн.

Д.Ганбат: Бид хэд чинь одоо нэг
ажил явдлын дараа нэг оршуулгын ёслол
дээр байгаа юм шиг л байж байна л даа.

Үнэхээр ч бас тийм юм даа. Тийм.
Яагаад гэвэл нөгөө ардчиллын
элементүүд байна. Бид ардчилыг
сонгочихсон. Монгол Улсынхаа Үндсэн
хуулиар хүмүүнлэг, иргэний ардчилсан
нийгэм байгуулна гэгчсэн байгаа.
Саяхан сонгууль явчихсан байгаа.

Сонгуулиар Монгол Ардын намд
68 суудал өгсөн байгаа. 63-аас дээш бол
ялчихсан нам.

Тэгээд Та бүхэн хариуцлага хүлээх
ёстой. Сүүлийн 8 жил олигтой сөрөг
хүчингүй. Танайх бараг 80, 90 хувьтай
засаглалж. Ингээд ийм алдагдсан 8 жил
болсон.

Тэр нь юугаар илэрч байна вэ
гэхээр энэ ард түмний ядуурлаар
харагдаж байна. Монгол Улсын өнөөгийн
нөхцөл байдлаар харагдаж байна.

Ард түмний саналыг тоохгүй
ингэж нулимж болохгүй. Энэ ямар
учиртай, ямар Засгийн газар байгуулаад,
яаж ажиллах гээд байгаа юм бэ?

Би бол одоо энэ Монгол Ардын
намын Засгийн газар л гэж үзнэ.

Манай Ардчилсан намаас
чадварлаг хэдэн хүн орж ажиллаж байгаа
байх. Урьсан гэж ойлгож байна.

Ард түмэн арай өөрөөр сонгосон.
Хариуцлага тооцох ёстой. Хариуцлага
ярих ёстой.

Энэ мөрийн хөтөлбөр 4 жил
хэрэгжинэ. Энэ мөрийн хөтөлбөр чинь
хэрэгжихгүй бол хэнтэй нь яаж
хариуцлага тооцох юм бэ, хэн хариуцах
юм бэ гэдэг зүйлийг асууж тодруулмаар
байна.

Энэ бол одоо тэгээд ерөөсөө тэр
дорнынхон яриад байх шиг байна. “Би
хоолны нэр хэлэв ээ, та нар савхдав аа”
гэдэг шиг л юм байна шүү дээ.

Энд биелнэ гэхэд эргэлзээтэй. Тэр
мөнгө төгрөг нь ч хаана байгаа юм. 140
хөтөлбөр бэлдчихсэн гэж байна. Түүний
40 зурагтай гэнэ лээ. 100 нь зураггүй
гэсэн.

Гадаадын хөрөнгө оруулалт
байхгүй. Хэн ч гадаадын хөрөнгө
оруулалт орж ирнэ гэж найдахгүй байгаа.
Сүүлийн арваад жил тийм юм байхгүй
байсан. 2012 оноос Оюу Толгойг эс
тооцвол олигтой гадаадын хөрөнгө
оруулалт орж ирээгүй.

Энэ бүх юмаараа л хараат байна
шүү дээ. Бид нар. Гаднын. Эрчим хүч энэ
жил ямар байх юм. Тасарвал хэн
хариуцах юм гэсэн зүйлийг тодруулмаар
байх юм.

Газрын тосны үйлдвэрийг 2024
онд орно оо л гэж байсан. Тэгсэн чинь
асуусан чинь одоо 2028 онд. Заавал
сонгуулийн дараа л гэж хэлээд байх юм.

Тэгээд л ингээд л хойшоо яваад байдаг. Хэрвээ одоо яг ган, зуд болдог ийм үед нь бензин, шатахуунаа тасалдаг. Энэ явдал давтагдах уу, давтагдахгүй юу гэсэн зүйлийг асуугаад байгаа юм. Энэ жил.

Ганц нэг яамны нөхдүүд хариулж байна лээ. Бид албан ёсоор хариулт авч чадаагүй ээ. Амаараа ганц нэг ярьсан хүмүүс байгаа гэж байгаа юм.

Ийм юмнуудаа одоо яг үнэнээр нь хэлээд ингээд байвал ард түмэн чинь ажил амьдралаа зохицуулна шүү дээ.

Тэгэхгүй нэг л сайн сайхан болох гэж байгаа юм шиг ингээд хүлээлт үүсгээд байдаг. Ингээд яриад байдаг. Тэгээд олон жил ингэж худлаа ярилаа. Одоо нэг л удаа худлаа ярьчхаар тэр хүний үг одоо тэгээд цаашдаа ямар ч үнэ цэнгүй болдог.

Ер нь одоо ингээд нэг сайн сайхан зүйл хийх гээд ингээд муу юм хийдэг хүмүүсийн хажуугаар тэрийг нь ярьдаггүй, хэлдэггүй, дуугүй байдаг хүмүүс, их сайн хүмүүс бүр буруутай гэж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ Улсын Их Хурал одоо 126 хүнтэй болсон. “Зуун ямаанд жаран ухна” гээд яамдын тоо 18 ч билүү. 23 сайдтай болсон.

Х.Булгантуяа: Л.Гантөмөр Шадар сайд хариулах уу? Танай намаас бас одоо энэ Засагт хамтарч орно гээд танай намын дарга Шадар сайд болоод сууж байгаа шүү дээ.

Та гэв гэнэт өнөөдөр Улсын Их Хурал дээр ирснээ юу болчхов гээд гайхаад байж болохгүй шүү дээ.

Шадар сайд эхлээд хариулъя. Тэгээд нэмээд бусад сайд нараас шаардлагатай бол нэмээд хариулъя. Тэгэх үү? Н.Учрал сайдаас авхуулаад.

Л.Гантөмөр: Тийм. Зүгээр мэдээж энэ хамтарсан Засгийн газрын үйл хэрэгт эргэлзэж байгаа Их Хурлын гишүүд байгааг би үгүйсгэхгүй.

Бид хийж байгаа ажлаараа л энэ эргэлзээг тайлна гэдэг ийм итгэлтэй байгаа.

Бидний үйл хэрэг хэдэн сараар, нэг жилээр үр дүнгээ харуулаад явах ёстой.

Тийм учраас бид маш их шахсан төлөвлөгөөгөөр ажил хийнэ. Авлигаас салах хэрэгтэй.

Үнэхээр үйлдвэржилтийн бодлого харагдах ёстой. Эрчим хүчний хөрөнгө оруулалт нэмэгдэх хэрэгтэй. Гаднын хөрөнгө оруулагчид Монголд ирж чуулдаг ийм улс болно. Бизнес эрхлэгчид нь сэтгэл тэнүүн, урагшаа хараад алхдаг. Улс төржилт, ялангуяа хий улс төржилтөөс болж өнгөрсөн 30 жилд гарсан он, цагийн алдааг засахын төлөө цөмөөрөө хичээгээд явна гэсэн ийм эрмэлзэлтэй байгаа шүү. Гишүүд ээ.

Мэдээж эргэлзээгүй хүн үлдчих юм бол тэр чинь өөрөө бас худлаа шүү дээ.

Тийм учраас Д.Ганбат гишүүн шиг эргэлзэж байгаа, тээнэгэлзэж байгаа, одоо ер нь яах юм гэж хүлээж байгаа хүлээлт байгааг бид үгүйсгэхгүй.

Тэгэхдээ бидний тавьж байгаа зорилго бол улс орны эрх ашиг нэгдүгээрт. Улс орны хамгийн чухал эрх

ашиг юу вэ гэхээр эдийн засгийн тэлэлт байна. Хөгжих хэрэгтэй байна. Босож ирэх хэрэгтэй байна. Мөнгөтэй улс болох хэрэгтэй байна. Үйлдвэр эрхэлж чаддаг улс болох хэрэгтэй байна.

Энэ дээрээ бүх анхаарлаа төвлөрүүлж байгаа шүү. Гишүүд ээ.

Түүний хажуугаар засаглал нээлттэй. Д.Ганбат гишүүний байнга ярьж байгаа хүний эрх хамгаалагдсан ийм улс болж бид цаашаа явна.

Тэгээд үүнийхээ төлөө бид илүү хурдтай ажиллая гэсэн ийм л зорилготойгоор хамтарч байгаа.

Нөгөө талдаа сонгогчид Ардчилсан намыг зүгээр шүүмжлээд өг гэж санал өгөөгүй ээ. Би үүнийг хаана ч хэлж байгаа юм. Ардчилсан намыг мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлээч ээ гэж санал өгсөн.

Тийм учраас бид Ардчилсан нам сонгуулиар ярьж хэлсэн зүйлээ ажил хэрэг болгохын төлөө урагшаа хараад явах нь бидний хувьд сонгогчид, дэмжигчид, бидэнд санал өгсөн хүмүүсийн хувьд хамгийн чухал байгаа.

Хүний мууг үзэх амархан. Улс орны сайн сайхныг үзэх хэцүү байна.

Тийм учраас бид хэцүү талд нь гарч улс орныхоо сайн сайхан, дэвшүүлсэн хөтөлбөрөө ажил хэрэг болгохын төлөө хамтраад ажиллаж байгаа шүү гэдгийг бүгдээрээ хэлье.

Тэгээд бүх шатны намын байгууллагууд шийдвэрээ гаргасан.

Мэдээж энэ гаргасан шийдвэрийнхээ араас манай гишүүд

нэхэл хатуу, ажил хэрэгч саналуудыг дэвшүүлж, ажил хэрэгчээр урагшаа харж явна гэдэгт итгэж байна.

Х.Булгантуяа: Н.Учрал сайд нэмж хариулья.

Н.Учрал: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт энэ үнэлэх механизм их тодорхой суусан.

Ерөөсөө үйл ажиллагааны хөтөлбөрөө цэвэр байгаа нөөцөө хэрхэн хуваарилах вэ, төлөвлөх вэ л гэдэг зорилт.

Үүнд хэрхэн хүрэх вэ гэдэг дээр Засгийн газар үйл ажиллагааны төлөвлөгөөгөө энэ хөтөлбөр батлагдсаны дараа Засгаар оруулаад батална.

Тэгэхээр жишээ нь Д.Ганбат гишүүний асуулт дээр хэлэхэд энэ төлөвлөх буюу энэ хөгжлийн 4 жилийн төлөвлөх эрх бол өнөөдөр Ардчилсан нам удирдаж байгаа Эдийн засгийн хөгжлийн яаманд байгаа.

Засгийн газар дээр хадгалагдаж байдаг хянах буюу энэ урт хугацааны бодлого, дунд хугацааны бодлого, төрийн бүх шатны хяналт шинжилгээ, үнэлгээний эрхийг хуулиар нь Хяналт шинжилгээний үндэсний хороонд шилжүүлсэн. Үүнийг Ардчилсан намын төлөөлөл болсон сайд удирдана.

Тэгээд хууль зүйн асуудлыг эрхэлж байгаа салбар нь мөн бас Ардчилсан намд бид нар одоо энэ Засгийн газрын бүрэлдэхүүнд Ардчилсан нам.../минут дуусав/

Х.Булгантуяа: Н.Учрал сайдад нэмэлт минут

Н.Учрал: Тэгэхээр Ардчилсан нам хариуцаж байна гэсэн үг. Тэгэхээр маш ойлгомжтой.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг төлөвлөсөн Эдийн засгийн яамны ажлыг Ардчилсан намаас томилогдсон сайд удирдана. Энэ бол бие биедээ хяналт тэнцлийг хослуулах зорилтоор яг ингэж хийсэн.

Тийм учраас Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ мэдээж энэ үйл ажиллагааны хөтөлбөр дээрээ хариуцлагаа хүлээнэ. Тэгээд Та бүхэнд тайлагнана.

Тэгээд нэг зүйлийг хэлэхэд энэ Засгийн газрын гол зорилго ерөөсөө улс төржихгүйгээр ажил хийе л гэсэн. Асуудлаа хамтраад шийдье л гэсэн.

Тийм учраас энэ 15 төслийг урдаа гаргаад тавьсан.

Үнэхээр энэ хил холболтыг ингээд урагшлуулъя гэх юм болл Их Хурлаар тогтоол оруулах хэрэгтэй байгаа. Үнэхээр эдийн засгаа тэлье гэвэл тэр “Орано”-гийн гэрээн дээр ч гэсэн бид Их Хурлаас шийдвэр хүснэ. Оюу Толгой гэрээг сайжруулах дээр ч гэсэн Их Хурлаар оруулж танилцуулна.

Үүн дээр улс төржихгүйгээр хамтдаа байя гэвэл эдийн засаг тэлнэ. Олсон орлогоо иргэддээ эрүүл мэнд, боловсролд нь зарцуулъя. Ийм л зүйлийг хэлээд байгаа юм.

Түүнээс биш.../минут дуусав/

Х.Булгантуяа: Д.Ганбат гишүүн нэмж тодруулах уу?

Д.Ганбат: Юу л юм байна л даа. Хэн ч хариуцлага хүлээхгүй л гэдгийг л хэлж л байна л даа. Үүнийг чинь одоо нөгөө юу билээ. Манай С.Зоригийн хэлдгээр “Монгол хүний саруул ухаанд итгэж байна” гэдэг шиг. Саруул ухаантай хүмүүс доор нь л ойлгогчихно л доо. Ядаад байх юм байхгүй.

Тэгээд яах вэ, харж л байя. Цаашаа ажил төрөл явна. Тэгээд ард түмэн гэж байгаа. Хариуцлагатай байна шүү. Нөхөд өө.

Энэ хөдөө аж ахуйн кластер төсөл гээд Баянхонгор аймагт хэрэгжиж байгаа юм. Тэр ажлаа 50, 60 хувьтай байгаа мөртөө 80 хувьтай мөнгө төгрөг авчихсан байх юм.

Энэ одоо яг л бид нарын яриад хэлээд байгаа ийм яг амьдрал дээр нөгөө л зах зээлийн, малчдаа дэмжье, хүмүүсийг орлоготой ажилтай байлгая орон нутагт бас тэр ингэний сүүний үйлдвэрийг оруулчихъя, гадагшаа экспортолье гээд ийм ажлууд байгаа.

Тэгээд энэ юмаа бас араас нь хяналт тавьдаг.../минут дуусав/

Х.Булгантуяа: Ж.Энхбаяр сайд хариулах уу? Хөдөө аж ахуйн кластертай холбоотой.

Ж.Энхбаяр: Орон нутагт. Баруун бүсэд Ховдын аж үйлдвэрийн парк томоохон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил явж байна.

Мөн Баянхонгор аймагт энэ хөдөө аж ахуйн кластер хөгжүүлэх ажил нэлээн бас амжилттай урагшилж байгаа.

Орон нутгийн мөн төвийн бүс буюу Дархан, Сэлэнгийн бүсэд бас

хөгжүүлэх томоохон хөнгөн үйлдвэрийн парк, хүнсний үйлдвэрийн паркийн томоохон ажлууд өрнөнө.

Тэгээд Баянхонгор аймагт хэрэгжиж байгаа энэ асуудалтай холбоотой зүйл дээр сайн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулаад танд эргэж мэдэгдье.

Үнэхээр хугацаа амжаагүй байна шүү дээ. Дөнгөж 20 гаруй л хонож байна. Хөтөлбөрөө баталсны дараа, төсвөө баталсны дараа ингээд орно. Томилолт аваад Баянхонгор аймагт очъё.

Х.Булгантуяа: Доржзовдын Энхтуяа гишүүн.

Д.Энхтуяа: Сайн байцгаана уу? Надад хоёр асуулт байна.

Бид “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” гэсэн энэ хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэлэлцэж байна.

Энэ бол одоо ер нь зоригтой хөгжих юм байна. Хамтарсан Засгийн газрын энэ бүтэц байгуулагдсан дээр одоо энэ улс орныхоо хөгжлийг хурдасгах юм байна гэж ингэж ойлгож байна.

Том том мега төслүүдийг явуулах юм байна. Бидний хувьд нэг шинэ юм биш. Урьд нь “Алсын хараа-2050”, мөн “Шинэ сэргэлтийн бодлого” гээд маш олон гоё гоё нэртэй Засгийн газрын мөрийн хөтөлбөрүүд явж байсан.

Үүнтэй холбогдуулаад нэг асуулт байна.

2023 оны Үндэсний статистикийн хороо болон Нэгдсэн Үндэстний

Байгууллагын шилжилт хөдөлгөөний байгууллагаас хамтарсан судалгаа хийсэн байна.

Энэ судалгаан дээр Монгол Улсын хэмжээнд 140 мянга гаруй монгол хүмүүс гадаадад амьдарч байна гэсэн ийм судалгаа байна. Эдний дийлэнх нь буюу 46 хувь нь сүүлийн 5 жилийн хугацаанд Монгол Улсаас гарч явсан байна.

Мөн 15-аас 64 насны иргэдийн дундах 67 хувь нь гадагшаа ажиллах сонирхолтой гэсэн ийм мэдээллийг өгсөн байна.

Ингээд сүүлийн 8 жилийн цалингийн өсөлт ердөө 17 хувьтай байгаа. Энэ нь мэдээж түгжрэл, мөн хөдөлмөрийн насны хүмүүс эх орноосоо дүрвэх гол шалтгаан нь түгжрэл, энэ байгалийн бохирдол. Энэ бүртээс шалтгаалж байгаа энэ шалтгааныг бас дурдсан байна.

Ингээд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны мэдэгдэж байгаагаар Монгол Улсын зах зээлд 300 мянган хүнээр дутагдаж байна.

Ингээд гадаадад байгаа иргэдийн 70 гаруй хувь нь дээд боловсролтой, 67.1 хувь нь мэргэжилтнүүд байна гэсэн ийм судалгаа байна.

Тэгэхээр одоо энэ том мега төслүүдийг явуулахад мэдээжийн хэрэг эдийн засгаа өсгөх, тэлэх илүүтэйгээс энэ мега төслүүдийг чинь монгол хүмүүс, мэргэжилтэй монгол хүмүүс, боловсролтой хүмүүс л хийнэ биз дээ.

Тэгэхээр Засгийн газрын энэ мөрийн хөтөлбөрт энэ гадагшаа гараад дүрвээд гарчихсан мэргэжилтэй, нарийн мэргэжилтэй боловсон хүчнүүдээ буцааж

авчрах. Тийм ээ. Эх оронд нь ажиллуулах ийм ямар хөтөлбөр, ямар бодлого туссан бэ?

Бид бүгдээрээ л мэднэ. Гадаадад очоод л Ерөнхийлөгч, Ерөнхий сайд бүгдээрээ л монгол хүмүүстэйгээ уулздаг. Тэд нарын дийлэнх нь Монгол руугаа буцгамаар байна. Монголд үнэхээр цалин, амьжиргаа дээшлэх юм бол бид бас эх орондоо очмоор байна гэдэг ийм л саналыг хэлдэг шүү дээ.

Тэгээд л Засгийн газрын мөрийн хөтөлбөрт энэ бодлого яаж суусан бэ? Нэгдүгээр асуудал.

Хоёр дахь нь, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн 4 дүгээр хэсэгт “...хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” орж ирсэн байна. Тэгээд энэ дээр маш тодорхой юмнууд суусан байна.

Энэ дээр би бас сайшаалтай хандаж байна.

4.1.1.2-т “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хоёрдугаар хөтөлбөр батлуулж хэрэгжүүлнэ.” гэсэн байна.

Тэгэхээр энэ мэдээжийн хэрэг үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх. Тийм ээ. Нийгэм, соёлын эрхээс гадна яг энэ дээр монгол иргэдийнхээ эдийн засгийн эрх чөлөөг хангахад ямар бодлого энэ дээр сууж сууж өгсөн юм? Энэ ингээд хамтдаа асуулт байгаа юм.

4.1.3-т “...иргэний улс төрийн эрх чөлөөг бүрэн хангах, баталгаажуулах, жагсаал цуглаан хийх зөвшөөрөл олгох тогтолцоог хална” гэсэн байна.

Миний ойлгож байгаагаар өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа

хуулиар жагсаал, цуглаан хийхдээ зөвшөөрөл авдаггүй зохицуулалт байгаа гэж ойлгож байгаа.

Тэгэхээр үүнийг Засгийн газар зөвшөөрөл өгдөг гэж хүлээн зөвшөөрөөд, ийм хуультай гэж хүлээн зөвшөөрч байгаа юм уу?

Тэгэхээр энэ тогтолцоог яаж өөрчилж гэж бодож байгаа юм? Хуульдаа өөрчлөлт оруу болох юм уу?

Өнөөдөр яг энэ зөвшөөрөл авдаггүй яг энэ хууль үйлчилж байгаа гэж би ойлгож байгаа юм.

Дараагийн яг энэ бүлэгт нэгдсэн бас нэг асуулт бол “Ази тивийн хүний эрхийн төвийг Монгол Улсад байгуулна” гээд тэгж байна.

Ер нь хүний эрхийн талаар маш олон конвенцод нэгдсэн. Хүний эрхийн маш олон тунхаглалууд гарч байгаа.

Тэгэхээр яг үүнээс юугаараа ялгаатай юм? “Ази тивийн хүний эрхийн төвийг байгуулна” гэж энэ дээр оруулсан юм бэ? Нарийн юмнууд байгаа юу? Бодлого, буусан тийм төлөвлөгөө байгаа юу?

4.1.2-т “хэвлэлийн эрх чөлөө”.../минут дуусав/

Х.Булгантуяа: О.Алтангэрэл сайд хариулъя. Эхлээд. Тэгээд дараа нь Л.Энх-Амгалан сайд хариулах уу?

О.Алтангэрэл: Би дараа нь хариулчхаж болох уу? Л.Энх-Амгалан сайдын дараа.

Х.Булгантуяа: Л.Энх-Амгалан сайд эхний асуултад хариулъя. Д.Энхтуяа гишүүний.

Л.Энх-Амгалан: Д.Энхтуяа гишүүн ээ, хоёулаа жаахан хоёр өөр тоо л ярих гээд байна л даа.

Сая Гадаад харилцааны яамтай хамтарч хийсэн энэ гадаадад ажиллаж байгаа монголчуудын тоог нэгтгээд 242 мянга гэсэн нэг тоо байгаа.

Тэгэхээр ерөнхийдөө одоо энэ ирэх 4 жилд энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр гадаадад амьдарч байгаа Монголчуудаа эх орондоо авчрах чиглэлээр бас хэд хэдэн зорилтууд тусгачихсан байгаа.

Хамгийн гол нь бид тэд нарыг хүчээр авчрах биш яг ирэх тэр нэг мотивацуудыг л хийх ёстой байгаа юм л даа. Тийм ээ.

Тэгэхээр ерөнхийдөө бас нэг тийм сайн жишиг, сайн хандлага гэх юм уу тэр хандлагууд бас гарч байгаа ийм сайн тооцоонууд байна. Солонгост ажиллаж байгаа монголчууд хүрч ирээд эх орондоо жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлж байгаа 800 орчим иргэдийн тоо бас одоогоор байна.

Тэгээд бид Хөдөлмөр эрхлэлтийн сангаас сүүлийн жилүүдэд хэрэгжсэн, бүр нэлээн амжилттай хэрэгжсэн төслүүд бол эх орондоо буцаж ирээд. Одоо жишээ нь Солонгост оймсны үйлдвэрт ажиллаж байгаад хүрч ирээд энд оймсны үйлдвэр байгуулчихсан 4, 5 залуучууд байна шүү дээ. Жишээ татаж ярихад.

Тэд нарыг жижиг, дунд үйлдвэрийн зээлээр дэмжих, Хөдөлмөр эрхлэлтийн сангаас дэмжих энэ

хөтөлбөрүүд их амжилттай хэрэгжиж байгаа.

Тэгээд үүнийг ингээд бид нэг тийм дуудаад, даллаад хүрээд ирэхгүй л дээ. Тэгээд хүрч ирэхээр нь гадаадад ажилласан, тэр сурсан мэргэжлүүдийг нь ямар ч байсан хүрч ирэхэд нь гэрчилгээжүүлдэг, баталгаажуулдаг, тэр жижиг, дунд бизнесийг нь эхлэхэд тэр тодорхой хөнгөлөлттэй зээлүүдийг өгдөг.

Эд нар чинь өөрөө гадаадад маш их том технологи сурч ирж байгаа байхгүй юу. Ур чадварууд сурч ирж байгаа.

Тэгэхээр энэ чиглэлээр бас нэлээн аятайхан ийм зөв бодлогууд явчих болов уу гэж бодож байгаа.

Тэгээд бид Солонгостой хамтарч, Солонгосын Элчин сайдтай уулзалт хийж Солонгосоос буцаж ирж байгаа залуучуудыг хүрч ирэхэд нь Жижиг, дунд үйлдвэрийн сан буюу Хөдөлмөр эрхлэлтийн сангаас дэмжихээс гадна Солонгос, Монгол хоёроо хоёроо дундаа ингээд дундын энэ бизнесийг дэмжих ийм сан үүсгэвэл яасан юм бэ гэсэн саналыг тавьсан. Үүнийг нэлээн нааштай хүлээж авах гэж байгаа юм байна лээ.

Германд бас тийм байдаг. Германд ажиллаж байгаад, амьдарч байгаад хүрч ирэхэд нь Германаас технологи авчрахад 5-аас 20 мянган евро билүү? Тийм ээ? Та өөрөө бас Германд амьдарч байсан хүн. Мэдэж байгаа.

Тэгэхээр ийм чиглэлийн дэмждэг хөтөлбөрүүд бусад улс орнуудад их амжилттай хэрэгждэг юм байна.

Тэгэхээр энэ чиглэлээр хэрэгжүүлэх ийм боломжууд нь бас

байгаа болов уу л гэж харж байгаа шүү дээ. Д.Энхтуяа гишүүн ээ.

Х.Булгантуяа: О.Алтангэрэл сайд. Хүний эрхтэй холбоотой асуудлыг. Д.Энхтуяа гишүүн нэгмөсөн тодруулчих уу?

О.Алтангэрэл: Энэ хүний эрхтэй холбоотой асуудал дээр Жагсаал цуглааны журмын тухай хууль, нэн ялангуяа жагсаал хийхэд зөвшөөрлийн тогтолцоог хална гэхчхэн байгаа.

Яг өнөөдөр Жагсаал цуглааны журмын тухай хуулийг уншаад үзэхээр зөвшөөрдөг, зөвшөөрөл авдаг юу зүйл харагдахгүй боловч “бүртгүүлнэ” гэж байгаа.

Өнгөрсөн жил 2023 онд нийт Сүхбаатарын талбай дээр жагсаал хийхээр бүртгүүлэхээр хандсан 200 гаруй, 230 гаруй хүсэлтийг бүртгэж аваагүй татгалзсан байгаа.

Тэгэхээр албан ёсоор зөвшөөрдөг тогтолцоо байхгүй ч гэсэн зөвшөөрлийн эффекттэй. Бүртгэхгүй байна гэдэг нь өөрөө энэ жагсаал цуглаан хийх эрхийг хаагаад байгаа юм.

Тэгээд бид энэ Жагсаал цуглааны журмын тухай хуулиар “жагсаал” гэж юу юм, “цуглаан” гэж юу юм, “аяндаа үүссэн жагсаал” гэж альныг хэлэх юм. Үндэсний аюулгүй байдал, олон нийтийн аюулгүй байдлыг хөндсөн ийм жагсаал цуглаан ямар байх юм гэдгийг бүгдийг нь нарийвчлан зохицуулаад энэ тогтолцоог өөрчлөх шаардлагатай гэж үзэж л энэ хөтөлбөрт оруулсан юм.

Д.Амарбаясгалан: Д.Энхтуяа гишүүн тодруулъя.

Д.Энхтуяа: Л.Энх-Амгалан сайд аа, ойлгож байна. Эдийн засгийн янз бүрийн хөшүүрэг байгаа.

Гэхдээ 2000 оны эхээр санаж байна. Гадаадад гарсан монголчуудаа эргүүлж мэргэжилтнүүдээ авчрах “Зөгийн үүр” гээд. “Зөгийн үүр” ч билүү. Би андуурсан байж магадгүй. Ийм хөтөлбөр, бодлого хийж байсан.

Тийм учраас маш олон залуучууд нутаг орондоо буцаж ирж байсан юм. Тэгэхэд яг ийм тодорхой бодлого ороогүй юм байна гэж ойлголоо.

О.Алтангэрэл сайдаас тэр “Ази тивийн хүний эрхийн төвийг Монголд байгуулна” гэж. Энэ яг одоо ямар тогтолцоотой, юу байгуулах гээд байгаа юм бэ?

Х.Булгантуяа: О.Алтангэрэл сайд хэд хэдэн асуулт асуусан шүү.

Өмнө нь бас эдийн засгийн эрхийн асуудлаар бас асуулт тавьсан байсан. Бүрэн хариулаарай.

О.Алтангэрэл: Энэ Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бизнесийн эрх чөлөөг зохицуулж байгаа хуулиуд дээр шинэчилнэ гэж байгаа юм.

Нэн ялангуяа өнөөдөр энэ эдийн засгийн эрх чөлөөнд сөргөөр нөлөөлөөд байгаа хууль эрх зүйн орчин тодорхойгүй байдлыг арилгана. Хувийн эрх зүйгээ бид нэлээн сайн боловсронгуй болгоё. Олон хууль тогтоомжуудыг баталъя.

Нэн ялангуяа энэ “эвлэрүүлэн зуучлал”, “арбитр” зэрэг энэ бизнесийн үйл ажиллагаанаас шалтгаалсан маргааныг хянан шийдвэрлэдэг хууль зүйн тогтолцоогоо сайн болгоё.

Ер нь бид энэ бизнесийн эрх зүйн орчноо сайжруулахгүйгээр эдийн засгийн эрх чөлөөтэй холбоотой асуудлууд шийдэгдэхгүй юм байна. Олон жил ярьсан.

Дээрээс нь гишүүдийн нэлээн хөндөж байгаа “иргэн, захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэлийн хуулиудыг шинэчилнэ” гэсэн ийм зорилт оруулсан.

Д.Амарбаясгалан: Л.Энх-Амгалан сайд нэмж хариулъя.

Л.Энх-Амгалан: Д.Энхтуяа гишүүн ээ, тэр 2012-2016 онд тэр “Зөгийн үүр” гээд төсөл их тийм сүржин нэртэй даржин төсөл болсон шүү дээ. Тийм ээ.

Тэгээд баахан сэтгэлийн хөөрлөөр баахан залуучуудыг дуудаж ирээд. Ихэнх нь буцаад явчихсан шүү дээ.

Тэгэхээр одоо би тэр алдаа битгий давтагдаасай л гэж бодож байгаа юм. Тэр алдаа.

Тийм учраас одоо бид нэг их тийм сүржин нэртэй хөтөлбөр гэхээсээ илүү бодитой, прагматик эдийн засгийн хөшгүүрүүдийг хийх ёстой юм байна.

Манай Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр байгаа шүү дээ. Гадаадад ажиллаж амьдарч байгаа монголчуудыг эх орондоо эргэн ирэх тэр орчныг бүрдүүлэх, эдийн засгийн хөшүүргээр дэмжих гэсэн ийм заалтууд бас байгаа. Ерөнхий утгаараа ийм заалтууд орсон байгаа.

Хоёрт нь, таны хөндсөн энэ хөдөлмөрийн зах зээлийн эрэлт

нийлүүлэлтийн асуудал. Та их чухал асуудал хөндлөө.

Тэгэхээр энэ чиглэлээр бид энэ “ИХ ӨГӨГДӨЛ” дээр суурилсан бас ийм платформуудыг бид хөгжүүлж байна.

Тэгээд удахгүй бид Байнгын хороон дээрээ энэ платформуудаа танилцуулъя гэж бодож байна.

Х.Булгантуяа: Буланы Бейсен гишүүн. Б.Бейсен гишүүн асуулт асуусны дараагаар үг хэлэх гишүүдийн нэрс авна.

Тэгээд санал хураалт явахаар байгаа шүү.

Б.Бейсен: Уул уурхайн сайдаас асуулт асууя. Нэгдүгээрт.

Энэ Асгатын ордод хайгуул хийгээд 40 жил болж байна. Монгол Улсын стратегийн чухал орд мөн үү мөн. Одоо энэ хайгуул нь хэзээ дуусах юм? Нэгдүгээрт.

Дараа нь Зам, тээврийн сайдаас. Зам, тээврийн яамнаас хүн байгаа байх. Энэ Улаанхус-Цэнгэл чиглэлийн зам байна.

Та бүгд мэдэж байгаа. Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт аялал жуулчлалын бүсүүдийг хатуу хучилттай автозамаар холбоно гэсэн байгаа.

Таванбогдын чиглэлийн зам. Энэ сууж байгаа гишүүдээс ер нь Таванбогд явсан гишүүн цөөхөн байгаа байх.

Бэлчээрийн эвдрэл сүйрэл, нөгөө талаар тэр аялал жуулчлалын бүс рүү энэ чиглэгдэхгүй байна л даа.

Гэтэл Сагсайгаар дайруулна гээд байгаа. Сагсай сум чинь аймаг төвөөс шууд засмал татчихаж болно л доо. Тэрүүгээр дайрахаар ийм хохирол байна.

Нийтдээ 20 километрийн зөрүү байна. Тойруу. Энэ гарч байгаа өртөг нь Сагсай сумаар дайрвал намагтай газраар барина. 2 гүүр шинээр барина. Нийт өртөг нь 25-аас 30 хувь гаргах гээд байна. Засгийн газраас илүү зардал гарах гээд байна шүү дээ.

Гэтэл Улаанхусын тэнд чинь том гүүр нь баригдчихсан. Тэрийг тэгж шийдэж болохгүй юм уу?

Заавал Сагсайгаар дайруулж, тэр хавцал, уул даваагаар давж байснаас шууд Улаанхусын чиглэлээр барьчихвал бас ашигтай юм шиг байна. Энэ талаар Та бүгд юу бодож байна?

Нөгөө талаар энд зорчигчдын урсгал Улаанхус талд нь тэр Алтай Таванбогдын чиглэлд 70 хувь нь тэрүүгээр явж байна шүү дээ. Үүнийг яаж шийдэх гэж байна.

Эрүүл мэндийн сайд аа, Сангийн сайд хоёроос. Ер нь эмч, ажилчдын цалинг нэмэхгүй бол ер нь үнэхээр эмч ажилчдад дутагдалд ороод байна.

Сайдын хүч үрэхгүй байна даа. Бас Засгийн газар дэмжихгүй байна. Энд сууж байгаа гишүүн бас дэмжээрэй. Үүнийгээ. Сувилагч нар нь гадагшаа явж байна.

Энэ 4 жилд одоо бараг сүлжээг нь нэг дахин нэмчихмээр байх юм. Үнэхээр ачаалал нь их, цалин бага ийм асуудал байна.

Монголын үндэсний эмийн үйлдвэрийг барих тал дээр энэ 4 жилд юм оруулахгүй юм уу? Эмийнхээ 70 хувийг импортоор авдаг. Манайх. Дотооддоо энэ үндэсний аюулгүй байдалтай холбоотой. Эм дотооддоо үйлдвэрлэвэл яасан юм. Үүнийг бас мөрийн хөтөлбөрт оруулж болоогүй юм уу?

Энэ “Бүсийн оношилгооны төв” гээд яриад байна.

Ер нь ачаалал буурахгүй л дээ. Аймгуудын төвийг нэг нэгээр оношилгооны төвийг нь сэргээгээд иж бүрэн оношилгооны төвтэй, MRI аппараттай, бүх шинжилгээг хийдэг болгочихвол мэргэжлийн эмчээр хангадаг. Ядахдаа 4 жилд. Энэ 2028 он хүртэл нэг нэгээр нь 4 аймгийг оношилгооны төв. Бүгдийг нь нэг зэрэг байгуулах боломж байхгүй л дээ.

Энэ талаар Та ямар бодолтой байна?

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас асуух гэж байна. Энэ Хөдөө аж ахуйн сайдад түрүүн би саналаа хэлсэн.

Ер нь одоо малчдын тулгамдсан асуудал малын түүхий эдийн асуудал байна. Одоо Ховдод нэг баригдах гэж байна. Одоо зарим түүхий эдээ Дарханы арьс ширний үйлдвэрт зөөх асуудал гарч байна л даа. Энэ ядахдаа бүсчилж 4 газар, баруун, зүүн, урд, хойд бүс. Төвийн бүсэд тэртээ тэргүй Дархан байж байгаа юм чинь.

Малын түүхий эд боловсруулах үйлдвэр барих асуудлыг энэ удаагийн мөрийн хөтөлбөрт оруулж болоогүй юм уу?

Боловсролын сайдаас. 1 минут тодруулга.../минут дуусав/

Х.Булгантуяа: Эхлээд Н.Учрал сайд хариулах уу? Замын маршруттай холбоотой. Зам, тээврийн сайд нь байхгүй байгаад байна шүү дээ. Эсвэл Эдийн засаг, хөгжлийн сайд баймаар байх юм.

Уул уурхайтай холбоотой Ц.Туваан сайд.

Ц.Туваан: Б.Бейсен гишүүний асуултад хариулья.

Энэ Асгатын мөнгөний орд газар яг төрийн өмчийн гэдэг харьяаллаараа “Эрдэнэс Монгол” нэгдлийн харьяанд байдаг.

Тэгээд одоо бидэнд байгаа мэдээллээр “Эрэнчулуу” гээд компани энэ тендерт нь шалгарчихсан үйл ажиллагаагаа эхлүүлээд явж байгаа гээд.

Ерөнхийдөө чиглэл нь энэ нөөцийг нэмэгдүүлэх чиглэл. Дээрээс нь бид бүгдээрээ мэддэг. Энэ Асгатын мөнгөний орд руу очих энэ зам Монголын талаас очих асуудал нэлээн хүнд байдаг.

Тэгэхээр энэ дээр өнгөрсөн парламентын хугацаанд бас ажлын хэсэг ажилласан. Тэгээд энэ замын асуудал.

Дээрээс нь тэнд байгаа уурхайн амнуудыг цэвэрлэж нэвтрэх гээд ийм асуудлууд байгаа.

Тэгээд манайх Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам. Энэ дээр төрийн өмчтэй уул уурхайн компаниуд “Эрдэнэс Монгол” нэгдэлд явдаг.

Тэгэхээр манайхтай уялдаа хангах, бодлогоо хэрэгжүүлэх тал дээр хамтарч ажиллах гэдэг тал дээр бид нэг шийдэл гаргахгүй бол янз бүрийн бодлогын асуудлууд, аудитын хязгаарлалттай юм уу, хангалтгүй дүгнэлтүүдтэй асуудал орж ирэхээр манай яам ордог. Бусад асуудал дээр ингээд бас нягт харилцан уялдаатай ажиллагаа дутагдаж байгааг бас энэ ташрамд хэлье.

Х.Булгантуяа: Эрүүл мэндтэй холбоотой асуулт. Т.Мөнхсайхан сайд.

Т.Мөнхсайхан: Энэ эмийн үйлдвэрүүдийг бид маш сайн дэмжиж байж үнэтэй эм, чанаргүй эмийн асуудал сууриараа шийдэгдэх юм билээ.

Тэгээд манай улсад үйлдвэрлэл хийгээд зөвхөн дотоодынхоо хэрэгцээг хангахаар энэ тоо ширхэг нь үнэхээр бага. Ашигтай ажиллах боломж муутай юм билээ.

Тэгэхээр бид үүнийг гадагшаа хэрхэн яаж экспортлох боломж байна вэ? Энэ түвшинд нь эмийн үйлдвэрүүдийг яаж дэмжих вэ гэдэг бодлогыг яагаад, хувийн хэвшлүүдтэйгээ бас уулзалтууд хийсэн.

Эд нарт бага хүүтэй хөрөнгийн эх үүсвэрүүд л туйлын чухал байгаа юм билээ.

Тэгээд мөрийн хөтөлбөрт “эмийн үйлдвэрүүдийг дэмжих, экспортод гаргах боломжийг нь хангах” гээд 2.1.3.2 дээр бүр тодорхой заагаад өгчихсөн байгаа.

Энэ “Бүсийн оношлогоо, эмчилгээний төв”-үүдийг бид ер нь нэлээн сайн хөгжүүлж байж Улаанбаатарт төвлөрөөд байгаа энэ эмнэлгийн тусламж, үйлчилгээ төвлөрөл

саарч, чанартай тусламж, үйлчилгээг хүндрэл багатайгаар үзүүлэх боломж бүрдэх юм билээ. Энэ дээр ер нь.../минут дуусав/

Х.Булгантуяа: Т.Мөнхсайхан сайдад нэмж минут өгье.

Т.Мөнхсайхан: Тэгэхээр эхний ээлжид бид 6 “Бүсийн оношлогоо, эмчилгээний төв дээр одоо энэ жишиг төвүүдийг барьж байгуулъя гээд Азийн хөгжлийн банктэй эхний ээлжийн яриа хэлэлцээр дээ орчихсон явж байгаа. Энэ ажлууд маань ирэх жилээс бас ажил хэрэг болоод явна гэж бодож байна.

Гэхдээ бид цаашдаа ер нь бодох ёстой юм билээ.

Манай улс ер нь 10 мянган хүнд ногдох орны тоо, эмчийнхээ тоогоор ер нь дэлхийд нэлээн дээгүүр ороод байгаа.

Тэгэхээр бид л нөгөө нийгмийн эрүүл мэндийн бодлого руугаа л сайн орох шаардлагатай байгаа.

Эмч, эмнэлгийн ажилчдын цалин мөнгө өнөөдөр үнэхээр амьдрал ахуйд хүрэлцэхгүй байгаа. Эрүүл мэндийн салбарын бараг 80 гаруй хувь нь цалингийн зээлтэй. Ингээд цалингаас цалингийн хооронд зээлээ төлж амьдардаг ийм нөхцөл байдалтай байгаа.

Гэхдээ бид цаашдаа манай эрүүл мэндийн салбарын нийт санхүүжилтийг нэмэгдүүлж байж эмч, эмнэлгийн ажилчид гүйцэтгэлээр нь очих мөнгөн хэмжээ, ер нь хөдөлмөрийн үнэлэмжийг нь нэмэгдүүлж байж.../минут дуусав/

Х.Булгантуяа: Хөдөө аж ахуйтай холбоотойгоор Ж.Энхбаяр сайд.

Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд.

С.Батболд: Б.Бейсен гишүүний асуултад хариулъя.

Энэ хөтөлбөрт хилийн боомтуудыг холбох, аймгуудыг хооронд нь холбох, мөн аялал жуулчлалын гол бүсүүдийг холбох ийм зорилтууд тусгагдсан.

Энэ хүрээнд “5 цагариг” хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 2800 орчим километр зам төлөвлөгдөж байгаа.

Ирэх 4 жилийн хөтөлбөрт бид нийтдээ энэ 2800-аас хилийн боомт, аймгуудыг холбох замууд явагдана. Энэ дотор нийтдээ 51 сумыг хатуу хучилттай авто замаар холбоно гэсэн байдлаар төлөвлөлтөд саналаа өгсөн байгаа.

Таны хэлсэн санал Цэнгэл сум, Өлгийг холбох одоо явж байгаа хэсэг байгаа. Цаашаа Цэнгэл сумаар дамжаад аялал жуулчлалын гол бүс болох Алтай Таванбогд руу хүрэхээр төлөвлөгдсөн боловч яг одоогоор саяын хэлсэн энэ зургууд хийгдээгүй байгаа. Зураг, ТЭЗҮ-гээр энэ саналуудыг бид хийхдээ таны саналыг тусгаж авч үзье.

Х.Булгантуяа: Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах төвүүдийг бүсчилсэн маягаар зохион байгуулалтыг хангаж байгаа.

Баруун бүсэд Ховдын хөнгөн үйлдвэрийн парк. Хөрөнгө оруулалтын хэмжээ 100 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт. Хувийн хэвшлээс нэлээн орж байгаа. Улсын төсвөөс 40 гаруй тэрбум төгрөгийн дэд бүтцийн

барилга, байгууламжийг нь барьж өгч байгаа.

Ингээд ирэх онд гэхэд үндсэндээ Ховдын энэ парк ашиглалтад орно.

Тэгсэн нөхцөлд баруун бүс нутгийн хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд томоохон дэвшил гарна.

Х.Булгантуяа: Б.Бейсен гишүүн тодруулах уу? Тэгье. Б.Бейсен гишүүн тодруулга.

Б.Бейсен: Энэ орчны эрүүл ахуйг ч бодсон ч гэсэн ер нь аймгуудын хогийн асуудал байж байна.

Үүнийг төсөл, хөтөлбөрт оруулаад хог боловсруулах асуудлыг шийдэх боломж байна уу? Засгийн газрын хэмжээнд үүнийг шийдэхгүй бол ер нь аймгуудын хэмжээнд нэлээн асуудал. Ариун цэврийн нөхцөл, эрүүл ахуйн орчны бохирдол нэлээн алдагдаж байгаа. Энэ талаар ямар бодлого барьж байна?

Х.Булгантуяа: Байгаль орчны сайд байхгүй байна. Н.Учрал сайд хариулах уу?

Аймаг орон нутгийн хогийн менежментийн асуудал. Байгаль орчны яамнаас, ажлын хэсгээс хүн байна уу? Төрийн нарийн Э.Баттулга.

Э.Баттулга: Б.Бейсен гишүүний асуултад хариулъя.

Төвлөрсөн хогийн цэгүүдийн асуудал эхний ээлжид бид усны хамгаалалтын бүсэд орсон, эсвэл ачааллаа дийлэхгүй болчихсон байгаа аймгуудын төвлөрсөн хогийн цэгүүдийг дарж булаах, шинээр стандартын

шаардлага хангасан гуравдугаар зэрэглэлийн хогийн цэгүүдийг байгуулах ажлыг зохион байгуулж байгаа.

Тэгэхдээ үүнийг орон нутаг Хогийн тухай хуульдаа нийцүүлээд шийдэх ёстой.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас 2025 ондоо багтаад аюултай хог хаягдлын хадгалах цэгүүдийг бүх аймгийн төвүүдэд байгуулна гэсэн бодлого чиглэлтэй явж байгаа.

Х.Булгантуяа: Гишүүд асуулт асууж дууслаа.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй холбоотой үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү.

Ж.Баясгалан гишүүнээр тасалъя.

Засгийн газрын гишүүд сууж байгаарай. Манай Их Хурлын гишүүд хөтөлбөртэй холбоотой санал, үг хэлж байна. С.Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Бид маш чухал асуудлыг хэлэлцэж байна.

Сонгуулийн үр дүнгээр улс төрийн намууд зөвшилцөж, эвслийн Засгийн газар байгуулах, хамтран Засгийн газар байгуулах ийм улс төрийн шийдэлд хүрсэн.

Улс төрийн намууд сонгуульд өрсөлдөхдөө сонгуулийн мөрийн хөтөлбөрөөр голлож зорилтоо дэвшүүлж,

тодорхой асуудлуудыг шийдэх шийдлээ сонгогчдод танилцуулж, үүгээрээ өрсөлддөг.

Үүний үр дүн ч гэсэн гарсан. Эвслийн Засгийн газарт баруун төвийн үзэл баримтлалтай хоёр улс төрийн нам, зүүн төвийн үзэл баримтлалтай нэг улс төрийн нам нэгдсэн ийм л шинэ үр дүн гарсан гэдгийг хэлье.

Гэхдээ энэ үр дүн бидэнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг нарийн судалж, нарийн хэлэлцэж тооцох даалгаврыг дагуулсан гэдгийг бид ойлгож байгаа.

Энэ амаргүй даалгавар. Нөгөө талдаа энэ бас сайн боломж гэж харж байгаа юм.

Үнэхээрийн боломж гэдгийг онцлох ёстой. Яагаад гэхээр зэрэг бид баруун төвийн намуудыг гол төлөв нийгэм, эдийн засгийн эрх чөлөөг харьцангуй олох замаар нийгмийн болон эдийн засгийн асуудлыг шийдэхэд чиглэсэн тодорхой зорилтуудыг дэвшүүлээд, түүнийхээ үр дүнг хүлээж байдаг ийм намууд гэж ойлгодог.

Зүүний намууд гол төлөв нийгмийн чиг баримжаатай бодлогоор дамжуулаад эдийн засгийн өсөлтийг хангах, нийгмийн тэгш байдлыг хангаж чиглэсэн ийм бодлогыг дэвшүүлдэг.

Тэгэхээр аль алиныг нь илэрхийлсэн ийм сонгуулийн мөрийн хөтөлбөр бий болж байна гэдгийг онцлон тэмдэглэмээр байна.

Засгийн газрын ажлын хэсэг, Улсын Их Хурлаас ажлын хэсэг гарсан.

Засгийн газрын ажлын хэсгийн бэлэн болгосон үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлтэй Улсын Их Хурлын гишүүд маш анхааралтай танилцсан.

Өнгөрсөн өдрүүдэд энэ чиглэлээр Байнгын хороод маш ажил хэрэгч саналууд өрнөлөө.

Зарим зүйл дээр мэдээж хэрэг санал нэгдэхгүй зүйл байгаа. Зарим дээр үнэхээрийн бидний хувьд энэ 4 жилийн хугацаанд хийж чадахгүй болов уу гэсэн ийм болгоомжууд байгаа.

Гэлээ гэхдээ хөтөлбөр өөрөө аль аль түвшинд улс орны төв хэмжээнд тулгамдаад байгаа нийгэм, эдийн засгийн, цаашлаад засаглалын, тэр битгий хэл гадаад, дотоод нөхцөл байдалтай холбоотой асуудлыг шийдэх боломж олгож байгаа ийм мөрийн хөтөлбөр болж байна гэдгийг хэлье.

Хүний хөгжлөө хангая гэж байгаа. Боловсролын чиглэлээр маш чухал зорилтууд дэвшсэн.

Нийгмийн хамгааллын чиглэлээр, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр маш чухал зорилтууд бас дэвшигдсэн байгаа.

Үүнтэй уялдаад эдийн засгийн хамгийн чухал арга хэрэгслүүд болох дэд бүтэц рүү чиглэсэн томоохон хөрөнгө оруулалтуудыг энэ удаагийн мөрийн хөтөлбөрт бас дэвшүүлсэн.

Энэ нь өөрөө бидний хувьд томоохон боломж. Цаашдаа дунд хугацаанд, урт хугацаанд гарах томоохон үр дүн. Цаашлаад нийгмийн сайн сайхан байдлыг хангахад, нийгмийн хөгжлийг хангахад чиглэсэн сайн үр дүн авчирна гэдэгт эргэлзэхгүй байна.

Ийм учраас бид мэдээж хэрэг энэ хөтөлбөрийг өнөөдөр маш нухацтай хэлэлцэж байна. Асуултууд их гарч байна. Энэ дээр бас ажиллана гэж бодож байна.

Хамгийн гол зүйл бол мэдээж хэрэг бид зорилгоо тодорхойлох. Зорилтын дагуу төлөвлөгөөг Засгийн газар нарийн хийгээд, үүний дагуу хэрэгжилтийг хангах. Хэрэгжилтийг хангах явцад Улсын Их Хурал өөрөө шаардлагатай үед дэмжлэг үзүүлж, шаардлагатай үед хяналт тавьж ажиллах ийм л нөхцөл байдлыг бид хүлээж байна.

Энэ үүднээс нь аваад үзэх юм бол эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ, та бүхэн бидний хамтран боловсруулсан энэ баримт бичгийг дэмжиж саналаа өгөөч ээ гэдэг энэ саналыг би илэрхийлж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан:

Хажекберийн Жангабыл гишүүн үг хэлнэ.

Х.Жангабыл: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.2.20 дахь заалт болгон Даянгийн боомтыг хатуу хучилттай авто замаар холбох бүтээн байгуулалтыг эхлүүлнэ гээд мэргэжлийн Байнгын хороогоор дэмжигдээд Төрийн байгуулалтын байнгын хороонд орсон.

Төрийн байгуулалтын байнгын хороо хороонд дэмжигдээгүй байна.

Тэгэхээр ажлыг мөрийн хөтөлбөрт оруулья гэхээр агуулгаараа мөрийн хөтөлбөрт орчихсон байгаа.

Төлөвлөгөөнд оруулаад ажлыг хийж болох талаар хариулт өгдөг. Нэг бөөрөнхий.

Тэгэхээр ер нь энэ мөрийн хөтөлбөрт баруун бүсэд Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцаас өөр олигтой мега төслүүд ороогүй л дээ.

Баруун бүс дэд бүтэц, тэгээд уурхай сул хөгжсөн. Тэгээд энэ Даянгийн боомтыг хатуу хучилттай авто замаар холбох талаар бас санал хураалт явагдах юм байна.

Гишүүдэд энэ саналыг дэмжиж өгөөрэй гээд хүсэх байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн үгээ хэлнэ.

С.Эрдэнэбат: Засгийн газрын ирэх 4 жилийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт олон сайхан төсөл, хөтөлбөрүүд орж ирж байгаа.

Эдийн засгаа тэлэхэд голчлон чиглэх учиртай гэдгийг хэлмээр байгаа юм.

Хоёрдугаарт, энэ төсөл, хөтөлбөрийн бодит үр өгөөж эргээд бусад олон салбаруудаа тэжээн тэтгэх, эргээд өртгөө нөхөх энэ тал руу нь анхаарах хэрэгтэй. Зээл аваад төсөл, хөтөлбөр босгоод. Тэгээд энэ нь эргээд эдийн засгаа дэмжихгүй, гадаад дотоодын цөөхөн хэдэн хүмүүсийн ашиг, орлого болоод явна гэх юм бол энэ зохисгүй.

Тийм учраас ирэх 4 жил иргэдийн дундаж орлого яаж өсөх вэ, дундаж орлоготой иргэдийнхээ тоог хэдэн хувьд хүргэх вэ гэдэг энэ зүйлүүдийг бүх төсөл,

хөтөлбөр салбар болгон бас үүнийг бодож байх учиртай юм.

Энэ бол зөвхөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ч гэдэг юм уу ийм ажил биш. Бид бас энэ талаас нь харах гээд байдаг.

Тийм учраас энэ тал дээр анхаараарай гэдгийг давхар захиж хэлмээр байгаа. Олон төрийн албаны шинэчлэл гээд. Тэр төрийн албанд жил болгон 10 хувь бууруулна гээд зүгээр нэг тоо бодож байгаад тавьчихдаг зүйл байж болохгүй. Энэ хасагдсан гэж би ойлгож байгаа.

Цаашдаа энэ олон төсөл, хөтөлбөрүүд, шинэ байшин, барилгуудын дотор хүн ажиллана. Тэнд төрийн албан хаагч нар, багш, эмч, төрийн үйлчилгээний олон ажилтан ажиллаж байгаа. Хүн ам маань өсөж байгаа.

Тийм учраас харин тэр цомхон гэдэг дотор шинэ технологи, мэдээлэл энэ зүйл дээр нь хараад илүү их чадварлаг, байгаа боловсон хүчнээ илүү олон ажлуудыг давхар хийж болох ийм боломжийг нь бүрдүүлсний дараа энэ тооны асуудлыг сайн мэдэж байж цаана нь ярихгүй бол хий улс төрийн байдлаар цөөрүүлчихсэн гэдэг нэр авахын тулд цөөрүүлэх биш. Энэ талаас нь анхаараарай гэдгийг хэлмээр байна.

Нийт төрийн албан хаагчид болон ер нь энэ бүх салбаруудын цалин хөлсний асуудалд анхаарал хандуулахаас гадна яг энэ тулгамдаад байгаа хөдөө орон нутаг энэ салбарууд дээр харж байхад хамгийн чухал ард иргэдийн хүлээж байгаа, одоо хэдхэн хоногийн дараа сургууль эхлэх гэж байна. Багш дутагдалтай байгаа. Цөөлөх биш бүр дутагдалтай байгаа. Эмнэлгүүдэд сувилагч дутуу байгаа.

Тэгээд энэ хүмүүсийн асуудлыг тэр орон сууц болон бусад асуудлаар нь тэргүүн ээлжид авч үзэх нь зүйтэй юм. Тэр төсөв, санхүүгийнх нь хувьд ч гэсэн авч үзэхийг би хүсэж байна.

Тэгээд эвлэлдэн нэгдэх, хүний эрхийг дээдэлсэн парламент байна гээд бид тунхагласан. Энэ маш зөв. Энэ зүйлийгээ Засгийн газрын орж ирсэн мөрийн хөтөлбөр дээр зарим гишүүд зарчмын санал гаргаад тэр нь бараг дэмжигдэх юм шиг яваад байгаа. Би энэ дээр анхаараасай гэж бодож байгаа.

Бид “Азийн хүний эрхийн төв байгуулна”, “Ардчилсан нийгмийг бэхжүүлнэ”, “парламентыг илүү нийгэмжүүлнэ” гэж ярьж байгаа.

Тийм учраас энэ эвлэлдэн нэгдэх эрх. Тэгээд тэр жагсаал, цуглаан хийх эрх гээд өнгөц харахад нээлттэй мэт боловчиг аягүй олон тээгүүд бас байгаад байдаг юм.

Энэ тал дээр нь эрх зүйн хувьд нь нэлээн шинэчилж өгөх нь зүйтэй юм гэдгийг хэлмээр байна.

Тэгээд Эрүүл мэндийн даатгалын сан маань хүртээмжгүй. Нэлээн асуудал байгаа. Гэхдээ үүнийг хүртээмжтэй болгохын тулд манай Их Хурлын гишүүд маань суурь үйлчилгээнүүдийн салбарууд дээр очиж танилцах, асуудлыг нь маш сайн ойлгож байж саналаа гаргахгүй бол би ингээд харж байхад мэргэжлийн яам болон мэргэжлийн Байнгын хороодын зарим саналууд манай гишүүд маань ерөнхий нэг сураг байдлаар харж байгаад санал өгчхөөд эсрэг тэсрэг болгочоод байгаа асуудлууд байгаа.

Тийм учраас энэ мөрийн хөтөлбөрт олон анхаарах зүйлүүд дээрээ Засгийн газар өөрийнхөө асуудлуудыг хамгаалаад. Мөн болохгүй.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дуламын Бум-Очир гишүүн.

Д.Бум-Очир: Баярлалаа. Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг ерөнхийд нь дэмжиж байгаага юуны өмнө илэрхийлье.

Нэлээд олон гишүүд ярьсан. Энэ байдлаараа байвал Монгол Улс багшгүй болно. Ард түмний хүүхдүүд ямар багшаар яаж хичээл заалгах юм бэ гэдэг асуудлыг Ц.Мөнхтуяа гишүүн тэргүүтэй олон гишүүд хөндөж байна.

2030 он гэхэд 23 мянган багш дутагдана. Ийм тооцоог сайд өөрөө хэлсэн байгаа. Үүнийг мэдэж байгаа.

Гол учир нь ерөөсөө цалин бага, ажлын ачаалал их. Үүнээс болоод бидний хүүхдүүд орос хэлний багшаар англи хэл заалгаад, түүхийн багшаар нийгмээ заалгаад, химийн багшаараа биологио заалгаад олон жил ингэж явсан.

Энэ байдлаас бид яаралтай гарах хэрэгтэй. Энэ ажлыг энэхүү мөрийн хөтөлбөрт тусгаж оруулж ирсэнд баяртай байгаага илэрхийлмээр байна.

Энэ ачаалал их байгаа олон шалтгаан байгаагийн нэг нь хүүхдүүдийн сурагчдын тоо анги дүүргэлт 50 орчим хүүхдэд хүрчихсэн байгаа. Ялангуяа аймаг болоод сумдад. Үүнийг түрүүн Ц.Мөнхтуяа гишүүн хэлж байсан.

Тэгэхээр бид яамаар байна вэ гэхээр энэ хүүхдийн тоог анги дүүргэлтийг буулгамаар байна.

Одоогийн стандарт 30-аас 35 байгаа. Дэлхийн олон улсын стандарт 25 байгаа. 25 дээр аваачмаар байна. Тэгэхгүй 30, 35 гэдэг бол бас олон шүү.

Энэ байдлаар үндэслээд бид. Та бүхэн бодоод үзээрэй. 1 дүгээр ангийн багш 40 минут хичээлээ заахад 50 хүүхдийг тойроод явж амждаггүй. Нэг хүүхдэд 1 минут зарцуулж амждаггүй ийм нөхцөл байдалтай байгаа. Энэ үед бид багшаас ямар чанар шаардах юм бэ? Ийм нөхцөл байдал үүсээд байгааг Та бүхэн мэдэж байгаа.

Энэхүү нөхцөл байдлуудыг шийдвэрлэх зорилгоор одоогийн энэхүү мөрийн хөтөлбөрт олон сайхан зүйл туссан байгаа.

2.2.3.3.багшийн цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх.

Миний ойлгож байгаагаар яаман дээр илүү дүү нарийвчилсан төлөвлөгөө гарна гэж бодож байна.

Тэгэхээр тэр нарийвчилсан төлөвлөгөөг танилцуулаарай. Яаж үе шаттайгаар.

Улсын дунджид хүргэнэ гээд байгаа. Зүгээр миний хүсэлтээр улсын дунджаас бүр давуулмаар байгаа шүү. Дотоодын нийт бүтээгдэхүүний 20 хувьд хүргэх хэрэгтэй байгаа. 2024 онд 15 байгаа. Энэ жил 17 хувьд хүргэнэ гэсэн иймэрхүү зүйлс явж байна лээ. Үүнийг биелүүлээрэй.

Дараагийн нэг зүйл бол тэр анги дүүргэлтийг стандартад нь аваачна гээд байгаа.

Үүнийгээ дутагдалтай газруудад нь барилга, байгууламжаа байгуулах асуудал дээрээ илүү их анхаараарай.

Багш нарын гүйцэтгэлийн үнэлгээ гээд маш их хэрүүлтэй юм байдаг. Үүнийг мөн сайжруулна гэж байгаа. Үүнийг яг яаж сайжруулах гэж байгаа юм гэдгийг хармаар байна.

Түүнчлэн хүний нөөцийн асуудал дээр маш зөв зүйлс туссан. Цэцэрлэгийн багш гээд тэгэхэд 10 мянга, бага ангийн багш 2 мянга, ерөнхий боловсролын сургуулийн багш 11 мянгыг бэлдэнэ гэж байна.

Яг яаж бэлдэх гээд байгааг яамны нарийвчилсан төлөвлөгөө дээрээс харахыг хүсэж байна.

Бид боловсролын салбарт хийж байгаа хөрөнгө оруулалтаасаа хэзээ ч татгалзаж ёсгүй юм. Энэ бол зөвхөн багш нарын цалинг нэмж байгаа үйл явдал биш. Энэ бол татвар төлөгчдийн хүүхдүүдэд буюу Монголын ирээдүйд хөрөнгө оруулалт хийж байгаа зүйл гэдгийг эрхэм гишүүд Та бүхэн маань анхаарч дэмжээсэй гэж хүсэж байна.

Дараагийн нэг зүйл юу гэхээр нь соёлтой холбоотой асуудал дээр хоёр, гурван зүйл хэлбэ.

Сумын төвд соёлын төв байгуулах асуудлыг дэмжиж байгаа гэдгийг би онцгойлон хэлмээр байна.

Түүнчлэн соёл гэдэг зүйл гар утсанд байдаг юм биш ээ. Хүний оюун ухаанд байдаг юм шүү. Соёлыг хүнийг

хүн болгодог хамгийн чухал зүйл соёл шүү. Би өөрөө “соёлын хүн судлал” гэдэг мэргэжилтэй ийм хүн юм.

Энэ 126 гишүүд дотроос ийм мэргэжилтэй хүн цөөхөн болов уу гэж бодож байна.

Тийм учраас Та бүхэн бас энэ асуудлыг хүндэтгэж үзэх болов уу гэж бодож байна.

Бид хүмүүсээ соёлтой, боловсролтой болгохгүй бол, монгол хүнээ Монгол болгохгүй бол, Монгол Улсаа Монгол байлгаж чадахгүй шүү. Энэ бол бидний соёлтой хамаатай хамгийн чухал хүчин зүйлс байгаа.

Дараагийн нэг зүйл тэр шинэ хоршооны тухай асуудал. Түрүүн бас гишүүд уг нь зөв л юм ярьж байна лээ дээ. О.Амгаланбаатар гишүүнтэй зарим талаар санал нэг байна.

Бид өмнө нь олон янзын гашуун туршлагатай. Тогтвортой амьжиргаа төсөл дээр “Малчдын бүлэг” гэж гарсан. “Ногоон алт” төсөл дээр “бэлчээр ашиглах хэсэг” гэж гарсан. Энэ хэсгүүд маань энэ төслүүдэд орсон малчид маань хоршоо болж чадаагүй олон тохиолдол байгаа. Эндээс бид суралцах юм их байгаа шүү гэж хэлмээр байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн үг хэлнэ.

М.Нарантуяа-Нара: Засгийн газрын мөрийн хөтөлбөртэй холбоотой асуудлуудаар.

Түрүүн хэлж байна л даа. Ер нь тодорхой товч яг ийм тодорхой хариулт

ерөөсөө өгөхгүй юм. Тийм учраас би зүгээр хэлмээр санагдлаа.

Нэгдүгээрт, мөрийн хөтөлбөр орж ирэхдээ судалгаа хийгээд. Тийм ээ. Хамрах хүрээгээ тодорхой болгоод, түүн дээрээ ийм хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж орж ирдэг байх гэж би хувьдаа бодоод байгаа юм.

Тэгээд цалинтай эцэг, эх гээд нэрлэхсэн байгаа энэ юмаа түрүүн Нийгмийн хамгааллын сайд маань хэлсэн. Одоо энэ хавтгайрсан халамж хэтэрчихсэн байна. Халамжийг танах хэрэгтэй. Үүнтэй санал нэг байгаа.

Тэгэхдээ үнэхээр одоо жишээлбэл 120 мянган хүнсний талоноор амьдардаг иргэд байна гээд ингээд яриад байгаа.

Үнэхээр хөл гар, эрүүл мэндийн хувьд бүрэн бүтэн мөртөө энэ төрийн халамж аваад, ажилгүйдэл ядуурлын тоог нэмээд байгаа энэ хавтгайрсан халамжийнхаа юмыг шинэ сайд маш сайн тодорхой болгоод энэ хэрэгцээгүй, шаардлагагүй энэ халамжаасаа танаад, харин үнэхээр энэ ээжүүдийн.

Жишээлбэл, ээж гэдэгт хэдээс хэдэн насны хүүхэдтэй ээжүүд багтах юм бэ гэдгээ маш сайн тодорхой болгоод ээжүүдэд энэ “Цалинтай эцэг, эх” гэсэн хөтөлбөрөө үнэхээр цалин шиг цалин олгоосой гэж хүсэж байна.

Тэгэхгүйгээр жишээлбэл ээжүүдийн цалин гэхээр хүмүүс нэг насан туршдаа ээж хүн гэдгээрээ нэг халамж авах гэж байгаа юм шиг бодоод байж бас магадгүй. Тийм юм ерөөсөө байхгүй.

Ялангуяа хүүхдийн насжилтын үе шат гэж байдаг.

▷ 28 хоногтой хүүхдийг “нярай хүүхэд”,

▷ 6 сар хүртэл “нялх хүүхэд”,

▷ 2 сар хүртэл “бага насны хүүхэд” гээд ингээд нэрлээд явдаг шүү дээ.

Тэгэхээр үүнийгээ маш сайн тодорхой болгоод оруулаасай.

Хэрвээ тэгэх боломж байхгүй бол энэ мөрийн хөтөлбөрт тусгасан байгаа “цалинтай эх” гэдэг нэршлээ 50 мянгаар нь үргэлжлүүлэх гэж байгаа бол 50 мянган төгрөг ч гэсэн хаа юм гэдэг ийм нэршлээр өөрчилдөг юм уу, яадаг юм.

Тэгэхгүй нэг ийм. Одоо хагас өдрийн цалин ч 50 мянган төгрөг байхгүй байгаа шүү дээ.

Тэгэхээр манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны шинэ сайд маань маш сайн шинэ нэмэлт судалгаануудыг хийгээд, ээжүүдийн энэ хамрах хүрээг тодорхой болгоод. Үнэхээр боломж байгаа бол тэр хэрэгцээгүй тараад байгаа халамжаа танаад харин энэ ээжүүдэд тодорхой хугацаанд төрийн халамж хэрэгтэй цаг хугацаанд нь халамжлаад эргээд энэ хүмүүс ажилдаа ордог, ажлаа хийдэг, үр хүүхдээ өсгөдөг ийм тусгай ийм онцгой сегмент байгаа гэдгийг хэлмээр байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Гомбын Ганбаатар гишүүн үгээ хэлнэ.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд ээ. Гишүүд ээ.

Тэгээд энэ хамтарсан Засгийн газрын энэ 4 жилийн үйл ажиллагааны

мөрийн хөтөлбөрт сэтгэл хангалуун байгаа. Бас нэлээн томоохон төслүүд, ялангуяа тэр улс орны эдийн засгийг тэлэх 14 томоохон төслийн 9 нь манай говийн бүсэд хэрэгжихээр байгаа.

“Нефтийн үйлдвэр”, тэр “Орхон-Онги” гол, “Хэрлэн-Тооно” төсөл гээд л. Тэгээд зэсийн үйлдвэр, дулааны станц гээд олон томоохон төслүүд хэрэгжихээр.

Дээр нь говийн бүсээс дэвших гээд явж байх үедээ амласан зүйлүүд бас энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт бүрэн орсонд сэтгэл хангалуун байгаа гэдгээ хэлье.

Энэ Засгийн газраас 5 гол зүйлийг л хүсэж байгаа.

Нэгдүгээрт нь, сая М.Нарантуяа-Нара гишүүн ярьж байна. Халамжийн бодлого.

Энэ халамжаа нэг цэгцлэхгүй бол очигдөр тэр Төсвийн байнгын хороон дээр тэр Л.Мөнхзул Төрийн нарийн бичгийн даргын ярьснаар хүүхдийн мөнгө ороод давхардсан тоогоороо хүн амынх нь 60 гаруй хувь халамж авдаг ийм улс гэж ер нь юу байх вэ дээ. Энэ халамжаа нэг цэгцлэх цаг болсон.

Хоёр дахь асуудал. Цомхон бөгөөд төрийн энэ чадварлаг албаны асуудал байгаа. Түрүүнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга ярьж байна.

Гурав дахь нь, мэдээж төсвийн зардлаа оновчтой байлгах асуудал.

Дөрөв дэх нь, бизнесийн орчноо сайжруулах. Энэ татвар, хууль эрх зүйн орчноо бизнест бас нэг ээлтэй орчин бий болгох асуудлыг Та бүхнээс хүлээж байгаа.

Тав дахь гол асуудал бол гадаадын шууд хөрөнгө оруулалтын асуудал байгаа.

Энэ 5 зүйл дээр энэ Засгийн газар анхаарч ажиллаасай гэж хүсэж байгаа.

Тэгээд энэ 5-ыг бид хийж чадах юм бол энэ 4 жилийн хугацаанд. Дээрээс нь энэ мөрийн хөтөлбөртөө орсон томоохон төслүүдээ явуулж чадвал монгол хүний амьдрал, монгол хүний амьдралын чанар сайжрах юм гэж бодож байгаа.

Бас нэг бүс нутгийн чанартай зүйл бол энэ нэг нефтийн үйлдвэр байна. Аль 2017 онд л шавыг нь. 2017 оны 9 дүгээр сард л 2022 онд орно гээд шав тавьж байсан. Одоо ашиглалтад орохоос хойш 2 жилийн хугацаа өнгөрлөө.

Гишүүдэд өгсөн мэдээллээр одоо энэ нефтийн үйлдвэр чинь үндсэндээ ажлынхаа гүйцэтгэлийн дөнгөж 17 хувьтай. Дээрээс нь Энэтхэг Улсын ЭКСИМ банкнаас авах нөгөө тэрбум 200 гаруй сая зээлийнхээ 21 хувийг аваад зарцуулчихсан.

Гэтэл ажлынх нь гүйцэтгэл 17 хувьтай байж байдаг.

Одоо Засгийн газрын мөрийн хөтөлбөрт 2027 онд орохоор ярьж байгаа юм байна.

Одоо 17 хувийн гүйцэтгэлтэй байгаа юман дээр ингээд сайн анхаарахгүй бол. Энэ удирдлага арга зүйгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт явдаг юм байна. Би түрүүнд Ц.Туваан сайдаас асуулаа.

2028 он гэхэд бас л өнөөхөө ярьсаар гэдэг шиг ахиад нефтийн үйлдвэр яриад байж байх вэ гэдэг санаа зовнил байна.

Тийм учраас энэ дээр холбогдох газруудад нь сайн анхаарч ажиллахгүй бол энэ нефтийн үйлдвэрийн чинь ажлын гүйцэтгэл дэндүү хариуцлагагүй байна.

Сая бас төсвийн тодотголоор бид санхүүжилтэд нь 52.7 тэрбум төгрөгийг 2024 онд санхүүжүүлэх гүйцэтгэлтэй уялдуулаад төсвийн тодотголд нь баталж өглөө.

Тэгээд ерөнхийдөө сая ингээд төсвийн тодотгол явж байх үед нэг хамтарсан Засгийн газар юм чинь Улсын Их Хурлын бүлгүүд аль аль нь дэмжихгүй яах вэ гэсэн хандлага ажиглагдаад байна.

Засгийн газрын үйл ажиллагаа “зөвд чинь зөөлөн, бурууд чинь хатуу явна шүү” гэдгийг энэ ташрамд хэлье.

Түүнээс аль нэг намын бүлэг байлаа гээд буруу явах юм бол дэмжээд явна гэсэн ойлголт байхгүй.

Нэг хоржоонтой үг байдаг. “Эхнэр, нөхөр хоёр хамт унтсан ч зүүд нь тусдаа” гэж.

Үнэхээрийн энэ Засгийн газар хамтраад зөв явах юм бол дэмжээд явна гэдгийгээ бас энэ ташрамд хэлье.

Тэгээд амжилт хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Отгоншарын Батнайрамдал гишүүн үг хэлнэ.

О.Батнайрамдал: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсын эдийн засгийг бүтэц талаас нь, сүүлийн 15 жил гарсан үсрэнгүй хөгжил талаас нь, өсөлт талаас нь аваад үзсэн ч гэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт маш том байр суурь эзэлсээр ирсэн.

Тэр дундаа Оюу Толгойн бүтээн байгуулалт.

2023 оны төгсгөлөөр гэхэд нийтдээ бараг 17.4 тэрбум доллар Монгол Улсын эдийн засаг руу хөрөнгө оруулалт хэлбэрээр орж ирсэн гэсэн үг.

Тэгэхээр мэдээж гадаад валютын нөөцөд энэ хөрөнгө оруулалтаар дамжаад Монгол Улсын эдийн засагт үржиж байгаа үржвэрийг нь аваад үзэх юм бол маш том хөрөнгө оруулалт гэсэн үг.

Тэгэхээр ер нь ойролцоогоор Оюу Толгойн бүтээн байгуулалт жил бүр 1.5-аас 2 тэрбум долларыг Монгол Улс руу оруулдаг гэсэн үг.

Тэгэхээр дараа жил 2025 он гэхэд нөгөө Оюу Толгойн жил болгон тэр 2 тэрбум доллар оруулж ирж байсан бүтээн байгуулалт маань дуусаж байгаа юм.

Тэгэхээр жил болгон эдийн засаг руу орж ирдэг тэр гадаад валютын нөөц нэг талаасаа байхгүй болно гэсэн шинэ бодит байдалтай бид 2025 онд нүүр тулна гэсэн үг.

Оюу Толгой төсөл дээр нийтдээ 20, 22 мянга орчим ажилчид ажиллаж байгаа юм.

Тэгэхээр Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт дуусахаар энэ 20 мянга орчим ажилчдын бараг хагас нь

нэг ёсондоо ажилгүй болох ийм дүр зураг бас харагдаж байгаа юм л даа.

Тэгэхээр энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт энэ том мега төслүүдийг явуулна гээд 14 мега төслийг оруулж ирсэн. Тийм ээ.

Тэгэхээр энэ 2025 оноос өгсүүлээд бид энэ Оюу Толгойн бүтээн байгуулалт дууссанаараа гарах үр дагаврыг хэрхэн нөхөх вэ?

Эдийн засгийн өсөлтийг бид яг тогтсон хэмжээндээ барихын тулд энэ гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хаанаас нөхөх вэ. Буцаад тэр Оюу Толгой дээр ажил орлогогүй болох тэр 10 мянга, тэр Оюу Толгойн бүтээн байгуулалтыг дагаад маш их ур чадвар бас бий болсон байдаг. Тэр ханган нийлүүлэгчдийг аваад үзэх юм бол.

Тэгэхээр өнөөгийн эдийн засаг, тэр дундаа уур уурхайн салбар тэр ажилгүй болох 10 мянган хүнийг шингээн авах боломжгүй.

Тэгэхээр заавал нэг мега төсөл хэрэгжиж байж буцаад түүнээс эрэлт үүснэ, буцаад түүнээс гадаадын шууд хөрөнгө оруулалт орж энэ орон зайг бас зайлшгүй нөхөх ийм дүр зураг дараа жилээс эхлээд харагдаж байгаа юм.

Тийм учраас бид тэр 14 төсөл дотроо ч гэсэн аль нь эхлээд хамгийн түрүүнд заавал хэрэгжих ёстой юм. Хэрэгжиж байж буцаад энэ Оюу Толгойн бүтээн байгуулалт дууссанаараа гадаадын шууд хөрөнгө оруулалт багасах тэр орон зайг хэрхэн нөхөх вэ.

Тэр ажилгүй болох 10 мянга мянган хүнийг буцаад ямар мега заслууд руу бас ингээд ханган нийлүүлэгчээр ч

юм уу, контрактаар ч юм уу ажилд оруулах вэ.

Тэгэхээр үүнийг бид мөрийн хөтөлбөртөө, тэр дундаа мөрийн хөтөлбөрийг дагаад гарч ирэх нарийвчилсан төлөвлөгөөндөө маш уялдаатай заавал тусгах хэрэгтэй.

Тэгэхээр ингэж байж бид бас яг зорилтот эдийн засгийн өсөлтөө цаашдаа авч явах боломжтой болно.

Тэгэхээр энэ бүтээн байгуулалт Монголд ялангуяа уур уурхай, түүнийг дагасан дэд бүтцийн салбарт маш том цахиур хагалсан маш том ур чадварыг бий болгосон.

Тэгэхээр дараагийн бүтээн байгуулалт нь гацсаар байгаад тэр ур чадвар бас алга болчих вий гэсэн айдас байгаа юм.

Тэгэхээр үүнийгээ илүү нарийвчилсан төлөвлөгөөндөө. Энэ болох, энэ гарч ирэх үр дагаврыг бас тооцоолж байж нарийвчилсан төлөвлөгөөндөө тусгаж заавал оруулаасай гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: 5 гишүүн үг хэлсний дараа санал хураалт шууд эхэлнэ. Гишүүдийнхээ ирцийг хангая.

Мөнхчулууны Энхцэцэг гишүүн үг хэлнэ. Алга байна. Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн үг хэлнэ.

Х.Тэмүүжин: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг баталж байгаатай холбоотойгоор Улсын Их Хурал дээр жоохон нэг талыг барьсан андуу ойлголт бас яваад байгааг хэлэхээс өөр арга алга.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг Улсын Их Хурал баталж байгаа.

Засгийн газар түүгээрээ баталдаг байсан бол зөвхөн нэг талтай. Бид ийм юм хиймээр байна гэдэг үг байх байсан байх.

Улсын Их Хурал баталж байгаагийн гол зорилго бол та нараар бас

- *ийм ажил хийлгэмээр байна,*
- *хийж байгаа ажлыг чинь ингэж үнэлмээр байна,*
- *үүнийг нь хийсэн,*
- *үүнийг нь хийгээгүй*

гэж хэмжих хэмжүүртэй баймаар байна гэдгийг хэлэх гэж оролдож байгаа юм.

Тийм учраас Засгийн газрын зүгээс ярьж байгаа жоохон ерөнхийлөөд биччихье, энэ нь энд агуулагдаж байгаа, тодорхой нэг юм нэрлээд яах вэ гэх мэтчилэн энэ үгүүд бол хуурмаг шүү.

Улсын Их Хуралд аль болох

- *хянагдахгүй,*
- *хэмжигдэхгүй,*
- *баригдахгүй*

гэдэг бодлынх нь илрэл гэдгийг бас Улсын Их Хурлын гишүүд анзаарч анхаарч байх ёстой.

Хоёрт нь, би дахиад нэг зүйлийг хэлэх гээд байгаа юм.

Энэ гурван нам хамтраад энэ Засгийн газар зориг гаргаад томоохон өөрчлөлт хийе гэж байгаа бол эдийн засгийн том өөрчлөлтүүд хийж болно.

Гэхдээ хуулийн хүний эрхийн энэ шударга ёсныхоо тал дээр бас жоохон дорвитой өөрчлөлт хийхгүй бол эдийн засгийн өөрчлөлт хийх гэж байгаа ахлахууд чинь бүгд ер нь авлигын хэрэг болоод шоронд явна шүү.

Нөгөөтээгүүр энэ гүйцэтгэх ажлын хавтгайрчихсан, хувийн мэдээллийг төрд олж аваад тэр нь шүүх рүү явдаггүй, хэн нэгэн даргын сейфт хадгалагддаг, тэр мэдээллээр хэн нэгнийг шантаажилдаг, бизнесийг нь тонож дээрэмдэх гэж оролддог, мэдээллийг нь авчирч өгсөн хүнийг албан тушаал ахиулж дээш нь тавьдаг болчихсон энэ тогтолцоог өөрчлөхгүй бол шийдвэр гаргалт чинь бизнесийн хүрээнд ч, улс төрчдийн хүрээнд ч ардчилал гарахаа байсан шүү. Эрх чөлөө тодорхойлохоо байсан юм шүү.

Тийм учраас би бүр хариуцлагатайгаар хэлмээр санагдаад байгаа юм.

Энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.1.13-т байгаа энэ заалт бол түүхтэй заалт.

Энэ заалтыг 2016 онд оруулж ирэхэд Ерөнхий сайдаа унах хэмжээнд хүртэл хуулийн байгууллага чинь боссон юм шүү.

Нэг өглөө босоход өдөр тутмын хэвлэлүүдээр цагдаа, тагнуул, АТГ-ын даргууд мэдэгдэл хийгээд “Засгийн газрын өргөн барьсан хуулийг татаж ав” гээд Ерөнхий сайд аа айлгаж байсан.

Тэр үйл явдлын дараа энэ Чимгээ, Содномдаржаа гэх мэтчилэн С.Зоригийн хэргийн аллагатай холбоотойгоор гүйцэтгэх ажил нэрийн доор яаж эрүү

шүүлт болдог тухай хангалттай их ярьсан.

Энэ сонгуулиар яг энэ сэдвээр хангалттай их шоудсан.

Эрүү шүүлт, гүйцэтгэх ажил хоёр чинь нэг зоосны хоёр тал болсон.

Үүнийгээ шийдэх тухай алхам хийхгүй шоудах тухай ярьж байгаа бол иргэд итгэхгүй байгаа шүү.

Шийдэх гээд бичээд Засгийн газар нь оруулаад ирэхээр Улсын Их Хурал дээр энэ заалтыг хасах гэж санал гаргадаг. Одоо бүр бүдгэрүүлэх гэж санал гаргадаг.

Тодорхой байгаа, хэмжигдэхүйц байгаа асуудлыг зүгээр ингээд заачихъя гээд хууль хүчний байгууллагуудын арын өрөөнөөс гар хөл нь олоод санал явуулж байгаагаа одоо болих хэрэгтэй.

Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний төлөөлөгч болохоос биш хуулийн байгууллагын буруу явж байгаа арга замын төлөөний хүмүүс ерөөсөө биш шүү. Үүнийгээ бас сайн бодоорой.

Эцэст нь хэлэхэд, Дахиад хэлье.

Яг Герман шиг нууц цагдаагийнхаа гарт орчихсон улс орнууд яаж салсан бэ гэхээр

► парламентын хяналт,
► шүүхийн хяналт,
► иргэний хяналт гурваа л сайжруулж байж энэ гажгаас гарсан.

Парламентын хяналтын асуудал нь Засгийн газрын ажил биш учраас энд бичээгүй.

Шүүх иргэний хяналтыг нь яг энэ заалт дээр бичсэн. Шүүхэд хянагдахыг хүсэхгүй, иргэндээ үнэнээ харуулахыг хүсэхгүй байгаа хүмүүс байнга араар нь хүчирхийлэл хийдэг ногоон малгайтан байдаг.

Энэ дээр Улсын Их Хурлын гишүүд минь.../минут дуусав/

Д.Амарбаясгалан:

Рэнцэндоржийн Батболд гишүүн үг хэлнэ.

Р.Батболд: Гишүүдэд өдрийн мэнд хүргэе.

Тэгээд Засгийн газрын хөтөлбөр батлах явж байна.

Тэгээд энэ ямар ч байсан гурван нам нийлээд байгуулсан Засгийн газар. Энэ мөрийн хөтөлбөр нь батлагдаад явах байх.

Тэгээд энэ дээр ганц хоёр л юм хэлмээр байгаа юм.

Энэ 40 их наядын хөрөнгө оруулалттай том том төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр яваад байна. Тэгээд энэ нь орж ирж байна.

Тэгээд засагт нийлсэн энэ намууд ер нь энэ талаараа ярилцсан юм уу, ярилцаагүй юм уу гэж нэг сонирхолтой асуудал төрөөд байгаа юм.

Энэ оруулж ирж байгаа асуудал нь Төсвийн байнгын хороон дээрээ хүртэл уначих гээд ингээд сонин болоод байдаг.

Тэгээд цаашдаа энэ хамтарсан Засгийн газар чинь ер нь аль зэрэг урт настай юм бэ гэж хүртэл бодогдоход л хүргээд байна л даа.

Тэгээд дээрээс нь эх үүсвэр нь тодорхойгүй энэ 40 их наядын асуудал яриад. Үүнтэй холбоотой улсын төсвөөс гаргах баахан мөнгө яриад байдаг. Энэ бас нэг жоохон учир дутагдалтай байна л гэж хэлмээр байна.

Энэ Боловсролын сайдад хандаад бас ганц хоёр үг хэлчихмээр байх юм.

Энэ том төслүүд хэрэгжлээ гэхэд, одоо жишээлбэл тэр гүүр, туннелийн асуудлууд байгаад байдаг. Үүнийг ашиглаад үндэсний боловсон хүчнээ бэлдээд авчих бодлого боловсруулахгүй юм уу. Энэ чинь 4, 5 жилийн хөтөлбөр яваад байдаг.

Өнөөдрөөс эхлээд төлбөргүйгээр ч хамаагүй оюутан суралцуулаад энэ инженерүүдийг нь бэлдээд авах тал дээр ер нь анхаарч болдоггүй юм уу гэдэг нэг асуудал яваад байдаг. Үүнийг яаж хэрэгжүүлэх юм болоо гэж бодож байна.

Энэ хөтөлбөрт орж ирсэн дунд нь байсан заалтуудаас зарим нэг асуудлууд бас алга болчихсон. Нэр зааж орж ирсэн энэ сэргээгдэх эрчим хүчний төслүүдээс нэр заасныг нь хасъя гэсэн санал ороод ирчихсэн яваад байна л даа.

Энэ тэгэхээр нэг эрх ашиг яваад байдаг юм болов уу. Ямар учиртай байдаг юм бол гээд асуучихмаар байна.

Иргэний Зориг Ногоон Нам бол угаасаа энэ ногоон эрчим хүч, ногоон хөгжлийг дэмжиж байгаа учраас сэргээгдэх эрчим хүч тал дээр бас их анхаарч ажиллана гэж бодоод байгаа.

Тэгээд иймэрхүү асуудлууд байгаад байна гэж л хэлье дээ. Энэ дээрээ анхаарч ажиллаач ээ л гэж хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Жадамбаагийн Баясгалан гишүүн үг хэлнэ.

Ирцээ бүрдүүлээрэй. Шууд санал хураалт эхэлнэ шүү.

Ж.Баясгалан: Энэ өдрийн мэндийг энд байгаа бүх хүмүүст хүргэе.

Тэгээд энэ удаагийн Улсын Их Хурал бол салбар салбарын төлөөлөлд орсон маш эрүүл парламент болж байгаа болов уу гэж бодлоо.

Одоо тэгээд эхний гаргаж байгаа шийдвэрүүдийг харахад ч гэсэн. Ерөөсөө яг салбар салбараас өөр өөрсдийнхөө саналыг оруулж ирж байна. Өөр өөрсдийнхөө саналыг тусгаж байна. Бас хамгаалж чадаж байна гэдэг нь хамгийн гол асуудал байна.

Тэгээд ер нь энэ заалтуудаас харж байгаад би хэдхэн юм хэлье.

Нэгдүгээрт, энэ “хөгжлийн бэрхшээлтэй” буюу “тусгай хэрэгцээт иргэд” гэдэг бол Монгол Улсын нийт өрхийн 13 хувийг хамарч байгаа шүү дээ.

Тэгээд Монгол Улсын бүх газар нутгийн хувьд тархмал байгаа.

Тэгээд энэ дээр энэ 19 дүгээр зүйл дээр байгаа юм. Төрийн байгуулалтын байнгын хороос орж ирсэн. Өнөөдөр хэлэлцэх асуудлын.

19 дүгээр зүйл дээр Нийгмийн бодлогын байнгын хороон дээр

унагаачихсан нэг асуудал байгаа. Энэ бол гол агуулгын зүгээр би та нарт хэлэх юм бол орон нутагт, аймгуудад “Хөгжлийн бэрхшээлтэй хүний төв” гэж байдаг. Үүнийг барихыг болиулья гэсэн тийм ерөнхий санал байсан.

Тэгэхээр энэ бол болохгүй. Яагаад гэвэл хөгжлийн бэрхшээлтэй хүн бол “А” цэгээс “Б” цэгт хүрэхдээ бусад хүмүүсээс илүү их хүч хөдөлмөр зарцуулдаг, илүү их цаг хугацаа зарцуулдаг, илүү их энерги зарцуулдаг.

Тэгэхээр Баян-Өлгий аймагт байгаа хүн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний төв”-өөр үйлчлүүлэх гэж, хөгжлийн бэрхшээлтэй хүнийхээ асуудлыг шийдүүлэх гэж, сэтгэл зүйчтэй уулзах гэж тэр дараагийн аймаг руу, эсвэл Улаанбаатар хот руу явж болохгүй.

Тэр хооронд тэр гэр бүл яах билээ, тэр хүн ажиллангаа эмчилгээгээ хийлгэх ёстой тохиолдолд яах билээ.

Ийм болохоор ерөөсөө энэ 19-ийг дэмжээгүйгээр нь Та бүхэн маань бас дэмжиж өгөөрэй. Энэ бол мэдээж мэргэжлийн Байнгын хороо нь дэмжээгүй учраас энэ санал унах ёстой гэж бодож байна.

Тэгээд хоёрдугаарт гэвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тал дээр оруулсан саналуудыг маш сайн оруулж өгсөн. Энд маш их баяртай байгаа. Яагаад гэвэл нэгэнт л энэ салбарыг мэдэхийн хувьд, энэ зовлонг өдөр болгон туулж байгаагийн хувьд үг, үсэг болгоноор нь оруулж өгсөн.

Тэгээд ялангуяа энэ “стандартыг албан байгууллагад” гэж байхгүй байсныг “албан байгууллагад” гэж

оруулж өгсөн Байнгын хорооддоо баярлалаа.

Тэгээд үүнийг дэмжиж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Хөгжлийн бэрхшээл гэдэг бол төрмөл юм биш ээ. Энэ олдмол байдаг. Энэ бол хэнд ч тохиолддог, хэзээ ч ирдэг.

Тэгэхээр “Хөгжлийн бэрхшээлтэй хүний төв”-өөр зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүн үйлчлүүлнэ гэсэн ойлголт бас биш шүү.

Тэнд дөнгөж гэмтсэний дараа, харвалтын дараах, ерөөсөө хүүхдүүд хүртэл сэтгэл зүйчтэй уулзах боломжтой төв нээгдэж байгаа.

Өнөөдөр 5 аймагт ийм төв байгаа. 5 аймгаар тавуулангаар нь явсан. Тэр төв дээр очиж байгаа хүмүүс сэтгэл санаа маш өндөр байгаа.

Тийм болохоор энэ төвүүд бүх аймагтаа байх ёстой гэдэг дээр хатуу байр суурьтай байна. Та бүхэн минь тэгээд үүнийг дэмжиж өгөөрэй. Баярлалаа.

Д.Амарбаясгалан:

Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн үг хэлнэ.

Н.Батсүмбэрэл: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг дэмжиж байгаа.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр ирэх 4 жилийн гол бодлогын баримт бичиг байна гэж харж байна.

Ийм учраас энэ том бодлогын асуудал нэлээн түлхүү орж байгаа явдлыг дэмжиж байна.

Тэр дотор энэ бүсчилсэн хөгжлийн асуудлыг ихээхэн дэмжиж байгаа.

2024 оны Улсын Их Хурлын 67 дугаар тогтоолоор Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлагдсан байна. Үүнийг улам цааш нь хөгжүүлж явуулах зайлшгүй шаардлага байна.

Энэ жилийн Улсын Их Хурлын сонгуульд 6 бүсэд түшиглэж хийгдлээ. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд сая бүс болоод байгаа аймгуудын чухам аль нь төв нь байх вэ гэдгийг эдийн засгийн болон хүн амын нягтаршил байгалийн хүчин зүйлийн тооцоогоор нь гаргаж оруулж өгөх нь зүйтэй байна.

Цаашлаад энэ сумдыг хооронд нь нэгтгэх. Заримыг нь хөгжлийн хувьд дэмжиж өгөх. Хил, зах хязгаар сумдаа илүү дэмжих гэдэг юм уу ийм бодлогоор сумдын тоог цөөлөх, хооронд нь нэгтгэж хөгжих бололцоотой байдлаар нь загварчлалд оруулах ийм зайлшгүй шаардлагатай гэж харж байгаа.

Үүнийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу гаргах төлөвлөгөөнд тусгахыг захиж хэлж байна.

Энэ гаргасан судалгаа харлаа. Судалгаан дээр Монгол Улсын микро эдийн засгийн хөгжлийн загвараар 90 бүс буюу орон нутгийн хөгжлийн 90 төв байж болох юм байна гэдэг загвар төсөөллийг гаргачихсан юм байна. Энэ их ултай байж мэдэхээр юм байна.

Үүнийг бид хийж чадах юм бол энэ 90 микро бүсийг нь дагуулаад бизнес инкубатор төвүүд, хөгжлийн олон

кластерууд бий болох бололцоотой. Хөрөнгө оруулалт ч өөрөө эрэмбэтэй болж ирэх юм. Одоо бид энд соёлын төв барих уу, барихгүй юу, эрчим хүчээ хийх үү гэж хэрэлдээд сууж байх биш.

Сонгогдсон гишүүд маань нэг амьсгаагаар сумдынхаа нэрийг тоолоод сууж байх биш. Нөгөө хэдэн жалга довныхоо хэдэн байшин барилгынхыг яриад сууж байх биш. Арай илүү хөгжлийн загвар луу орох болов уу гэж харж байгаа.

Ийм учраас Засгийн газрын 2024-2028 онд баримтлах энэ үйл ажиллагааны хөтөлбөр дээр бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаа нэлээн түлхүү авч яваарай. Үүнийгээ хөтөлбөрүүддээ сайн тусгаарай.

Улс орны гадаад бодлого ч өөрөө энэ рүү нэлээн түлхүү, бүс нутгийн болон томоохон интеграц руу нэлээн хүчтэй, идэвхтэй улс төрийн олон улсын байр суурьтай бид ажиллаж байна.

Тэгэхээр Монгол Улсын хөгжлийн загварчлалаа бид энэ байдлаар харах хэрэгтэй байна. Ингэж байж бидний нөгөө яриад байгаа хөгжлийн том зураглалууд маань урагшаа явах нь гэдгийг онцолж хэлье.

Тэгээд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эдийн засгийн хөгжлийн яам, бусад холбогдох яамдууд энэ дээрээ тооцож сумдуудаа нэгтгэхийн цаана хөгжүүлэх асуудал.

Аймгуудын нэгтгэсэн бүсийн хөгжлийг цааш нь явуулж, бүсийн тулгуур төвүүдээ ганц эдийн засгийн биш хүн амын нягтаршил, бусад хөгжлийн суурь нөөцүүдээр нь тулгуурлаж төвүүдээ зуруулж гаргаад дэмжээд,

хөрөнгө оруулалтын эрэмбээ ч гэсэн үүнтэй нь нийцүүлж явахыг хэлж байна.

Д.Амарбаясгалан:

Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн үг хэлнэ.

М.Бадамсүрэн:

Хүний амьдралыг аз жаргалтай болгодог гол хоёр зүйл юу вэ гэж.

Нэгдүгээрт, үр хүүхэд. Хоёрдугаарт, байгаль эх дэлхий.

Тэгээд монголчууд үүнийг хэлэхдээ “Үртэй бүхэн жаргаж, үндэстэй бүхэн дэлгэрдэг” гэдэг.

Тэгээд би үүнтэй холбоотой Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн талаар Байнгын хороон дээр санал хураасан. Энэ зарчмын зөрүүтэй саналын 4 зүйл дээр саналаа хэлье.

Нэгдүгээрт, 31 дэх хэсэгт байгаа энэ Засгийн газрын өргөн мэдүүлсэн “Тусгай хамгаалалттай газар нутгийг өргөтгөнө.” гэснийг Байнгын хороон дээр энэ “өргөтгөнө” гэдгийг нь хасчихсан байна лээ.

Тэгээд Тусгай хамгаалалттай газар нутгийг нийт нутаг дэвсгэрийн 30 хувьд хүргэх гэж “Алсын хараа-2050” бодлогын баримт бичиг тусгасан байгаа.

Ер нь Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг ямар ч улс орон “нэмэгдүүлнэ” гэж зорилт тавьдаг болохоос биш “хасна” гэдэг зорилт хэзээ ч тавьдаггүй.

Тийм учраас үүнийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр хэвээр нь үлдээх шаардлагатай гэж саналаа хэлж байна.

Хоёрдугаарт нь, энэ зарчмын зөрүүтэй саналын 7 дахь хэсэгт байгаа.

Хүүхдийг хөгжүүлэх талаар. Өөрөөр хэлбэл Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хүүхэд хамгааллын чиглэлээр 4-өөс 5 заалт байгаа болохоос биш хүүхдийг хөгжүүлэх чиглэлээр нэг ч заалт тусгагдаагүй байна лээ.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр шүү дээ.

Тэгэхээр хөгжсөн хүүхэд хамгаалагдана гэж үздэг. Өөрөөр хэлбэл хөгжсөн, өөрийгөө авч явах чадвартай хүүхэд өөрийгөө хамгаална гэж үзэж байгаа юм.

Тийм учраас энэ дээр хүүхдийг хөгжүүлэх дугуйлан секц, хичээлээс гадуурх энэ үйл ажиллагааг бодлогоор дэмжих гэдэг энэ саналыг зарчмын зөрүүтэй саналаар Байнгын хороон дээр дэмжээгүй. Үүнийг бас дэмжих нь зүйтэй гэж үзэж байгаа.

Гуравдугаарт нь, “Баялагтаа эзэн МОНГОЛ ХҮН” гээд байгаа. Үүнийг маш их тунхагладаг.

Тэгэхдээ яг баялагтаа, ялангуяа орон нутгийн иргэд бас эзэн болж чадаж байна уу, үгүй юу гэдэг асуудал хамгийн чухал. Өөрөөр хэлбэл сөрөг нөлөөлөлд өртөж байгаа тэр бүс нутгийн иргэдэд энэ баялгийн өгөөж тодорхой хувь нь хүртдэг байх энэ олон улсын зарчимтай.

Тэгээд энэ зарчмын дагуу л асуудлыг тавиад байгаа юм.

Хоёрдугаарт нь, энэ уул уурхайн баялаг нийтийн өмч, ард түмний өмч, эцэг өвгөдөөс үлдээсэн өмч.

Тийм учраас үүнийг энэ төсвийн хөрөнгөтэй бас адилтгаж үзэх ёстой гэж үзэж байгаа юм. Өөрөөр хэлбэл хэдийгээр хувийн хэвшил үүнийг олборлож эргэлтэд оруулж байгаа ч гэсэн Монголын хөрсөнд орох баялаг учраас энэ баялгийг ашиглаж байгаа компаниудын, ялангуяа газрын тос бүтээгдэхүүн авах гэрээтэй. Уул уурхайн компаниуд тусгай зөвшөөрөл эзэмшдэг. Төрөөс.

Эдгээр үйл ажиллагааны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг ил тод болгох, олон нийтэд нээлттэй болгох, төрийн өмчит компаниудтай адил энэ худалдан авах ажиллагаа нь ил тод байж, энэ нь нийт иргэдэд үр ашгаа өгдөг байх, тэднийг чадавхжуулдаг байх гэсэн ийм санал.

Дөрөвдүгээрт нь, энэ зарчмын зөрүүтэй саналын 30 дахь хэсэгт байгаа. 3.3.4.7 гээд.

Одоо энэ хөдөө аж ахуйд тулгарч байгаа нэг том асуудал байна. Энэ бол бэлчээр ашиглалт. Үүнийг бэлчээр ашиглах хууль гэдэг асуудал нэлээн яригдаж. Тэгээд нэлээн олон талаас нь авч үзэхгүй болохгүй.

Тийм учраас одоо хамгаалах гол арга бол өвөлжөө, хаваржааны доорх газар болон энэ гүний худгийн цооногийн хоорондын зай, доод хэмжээг нь заавал тогтоож өгөх шаардлагатай байгаа.

Малчид үүнийг маш их хүсэж байгаа. Ингэхгүй бол үндсэндээ бэлчээрт талхлагдаад маш хүнд байдалд бид орно. Өөрөөр хэлбэл эх дэлхий маань энэ хөдөө

аж ахуйн малчид, иргэдийн амьжиргаа, энэ эдийн засгийн асуудал их хүнд байдалд орж байгаа.

Тийм учраас үүний доод хэмжээг тогтоож өгөх ёстой.

Өмнөх нийгмийн үед 20 сая малтай байхдаа Монгол Улс өвөлжөө, хаваржааг хооронд нь 5 километрийн зайтай л барьдаг зарчимтай байсан шүү дээ. Одоо 70, 80 сая толгой малтай.

Тэгэхээр бэлчээрээ хамгаалж үүнийг зохистой ашиглана гэдэг бол ус агаар мэт чухал байгаа. Үүнийг би бас зүүн бүсээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд иргэдийнхээ саналыг дайж байгаа.

Тэгэхээр үүний хоорондын зайг ингэж стандартаар тогтоож өгөх ёстой.

Ер нь барилга ч гэсэн Хот байгуулалтын хуулиар 70, 30 гэдэг зүйл ярьдаг. Үүнийг ч гэсэн өндрөөс нь хамааруулж айлын нь тооноос хамааруулж тогтоодог.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй нийт 151 санал байгаа.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

**Нэг.Төрийн байгуулалтын байнгын
хорооны дэмжсэн санал**

1.Тогтоолын төслийн 2 дахь заалтын 3 дахь дэд заалтын “улсын төсөвт тусган хэрэгжүүлэх” гэснийг “улсын төсвийн төсөлд тусган өргөн мэдүүлэх” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Р.Сэддорж, Д.Жаргалсайхан, Г.Лувсанжамц, Д.Рэгдэл, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Г.Уянгахишиг, Б.Энхбаяр. Цаашид “Ажлын хэсэг” гэх. Санал хураалт. /алх цохив/

49.1 хувиар санал уналаа.

2.Тогтоолын төслийн 3 дахь заалтын “уул уурхай, говийн унаган байгаль, түүх, соёлын өв,” гэсний дараа “шинжлэх ухаан,” гэж “Аж үйлдвэрийн төрөлжсөн, ногоон эрчим хүчний” гэсний өмнө “Технологи,” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал. Санал хураалт. /алх цохив/

46.4 хувиар санал уналаа.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын бүлэг, зүйлийн нэрийн жагсаалт бүхий агуулга хэсгийг хасаж, “Өмнөтгөл” хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН 2024-2028 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨР**

Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар олонхыг бүрдүүлсэн Монгол Ардын намаас Засгийн газрын бүрэлдэхүүнд Ардчилсан нам, ХҮН намыг урьж, хамтарсан Засгийн газрыг байгуулсан.

Засгийн газар хөгжлийн тулгамдсан асуудал, тулгарч байгаа сорилтуудыг илүү хурдан, үр дүнтэйгээр шийдвэрлэх, бүрэн эрхийнхээ хугацаанд бүтээлчээр, тогтвортой хамтран ажиллах зорилгоор “ХУРДАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ЗОРИГ” хамтарсан Засгийн газрын гэрээг байгуулсан. Тус гэрээг удирдлага болгон 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд дэвшүүлсэн Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын мөрийн хөтөлбөрт суурилсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулахдаа:

Үндэсний эв нэгдэл, үндэсний эрх ашгийг эрхэмлэж, эрх зүйт төрийн үндсэн зарчмуудыг удирдлага болгон;

Улсын эрх ашиг нэгдүгээрт, улс төрийн намын эрх ашиг хоёрдугаарт, эцэст нь хувийн эрх ашиг байх зарчмыг үнэт зүйлээ болгон;

“Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй, хурдтай шийдвэрлэхийг зорин;

Монгол Ардын намын мөрийн хөтөлбөрт туссан нийгмийн бодлогын шинэчлэл, бүсчилсэн хөгжлийн бодлого, авлигагүй төр, шударга ёсыг бэхжүүлэх цахим засаглал, эхлүүлсэн томоохон төсөл, арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зорилтууд, Ардчилсан намын мөрийн хөтөлбөрт туссан хүний

хөгжил, хувийн өмчийн эрхийн хамгаалалт, технологи суурьтай мэдлэгийн эдийн засаг, бизнес, хөрөнгө оруулалтын орчин, эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулах, шударга төрийн зорилтууд, ХҮН намын мөрийн хөтөлбөрт туссан эрчим хүчний болон боловсролын салбарын шинэчлэл, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, төрийн худалдан авах ажиллагааны бодлогыг шинэчлэх, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах зорилтуудыг тэргүүлэх чиглэл болгон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бодлогын үндсэн 4 чиглэлийг тодорхойлж, тэдгээрийн хүрээнд тус бүр 4 зорилго, нийт 593 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгалаа.

Бүсүүдийг төрөлжүүлэн хөгжүүлж, бүс бүхэнд ялгаатай татварын бодлого хэрэгжүүлэх бөгөөд **Хангайн** бүсийг “Уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн, хот байгуулалтын дэд бүс”, **Баруун** бүсийг “Эрчим хүчний төрөлжсөн, байгалийн аялал жуулчлалын дэд бүс” болгон, **Хойд** бүсийг “Байгалийн аялалын жуулчлалын төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” болгон, **Говийн** бүсийг “Аж үйлдвэрийн төрөлжсөн, ногоон эрчим хүчний дэд бүс” болгон, **Төвийн** бүсийг “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” болгон, **Зүүн** бүсийг “Түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн, эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүс” болгон төрөлжүүлэн хөгжүүлнэ.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд дараах 14 мега төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөлөө:

1. “Гашуунсухайт-Ганцмод”, “Ханги-Мандал”, “Шивээхүрэн-Сэхээ” хилийн боомтуудын хил дамнасан

холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барина. Тус төслийг хэрэгжүүлснээр нийт экспортын хүчин чадал 40 сая тонноор буюу Гашуунсухайт-Ганцмод 20 сая тонн, Ханги-Мандал боомт 10 сая тонн, Шивээхүрэн-Сэхээ боомт 10 сая тонноор нэмэгдэж, экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэж, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэх, зорчигчид ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэнэ.

2. Тавантолгойн 450 мВт-ын дулааны цахилгаан станцыг барина. Тус төслийг хэрэгжүүлснээр жилд 3150.0 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, Оюутолгойн өсөн нэмэгдэх 2,242.5 сая кВт.ц хэрэглээ болон Тавантолгойн орд газрууд, бусад стратегийн ач холбогдолтой өмнөд бүсийн уул уурхайн төслийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг дотоодоос хангах боломж бүрдэнэ. “Оюутолгой” ХХК-ийн БНХАУ-аас импортолж байгаа 110-120 сая ам.долларын вальютын урсгалыг зогсооно. Барилга угсралтын явцад давхардсан тоогоор 2000, ашиглалтад орсноор 300 байнгын ажлын байр шинээр бий болно.

3. Эрдэнэбүрэнгийн 90 мВт-ын усан цахилгаан станцын төслийг хэрэгжүүлнэ. Тус төслийг хэрэгжүүлснээр Жилд 366 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх ба баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг 2027 оноос эхлэн 100 хувь найдвартай, тасралтгүй хангах боломж бүрдэж, 52,000 ахуйн хэрэглэгчийг хангах эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болж, баруун аймгуудын 4,430 аж ахуйн нэгж, 5,400 орон сууц, 36,000 гаруй гэр

хорооллын хэрэглэгчийг дотоодын цахилгаан эрчим хүчээр бүрэн хангана. ОХУ, БНХАУ-аас жил бүр импортоор авч байгаа 17.5 тэрбум төгрөгийг хэмнэнэ.

4.Эгийн голын 310 мВт-ын усан цахилгаан станц барина. Тус төслийг хэрэгжүүлснээр эрчим хүчний системийн найдвартай, тогтвортой, шуурхай ажиллагааг хангаж, системийн эх үүсвэрийн зохистой харьцааг бүрдүүлнэ. ОХУ-д жил бүр төлдөг 25 сая ам.долларын импортын төлбөрийг хэмнэнэ. Түүхий нүүрсний хэрэглээг жил бүр 438,7 мянган тонноор, хүлэмжийн хийн ялгаруулалтыг 709 мянган тонноор бууруулна. 5.7 тэрбум шоо метр цэвэр усны нөөц бүрдүүлж, Монгол Улсын усан хангамжийн аюулгүй байдлыг хангана.

5.Сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэрийг хөгжүүлнэ. Монгол Улс нь судалгаагаар 2,600 гВт сэргээгдэх эрчим хүчний нөөцтэй болох нь тогтоогдсон бөгөөд шинээр эх үүсвэрүүдийг бий болгох замаар өсөн нэмэгдэж байгаа дотоодын цахилгаан эрчим хүчний дутагдлыг нөхөх, бусад улс руу экспортлох боломжтой. Сэргээгдэх эрчим хүчний салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулснаар уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх боломж бүрдэж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, нүүрс хүчлийн хийн арилжаанд оролцож, нэмэлт орлого олох боломж нээгдэнэ.

6.Хэрлэн-Тоонот, Орхон-Онги ус дамжуулах хоолойг барих төслийг хэрэгжүүлнэ. Хэрлэн голын олон жилийн дундаж урсацын 5-9%-ийг битүү хоолойгоор дамжуулан Хэнтий, Чойр, Дорноговь, Өмнөговь аймгийн хүн ам, мал аж ахуй, үйлдвэр, уул уурхайн усны

хэрэгцээг бүрэн хангана. Жилдээ 30 мян.тн хүлэмжийн хийг бууруулна. “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд усны асуудлыг шийдвэрлэж, цөлжилт, хуурайшилтыг сааруулна.

Онги гол болон Улаан нуурыг сэргээж, усны түвшин тогтворжиж, Онги голын дагууд оршин сууж байгаа 29.2 мянган хүн ам, 230 гаруй мянган толгой мал сүргийг гадаргын усаар хангах нөхцөл бүрдэнэ. Агаар, хөрсний чийгшил, газрын доорх усны тэжээгдэл нэмэгдэж, нуурын орчны бүсийн экосистем, биологийн олон янз байдал сэргэж, хөрсний элэгдэл эвдрэлд орох нөхцөл багасаж, цөлжилтийг бууруулна.

7.Эрэнцав-Чойбалсан-Баруун Урт-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр замыг барина. Тус төслийг хэрэгжүүлснээр худалдааны эргэлтийг нэмэгдүүлж, тээврийн зардлыг бууруулна.

8.Монгол, Францын хамтарсан Ураны төслийг хэрэгжүүлнэ. Төсөл хэрэгжиж, үйлдвэрлэл бүрэн хүчин чадлаараа ажилласнаар жилд 2,500 тонн ураныг олборлож экспортолно. Төсөл хэрэгжих хугацаанд улс, орон нутгийн төсөвт 1 тэрбум гаруй ам.долларын татвар төлнө. Үйлдвэрлэлийн туршилтын төсөл дээр үндсэн үйлдвэрлэлийн олборлолт эхлэхэд 1,000 гаруй ажлын байр бий болно. Улс, орон нутгийн хэмжээнд томоохон худалдан авалт, бизнесийн боломж нэмэгдэнэ. Монгол Улсад атомын цахилгаан станцыг барих суурь судалгааг хийнэ.

9.Нүүрс-хими, Кокс-химийн цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, боловсруулах үйлдвэрлэлийг нэг шат

ахиулснаар экспортын орлогыг нэмэгдүүлэх, олон улсын түүхийн эдийн үнээс хараат байдлыг бууруулах боломж бүрдэнэ.

Кокс-химийн үйлдвэрийн нүүрс баяжуулах үйлдвэрийн 1 дүгээр шатанд 10 сая тонн коксжих нүүрсийг угааж, 5.4 сая тонн баяжуулсан нүүрс, 3 сая тонн завсрын бүтээгдэхүүн (мидлинг) үйлдвэрлэнэ. 2.7 сая тонн баяжуулсан нүүрсийг боловсруулж, 2 сая тонн хатуу кокс, 107 МВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэнэ. Дотоодын хэрэглээнээс илүү гарсан 1.5 сая тонн коксын бүтээгдэхүүнийг экспортолно. “Алтанширээт” үйлдвэрлэл технологийн паркийг байгуулснаар 140 га талбайд төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэр, нүүрс угаах үйлдвэр, коксын үйлдвэр, төмрийн хүдрийн хорголжийн зэрэг дагалдах үйлдвэрүүд бүхий 500 мян.тн/жил ширэм үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр ашиглалтад орно.

10.Зэс боловсруулах цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр жилд 560 мянган тонн зэсийн баяжмал боловсруулж, 125 мянган тонн катодын зэс, 72 кг алт, 38.2 тонн мөнгөн гулдмай болон 182 мянган тонн элементийн хүхэр үйлдвэрлэж, 1.1 тэрбум ам долларын борлуулалтын орлогыг бүрдүүлнэ. Катодын зэсийн үйлдвэр нь дотоодын зэс утас, кабель, цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэх салбарыг хөгжүүлэхэд томоохон түлхэц үзүүлнэ. Үйлдвэрээс гарган авах 182 мянган тонн элементийн хүхэр нь химийн болон бордооны үйлдвэрлэлд өргөн ашиглагдах тул нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг нэмэгдүүлнэ.

11.Гангийн цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг

хэрэгжүүлснээр дотоодын тасралтгүй нэмэгдэж байгаа ган арматур болон бусад ган бүтээгдэхүүний хэрэгцээг дотооддоо бүрэн хангах зорилтын хүрээнд 1.0 сая тонн ган бэлдэц, бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Гангийн үйлдвэрийг ашиглалтад оруулж эхний ээлжид 500 мянган тонн ширэм, 500 мянган тонн ган бэлдэц үйлдвэрлэж, ган бэлдцээс барилгын арматур, булан төмөр, төмөр утас зэрэг ган бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, дотоодын барилгын арматурын хэрэгцээг бүрэн хангана.

12.Газрын тос боловсруулах цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр жилд 1.5 сая тонн түүхий тосноос 1.3 сая тонн бүтээгдэхүүн гарган авч, дотоодын газрын тосны хэрэглээний 55 орчим хувийг бүрэн хангах, импортын хараат байдлыг бууруулах, шатахууны үнийг бие даан уян хатан зохицуулах боломж бүрдэнэ.

13.Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ. Тус төсөл хэрэгжсэнээр жилд гадаад орны алт цэвэршүүлэх үйлдвэрт цэвэршүүлж, мөнгөжүүлдэг алтны 70 хувийг дотооддоо цэвэршүүлэх боломж бүрдэнэ. Баяжуулсан алтны хувийг нэмэгдүүлж, олон улсын зах зээлд борлуулж, валютын орлогыг нэмэгдүүлэх боломжтой. Монгол Улс алтаа одоог хүртэл гадаад орнуудад цэвэршүүлж байгаа бөгөөд үйлдвэр ашиглалтад орсноор үүнтэй холбогдон гарах тээвэр, даатгал, хамгаалалтын зардлыг хэмнэнэ.

14.Үндэсний хиймэл дагуулыг хөөргөнө. Монгол орны нийт газар нутгийн 26.8 хувьд 4G сүлжээ нэвтэрсэн. Үлдсэн 73.2 хувь буюу орон нутгийн иргэд, малчин айл өрхийг шилэн кабелиар интернет сүлжээнд холбоход

шаардлагатай 29.0 их наяд төгрөгийг хэмнэж, улс орны өнцөг булан бүрд интернетийн сүлжээ нэвтэрнэ. Байгалийн гамшиг, гэнэтийн аюул, ослын үед газрын сүлжээнд саад, доголдол гарсан тохиолдолд сансрын холбооны сүлжээ нь найдвартай холбооны сүлжээ болно.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа. Санал хураалт. /алх цохив/

Энэ хонх дуугарахгүй байна. Санал хураалтыг хүчингүй болгоё. Зарчмын зөрүүтэй санал шүү дээ.

Д.Энхтуяа гишүүнд микрофон өгье. Ямар санал гаргах гээд байна. Сонсъё.

Д.Энхтуяа: Үүний өмнөх хоёр дахь асуудал дээр миний микрофон ажиллаагүй. Тэгээд дээрээс нь гишүүний ирц жаахан дутуу байсан учраас дахин санал хураалт хийлгэж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Өмнөх санал хураалтууд өнгөрчихсөн. Дараагийн санал хураалт эхэлчихсэн явж байна.

Тэгэхээр энэ санал хураалт явагдана. Энэ гурав дахь санал хураалт байгаа. Санал хураалт явуулья. /алх цохив/

56.6 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.1.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.1.1.“20 минутын хот” буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын баримт бичгийг боловсруулж, түүнд

суурилсан “Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040” болон бусад хот суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

60.2 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр хавсралтын “1.1.2. Эрчим хүчээр хангагдсан хот” зорилтод доор дурдсан агуулгатай 1.1.2.12 дахь заалт нэмэх:

“1.1.2.12.Багануурын дулааны станцын зуух, дулаан дамжуулах сүлжээг өргөтгөн шинэчилж, засварлана.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

57.5 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.1.3.5 дахь заалтын “татварын хөнгөлөлт” гэснийг “дэмжлэг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

48.7 хувиар санал дэмжигдсэнгүй.

Ж.Золжаргал гишүүн горимын санал.

Ж.Золжаргал: Ирцэд орчихоод эзгүй байгаа гишүүдийг ирцээс нь гаргахгүй бол санал эсрэг гэж автоматаар ороод тэгээд харьцаа нь алдагдаад байна л даа. Энэ дээр арга хэмжээ авах боломжтой юу?

Д.Амарбаясгалан: Дэгийн дагуу явагдаж байна.

Ирцэд байхгүй гишүүд дэгээрээ эсрэг саналд тооцогдоно.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь.

Ж.Батсуурь: Би сая санал өгсөн боловч гацаад саналд орсонгүй. Энэ саналыг хүчингүй болгож өгнө үү. Дахин санал хураалт хийж өгнө үү.

Д.Амарбаясгалан: 6 дахь саналыг. Санал хураалт явагдсан. Зарим гишүүдийн санал өгөх процесс дээр доголдол үүссэн учраас саналыг хүчингүй болгох санал хураалтыг явуулж, дахин санал хураалт явуулна.

Саналыг хүчингүй болгох санал хураалт. /алх цохив/

Горимын санал дэмжигдлээ.

6 дахь санал хураалтыг дахиж явуулья.

Төслийн 1 дүгээр хавсралтын 1.1.3.5 дахь заалтын “татварын хөнгөлөлт” гэснийг “дэмжлэг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

54.9 хувиар санал дэмжигдлээ.

7.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “1.1.3.Гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулалт” зорилтод доор дурдсан агуулгатай 1.1.3.7 дахь заалт нэмэх:

“1.1.3.7.Гэр хорооллын бүсэд эрчим хүчний хэмнэлттэй, ногоон, пассив барилгын стандарт болон ногоон

санхүүжилтийн шаардлага хангахуйц бие даасан инженерийн шийдэлтэй, загвар хорооллыг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын түншлэлд үндэслэн барьж байгуулна.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, С.Бямбацогт, Б.Жаргалан. Санал хураалт. /алх цохив/

61.9 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.1.5.3 дахь заалтын “уялдаа холбоог хангаж,” гэсний дараа “зорчигч тээврийн логистик төвийн хамт” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

58.4 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 1 дүгээр хавсралтын “1.2.1, 1.2.2 дахь зорилтуудын гарчгийн “Дагуул хотуудын” гэсний өмнө “Улсын зэрэглэлтэй болон” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

53.1 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.2.1.5 дахь заалтыг “3.3.7.Шинжлэх ухаан, технологи, инновац” гэсэн зорилтод шилжүүлэх.

“1.2.1.5.Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборыг ашиглалтад оруулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

59.3 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.2.2.1 дэх заалтын “Номтын аманд” гэсний дараа “эрчим хүчний хэмнэлттэй” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

61.9 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 1 дүгээр хавсралтын “1.1.3.Хойд бүс-“Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” зорилтод доор дурдсан агуулгатай 1.3.3.6 дахь заалт нэмэх:

“1.3.3.6.Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн авто замыг барина.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут. Санал хураалт. /алх цохив/

55.8 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн “1.3.4.Говийн бүс-“Аж үйлдвэрийн төрөлжсөн, ногоон эрчим хүчний дэд бүс” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“1.3.4.6.Даланзадгадад 50 мВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станцыг барина.” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

61.9 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.4.3, 3.3.3.24, 3.3.3.25, 3.3.3.26, 3.3.3.31 дэх дараах заалтуудыг тус тус хасах:

“1.3.4.3.Говийн бүсэд нар, салхины тус бүр 100 МВт хүртэл хүчин чадалтай цахилгаан станц барина.

3.3.3.24.Өмнөговь

аймгийн нутаг дэвсгэрт нар, салхины нөөцийн давхцалын бүсүүдийг түшиглэн 3 ГВт-ын нар, салхины сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг барьж байгуулах, экспортлох төслүүдийг дэмжинэ.

3.3.3.25.Чойрт 100 МВт

салхи, 40 МВт цэнэг хураагуурын төслийг хэрэгжүүлнэ.

3.3.3.26.Мандалговь 200

МВт нарны цахилгаан станц, 100 МВт цэнэг хураагуурын төслийг хэрэгжүүлнэ.

3.3.3.31.Мандалговийн

2,000 МВт нар-салхины эрчим хүчний паркийн төслийг хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

41.6 хувиар санал уналаа.

15.Төслийн 1 дүгээр хавсралтын “1.4.2.Орон нутгийн хөгжлийн нийтлэг зорилт” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“1.4.2.7.Аймгийн төвүүд болон томоохон хот, суурин газрын агаарын бохирдлыг бууруулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

61.9 хувиар санал дэмжигдлээ.

16.Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.1.Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“2.1.1.9.Өсвөр үеийн охид, хөвгүүдийн дунд бэлгийн болон нөхөн

үржихүйн эрүүл мэндийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх, үе тэнгийн зөвлөгч бэлтгэх, тэднээр дамжуулан мэдээллийг өсвөр үеийнхэнд хүргэх, шаардлагатай үйлчилгээнд зуучлах нууцлалтай чатбот үйлчилгээг хөгжүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

61.9 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.1.Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“2.1.1.11.Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх үндэсний төлөвлөгөөг баталж, төр болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

64.6 хувиар санал дэмжигдлээ.

18.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1.1.21 дэх заалтын “стандартыг” гэсний дараа “албан байгууллага,” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан. Санал хураалт. /алх цохив/

63.7 хувиар санал дэмжигдлээ.

19.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1.1.23 дахь заалтын “байгуулна” гэснийг “хүртээмжтэй, тэгш боломжоор хангагдах нөхцөлийг бүрдүүлэн ажиллана.” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун. Санал хураалт. /алх цохив/

44.2 хувиар санал дэмжигдсэнгүй.

20.Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.1.Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого” зорилтод доор дурдсан агуулгатай 2.1.1.26 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“2.1.1.26.Төр, хувийн хэвшил, нийгмийн түншлэлийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамж, үйлчилгээний чанарыг сайжруулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

60.2 хувиар санал дэмжигдлээ.

21.Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.1.Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого” зорилтод доор дурдсан агуулгатай 2.1.1.30 дахь заалт нэмэх:

“2.1.1.30.Төрийн бүх шатны байгууллагууд залуу мэргэжилтнүүдийг дэмжих тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг. Санал хураалт. /алх цохив/

50.4 хувиар санал дэмжигдлээ.

22.Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.1.Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого” зорилтод доор дурдсан агуулгатай 2.1.1.31 дэх заалт нэмэх:

“2.1.1.31.Залуу гэр бүлд зориулсан урьдчилгаа төлбөр, хүүгийн таатай

нөхцөл бүхий орон сууцны тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг. Санал хураалт. /алх цохив/

60.2 хувиар санал дэмжигдлээ.

23.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.1.1.4.Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймаг, дүүрэгт төр хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийг ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн нөхцөлийг бүрдүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан. Санал хураалт. /алх цохив/

53.1 хувиар санал дэмжигдлээ.

Би Байнгын хорооны дэмжсэн, дэмжээгүйг уншаад явах уу? Орж ирсэн саналыг л дэмжихээр л санал хураалгаж байгаа шүү дээ. Дэмжээгүй, дэмжсэн саналууд бүгд орж ирж байгаа.

24.Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.2.Хөдөлмөр эрхлэлт” зорилгод доор дурдсан агуулгатай 2.1.2.10 дахь заалт нэмэх:

“2.1.2.10.Хөдөлмөр, нийгмийн гурван талт оролцоонд тулгуурлан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тогтолцоог сайжруулна.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар. Санал хураалт. /алх цохив/

Тайлбар авъя аа..? Энэ санал хураалтын талаар. Тийм. Үг хэлэх л эрх байгаа. Энэ Байнгын хорооноос бэлдэж ирсэн санал хураалт дэмжсэн, дэмжээгүй санал хоёулаа хамтдаа санал хураагдаад явж байгаа.

Би тэгвэл энэ тодруулга хэлбэрээр нь мэргэжлийн Байнгын хороо нь дэмжсэн, дэмжээгүйг нь бас нэмэлтээр хэлээд явъя.

Ийм байна шүү. Гишүүд ээ. Мэргэжлийн Байнгын хороодын дэмжсэн, дэмжээгүй саналуудыг Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн хэлбэрээр орж санал хураагдаж байгаа.

Тэгэхээр одоо хураагдаж байгаа саналууд Төрийн байгуулалтын байнгын хороон дээр дэмжигдсэн саналууд байгаа гэж ингэж ойлгоорой.

25.Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.2.Хөдөлмөр эрхлэлт” зорилгод доор дурдсан агуулгатай 2.1.2.11 дэх заалт нэмэх:

“2.1.2.11.Суралцангаа хөдөлмөрлөх/хөдөлмөрлөнгөө суралцах хосмог ажлын байрыг нэвтрүүлэхтэй уялдуулан дадлагажигчийн цалин хөлс, хөдөлмөрийн нөхцлийн талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн. Санал хураалт. /алх цохив/

63.7 хувиар санал дэмжигдлээ.

26.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1.3.11 дэх дараах заалтыг хасах.

“2.1.3.11.Орлого багатай иргэдийн нэмэлт орлогын эх үүсвэрээс авах татварыг бодлогоор бууруулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

47.8 хувиар санал дэмжигдсэнгүй.

27.Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.3.Нийгмийн баталгаа” зорилгод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“2.1.3.17.Улс төрийн амлалтаар өрх, иргэнд халамжийн нийтлэг мөнгөн шилжүүлэг олгохгүй байхаар нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг өөрчилнө.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

56.6 хувиар санал дэмжигдлээ.

28.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2.3.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.2.3.2.Багшийн мэргэжил дээшлүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэн, багшлах эрх олгох хялбаршуулсан сургалтын зохицуулалт бий болгож, багш бус мэргэжилтэй шилдэг боловсон хүчнийг багшаар бэлтгэх замаар багшлах хүний нөөцийн чадавхыг сайжруулж, багшийн хомсдолыг бууруулна.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар. Санал хураалт. /алх цохив/

56.6 хувиар санал дэмжигдлээ.

29.Төслийн 1 дүгээр хавсралтын “2.2.4.Цахимжсан боловсрол” зорилгод доор дурдсан агуулгатай 2.2.4.5 дахь заалт нэмэх:

“2.2.4.5.Сургалтын байгууллагын интернэтийн дэд бүтцийг сайжруулах, хүүхэд бүрийг компьютержүүлэхэд санхүүгийн түрээсийн системийг нэвтрүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Ж.Баярмаа. Санал хураалт. /алх цохив/

61.1 хувиар санал дэмжигдлээ.

30.Төслийн 1 дүгээр хавсралтын “2.3.2.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж” зорилгод доор дурдсан агуулгатай 2.3.2.8 дахь заалт нэмэх:

“2.3.2.8.Сэргээн засах тусламж, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдэд урт болон богино хугацаагаар, цогц байдлаар, нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээг үзүүлж, чанар, аюулгүй байдлыг хангана.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан. Санал хураалт. /алх цохив/

62.8 хувиар санал дэмжигдлээ.

31.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.4.3.3 дахь заалтын “мастер төлөвлөгөө” гэсний дараа “хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.8 хувиар санал дэмжигдлээ.

32.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.4.3.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.4.3.5.Хот суурин газарт үерийн эрсдлийн үнэлгээг ерөнхий болон нарийвчилсан байдлаар хийж инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг боловсруулж үе шаттай хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ. Санал хураалт. /алх цохив/

61.1 хувиар санал дэмжигдлээ.

33.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.1.3.Банк, санхүү, даатгалын салбарын реформ” зорилгод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“3.1.3.11.Хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжиж эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын стандартын дагуу баригдах амины орон сууцны ипотекийн зээл болон жижиг, дунд үйлдвэрийн тогтвортой, ногоон зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор “Монголын ногоон санхүүгийн корпорац”-ыг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын түншлэлд үндэслэн байгуулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

60.2 хувиар санал дэмжигдлээ.

34.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.2.1.Татвар, нийгмийн даатгалын реформ” зорилгод доор дурдсан агуулгатай 3.2.1.8 дахь заалт нэмэх:

“3.2.1.8.Хөдөө орон нутгаас Улаанбаатар хотыг чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулах, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор бүсийн ялгаатай татварын тогтолцоог бүрдүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт. Санал хураалт. /алх цохив/

57.5 хувиар санал дэмжигдлээ.

35.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.2.2.Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин” зорилгод доор дурдсан агуулгатай 3.2.2.14 дэх заалт нэмэх:

“3.2.2.14.Төсвийн хөрөнгө оруулалтыг их өгөгдөлд суурилан төлөвлөнө.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

58.4 хувиар санал дэмжигдлээ.

36.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.2.2.Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин” зорилгод доор дурдсан агуулгатай 3.2.2.15 дахь заалт нэмэх:

“3.2.2.15.Экспортын гол бүтээгдэхүүнүүдийн зах зээлд нэвтрэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний гадаад экспортыг нэг цонхны бодлогоор дэмжинэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин. Санал хураалт. /алх цохив/

61.1 хувиар санал дэмжигдлээ.

37.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1.1 дэх заалт, 3.3.1.7 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.1.1.Уул уурхайн салбарын түүхий эдийн боловсруулалтын түвшин болон хүнд үйлдвэрлэлийн хүчин чадлыг өсгөж, экспортын орлогыг нэмэгдүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

58.4 хувиар санал дэмжигдлээ.

38.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1.2 дахь заалтын “Геологийн эрэл хайгуулын” гэснийг “Геологийн судалгаа, эрэл, хайгуулын” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

61.1 хувиар санал дэмжигдлээ.

39.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.1.3.Оюутолгойг түшиглэсэн зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Ажлын хэсгийн дарга Ж.Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ өдөр С.Ганбаатар гишүүний яриад байсан асуудал байгаа юм.

Тэгээд энд Оюу Толгойг түшиглэсэн зэсийн хайлуулах,

боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ гэсэн байгаа.

Одоо наад заалтаар чинь зөвхөн Оюу Толгойн зэсийг баяжуулах ийм болчихлоо. Монгол Улсын хэмжээний олборлож болох зэсийг баяжуулах ийм боломж бололцоог нь нээгээд, томъёоллыг арай ондоогоор оруулж өгөөч ээ л гэсэн ийм саналыг бас тавиад байгаа юм л даа.

Уг нь Байнгын хороон дээрээ манай хүн энэ асуудлуудаа дэвшүүлээд тэгээд тэр ирц нь болоогүй юм уу, яасан юм. Юм нь болж өгөхгүй л орж ирчхээд байгаа юм.

Тэгэхээр Таныг гүйцээн боловсруулах гэдэг чиглэл өгөөч ээ гэсэн ийм хүсэлтийг тавьж байгаа юм.

Дахиад буцаад Байнгын хороотой нь ярья гээд. Тийм ээ. Тийм. Тэгэхээр саяын санал хураалтыг хүчингүй болгож өгөөч ээ. Гүйцээн боловсруулах чиглэл өгөөч ээ гэсэн ийм хүсэлт тавьж байна.

Д.Амарбаясгалан: 39 дээр. Тийм ээ. Саяын санал хураалт хүчингүй болсон юм байна. Төхөөрөмж гацсан гээд.

Тэгэхээр энэ 39-ийг гүйцээн боловсруул гээд Байнгын хороонд буцаая. Тийм ээ. Тэгье. Гүйцээн боловсруулж, эцсийн хэлэлцүүлгээр оруулж ирье. /алх цохив/

40.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1.4 дэх дараах заалтыг хасах.

“3.3.1.4.Оюутолгойтой дүйцэхүйц дараагийн стратегийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

40 дүгээр асуудал унаж байна.
Тийм ээ. Дэмжигдээгүй унаж байна.

41.Төслийн 1 дүгээр хавсралтын
3.3.1.6, 3.3.1.12 дахь заалтуудыг нэгтгэн
доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.1.6.Дорноговь аймагт
дотоодын түүхий эдэд түшиглэсэн газрын
тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад
оруулж, олон улсын стандартын
шаардлага хангасан авто бензин,
түлшний тодорхой хувийг дотоодоосоо
хангах нөхцөлийг бүрдүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

63.7 хувиар санал дэмжигдлээ.

42.Төслийн 1 дүгээр хавсралтын
“3.3.1.Уул уурхай” зорилтод доор
дурдсан агуулгатай 3.3.1.15 дахь заалт
нэмэх:

“3.3.1.15.Стратегийн ач холбогдол
бүхий Эрдэнэтийн зэс, молибдений
ордын талбайн хил заагийн хүрээнд
багтаж буй Оюут болон бусад хэсгүүдэд
эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх,
нөөцийг тогтоож, ашиглалтад бэлтгэх
ажлыг эхлүүлэх, эрэл, хайгуулын ажилд
дэвшилтэт техник, технологи, хиймэл
оюун ухааныг нэвтрүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.4 хувиар санал дэмжигдлээ.

43.Төслийн 1 дүгээр хавсралтын
“3.3.1.Уул уурхай” зорилтод доор

дурдсан агуулгатай 3.3.1.16 дахь заалт
нэмэх:

“3.3.1.16.Нүүрс-химийн
технологийг эзэмших, боловсон хүчнээ
бэлтгэх, ирээдүйн томоохон төслийн
техник, эдийн засгийн үзүүлэлтүүдийг
тодорхойлох зорилгоор туршилт
тохиргооны бага оврын үйлдвэр
байгуулан хийн түлш, нийлэг материал,
ус төрөгч гарган авна.”

Санал гаргасан:Улсын Их Хурлын
гишүүн Ж.Золжаргал. Санал хураалт.
/алх цохив/

58.4 хувиар санал дэмжигдлээ.

44.Төслийн 1 дүгээр хавсралтын
“3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр
логистик” зорилтын 3.3.2.18, 3.3.2.20
дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар
өөрчлөн найруулах:

“3.3.2.18.Гашуунсухайт-Ганцмод,
Шивээхүрэн-Сэхээ, Ханги-Мандал,
Бичигт-Зүүнхатавч боомтуудын хил
дамнасан төмөр замуудыг барьж хөрш
орны төмөр замтай холбоно.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.4 хувиар санал дэмжигдлээ.

45.Төслийн 1 дүгээр хавсралтын
3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр
логистик” зорилтод доор дурдсан
агуулгатай 3.3.2.24 дэх заалт нэмэх.

“3.3.2.24.Эрэнцав-Чойбалсан-
Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн
төмөр замыг барина.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

69.0 хувиар санал дэмжигдлээ.

46.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр, логистик” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.2.25 дахь заалт нэмэх:

“3.3.2.25.Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудлыг 4D ангилалын болгон өргөтгөнө.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

60.2 хувиар санал дэмжигдлээ.

47.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.2.26 дахь заалт нэмэх.

“3.3.2.26.Ханх-Хатгал чиглэлийн автозамыг барина.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

57.5 хувиар санал дэмжигдлээ.

48.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.3.3.Сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг нийгмийн үйлчилгээний байгууллагуудын барилга байгууламжийг пассив барилгын стандартад нийцүүлж, эрчим хүчний хэмнэлттэй технологит шилжүүлэх арга хэмжээ авна.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц. Санал хураалт. /алх цохив/

61.1 хувиар санал дэмжигдлээ.

49.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.3.Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.3.12 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“3.3.3.12.“10,000 нарны дээвэр” хөтөлбөрийг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын шугамаар хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

64.6 хувиар санал дэмжигдлээ.

50.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3.35 дахь дараах заалтыг хасах:

“3.3.3.35.Дархан УХУЦС 100 МВт төслийг хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

40.7 хувиар санал дэмжигдсэнгүй.

51.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3.41 дэх дараах заалтыг “1.4.1.Шилжилт хөдөлгөөн” зорилтод шилжүүлэх.

“3.3.3.41.Төрийн байгууллагуудын эрхлэх асуудал, чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааны хамрах хүрээг нь харгалзан нийслэл Улаанбаатар хотоос үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээнд Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг холбогдох харьяа байгууллагуудын хамт Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

50.4 хувиар Хөдөө аж ахуйн яам нүүхээр боллоо.

52.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3 дахь заалтын 3.3.3.37 дахь дэд заалтаас “Сонгино-Дархан” гэснийг хасаж доор дурдсан агуулгатай 3.3.3.42 дахь заалт нэмэх:

“3.3.3.42.Сонгино-Дархан чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж, эрчим хүчний найдвартай ажиллагааг дээшлүүлнэ”.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг. Санал хураалт. /алх цохив/

62.8 хувиар санал дэмжигдлээ.

53.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.3.Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.3.43 дахь заалт нэмэх:

“3.3.3.43.Байгалийн хий дамжуулах хоолойн төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга. Санал хураалт. /алх цохив/

Санал 33.6 хувиар дэмжигдсэнгүй.

54.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” гэсэн зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.2 дахь заалт нэмэх:

“3.3.4.2.Хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгохтой

холбогдуулан зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, нөөц санг бүрдүүлж хоршооны гишүүн малчинд олгосон хөнгөлөлттэй зээлийн хүүгийн зөрүүг төрөөс хариуцна.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай.

40.7 хувиар санал дэмжигдсэнгүй.

55.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.4.4 дэх заалтын “экспортлоход анхаарна” гэснийг “экспортлоно” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

53.1 хувь.

56.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.29 дэх заалт нэмэх:

“3.3.4.29.Мал аж ахуй, газар тариалан, жимс, хүнсний ногоо тариалалтад дэмжлэг үзүүлэх зорилготой хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн түрээсийн аж ахуйн тогтолцоог бий болгоно.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

61.9 хувиар санал дэмжигдсэн байна.

57.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.30 дахь заалт нэмэх:

“3.3.4.30.Хоршоодод “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг байгуулах, хувьцаа эзэмших, хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлж, хоршооны үйл ажиллагааг дэмжих зорилготой “Малын эзэн-Үйлдвэрийн эзэн” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

63.7 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү дэмжсэнээр санал өгсөн. Төхөөрөмж ажилласангүй гэж байна. Протоколд дэмжсэнээр өгье. Миний төхөөрөмж бас гацсан байгаа. Дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье.

58.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.31 дэх заалт нэмэх:

“3.3.4.31.Хөдөө аж ахуйн салбарын боловсон хүчин, залуу малчид, тариаланчдыг бэлтгэх зохистой бодлогыг хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал. Санал хураалт. /алх цохив/

66.4 хувиар санал дэмжигдлээ.

59.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.32 дахь заалт нэмэх:

“3.3.4.32.Сорт, сорилын төв, үрийн аж ахуйг дэмжиж, үрийн шинэчлэл

хамгаалалтыг сайжруулан, гол нэр төрлийн тариалангийн үр үйлдвэрлэлд урамшуулал олгоно.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал. Санал хураалт. /алх цохив/

56.6 хувиар санал дэмжигдлээ.

60.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.33 заалт нэмэх:

“3.3.4.33.Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх, хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн нөөц бүрдүүлэх хүрээнд жил бүр 100.0 мян.тн хүнсний улаан буудайн нөөц бүрдүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал. Санал хураалт. /алх цохив/

60.2 хувиар санал дэмжигдлээ. Ж.Батжаргал гишүүн дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье.

61.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.5.Дөрвөн улирлын аялал жуулчлал” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.5.12 дахь заалт нэмэх:

“3.3.5.12.Дундговь аймгийн Цагаан суварга орчмын палеонтологийн нөөцөд тулгуурлан аялал жуулчлалын тусгай бүсийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

61.9 хувиар санал дэмжигдлээ.

62.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.6.Соёлын бүтээлч үйлдвэрлэл” зорилтын гарчгийг “3.3.6.Соёл урлаг, соёлын өв уламжлал, соёлын бүтээлч үйлвэрлэл” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

54.9 хувиар санал дэмжигдлээ.

63.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.6.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.6.4.Түүхэн дурсгалт барилга байгууламжийг сэргээн засварлах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, “Соёлын биет өвийг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

62.8 хувиар санал дэмжигдлээ.

64.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.7.1 дэх заалтын “Шинжлэх ухаан” гэсний өмнө “Шинжлэх ухаан технологийн арга хэмжээний зардлыг ДНБ-ий 1 хувьд хүргэж,” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

61.9 санал дэмжигдлээ.

65.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.7.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.7.7.Үндэсний эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн сангийн MORI платформыг олон улсын

жишигт нийцүүлэн хөгжүүлж, мэдлэгийн Data center байгуулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

58.4 хувиар дэмжигдлээ.

66.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.4.2.Уур амьсгалын өөрчлөлт” зорилтод доор дурдсан агуулгатай 3.4.2.9 дэх заалт нэмэх:

“3.4.2.9.Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд хот, суурин газруудад яндангүй бүс байгуулж эрчим хүч, усны ухаалаг хэрэглээтэй амины орон сууцны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа. Санал хураалт. /алх цохив/

56.6 хувиар санал дэмжигдлээ.

67.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.4.3.7 дахь заалтын “үйл ажиллагааг дэмжин” гэсний дараа “, Үндэсний ногоон барилгын үнэлгээний систем нэвтрүүлж,” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа. Санал хураалт. /алх цохив/

56.6 хувиар. Л.Гантөмөр сайд, Ч.Анар гишүүн нар дэмжиж өгсөн. Протоколд тэмдэглэе.

68.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.4.3.Ногоон эдийн засаг, ногоон хөгжлийн загвар” зорилтод доор дурдсан агуулгатай 3.4.3.11 дэх заалт нэмэх.

“3.4.3.11.Орхон-Онги, Хэрлэн-Тоонот ус дамжуулах хоолойг барина.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Санал хураалт 56.6 хувиар дэмжигдлээ.

69.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.1.1.15 дахь дараах заалтыг хасах.

“4.1.1.15.Монгол Улсын Үндсэн хууль, хууль, хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн байгууллагын захиалгаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах, Улсын Их Хурлын хяналт шалгалтын үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх чиг үүрэг бүхий Хууль судлалын институтыг байгуулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

48.7 хувиар санал дэмжигдсэнгүй.

Х.Баасанжаргал гишүүн.
Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүнд микрофон өгье. Горимын санал.

Х.Баасанжаргал: Сая санал хураалтад миний санал орсонгүй. Хүчиггүй болгоод дахиад санал хураах.

Д.Амарбаясгалан: Ямар санал юм?

Х.Баасанжаргал: Саяын энэ 69.

Д.Амарбаясгалан: Горимын санал гаргаж байгаа юм уу?

Х.Баасанжаргал: Тийм.
Горимын санал гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Горимын санал гаргаж байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн.

Санал хураалтад дэмжиж санал өгсөн. Орсонгүй гэж байна.

Тэгэхээр санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулна гэсэн үг.

69 дэх саналыг хүчингүй болгох санал хураалт.

Санал хураалтыг хүчингүй болгох горимын санал хураалт дэмжигдсэнгүй.

70.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.1.1.17 дахь дараах заалтыг хасах.

“4.1.1.17.Үйлдвэрлэлийг өргөжүүлэх замаар хоригдлын ажлын байрыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг сайжруулан, улсын төсвийн ачааллыг бууруулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

49.6 хувиар санал дэмжигдсэнгүй.

70 дугаарр санал дэмжигдсэнгүй. Унасан байгаа. Одоо 71 дүгээр санал хураалт.

Гишүүд шийдсэн. Би шийдээгүй.

Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн. Үг авах юм байхгүй. Горимын саналын асуудал яригдана.

Х.Тэмүүжин: Уг нь түрүүний саналыг бид буруу ойлгоод явчихлаа. Одоо ингээд Үндсэн хуулийн зөрчил үүссэн.

Засгийн газар дээр Улсын Их Хурлын хяналт шалгалтыг гэрээгээр хийдэг байгууллага байгуулахыг зөвшөөрчихлөө.

Эрхэм гишүүд ээ, Та бүгдийг эрхийг Засгийн газар авчихлаа.

Д.Амарбаясгалан: Х.Тэмүүжин гишүүн тодруулаад хэлье.

Х.Тэмүүжин: Анх энэ төслийг хэлэлцэж байхад Б.Энхбаяр гишүүн бас хэлсэн.

Энэ 69 дээр байгаа санал Засгийн газраас орж ирэхдээ ингээд буруу томъёололтой ороод ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх чиг үүргийг Засгийн газар авч болохгүй. Энэ бол Улсын Их Хурлын ажил.

Гэтэл энэ дээр чинь маш буруу тодорхойлолт ороод л Үндсэн хуулийн зөрчилтэй ийм агуулга ороод ирлээ. Үүнийг хасъя гэж анх хэлэлцүүлгийн үед санал гаргасан. Ажлын хэсэг дээр дэмжиж санал хурааж санал дэмжигдсэн.

Сая гишүүд өөрсдөө анхааралгүй байсан уу, яасан. Өөрөө өөрсдийнхөө бүрэн эрхийг Үндсэн хууль зөрчиж Засгийн газар луу шилжүүлээ шүү гэж хэлж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр Х.Тэмүүжин гишүүний гаргаж байгаа санал нь 69 дүгээр саналыг дэмжээгүй. Тэр саналыг нь горимын санал гаргаад хүчингүй болгох санал гаргасан чинь бас дэмжигдээгүй байгаа.

Тэгэхээр Та яая гэж байгаа юм?
Б.Хэрлэн гишүүн. Горимын санал.

Б.Хэрлэн: 69, 70 дугаар санал дээр төхөөрөмж буруу ажиллаж, буруу дүн гарсан. 69, 70 аль аль дээр. Хүчингүй болгож өгнө үү. Тэгээд саналыг дахин хурааж өгнө үү гэсэн санал гаргаж байна.

Д.Амарбаясгалан: Б.Мөнхсоёл гишүүнд горимын санал өгье.

Б.Мөнхсоёл: Нэгдүгээрт, Б.Хэрлэн гишүүнтэй адилхан саналтай байна.

69 дээр буруу ойлгоод саналаа оруулсан. Х.Баасанжаргал гишүүн горимын санал хэлсэнд баярлаад дахиад өгсөн чинь уначихлаа. Тэгээд Х.Тэмүүжин гишүүнтэй, Б.Хэрлэн гишүүнтэй санал нэг байна. Тийм.

Тэгэхээр хүчингүй болгоё. Дахиад явуулъя. Тийм. Энэ чинь чухал учраас.

Д.Амарбаясгалан: Анхаарлаа төвлөрүүлж ажиллахыг хүсье. Гишүүдээс.

69 дүгээр санал хураалтаар дэмжээгүй саналыг горимын санал гаргаж хүчингүй болгох санал оруулсан. Бас дэмжигдээгүй.

Тэгэхээр энэ горимын саналыг эхлээд хүчингүй болгох санал хураалтыг явуулах нь. Санал хураалт. /алх цохив/

64.6 хувиар дэмжигдэж, горимын санал дэмжигдлээ.

Одоо 69 дүгээр саналыг дахиж санал хураалт явуулна. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураана. Санал хураалт. /алх цохив/

61.1 хувиар 69 дүгээр санал дэмжигдлээ.

70 дугаар санал унасан байгаа.

Улсын Их Хурлын гишүүн Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар горимын санал.

Б.Баярбаатар: 70 дээр горимын санал гаргая. Би дэмжсэн санал өгсөн боловч төхөөрөмж ажиллаагүй учраас саналыг хүчингүй болгож өгнө үү гэсэн горимын санал гаргая.

Д.Амарбаясгалан: Б.Баярбаатар гишүүний гаргасан горимын саналаар 70 дугаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя.

Одоо үндсэн санал хураалтыг явуулъя. 70 дугаар санал хураалт буюу Үйлдвэрлэлийг өргөжүүлэх замаар хоригдлын ажлын байрыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг сайжруулан, улсын төсвийн ачааллыг бууруулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

52.2 хувиар санал дэмжигдлээ.

Миний төхөөрөмж бас гацсан учраас дэмжсэн санал өгсөн. Орсонгүй. Протоколд тэмдэглэхийг хүсье.

71.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.1.1.18 дахь дараах заалтыг хасах.

“4.1.1.18.Хорих ял эдлүүлэх орчин, нөхцөлийг сайжруулах зорилгоор "Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага"-ын цогцолбор барилгыг ашиглалтад оруулж хүний эрхийг хангана.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

51.3 хувиар санал дэмжигдлээ.

72.Төслийн 1 дүгээр хавсралтын “4.1.2.Хэвлэлийн эрх чөлөө” зорилтод доор дурдсан агуулгатай 4.1.2.2 дахь заалт нэмэх:

“4.1.2.2.Олон нийтийн радио, телевизийн бие даасан байдлыг хангах, хариуцлагатай, хараат бус, иргэдийг соён гэгээрүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн нийтлэлийн бодлоготой болгох чиглэлээр эрх зүйн орчныг шинэтгэнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

61.9 хувиар санал дэмжигдлээ.

73.Төслийн 1 дүгээр хавсралтын “4.1.3.Иргэний нийгэм, хувийн хэвшил, төрийн түншлэл, хамтын ажиллагаа” зорилтод доор дурдсан агуулгатай 4.1.3.4 дэх заалт нэмэх:

“4.1.3.4.Тендэрийн үнэлгээнд төсөл хөрөнгө оруулалтуудын шууд дам нөлөөлөл, хүртээмж нэмэх, нийгмийн үнэлгээ хийх эрх зүйн орчин бий болгоно.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат. Санал хураалт. /алх цохив/

35.4 хувиар дэмжигдсэнгүй.

74.Төслийн 1 дүгээр хавсралтын “4.1.3.Иргэний нийгэм, хувийн хэвшил, төрийн түншлэл, хамтын ажиллагаа” зорилтод доор дурдсан агуулгатай 4.1.3.5 дахь заалт нэмэх:

“4.1.3.5.Иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог баталгаажуулан бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцооны тодорхой шалгуур үзүүлэлт бүхий нийтлэг журмыг баталж, төрийн байгууллагуудын ил тод байдлын түвшинг жил бүр үйлчилгээг хүртэгч төрийн бус байгууллага, иргэдээр үнэлүүлж индексжүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун. Санал хураалт. /алх цохив/

50.4 хувиар санал дэмжигдлээ.

75.Төслийн 1 дүгээр хавсралтын “4.1.3.Иргэний нийгэм, хувийн хэвшил, төрийн түншлэл, хамтын ажиллагаа” зорилтод доор дурдсан агуулгатай 4.1.3.6 дахь заалт нэмэх:

“4.1.3.6.Иргэний нийгмийн байгууллагууд болон сайн дурынхны нийгэм-эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг үндэсний тооцооны аргачлалаар үнэлдэг албан ёсны статистикийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун. Санал хураалт. /алх цохив/

54.0 хувиар санал дэмжигдлээ.

76.Төслийн 1 дүгээр хавсралтын “4.1.5.Парламентын засаглал ба эрх мэдлийн хяналт, тэнцэл” зорилтын гарчиг болон 4.1.5.1 дэх дараах заалтыг хасаж, 4.1.5.2 дахь заалтыг “4.1.1.Хүний эрх” зорилтын 4.1.1.6 дахь заалт болгон шилжүүлж, дугаарлалтыг өөрчлөх:

“4.1.5.1.Улс орны хөгжлийн амин чухал асуудлаар үндэсний зөвшилцөлд хүрч, төрийн залгамж чанар, бодлогын тогтвортой байдлыг хангах бөгөөд улс төрийн намуудыг нийтийн эрх ашгийн төлөө үйлчилдэг бодлогын институц болгох эрх зүйн орчныг бүрдүүлж, хатуу гишүүнчлэлээс татгалзаж, санхүүжилтийг ил тод болгоно.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

53.1 хувиар санал дэмжигдлээ.

77.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.1.6.5. дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.6.5.Хууль зүйн дэд бүтцийг хөгжүүлэх, бэхжүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

55.8 хувиар санал дэмжигдлээ.

78.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.1.2.“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

79.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.3 дахь заалтын “Авлига” гэсний өмнө “Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааг үргэлжлүүлж,” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

52.7 хувиар санал дэмжигдлээ.

80.Төслийн 1 дүгээр хавсралтын
4.2.1.4 дэх заалтыг хасах:

“4.2.1.4.Авлигаас олсон орлогыг хураан авч, тухайн орлогыг гэмт хэргийн хохирлыг барагдуулах, хууль сахиулах байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх болон нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

58.0 хувиар дэмжигдлээ.

81.Төслийн 1 дүгээр хавсралтын
“4.2.1.Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах үйл ажиллагаа” гэсэн зорилтод доор дурдсан агуулгатай 4.2.1.8 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“4.2.1.8.Улс төр дэх мөнгөний нөлөөллийг бууруулж, сонгогчдын саналыг худалдан авах аливаа ажиллагааг зогсооно.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа. Санал хураалт. /алх цохив/

55.9 хувиар санал дэмжигдлээ.

82.Төслийн 1 дүгээр хавсралтын
4.2.1.15 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.1.15.Тагнуулын үйл ажиллагаа болон нууц мөрдөн шалгах ажиллагааны зааг ялгааг тодорхой

болгож, эрх зүйн орчныг тус тусын хуулиар зохицуулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

61.3 хувиар санал дэмжигдлээ.

Би бас дэмжиж санал өгсөн. Эсрэг гарсан байна. Протоколд тэмдэглүүлье.

83.Төслийн 1 дүгээр хавсралтын
4.2.3.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.3.1.Чадахуйн зарчимд суурилсан оновчтой бүтэц бүхий төрийн албыг бэхжүүлж, төрийн албан хаагчийн бүтээмжийг нэмэгдүүлэн, төрийн албаны чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг боловсронгуй болгож, төрийн захиргааны албан хаагчдын тоог зохистой хэмжээнд хүргэнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар. Санал хураалт. /алх цохив/

55.9 хувиар санал дэмжигдлээ.

84.Төслийн 1 дүгээр хавсралтын
4.2.3.6 дахь заалтын “эвлэлдэн нэгдэж,” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар. Санал хураалт. /алх цохив/

36.0 хувиар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар. Горимын санал уу?

С.Зулпхар: Энэ хуулиар зохицуулагдсан байгаа юм.

Төрийн албан хаагч дотроос төрийн үйлчилгээний албан хаагч бол эвлэлдэн нэгдэх эрх нь нээлттэй байгаа. Боловсролын байгууллагууд, эмнэлгийн байгууллага гэх мэтчилэн.

Төрийн тусгай байгууллагад хуулиар энэ бол хязгаарлалттай байдаг. Энэ бол олон улсын жишиг. Угаасаа эдгээр албан хаагчдын хувьд хуулиар бусад эрхийг нь эдлүүлдэг юм байна. Цалин хөлс, нийгмийн баталгаа гээд.

Тэгэхээр одоо яг энэ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Санал хэлэх ямар ч боломж байхгүй. Гаргавал горимын санал гаргана.

Санал дэмжигдээгүй.

Улсын Их Хурлын гишүүн Сүрэнжавын Лүндэг. Яах гэж байгаа билээ? Горимын санал.

С.Лүндэг: Сая миний гацаад ажиллаагүй. Тэгээд энэ дээр дахиж санал хураах горимын санал гаргаж байна.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр 84 дүгээр саналыг хүчингүй болгох горимын саналыг Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэг гаргалаа.

Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэгийн саналаар саналыг хүчингүй болгох санал хураалт. /алх цохив/

Горимын санал дэмжигдсэнгүй.
39.6 хувиар.

Санал хураалтыг хүчингүй болгох горимын санал бас дэмжигдсэнгүй.

85.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.11 дэх дараах заалтыг хасах.

“4.2.3.11.Төрийн албан хаагчдын цахим мэдээллийг өөрт нь нээлттэй болгох замаар төрийн албан хаагчийн иж бүрэн цахим платформыг хөгжүүлж, мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдлыг сайжруулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

56.8 хувиар санал дэмжигдлээ.

86.Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“4.2.3.12.Хууль сахиулагчдын мэргэшил, нийгэм, эдийн засгийн баталгааг сайжруулж, хууль сахиулагч болон хууль сахиулах албаны эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль, эрх зүйн орчныг бий болгоно.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

54.1 хувиар санал дэмжигдлээ.

87.Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” зорилтод доор дурдсан агуулгатай 4.2.3.13 дахь заалт нэмэх:

“4.2.3.13.Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулж, ёс зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар. Санал хураалт. /алх цохив/

55.9 хувиар санал дэмжигдлээ.

88.Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” зорилтод доор дурдсан агуулгатай 4.2.3.14 дэх заалт нэмэх:

“4.2.3.14.“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” /2024-2030 он/ дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлж, ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэх соёлыг хэвшүүлж, нийгмийн ёс суртахууны үнэт зүйл бүхий сэтгэл зүйг төлөвшүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар. Санал хураалт. /алх цохив/

47.7 хувиар санал унасан байна.

89.Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” зорилтод доор дурдсан агуулгатай 4.2.3.15 дахь заалт нэмэх:

“4.2.3.15.Төрийн албаны ёс зүйн индекс, ёс зүйн дэд бүтцийг олон улсын туршлагад суурилан хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар. Санал хураалт. /алх цохив/

51.4 хувиар санал дэмжигдлээ.

90.Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.4.Орон нутгийн засаглалын бие даасан байдал” зорилтод доор дурдсан

агуулгатай 4.2.4.1 дэх заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“4.2.4.1.Орон нутгийн засаглалын бие даасан байдлыг бэхжүүлэх хүрээнд орон нутгийн босоо удирдлагатай байгууллагуудын томилгооны асуудлыг орон нутагт нь шилжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ. Санал хураалт. /алх цохив/

39.6 хувиар санал дэмжигдсэнгүй.

91.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.4.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.4.3.Хот байгуулалт, барилга, газрын талаарх холбогдох хуулийн уялдааг сайжруулж, төлөвлөлтөд суурилсан хот байгуулалтын тогтолцоог бий болгон, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрлийг олгож, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлагыг чангатгана.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

54.1 хувиар санал дэмжигдлээ.

92.Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.4.Орон нутгийн засаглалын бие даасан байдал” зорилтод доор дурдсан агуулгатай 4.2.4.4 дэх заалт нэмэх:

“4.2.4.4.Хороо, багийн хэмжээнд хэрэгжүүлэх тохижилтын жижиг төслүүдийг иргэдийн бүлэг, хөршийн холбоогоор гүйцэтгүүлэх боломжийг бүрдүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц. Санал хураалт. /алх цохив/

52.3 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал дэмжсэн санал өгсөн. Протоколд тэмдэглүүлье гэж хүсэлт өгч байна.

93.Төслийн 1 дүгээр хавсралтын “4.3.1.“E-Mongolia”-блок чейн-Цахим засаглал” зорилтод доор дурдан агуулгатай 4.3.1.6 дахь заалт нэмэх:

“4.3.1.6.Засгийн газрын тусгай сангуудын санхүүжилт, сонгон шалгаруулалтыг цахимжуулж ил тод болгоно.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

54.1 хувиар санал дэмжигдлээ.

94.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.4.1.3 дахь заалтын “ёс суртахууны доголдол,” гэснийг хасаж, 4.4.1.4 дэх заалтын “ёс зүйтэй” гэснийг “хариуцлагатай” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин. Үг байхгүй. Санал хураалт. /алх цохив/

55.9 хувиар санал дэмжигдлээ.

Горимын санал. Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэл.

О.Алтангэрэл: Үүнээс хойшоогоо найруулгын шинжтэй зүйлүүд нэлээн урт байна л даа.

Тэгээд манай Тамгынхан болох эсэхийг нь хэлнэ биз. Горимын санал гаргаад энэ найруулгын шинжтэй энэ их урт юмнуудыг уншихаас дарга аа авраад, найруулгыг дэмжих үү гэдэг дээр санал хурааа гэсэн ийм горимын санал гаргаж байна.

Д.Амарбаясгалан: Манай Их Хурлын Тамгын газраас. Горимын саналыг хүлээж авах боломжгүй гэж байна.

95.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.4.1.6, 4.4.1.7, 4.4.1.8, 4.4.1.9, 4.4.1.10, 4.4.1.11 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.4.1.6.Хилийн цэргийн байгуулалтыг хөгжүүлэх, мэргэшсэн хилчин, технологид суурилсан хил хамгаалах албыг бэхжүүлэн, зэвсэглэл, инженер, дохиолол хамгаалалт, радио релейн болон хяналтын систем, цэргийн холбоо, техник, нисгэгчгүй нисэх хэрэгсэл, тусгай хэрэгслээр бүрэн хангаж, хилийн цэргийн нисэх анги байгуулан, нисдэг тэрэг, нисэх онгоц ашиглах замаар хилийн аюулгүй байдлыг хангах, хилийн дэглэмийн гэрээг хэрэгжүүлнэ.

4.4.1.7.Хилийн боомтын сэргэлтийн бодлоготой уялдуулан авто зам, төмөр зам бүхий боомтуудад шалган нэвтрүүлэх анги байгуулж, боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, ухаалаг цахим гарц, дохиолол хяналт, хамгаалалтын нэгдсэн систем, тоног төхөөрөмжөөр хангана.

4.4.1.8.Хилийн цэргийн анги, салбарын албаны барилга, орон сууцыг шинэчилж, хилчдийн алба хаах, амьдрах нөхцөлийг сайжруулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Саналыг хүчингүй болгоё.
Төхөөрөмж гацлаа. Санал хураалт. /алх цохив/

51.8 хувиар санал дэмжигдлээ.

96.Төслийн 1 дүгээр хавсралтын
4.4.2.4 дэх дараах заалтыг хасах.

“4.4.2.4.Гадаад бодлогын үзэл баримтлалыг сансар судлал, шинжлэх ухаан, технологийн салбар дахь дэлхийн чиг хандлагатай нийцүүлэн шинэчилнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

40.9 хувиар санал уналаа.

Хэн горимын санал гаргах юм?
О.Саранчулуун. Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун горимын санал гаргая.

О.Саранчулуун: Төхөөрөмж маань ажиллаагүй учраас саяын явуулсан саналыг хүчингүй болгох санал гаргаж байна. Горимын санал.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр 96 дугаар санал хураалт дэмжигдээгүй.

Санал өгсөн боловч эсрэг гарсан учраас саналыг хүчингүй болгох горимын саналыг Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун гаргалаа. О.Саранчулуун гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

39.1 хувийн саналаар гаргасан горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар.

Чинбатын Анар гишүүн горимын санал.

Ч.Анар: Төхөөрөмж уншихгүй байгаа болохоор дахин санал хураалт явуулах горимын санал гаргаж байна.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан горимын санал дэмжигдээгүй.

Тэр санал хураалтыг хүчингүй болгох горимын саналыг Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар гаргалаа. Дэмжье гэсэн саналаар санал хураая. /алх цохив/

48.2 хувиар санал дэмжигдсэнгүй.

Төхөөрөмж бүрэн гүйцэд уншихгүй байгаад байна. Ахиж горимын санал гаргах уу?

97.Төслийн 1 дүгээр хавсралтын
4.4.2.15 дахь заалтын “дээшлүүлэх шаардлага улам нэмэгдэж байна” гэснийг “дээшлүүлнэ” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

51.8 хувиар санал дэмжигдлээ.

Ирцэд бүртгүүлчихээд ирж чадахгүй байгаа 4 Улсын Их Хурлын гишүүн өөрсдийн биеэр ирцээс хасагдах хүсэлт ирүүлсэн байна. Тэгэхээр энэ ирцээс хасъя.

Тэр хооронд санал хураалт явуулж болохгүй юм байна. Тэгэхээр 1 минут өгчихье.

4 гишүүнийг ирцээс хасъя. 1 минут шүү. Санал хураалт одоо шууд үргэлжилнэ шүү.

Хуралдаанаа үргэлжлүүлье.

98.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.4.3.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.4.3.7. “ЭХ ОРНЫ ДУУДЛАГА-ЭР ЦЭРГИЙН АЛБА”-ны хүрээнд батлан хамгаалах үйл хэргийг иргэдэд сурталчилж, хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлж, цэргийн сургалтын тогтолцоонд шинэчлэл хийж, цэргийн албаны төрлийг нэмэгдүүлэх замаар Зэвсэгт хүчин, алба хаагчийн олон нийтийн дэмжлэг, нэр хүндийг дээшлүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин. Санал хураалт. /алх цохив/

Би горимын санал гаргачихъя. Миний төхөөрөмж ажилласангүй. Тэгэхээр саяын санал хураалтыг хүчингүй болгох горимын санал хураалт гаргаж байна.

Горимын санал хураалтаар санал хураалт явуулъя.

Төхөөрөмж гацлаа. Санал хураалтыг хүчингүй болгоё. Санал хураалт явуулъя. Горимын саналыг хүчингүй болгох. Санал хураалтыг хүчингүй болгох горимын саналаар санал хураалт явуулъя. /алх цохив/

Төхөөрөмж гацлаа. Санал хураалтыг хүчингүй болгоё. Горимын саналаар санал хураалтыг явуулъя. /алх цохив/

50.9 хувиар түрүүчийн 98 дугаар саналын санал хураалтыг хүчингүй болголоо.

98 дугаар санал хураалтыг дахиж явуулна. Санал хураалт. /алх цохив/

57.4 хувиар санал дэмжигдлээ.

99.Төслийн 1 дүгээр хавсралтын “Эрсдэлийн удирдлага” гэсэн бүлгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, “4.4.Үндэсний сөрөн гэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм” гэсэн хэсэгт 4.4.5 дахь зорилт болгон шилжүүлж, 4.4.4 дэх зорилтын гарчгийн “, эрсдэлийн удирдлага” гэснийг хасах:

“4.4.5.Эрсдэлийн удирдлага

4.4.5.1.Геополитикийн тогтворгүй байдал, цар тахлын үеийн болон дараах эдийн засгийн хямрал, эрчим хүчний дутагдал, тээвэр логистикийн доголдол, хиймэл оюун ухаан, кибер аюулгүй байдал ба дэвшилтэт технологийн хурдацтай шилжилтийн тодорхой бус байдал, санхүүгийн эх үүсвэрийн хүрэлцээгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, байгаль, цаг уурын нөлөөлөл болон бусад эрсдэлийг даван туулах, хариу бэлтгэл арга хэмжээг шуурхай авах зорилгоор холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах, төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангасан эрсдэлийн удирдлагын цогц бодлого, төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.

4.4.5.2.Эрсдэлийг урьдчилан илрүүлэх, үнэлэх, эрэмбэлэх, хариу арга хэмжээ авах, хэрэгжилтэд үнэлгээ хийх системийг хөгжүүлж, эрсдэлийн удирдлагын шинэчлэлийг эхлүүлнэ.

4.4.5.3.Хамтрагч, түншлэгч талууд болон олон нийтэд мэдээллийг түргэн шуурхай хүргэх, солилцох нөхцөлийг бүрдүүлж, хамтын итгэлцлийг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлага,

түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэх хүрээнд гадаад болон олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

4.4.5.4. Эрсдэлийн удирдлагын үе шат бүрд иргэн, хуулийн этгээдийн оролцоог хангаж, урамшуулах бодлогыг дэмжинэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ. Санал хураалт. /алх цохив/

56.5 хувиар санал дэмжигдлээ.

100. Төслийн 1 дүгээр хавсралтын 4.4.4.10 дахь заалтын “Гамшгийн зураглал, эрсдэлийн мэдээллийн сан, гамшгийн эрсдэл хуваалцах механизмыг хөгжүүлнэ.” гэснийг “гамшгийн зураглал, байгаль орчин, уур амьсгалын эрсдэлийн мэдээллийн сан, гамшгийн эрсдэл хуваалцах механизмыг хөгжүүлж, олон нийтэд нээлттэй болгоно.” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

53.7 хувиар санал дэмжигдлээ.

101. Төслийн 2 дугаар хавсралтад “Үр дүн” баганад “Зах зээл дэх төрийн оролцоог бууруулах” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2023” гэж, “Суурь түвшин” баганад “76.2 %” гэж, Зорилтот түвшний “2025 он” баганад “77%” гэж, “2026 он” баганад “78%” гэж, “2027 он” баганад “79%” гэж, “2028 он” баганад “80%” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “ҮСХ” гэж, “Мэдээлэл цуглуулах арга” баганад “Статистик мэдээ” гэж, “Мэдээлэл цуглуулах

давтамж” баганад “Жилд нэг удаа” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

54.6 хувиар санал дэмжигдлээ.

102. Төслийн 2 дугаар хавсралтад 13 дахь мөр буюу “Үр дүн” баганад “Ёс зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ёс зүйн хороо, дэд хороодын чадавхын үнэлгээ” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2024” гэж, “Суурь түвшин” баганад “0” гэж, Зорилтот түвшний “2025 он” баганад “20” гэж, “2026 он” баганад “30” гэж, “2027 он” баганад “40” гэж, “2028 он” баганад “50” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Ёс зүйн хороо, дэд хорооны тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Ёс зүйн хороо, дэд хорооны чадавхын судалгаа” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жилд нэг удаа” гэж, 14 дэх мөр буюу “Үр дүн” баганад “Ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэх соёлыг хэвшүүлж, нийгмийн ёс суртахууныг төлөвшүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ёс зүйн зөрчлийн бууралт, нийгмийн нөлөөллийн үнэлгээ” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2024” гэж, “Суурь түвшин” баганад “Батлагдсан хөтөлбөр” гэж, Зорилтот түвшний “2025 он” баганад “30” гэж, “2026 он” баганад “50” гэж, “2027 он” баганад “75” гэж, “2028 он” баганад “85” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Олон эх үүсвэр” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил бүр” гэж, 15 дахь мөр буюу “Үр дүн” баганад “Төрийн албаны ёс зүйн

индекс, ёс зүйн дэд бүтцийг олон улсын туршлагад суурилан хэрэгжүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ёс зүйн үзүүлэлт” гэж, “Хэмжих нэгж” баганад “хувь” гэж, “Суурь он” баганад “2024” гэж, “Суурь түвшин” баганад “0” гэж, Зорилтот түвшний “2025 он” баганад “10” гэж, “2026 он” баганад “15” гэж, “2027 он” баганад “25” гэж, “2028 он” баганад “35” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Төрийн албаны олон улсын индекс (InCiSE)-ийн ёс зүйн (INT) үзүүлэлт” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Үндэсний үзүүлэлтийн судалгаа” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жилд нэг удаа” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар. Санал хураалт. /алх цохив/

Ж.Баясгалан гишүүн горимын санал.

Ж.Баясгалан: Төхөөрөмж сая ажиллаагүй тул санал хураалтыг хүчингүй болгох горимын санал байна.

Д.Амарбаясгалан: Ж.Баясгалан гишүүний гаргаснаар санал хураалтыг хүчингүй болгох горимын саналын санал хураалтыг явуулья.

50.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

102 дугаар санал хураалтыг дахиж явуулья. Дэмжье гэсэн томъёоллоор.

56.5 хувийн саналаар 102 дугаар санал дэмжигдлээ.

103.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтад “олон улсын ур чадварын үзүүлэлт” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд. Санал хураалт. /алх цохив/

52.8 хувиар санал дэмжигдлээ.

104.Зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан тогтоолын төслийн болон хавсралтын нэр томъёог жигдлэх, бүлэг, зүйл, хэсэг, заалт, дэд заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Энэ 104-ийнхөө санал хураалтыг явуулах юм байна. 104 дүгээр санал хураалт. /алх цохив/

61.1 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал орж ирж байна. Найруулгын саналыг уншиж эхэлье.

Найруулгын санал:

1.Тогтоолын төслийн 2 дахь заалтын 3 дахь дэд заалтын “мэдэгдэл” гэснийг “мэдэгдлийн” гэж, “төлөвлөгөө” гэснийг “төлөвлөгөөний” гэж, 3 дахь заалтын “төрөлжсөн,” гэснийг “төрөлжсөн бүс бөгөөд” гэж тохиолдол бүрд, тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “реформ” гэснийг “шинэчлэл” гэж, “реформыг” гэснийг “шинэчлэлийг” гэж тохиолдол бүрд, 1.3.6.1 дэх заалтын “Алтай овоо” гэснийг “Алтан овоо” гэж, 2.1.1.7 дахь заалтын “гэр бүл, хүүхэд хөгжил, хамгааллын” гэснийг “, гэр бүлийн” гэж, 2.1.1.12 дахь заалтын “хөгжил, нийгмийн” гэснийг “хөгжлийн болон нийгмийн” гэж, 2.2.1.4 дэх заалтын “тохируулгад” гэснийг “тохируулгат” гэж, 2.2.1.9 дэх заалтын

“чиглэнэ” гэснийг “чиглүүлнэ” гэж, 2.2.1.13 дахь заалтын “төгсдөг” гэснийг “төгсөх” гэж, 3.2.2.5 дахь заалтын “хүч” гэснийг “хүчний” гэж, 3.2.2.9, 3.2.2.10 дахь заалтын “баталж,” гэснийг “батлуулж” гэж, 3.2.2.10 дахь заалтын “саад тотгорыг” гэснийг “саадыг” гэж, 3.3.5.10 дахь заалтын “марс гарагт” гэснийг “марс гарагтай” гэж, 3.3.6.7 дахь заалтын “концепцоор” гэснийг “агуулгаар” гэж, 4.1.1.3 дахь заалтын “мөрдөн хавчигддаг” гэснийг “мөрдөн хавчигддаггүй байх” гэж, 4.1.2.1 дэх заалтын “ёс зүй” гэснийг “ёс зүйг баримтлан” гэж, 4.3.2.4 дэх заалтын “IoT” гэснийг “юмсын интернэт” гэж тус тус өөрчлөх.

2.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 1.1.4.4 дэх заалтын “хөдөлгөөн” гэсний өмнө “замын” гэж, 2.1.1.29 дэх заатын “хөтөлбөрт” гэсний өмнө “сургалтын” гэж, 2.1.4.2 дахь заалтын “шигшээ” гэсний өмнө “үндэсний” гэж, 2.2.1.6 дахь заалтын “эдийн засгийн” гэсний дараа “хувьд” гэж, 3.2.2.5 дахь заалтын “төлбөрөөс” гэсний өмнө “ажлын байрны” гэж, 3.4.1.1 дэх заалтын “төрхийг” гэсний өмнө “унаган” гэж, 4.2.1.12 дахь заалтын “камерын” гэсний дараа “хяналтын” гэж, 4.3.1.3 дахь заалтын “зэрэг бүх салбарт” гэснийг “болон бусад салбарт” гэж, 4.4.2.1 дэх заалтын “суурь” гэсний өмнө “гадаад бодлогын” гэж тус тус нэмэх.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2.1.7 дахь заалтын “дээд зэргээр” гэснийг, 2.2.4.2 дахь заалтын “дигитал” гэснийг, 3.1.1.3 дахь заалтын “Монгол Улсын Үндсэн хуульд заасан” гэснийг, 3.2.2.2 дахь заалтын “багц” гэснийг, 3.2.2.4 дэх заалтын “цахим” гэснийг, 3.3.4.4 дэх заалтын “ялангуяа” гэснийг, 4.3.2.5 дахь заалтын “аливаа” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ. Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

Х.Тэмүүжин гишүүнд микрофон өгье.

Х.Тэмүүжин: Тэр 102 гээд Б.Батбаатар гишүүний гаргасан нэг их олон багцалсан санал дотор **“НИЙГМИЙН ЁС СУРТАХУУНЫГ ТӨЛӨВШҮҮЛНЭ”** гэдэг үг орсон байна лээ.

Төрийн албан хаагчийн ёс зүйг сайжруулах замаар нийгмийн ёс суртахууныг төлөвшүүлэхгүй, олон нийтийн итгэл даах байдлыг нэмэгдүүлнэ.

Тэр агуулгаар нь засахгүй бол энэ нийгэм рүүгээ чиглэсэн, иргэд рүүгээ чиглэсэн ёс зүй, ёс суртахуун яриад эхлэх юм бол энэ чинь дарангуйлагч тогтолцооны л нэг ойлголт шүү дээ.

Энэ дээр гүйцээн боловсруулах дээр, найруулга дээр нэг үг, үсгийн засвар хийхгүй бол.

Д.Амарбаясгалан: Найруулга гүйцээн боловсруулахдаа анхааръя. Х.Тэмүүжин гишүүний саналыг. Тийм.

Хоёр.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал:

1.Тогтоолын төслийн 3 дахь заалтыг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг. Санал хураалт. /алх цохив/

41.7 хувиар санал дэмжигдсэнгүй.

О.Номинчимэг гишүүн горимын санал гаргах юм уу?

О.Номинчимэг: Энэ ингээд хасах юм бол одоо дахиад бусад тогтоолд...

Д.Амарбаясгалан: Горимын санал.

О.Номинчимэг: Төхөөрөмж гацаад байгаа учраас хүчингүй болгож, санал хураалт дахин явуулахыг хүсье.

Д.Амарбаясгалан: О.Номинчимэг гишүүн чинь дэмжиж санал өгсөн. Дэмжсэнээр гарсан учраас горимын санал нэрээ өгч болохгүй юм байна.

Отгоншарын Батнайрамдал гишүүнд горимын санал.

О.Батнайрамдал: Дарга аа, төхөөрөмж ажилласангүй. Тэгэхээр сая санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргаж байна. Дахин санал хураалгах.

Д.Амарбаясгалан: О.Батнайрамдал гишүүний горимын саналаар санал хураалт. Хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. /алх цохив/

Дахиад уналаа.

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн. Горимын санал.

Х.Баасанжаргал: Саяын санал хураалтыг хүчингүй болгоод дахиад санал хураая. Төхөөрөмж ажилласангүй.

Д.Амарбаясгалан:

Гончигдоржийн Уянгахишиг гишүүн. Горимын санал.

Г.Уянгахишиг: Горимын санал. Одоо ингээд үүнийг дэмжигдэх хүртэл ер нь унагаах юм уу гэдэг бас нэг сонин асуулт гарч ирээд байна шүү дээ. Тийм.

Тэгэхээр горимын санал бол сая явсан саналаараа явъя. Энэ дээр жишээлбэл 52, 56-ын ялгаа байхад нэг хүнийх болохгүй байна гэдгээр шууд дахиж явуулна гэдэг чинь бас зөв юм уу, үгүй юу гэдэг горимын санал байна.

Д.Амарбаясгалан: Санал хураалттай холбоотой горимын санал явагдаж байгаа.

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүний гаргасан горимын саналаар түрүүн хураасан 1 дүгээр асуудлын санал хураалтын дүнг хүчингүй болгоё гэдгээр санал хураалтыг явуулъя.

47.2 хувиар горимын санал дэмжигдсэнгүй.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.1.3.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.3.2.Цэвэрлэх байгууламжийн тархмал дэд төвүүдийг шинээр байгуулах, бие даасан, бага оврын ариун цэврийн байгууламжийн хэрэглээг бодлогоор дэмжих замаар нүхэн жорлонгийн тоог 2 дахин бууруулж, хөрсний бохирдлыг бууруулна.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан. Санал хураалт. /алх цохив/

45.4 хувиар санал дэмжигдсэнгүй.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын
“1.1.3.Гэр хорооллын дахин төлөвлөлт,
орон сууцжуулалт” зорилтод доор
дурдсан агуулгатай 1.1.3.7 дахь заалт
нэмэх:

“1.1.3.7.Эрчим хүчний хэмнэлтийг
бий болгох, нийслэлийн орон сууцны
дулаан алдагдлыг бууруулах зорилгоор
нэг удаа орон сууцны дулаалгын ажлыг
хийнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

18.5 хувиар санал дэмжигдсэнгүй.

Горимын санал байна уу?
Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн
горимын санал.

М.Нарантуяа-Нара: Горимын
санал дэвшүүлэх гэсэн юм. Дөнгөж сая
бид хэдийн бүгдийнх нь төхөөрөмж
ажилласангүй.

Тийм учраас саяын санал
хураалтыг хүчингүйд тооцоод дахин
санал хураах ийм горимын санал
дэвшүүлж байна.

Д.Амарбаясгалан: Мөнхтөрийн
Нарантуяа-Нара гишүүний горимын
саналаар санал хураалтыг хүчингүй
болгох санал хураалтыг явуулъя. /алх
цохив/

Санал хураалтыг хүчингүй болгох
горимын санал хураалт дэмжигдсэнгүй.

4.Төслийн 1 дүгээр хавсралтын
“1.3.5.Төвийн бүс- “Хөдөө аж ахуйн
төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс””
гэсэн зорилтын гарчгийг “1.3.5.Төвийн
бүс-“Эрчимжсэн хөдөө аж ахуй, аж

үйлдвэржилт, эрчим хүчний дэд бүс””
гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын
гишүүн Ж.Батжаргал. Санал хураалт. /алх
цохив/

Төрийн байгуулалтын байнгын
хорооны дэмжигдээгүй санал
дэмжигдсэнгүй.

5.Төслийн 1 дүгээр хавсралтын
1.3.5.3 дахь дараах заалтыг хасах:

“1.3.5.3.Шүрэнгийн усан
цахилгаан станц барина”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

25.9 хувь.

Нэг юм хэлдэг хурлын дэг байхгүй
ээ. Учлаарай.

6.Төслийн 1 дүгээр хавсралтын
“1.3.5.Төвийн бүс-“Хөдөө аж ахуйн
төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” гэсэн
зорилтод доор дурдсан агуулгатай 1.3.5.7
дахь заалт нэмэх:

“1.3.5.7.Дарханы арьс ширний
үйлдвэрийг барьж дуусгана.”

Санал гаргасан Улсын Их Хурлын
гишүүн Д.Жаргалсайхан. Санал хураалт.
/алх цохив/

Дэмжээгүй санал дэмжигдсэнгүй.

7.Төслийн 1 дүгээр хавсралтын
“2.1.1.Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн
бодлого” зорилтын “Хүүхэд” хэсэгт доор
дурдсан агуулгатай 2.1.1.9 дэх заалт
нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“2.1.1.9.Хичээлээс гадуурх үйл ажиллагаа буюу хүүхэд хөгжүүлэх секц, дугуйлан, сургалтын төвүүд, түүний багш нарт санхүүжилтийн болон байр, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн. Санал хураалт. /алх цохив/

15.7 хувиар санал дэмжигдсэнгүй.

8.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1.1.19 дэх заалтын “инфляц” гэснийг “өмнөх оны инфляцын жилийн дундаж болон” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан. Санал хураалт. /алх цохив/

30.6 хувиар санал дэмжигдсэнгүй.

9.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1.2.6 дахь заалтын “цалин хөлсийг” гэсний дараа “жил бүр” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат. Санал хураалт. /алх цохив/

23.1 хувиар санал дэмжигдсэнгүй.

10.Төслийн 1 дүгээр хавсралтын “2.1.2.Хөдөлмөр эрхлэлт” зорилгод доор дурдсан агуулгатай 2.1.2.2 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“2.1.2.2.Хөдөлмөрийн зах зээлд эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрийг хангасан цалин хөлсний тогтолцоог бий болгоно.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа. Санал хураалт. /алх цохив/

37.0 хувиар санал дэмжигдсэнгүй.

Дэгээрээ үг байхгүй. Горимын санал. Ж.Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Горимын санал гаргая.

Гишүүд маань жаахан юм бодохгүй бол бас арай дэндэж байгаа юм биш үү.

Энэ Байнгын хорооноос гарч ирсэн бодлого, энэ тэр гэсэн юмнуудаа бид нар чинь бодох ёстой шүү дээ. Яг одоо нөгөө телевизээр яриад байгаа кнопны гишүүд гэдэг зүйлээ баталж байна шүү. Хэдүүлээ.

Ямар ч бодлого байхгүй. Засгийн газраас орж ирсэн бодлого, тэр тусмаа төсөвтэй холбоотой асуудлууд, төсвийг хүндрүүлэх бүхий л асуудлуудыг хамаагүй ингээд босгоод байж болж байгаа юм уу?

Мэргэжлийн байнгын хорооноос орж ирсэн асуудал ч тэр, аливаа асуудлаар ингэж хандаж болохгүй шүү дээ.

Одоо нөгөө кнопны гишүүд гэдгийгээ баталж байна шүү. Та бүхэн маань. Бас жаахан бодолтой байхгүй бол болохгүй байх шүү. Горимын санал гаргачихлаа.

Д.Амарбаясгалан: Тэгээд яах юм. Дахиж бүгдийг нь санал хураах горимын санал юм уу?

Тэгвэл бүр эхнээс нь санал хураалт явуулъя. Тийм ээ.

Төрийн байгуулалтын байнгын хороон дээр ажлын хэсэг ярилцаад, тэгээд Төрийн байгуулалтын байнгын хороон дээр дэмжигдээгүй саналуудаар санал хурааж байгаа. Дэмжигдээгүй саналыг дэмжье гэсэн үг.

Нэг ёсондоо уг саналыг хасъя гэсэн саналыг нь чуулганы хуралдаан дээр дэмжиж санал хураалгах гэж байна гэсэн энэ зүйлийг бас Та бүхэн маань бодолцоод санал хураалтад орох нь зүйтэй байх.

11.Төслийн 1 дүгээр хавсралтын “2.2.1.Тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол” хэсэгт доор дурдсан агуулгатай 2.2.1.20 дахь заалт нэмэх:

“2.2.1.20.Хүүхэд хөгжлийн STEAM боловсрол олгох ордныг дүүргүүдэд байгуулна.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа. Төрийн байгуулалтын байнгын хороон дээр дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүддээ ахиад нэг тайлбар өгье. Гишүүд ээ, Ж.Бат-Эрдэнэ гишүүн ээ, манай гишүүд анхааралтай сонсож байгаарай.

Төрийн байгуулалтын байнгын хороон дээр дэмжигдээгүй санал гэдэг чинь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс хасагдаж байгаа санал гэж ойлгоно. Энэ өөрөө эдийн засаг, төсвийн хөрөнгө оруулалт, холбогдох бүх зүйлийг нь тооцоод ажлын хэсэг, мэргэжлийн Байнгын хороо хасъя гэж шийдсэн саналууд гэж ойлгоно.

Тэгэхээр энэ саналыг одоо дэмжиж санал өгнө. Дэмжихгүй санал өгвөл уг санал нь буцаад Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орно гэж ойлгох ёстой.

Тэгэхээр мэргэжлийн Байнгын хорооны гаргасан саналыг дэмжих нь уг санал хасагдаж байна гэдэг ойлголт байгаа шүү.

Тэгэхээр дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор Улсын Их Хурлын чуулган дээр санал хураалт явуулж байгаа.

Ингээд сая 11 дэх санал хураалтыг төхөөрөмж гацсан учраас цуцалсан байгаа. 11 дэх санал хураалтыг дахиж явуулъя. Дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томъёоллоор. /алх цохив/

Санал хураалт дэмжигдсэнгүй. Би бас дэмжиж санал өгсөн юм. Тэгсэн төхөөрөмж гацсан байна.

Горимын санал гаргах гишүүд байна уу? Алга байна.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг горимын санал.

П.Сайнзориг: Яг өнөөдрийн чуулган эхлэх үеийн ирц хангалттай байгаа боловч танхимд сууж байгаа гишүүдийн тоо бага байна. Дарга аа.

Тэгэхээр энэ бүлгүүд ирцээ бүрдүүлж энэ санал хураалтдаа оръё гэдэг ийм горимын санал байна.

Д.Амарбаясгалан: Танхимд байгаа гишүүдийн ирц хангалттай байна.

11 дүгээр санал хураалт дэмжигдээгүй. 39.8 хувиар.

12.Төслийн 1 дүгээр хавсралтын “2.2.1.Тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол” зорилгод доор дурдсан агуулгатай 2.2.1.21 дэх заалт нэмэх:

“2.2.1.21.Үндэсний цөөнхийн бага, дунд боловсрол эзэмших эрхийг хангах “Хос хэл”-ний бодлого, арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар.

Ингээд нэг зүйлийг гишүүд зөв ойлго. Дэмжигдээгүй саналыг дэмжиж санал хурааж байгаа гэдгээ өөрсдөө зөв ойлгоцгоо.

Ингээд 12 дугаар саналаар санал хураалтыг явуулъя. /алх цохив/

27.8 хувиар санал.

П.Наранбаяр сайд. Горимын санал.

П.Наранбаяр: Тэгэхээр энэ 11, 12 дугаар санал ер нь өөрөө алдаатай томъёололтой ийм саналууд байна.

Энэ төхөөрөмжүүд болохгүй байх шиг байна. Минийх ч гэсэн ерөөсөө ингээд орж гээд болохгүй байгаад байна.

Тэгэхээр горимын саналыг гацалттай байгаа учраас дахин энэ 11, 12-ыг санал хураалтад оруулах ийм саналтай байна.

“Хос хэлний бодлого” гэж байхгүй шүү дээ. Тийм.

Тэгээд энэ улс орон чинь өөрөө нэгдмэл нэг улс шүү дээ. Тэгэхээр зэрэг

энэ чинь манай хороогоор дамжиж орж ирээгүй шүү дээ.

Дэмжихгүй гэдгийг дэмжинэ гэсэн томъёоллоор санал хураагаад байна гэж ойлгож байгаа. Тийм. Тэгэхээр 11, 12-ыг дахиж оруулах.

Д.Амарбаясгалан: 11, 12-ыг дахиж хураалгах горимын санал гаргаж байна.

Манай Их Хурлын Тамгын газрын Техникийн албанаас бас утасдаад төхөөрөмж дээр гишүүд хурууны хээг дахин дахин уншуулснаас болоод төхөөрөмж гацах тохиолдол гараад байна. Тийм учраас 10 минутын завсарлага авч ресет хийх шаардлага байна гэж үзэж байна. 10 минут завсарлалаа.

Хуралдаанаа үргэлжлүүлье. Гишүүд танхимдаа орж ирье.

18.00 цаг болсон байна. Өнөөдрийн хэлэлцэх асуудал талдаа орж байгаа тул өнөөдрийнхөө чуулганы хуралдааны цагийг сунгаж хуралдъя.

Хэлэлцэх асуудалдаа орёе. П.Наранбаяр сайд горимын санал гаргасан. Тийм ээ. 11, 12 дугаар санал хураалтыг хүчингүй болгох горимын санал оруулсан байгаа.

Гишүүд цугласан байна. Боловсролын сайд П.Наранбаяр 11, 12 дугаар санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргасан байгаа.

Тэгэхээр Б.Наранбаяр сайдын гаргасан горимын саналаар 10 дугаар санал хураалт, 11 дүгээр санал хураалт хоёрыг хүчингүй болгох горимын санал гаргасан.

Б.Наранбаяр сайд 10, 11 гэсэн юм уу? 11, 12 дугаар саналыг гэсэн үү? Тийм. 11, 12 дугаар санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргасан. 12 дээр санал хураалт явуулаагүй байгаа. Тийм ээ. Явуулаагүй байгаа.

Тэгэхээр Б.Наранбаяр сайдын гаргасан горимын саналын дагуу 11 дэх санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн горимын санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

11 дүгээр санал хураалт. Санал хураасан. Дэмжээгүй. Б.Наранбаяр сайд горимын санал гаргасан. Дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд. Горимын санал.

Т.Доржханд: Төхөөрөмж ажилласангүй ээ, дарга аа. Санал хураалтыг хүчингүйд тооцоод дахиад санал хурааж өгнө үү. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн горимын санал гаргасан. Гишүүд энэ дээр их тийм анхааралтай хандаарай.

Би дахиад хэлье. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт мэргэжлийн Байнгын хорооноос дэмжигдээгүй орж ирсэн саналыг дэмжье гэдэг саналтай байхгүй юу. Тэгэхээр тэр дэмжигдээгүй саналыг нь дэмжиж байгаа. Уг асуудлыг нь дэмжиж байгаа гэж битгий ойлгоорой.

Байнгын хороон дээр дэмжигдээгүй саналуудыг Их Хурал дээр санал хурааж дэмжиж байгаа юм.

Жишээлбэл, 11 дүгээр санал хураалт Хүүхэд хөгжлийн STEAM

боловсрол олгох ордныг дүүргүүдэд байгуулна гэж байгаа юм.

Энэ өөрөө Засгийн газар үйл ажиллагааныхаа хөтөлбөрт оруулах боломжгүй гэдэг санал явж байгаа гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр ингээд гишүүд болгон ийм хөрөнгө оруулалтын санал гаргаад үйл ажиллагааны хөтөлбөрт орох нь буруу юм гэж Байнгын хороо үзсэнийг чуулган дэмжиж байгаа санал хураалт явуулаад байгаа юм.

Ингээд энэ санал хураалт дэмжигдээгүй. Унасан. Ингээд П.Наранбаяр сайд унасан саналыг босгох буюу дэмжиж өгөөч ээ гэж горимын санал гаргасан.

Сая санал хураалт дэмжигдээгүй.

Тэгэхээр П.Наранбаяр сайдын гаргасан горимын санал унасан учраас буцааж босгох, дэмжих саналыг Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд гаргаж байна.

Т.Доржханд гишүүний гаргасан саналыг дэмжвэл П.Наранбаяр сайдын гаргасан санал дэмжигдээд, тэгээд уг үндсэн санал буюу дэмжээгүй саналыг дэмжих санал босно гэсэн үг.

Тэгэхээр үүнийг будлиулахгүй байхын үүднээс Т.Доржханд гишүүний гаргасан саналыг дэмжих юм бол 11 дэх санал хураалт дахин явагдана гэж ойлгоё.

Тэгэхээр Т.Доржханд гишүүн горимын саналаа тодорхой хэлчих. Микрофоныг нь өгье.

Т.Доржханд: Төхөөрөмж маань үнэхээр ажилласангүй. Тийм болохоор түрүүчийн санал хураалтыг хүчингүй

болгоод дахин санал хураалт явуулж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

М.Нарантуяа-Нара гишүүн горимын санал гаргая гэж байна.

М.Нарантуяа-Нара: Жишээлбэл, энэ 11 дээр манайхан нэг юмыг аягүй сайн анзаарахгүй бол.

Одоо энэ **“STEAM хөтөлбөр”** гэж байдаг юм шүү дээ. Энэ нөгөө **“Science, Technology, Engineering, the Arts and Mathematics”** гээд.

Д.Амарбаясгалан: Горимын санал. Хэлэлцүүлэг явагдаагүй байна.

Тэгэхээр Т.Доржханд гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. /алх цохив/

51.8 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд 11 дэх саналыг дахиж санал хураана. Гишүүд маань анхааралтай сонсож байгаарай.

11 дүгээр саналыг Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэж санал өгье. Дэмжээгүй саналыг дэмжинэ. Санал хураалт. /алх цохив/

51.8 хувийн саналаар 11 дүгээр санал дэмжигдлээ.

Ер нь зарчмын хувьд мэргэжлийн Байнгын хорооны дэмжээгүй саналуудыг Их Хурал бодлогын хувьд дэмжиж байгаа гэдэг л агуулга энэ дээр гарч ирж байгаа ойлгоорой. Гишүүд.

12 дахь санал дээр бас санал хураалт явуулаад 27.8 хувийн саналаар асуудал дэмжигдээгүй байсан.

Энэ дээр П.Наранбаяр сайд бас горимын санал гаргаад энэ саналыг хүчингүй болгож өгөх санал хураалт явуулахыг хүссэн байгаа.

Тэгэхээр 12 дугаар саналыг, дэмжээгүй саналыг хүчингүй болгож өгөөч ээ гэж гаргасан П.Наранбаяр сайдын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

51.5 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд 12 дугаар саналыг бас Үндсэн хуулийн зөрчилтэй байж болзошгүй гэж зарим гишүүдээс асуудал гарч байгаа учраас гүйцээн боловсруулаад, эцсийн хэлэлцүүлэг дээр дахин оруулж ирэхийг Төрийн байгуулалтын байнгын хороонд чиглэл болгож байна. /алх цохив/

Хүчингүй болгох санал дэмжигдсэн. Тэгэхээр хүчингүй болж байгаа юм.

13.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2.4.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.2.4.1.Боловсролын бодлого, санхүүжилт, хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хүн ам, орон зайн их өгөгдөлд тулгуурласан хиймэл оюун ухаан ашиглах замаар боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүн, үр ашгийг сайжруулна.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар. Санал хураалт. /алх цохив/

14.Төслийн 2.3.4.3 дахь заалтын “эрүүл мэндийн ажилтны” гэсний дараа “цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулж” гэж нэмж, “алслагдсан” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, О.Саранчулуун. Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 1 дүгээр хавсралтын “2.4.1.Баялагтаа эзэн Монгол” зорилтод доор дурдсан агуулгатай 2.4.1.9 дэх заалт нэмэх:

“2.4.1.9.Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг Засгийн газартай байгуулсан аж ахуйн нэгжүүд, уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн үйлчлэлд хамруулна.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалт 54.5 хувиар дэмжигдлээ.

16.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.4.2.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.4.2.7.Үл хөдлөх салбарын хамтын хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн орчныг бүрдүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Сая гишүүд ирцэд орж гараад давхардсан үйлдлүүд хийгдээд байгаа. Төхөөрөмж саатах тохиолдол гарч байна гэж байна.

Тэгэхээр нэг удаагийн туршилтын санал хураалт явуулж үзье. Бүгдээрээ зөвшөөрснөөр санал өгч үзье. Зөвшөөрсөн. Туршилтын санал хураалт. /алх цохив/

Санал хураалтаа үргэлжлүүлье. 16 дугаар саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураана. /алх цохив/

41.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Б.Батбаатар гишүүн горимын санал гаргая.

Б.Батбаатар: Энэ Улсын Их Хурал, парламент 4 жил Засгийн газрын хөтөлбөрийг батлах үйл ажиллагаа явж байна. Төсвийн тодотгол. Ингээд цааш цаашдаа зөндөө олон зүйл батална.

Их Хурал дээр гарч байгаа нэг үг. /микрофон хаагдав/

Д.Амарбаясгалан: Санал хураалт.

17.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.2.1.Татвар, нийгмийн даатгалын реформ” зорилтод доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“3.2.1.8.“Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг шинэчилнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

54.8 хувиар санал дэмжигдлээ.

18.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.1.Уул уурхай” зорилгод доор дурдсан агуулгатай 3.3.1.17, 3.3.1.18 дахь заалт нэмэх:

“3.3.1.17.Эрдэнэтийн овооны Оюут ордын нөөцийг тооцоолон, ТЭЗҮ-ийг эцэслэж, ашиглалтад оруулахад бэлэн болгоно.”

“3.3.1.18.Эрдэнэтийн стратегийн ордын талбайн эрэл хайгуулын ажлын хүрээнд хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологи ашиглан дахин шинэ стратегийн орд нээж, ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг эхлүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж. Санал хураалт. /алх цохив/

59.6 хувийн саналаар санал уналаа.

19.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилтын 3.3.1.13, 3.3.2.17 дахь дараах заалтуудыг хасах:

“3.3.1.13.“Сайншанд-Баруун-Урт-Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлнэ.”

“3.3.2.17.“Сайншанд-Баруун-Урт-Хөөт” чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

56.7 хувиар санал дэмжигдлээ.

20.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр

логистик” гэсэн заалтад доор дурдсан агуулгатай 3.3.2.20 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“3.3.2.20.Даянгийн боомтыг хатуу хучилттай авто замаар холбох бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл. Санал хураалт. /алх цохив/

31.7 хувиар санал дэмжигдсэнгүй.

21.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилгод доор дурдсан агуулгатай 3.3.2.27 дахь заалт нэмэх:

“3.3.2.27.Хутаг-Өндөр сумаас Бага илэнхийн хилийн боомт хүртэл 146 км хатуу хучилттай авто замыг барина.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн, Л.Энх-Амгалан, Д.Батлут, Б.Бат-Эрдэнэ, Д.Үүрийнтуяа. Санал хураалт. /алх цохив/

20.2 хувиар санал дэмжигдсэнгүй.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Оюунсайханы Алтангэрэл гишүүн горимын санал.

О.Алтангэрэл: Төхөөрөмж ажилласангүй. Тэгээд саяын санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргаж байна.

Д.Амарбаясгалан: О.Алтангэрэл гишүүний гаргасан горимын саналаар 21 дүгээр асуудлын хураасан саналыг хүчингүй болгох горимын саналаар санал хураалт явуулъя.

25.0 хувиар горимын санал дэмжигдсэнгүй.

22.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.2.28 дахь заалт нэмэх:

“3.3.2.28.Эрдэнэт хотын доторх авто замын барилга угсралт, шинэчлэлт, өргөтгөл, их засварын ажлыг гүйцэтгэнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн, Л.Энх-Амгалан, Д.Батлут, Б.Бат-Эрдэнэ, Д.Үүрийнтуяа. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбатын микрофоныг өгье. Горимын санал.

Г.Очирбат: Төхөөрөмж ерөөсөө болохгүй байна. Хурлын дарга аа. Дахиад санал хураах уу? Ер нь яах вэ?

Түүрүүнээс хойш. Минийх бол өнөөдөр бараг ингээд арван хэд дэх тохиолдол нь боллоо. Хэлэхгүй байж байгаад л хэлж байна л даа. Төхөөрөмж болохгүй байна.

Тэгээд горимын санал гаргаад дахиад санал хураая.

Д.Амарбаясгалан: Г.Очирбат гишүүн санал хураалтыг хүчингүй болгоод дахин санал хураалт явуулах горимын санал гэж ойлгох уу?

Г.Очирбат гишүүний гаргасан горимын саналаар сая явуулсан санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг эхлүүлье. /алх цохив/

29.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

23.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.2.29 дэх заалт нэмэх:

“3.3.2.29.Мөрөн-Их-Уул-Рашаант-Өлзийт-Хайрхан-Тэрхийн цагаан нуур босоо чиглэлийн хатуу хучилттай авто замыг барьж дуусгана.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн, Л.Энх-Амгалан, Д.Батлут, Б.Бат-Эрдэнэ, Д.Үүрийнтуяа.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

36.2 хувийн саналаар санал уналаа.

24.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.3.Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” гэсэн зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.3.44 дэх заалт нэмж, 3.3.3.30 дахь заалтаас “Чойр-Сайншанд чиглэлийн 220 кВ,” гэснийг, 3.3.3.37 дахь заалтаас “Тавантолгойн ДЦС-Оюутолгой,” гэснийг тус тус хасах.

“3.3.3.44.Тавантолгой-Оюутолгой чиглэлийн 220кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, Чойр-Сайншанд чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг тус тус барина.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

45.7 хувиар санал дэмжигдсэнгүй.

25.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3.38 дахь дараах заалтыг хасах.

“3.3.3.38.Аймгийн төвүүд, сум суурин газруудын дулаан хангамжийн дэд бүтцийг сайжруулах, үр ашиг өндөртэй нүүрс, сэргээгдэх эрчим хүчний технологийг ашигласан станцуудыг байгуулах суурь судалгааг хийх, төслүүдийг эхлүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

45.7 хувиар санал дэмжигдсэнгүй.

26.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.3.Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.3.45 дахь заалт нэмэх:

“3.3.3.45.Мөрөн хотод 50 мВт-аас доошгүй хүчин чадалтай дулааны цахилгаан станц байгуулах бэлтгэл ажлыг хангана.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн, Л.Энх-Амгалан, Д.Батлут, Б.Бат-Эрдэнэ, Д.Үүрийнтуяа. Санал хураалт. /алх цохив/

38.1 хувиар санал дэмжигдсэнгүй.

27.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.3.Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.3.46 дахь заалт нэмэх:

“3.3.3.46.Эрдэнэт хотын цахилгаан хангамжийг сайжруулахад шаардлагатай 35 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барина.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн, Л.Энх-Амгалан, Д.Батлут, Б.Бат-Эрдэнэ, Д.Үүрийнтуяа. Санал хураалт. /алх цохив/

38.1 санал дэмжигдсэнгүй.

Горимын санал. Батын Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: Энэ төхөөрөмжийн шаардлагыг хангасны дараа санал хураалтдаа орвол яасан юм бэ.

Үүнийгээ нэг гацхааргүй болгоод. Тэгэхгүй бол байнга горимын санал гаргахаас. Горим гаргахад ч түвэгтэй болж эхэлж байгаа шүү дээ.

Та ч гэсэн байна уу гэж асуух нь ч гэсэн дэмий зүйл болчихоод байна.

Д.Амарбаясгалан: Горимын санал. Сая түр зогсоогоод техникийн албаныхан ажилласан.

Санал хураалтуудаа хураагаад, үнэхээр болохгүй бол бас тийм арга хэмжээ авч болох байх.

28.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.3.Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.3.47 дахь заалт нэмэх:

“3.3.3.47.Эрчим хүчний салбарт реформ хийж, салбарын эрх зүйн орчныг сайжруулах ажлын хүрээнд Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулиуд болон холбогдох хууль тогтоомжийг шинэчилнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг. Санал хураалт. /алх цохив/

21.0 хувиар санал дэмжигдсэнгүй.

29.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.3 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“3.3.4.3.Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, хоршооны загвар төслүүдийг бэлтгэх, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий сургагч багш нарыг бэлтгэх, сургалт зохион байгуулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай. Санал хураалт. /алх цохив/

33.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

30.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” гэсэн зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.7 дахь заалт нэмж, дугаарлалтыг өөрчлөх:

“3.3.4.7.Бэлчээрийг зохистой ашилах, хамгаалах үүднээс малчдын өвөлжөө, хаваржааны доорх газрын хоорондын доод зай хэмжээг, мөн гүний худгийн цооног хоорондын доод зай хэмжээг тогтоох, дээрх газруудыг эзэмших, ашиглах эрхийг бусдад шилжүүлэхийг хориглох, арилжихыг хориглох, зөвхөн үр хүүхэддээ өвлүүлдэг байх эрх зүйн өөрчлөлт оруулна.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн. Санал хураалт. /алх цохив/

46.7 хувиар санал уналаа. Санал дэмжигдсэнгүй.

31.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.4.1.1 дэх заалтын “тусгай хамгаалалттай газар нутгийг өргөтгөн,” гэснийг “тусгай хамгаалалттай газар нутгийн” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга. Санал хураалт. /алх цохив/

42.9 хувиар санал уналаа. Унасан санал дэмжигдсэн.

32.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” гэсэн зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.29 дэх заалт нэмэх:

“3.3.4.29.Малчдад эрчим хүчний хэмнэлттэй өвлийн жишиг сууцны загвар түгээж, мэдлэг олгоно.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа. Санал хураалт. /алх цохив/

45.7 хувиар санал уналаа.

33.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.1.1.2 дахь дараах заалтыг хасах.

“4.1.1.2.“Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний II хөтөлбөр” батлуулж, хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

52.4 хувиар санал дэмжигдлээ.

34.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.1.4.Авлигаас олсон орлогыг хураан авч, тухайн орлогыг хүүхэд хамгаалах сан, хүүхдийн эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэн зарцуулна.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара. Санал хураалт. /алх цохив/

54.3 хувиар санал дэмжигдлээ.

35.Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.1.Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах үйл ажиллагаа” зорилтод доор дурдсан агуулгатай 4.2.1.8 дахь заалт нэмэх:

“4.2.1.8.Авлигатай тэмцэх газрын салбарыг 21 аймагт байгуулна.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ. Санал хураалт. /алх цохив/

63.8 хувиар санал дэмжигдлээ.

36.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.13 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.1.13.Нууц мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн орчныг хүний эрхийг дээдлэх зарчимд тулгуурлан тодорхой болгоно.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг. Санал хураалт. /алх цохив/

Саналыг хүчингүй болгоё. Төхөөрөмж гацсан байна. Санал хураалтыг дахиж явуулна. Бэлтгэл хангая.

Бүлгийн дэд дарга Х.Тэмүүжин гишүүнд 1 минут.

Х.Тэмүүжин: Яг энэ асуудал дээр хэрвээ О.Номинчимэг гишүүн саналаа татаж аваад дараагийн хэлэлцүүлэг дээр тодотгоод, найруулгын өөрчлөлт хийхээр Улсын Их Хурлын даргаас алх цохивол манай энэ дээр завсарлага авах шаардлагагүй.

Энэ цаашаагаа санал хураалт яваад хэрвээ Байнгын хороон дээр унасан энэ санал дэмжигдээд босоод ирэх юм бол бүлэг завсарлага авна.

Д.Амарбаясгалан: Энэ санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг үг авч болно.

О.Номинчимэг: Баярлалаа. Анхны төсөл 4.2.1.13 дээр бас учир дутагдалтай найруулгаар ороод ирсэн асуудал байгаа юм.

Тэгээд үүнийг ер нь хууль тогтоомж, тэр Германы эрүүгийн хуулийг харж хийсэн гээд. Түүнийг нь харахаар илүү сайжруулж бичихгүй бол жаахан буруу ойлгогдох ч юм уу, тийм ээ илүү цар хүрээг нь тэлсэн байдлаар ойлгогдохоор байгаа.

Тийм учраас үүн дээр би ийм санал гаргаад, ер нь хүний эрхийг дээдлэх зарчимд тулгуурлаж өөрчлөн найруулах гэсэн санал.

Хэрвээ Х.Тэмүүжин гишүүн өөрөө энэ дээр Улсын Их Хурлын даргаас чиглэл аваад, дахиад гүйцээн

боловсруулах чиглэлээр энэ дээр ажиллаж болно гээд, Улсын Их Хурлын дарга үүнийг зөвшөөрөх юм бол миний хувьд энэ саналаа татаж авахад боломжтой гэж үзэж байгаа.

Д.Амарбаясгалан: Тэгвэл 36 дугаар асуудлыг гүйцээн боловсруулах чиглэлийг Байнгын хороонд өгье. /алх цохив/

37.Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.3.Төрийн албаны реформ” зорилтыг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.3.Төрийн албаны шинэчлэл

4.2.3.1.Хөгжлийн бодлого, чиг үүргийн шинжилгээнд тулгуурласан захиргааны оновчтой, уян хатан, үр дүнтэй, үр ашигтай төрийн албаны бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний төрлийг оновчилж, чадахуйн зарчимд суурилсан чадварлаг, цомхон, төрийн албыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн албан хаагчийн ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үнэлгээний менежментийг сайжруулан, төрийн захиргааны албан хаагчдын тоог үе шаттайгаар зохистой хэмжээнд хүргэнэ.

4.2.3.2.Хяналт шалгалт, хүний нөөцийн аудитын тогтолцоог оновчтой бүрдүүлж, хууль, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээг гүйцэтгэл, үр дүнд суурилан үнэн зөв, бодитой хийж, олон улсын үнэлгээнд нийцүүлнэ.

4.2.3.3.Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг үргэлжлүүлэн эрчимжүүлж, төрийн мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн халах,

иргэн, хуулийн этгээд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй авах нөхцөлийг бүрдүүлнэ.

4.2.3.4.Эрх мэдлийн төвлөрөл үүсгэсэн хууль тогтоомжийг өөрчилж, хөгжлийн чиг хандлага, бүсчилсэн хөгжилд нийцүүлэн, төрийн албаны хууль тогтоомжийн шинэтгэлийг эрчимжүүлнэ.

4.2.3.5.Төрийн албанд ёс зүйн төлөвшлийг бэхжүүлж, ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг бий болгох, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг төрийн бүх шатны байгууллагад хэрэгжүүлэх, төрийн албаны чадамжид суурилсан хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд ёс зүйн хэм хэмжээ, шалгуур үзүүлэлтийг суурь болгоно.

4.2.3.6.Төрийн албан хаагчийг улс төр, удирдлагын хууль бус шийдвэр, аливаа дарамт шахалт, улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх зарчмыг хангах, эвлэлдэн нэгдэж, эрх ашгаа хамтран хамгаалах боломжийг бүрдүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгон, тогтвортой ажиллах нөхцөлөөр хангана.

4.2.3.7.Төрийн албаны хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, чадавхыг бэхжүүлэх, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх, хөгжүүлэх тогтолцоог сайжруулж, төрийн албанд таваас дээш жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн гурван жилд нь “маш сайн” үнэлэгдсэн төрийн албан хаагчийг гадаад улс орны болон ахисан түвшний сургалтад хамруулах чиглэл баримтална.

4.2.3.8.Төрийн албаны сургалтын байгууллагын бүтэц, төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлж, сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.

4.2.3.9.Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны зохистой бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, төрийн албан хаагчийг адил, тэгш боломжоор хангана.

4.2.3.10.Төрийн албаны нэгдсэн тоо бүртгэлийг чанаржуулж, цахим мэдээллийг албан хаагчдад өөрт нь нээлттэй болгох замаар төрийн албан хаагчийн иж бүрэн цахим платформуыг хөгжүүлэн, мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдлыг хангана.

4.2.3.11.Төрийн албанд сэтгэлгээ, дүн шинжилгээ хийх, боловсруулах, монгол хэлийг ярианы болон бичгийн өндөр ур чадвартай иргэнийг сонгон шалгаруулах хэлбэр, эрх зүйн орчныг шинэчлэнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

63.8 хувиар санал дэмжигдлээ.

38.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Төрийн албаны ёс зүйн зарчмуудад үндэслэсэн суурь шалгуур үзүүлэлтийг боловсруулж, төрийн албаны чадамжид суурилсан хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг үнэлж дүгнэнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн. Санал хураалт. /алх цохив/

47.6 хувиар санал дэмжигдсэнгүй.

39.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.3.8.Төрийн албаны сургалтын байгууллагын хөтөлбөрийг төрийн албаны шинэчлэлд нийцүүлж, сургалтын байгууллагын чадавхыг бэхжүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар. Санал хураалт. /алх цохив/

39.0 хувиар санал дэмжигдсэнгүй.

40.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.3.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.3.9.Төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгааны зохистой бодлого баримтлан, орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлнэ. Төрийн албанаас эрт тэтгэвэрт гарч буй иргэдэд хөдөлмөрлөх, бичил, жижиг, дунд бизнес эрхлэх, орлого олох, баялаг бүтээх боломжийг бүрдүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар. Санал хураалт. /алх цохив/

54.3 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг. Горимын санал.

О.Номинчимэг: Дараагийн 41, 42 дугаар саналыг миний бие Төрийн байгуулалтын байнгын хороон дээр гаргасан.

Тэгээд Байнгын хороогоор дэмжигдээгүй энэ саналаа татаж авахыг хүсэж байна. Санал хураалгахгүйгээр татъя.

Д.Амарбаясгалан: 41, 42 дугаар санал Байнгын хороо дэмжээгүй тул Улсын Их Хурал дээр санал хураахаас татаж авч байна. Тийм ээ.

43.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.4.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.4.1.Хотын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг харгалзан боловсруулан батлуулж, үүнтэй уялдуулан төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, зарцуулалтын бодлогыг хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц. Санал хураалт. /алх цохив/

27.6 хувиар санал дэмжигдсэнгүй.

44.Төслийн 1 дүгээр хавсралтын “4.2.4.Орон нутгийн засаглалын бие даасан байдал” зорилтод доор дурдсан агуулгатай 4.2.4.5 дахь заалт нэмэх:

“4.2.4.5.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хуулийг боловсронгуй болгох замаар боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хүн амын тоотой уялдуулан хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар. Санал хураалт. /алх цохив/

44.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Ингээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Ингээд хэлэлцэх асуудлын дарааллаар явж байгаа. 4 дэх асуудлыг бид алгассан байгаа.

Тэгэхээр 4 дүгээр асуудлаа хэлэлцүүлж эхэлье.

Тав. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах

Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах.

зөвлөлийн дарга Лхагвадоржийн Энхбилэг танилцуулна.

Нэр дэвшигчийн талаарх танилцуулгыг Шүүхийн ерөнхий

Индэрт урьж байна.

Л.Энхбилэг: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно” гэж, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт “Ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулснаар томилуулах саналыг Ерөнхийлөгчид хүргүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 104 дүгээр зүйлийн 104.2 дахь хэсэгт “нэр дэвшигчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Хууль зүйн байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд танилцуулна” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчийн сул орон тоонд сонгон шалгаруулалтын нөөцийн оноогоор нэгдүгээрт эрэмбэлэгдсэн нэр дэвшигч Энэбишийн Золзаяаг Улсын Их Хурлын чуулганд танилцуулж байна.

Нэг. Товч намтар.

Энэбишийн Золзаяа нь 1970 онд Улаанбаатар хотод төрсөн. 54 настай. Эмэгтэй. Ам бүл 4. Нөхөр, 2 хүүхэдтэй хамт амьдардаг.

1978-1988 онд Нийслэлийн 18 дугаар сургууль, 1988-1994 онд Оросын Холбооны Улсын Москва хот дахь Нийтийн ахуйн үйлчилгээний улсын академид инженер, техникийн ухааны магистр, 1996-1999 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн эрх зүйч, бакалавр, 2009-2016 онд

Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль Хууль зүйн ухааны магистрын зэргийг тус тус хамгаалсан. Эрх зүйч мэргэжилтэй.

Э.Золзаяа 1999-2024 онд Нийслэлийн шүүхийн Тамгын газар Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, 2004-2006 онд Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгч, 2006-2013 онд Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч, 2014-2015 онд Иргэний хэргийн давж заалдах шатын шүүхийн 10 дугаар шүүхийн шүүгч, 2015 оноос Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатын шүүхийн шүүгчээр ажиллаж байна.

Нэр дэвшигч Э.Золзаяа нь төрийн албанд 24 жил 7 сар, шүүгчээр 19 жил 9 сар. Үүнээс давж заалдах шатын шүүхийн шүүгчээр 10 жил 6 сар ажилласан байна.

Хоёр. Хуульд заасан шалгуур хангасан байдал.

Нэр дэвшигч Э.Золзаяа Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан хяналтын шатын шүүхийн шүүгчид тавих болзол шаардлагыг дараах байдлаар хангасан байна.

Нэг. Хууль зүйн дээд боловсролтой байх. Дээр танилцуулсан. Энэ заалтыг хангасан.

Мөн Шүүхийн тухай хуулийн 31-д 35 нас хүрсэн Монгол Улсын иргэн байхыг шаарддаг. Э.Золзаяа 1970 оны 6 сарын 30-ны өдөр төрсөн, 54 настай, Монгол улсын иргэн байна.

Эүүгийн хариуцлага хүлээж байгаагүй.

Энэ нь Цагдаагийн ерөнхий газрын лавлагаагаар тодорхойлогдоно.

Шүүгчид нэр дэвших үедээ яллагдагчаар татаагүй нь Улсын Ерөнхий прокурорын газрын лавлагаагаар мөн тогтоогдоно.

Шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон эрх бүхий эмнэлгийн мэргэшсэн эмчийн магадлаатай. Мөн эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр тэнцэнэ гэж дүгнэгдсэн.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх.

Нэр дэвшигч Э.Золзаяа хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй.

Монголын Хуульчдын Холбооноос 2014 оны 7 сарын 07-ны өдөр Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл 2194 дугаартай гэрчилгээг шинээр олгогдсон.

Шүүгчээр ажиллах мэдлэг, чадвар, ёс зүйтэй байх.

Нэр дэвшигч Э.Золзаяа хууль зүйн мэдлэг чадварын шалгалтад 54.54 оноо, мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтад 22.17 оноо авч хяналтын шатын шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн.

Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх шаардлагыг хангасан. Нийтдээ шүүгчээр 19 жил 9 сар ажилласан байна.

Сүүлийн 6 жил улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй.

Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчийн гуравны хоёроос дээшгүй нь шүүгч байхыг шаардсан.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн гуравны хоёроос доошгүй нь энэ хуулийн 31.4.1-д заасан шүүгч байна гэсэн шаардлагыг хангасан байна.

Одоогоор Улсын дээд шүүхэд 24 шүүгч ажиллаж байгаагаас 18 шүүгч, 6 нь прокурор, өмгөөлөгч, магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн их дээд сургуулийн багш буюу бусад хуульчдын төлөөлөл ажиллаж байна.

Нэр дэвших Э.Золзаяа шүүгчээр 10-аас доошгүй жил ажиллах шаардлагыг хангасан.

Сонгон шалгаруулалтад тэнцсэн байдал.

Нэр дэвшигч Э.Золзаяа Хууль зүйн мэдлэг чадварын шалгалтад 54.54 оноо, мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтад 22.17. Нийт 76.71 оноо авч тухайн шалгалтад хоёрт эрэмбэлэгдсэн.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны 6 сарын 14-ний 173 дугаар тогтоолоор батлагдсан.

Ингээд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс санал болгох нь.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанд бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн 51

дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.8 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журмын 9.4-д заасныг баримтлан Улсын дээд шүүхийн шүүгчийн сул орон тооны сонгон шалгаруулалтад тухайн үед шалгалтаар хоёрт эрэмбэлэгдсэн нөөцийн оноогоор нэгдүгээрт эрэмбэлэн жагсагдсан хяналтын шатын шүүхийн шүүгчийн нөөц оноотой нэр дэвшигчээс нэгдүгээрт эрэмбэлэгдсэн нэр дэвшигч Энэбишийн Золзаяаг Улсын дээд шүүхийн шүүгчээр томилуулах саналыг Монгол Улсын Их Хуралд танилцуулж байна.

Баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Лхагвадоржийн Энхбилэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Энэбишийн Золзаяа Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч.

Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг танилцуулна.

Г.Уянгахишиг гишүүнийг индэрт урьж байна.

Г.Уянгахишиг: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2024 оны 8 дугаар сарын 08-ны өдөр Улсын дээд шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн нэр дэвшигч Энэбишийн Золзаяаг Улсын Их Хуралд танилцуулахаар ирүүлснийг Хууль зүйн

байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно” гэж заасан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 106 дугаар зүйлд заасан журмын дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Лхагвадоржийн Энхбилэг Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Энэбишийн Золзаяаг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар нэр дэвшигчтэй танилцах үед

Улсын Их Хурлын гишүүн **Б.Бат-Эрдэнэ** нэр дэвшигчээс Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зарласан сонгон шалгаруулалтад авбал зохих хэдээс хэдэн оноо авч тэнцсэн талаар, анхан болон давж заалдах шатын шүүх бүрэлдэхүүнийг тухайн шүүхийн ерөнхий шүүгч дангаар шийдвэрлэдэг эсэх талаар,

Улсын Их Хурлын гишүүн **Х.Тэмүүжин** шинжлэх ухааны академик маргааны асуудлаар Улсын Дээд шүүхийн шүүгчийн хувьд ямар зарчим барьж ажиллах талаар, мөн Улсын Дээд шүүхээс хууль хэрэглээний тайлбар гаргахтай холбоотой асуудлаар,

Улсын Их Хурлын гишүүн **Ц.Сандаг-Очир** шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн шүүгч нарын нөөцийн талаар, давж заалдах болон хяналтын шатын шүүхэд шалгалт өгч орох сонирхолтой шүүгч хангалттай байгаа эсэх талаар, Шүүхийн тухай хууль болон иргэний хэрэг хянан

шийдвэрлэхтэй холбоотой хууль тогтоомжийн талаарх нэр дэвшигчийн байр суурийг,

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал Хуульчдын холбооны талаар болон үндсэн эрхийн маргааны талаарх нэр дэвшигчийн байр суурийг сонсож, асуулт асууж, хариулт авсан.

Мөн Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нэр дэвшигчээс Улсын Дээд Шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн хувьд олон нийтэд хандан шударга ёсны талаарх байр сууриа илэрхийлэхийг хүсэж, Улсын дээд шүүхийн жендэрийн харьцаа, тэнцвэртэй байдлын талаар асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, С.Эрдэнэболд, Х.Тэмүүжин нар нэр дэвшигчид хандан үг хэлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 106 дугаар зүйлд заасны дагуу Улсын Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Энэбишийн Золзаяаг Хууль зүйн байнгын хороонд танилцуулсан талаарх санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар.

Х.Булгантуяа: Нэр дэвшилттэй холбоотой асуулт асуух, үг хэлэх гишүүд нэрээ өгье.

О.Цогтгэрэл, С.Амарсайхан гишүүнээр тасаллаа. П.Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

Ирцээрээ орохоор Л.Мөнхбаясгалан гишүүнийх юм байна шүү. Л.Мөнхбаясгалан гишүүний микрофоныг өгье.

Л.Мөнхсайхан: Э.Золзаяа нэр дэвшигчээс асуулт асууя.

Монгол Улс шударга ёсны хямралд орсон гэдгийг бүгдээрээ хүлээн зөвшөөрдөг.

Энэ дотроо хамгийн муу нэртэй нь хуулийн салбар.

Тэр дотроо шүүх. Шүүгч нар шударга биш. Шүүгч нар захиалгаар алх цохидог гэдэг ийм нийтлэг ойлголт байдаг.

Сая өнгөрсөн сонгуулиар явж байхад хуулийн салбарын болон ялангуяа шүүхтэй холбоотой асар их гомдол иргэдээс санал болгож ярьж хэлдэг.

Тэгэхээр би танаас ийм зүйл асуух гэсэн юм.

Яагаад шүүхийн нэр хүнд ингэж их унадаг юм бол? Энэ яг юундаа байдаг юм? Үнэхээр манай шүүгч нар тэгээд хэн нэгний захиалгаар шүүх хурал дээр хандаад байдаг юм уу? Авлига аваад байдаг юм уу? Эсвэл юунаас болоод энэ салбарын нэр хүнд ингээд уначхав аа?

Та үүнийг буцааж шүүхийн нэр хүндийг дээш нь гаргахын тулд, шударга

байдгаа гэдгийг нотлохын тулд яг ямар байр суурьтай байдаг вэ? Түүнийгээ илэрхийлж өгнө үү.

Х.Булгантуяа: Нэр дэвшигч Э.Золзаяа. Ажлын хэсгийн 5 номерын микрофон байна уу. Тийм ээ. 5 номерын микрофон.

Э.Золзаяа: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Миний бие Энэбишийн Золзаяа нь Монгол Улсын Дээд Шүүхийн шүүгчид нэр дэвшиж байгаа билээ.

Л.Мөнхбаясгалан гишүүний асуултад дараах байдлаар хариулья.

Шүүх хэргийг Үндсэн хууль болон хуульд нийцүүлэн хэрэг маргааныг шийдвэрлэдэг.

Шүүхийн нэр хүнд хаана унаад байна вэ гэдэг ийм асуудал асууж байна. Шүүх нээлттэй, ил тод байдлаар ажиллах ёстой.

Энэ байдлаар өөрийнхөө боломжийн хүрээнд ажиллаж байгаа. Шүүхийн шийдвэр нээлттэй байгаа.

Хэн аль нь уншихад сонирхсон шийдвэрээ олж уншихад нээлттэй. Шүүхийн шийдвэрт үндэслэлийг нь бичсэн байгаа.

Шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх ийм шаардлагыг хангах ёстой.

Шүүхийн шийдвэр ойлгомжтой, тодорхой бичигдсэн тохиолдолд хүмүүс шударга байна уу, шударга бус байна уу

гэдэг шалгуураа өөрсдөө хийчих боломжтой.

Түүнээс гадна шүүх хуралдаан нээлттэй явуулж байгаа. Шүүх хуралдааныг нээлттэй явуулж байгаа учраас хэн сонирхсон этгээд нь шүүх хуралдаанд оролцох боломжийг хангасан байх ёстой.

Харин шүүх өнөөдөр барилга, байшингийн хувьд болохоор асуудалтай байгаа. Үүнийхээ улмаас шүүх хуралдааны танхим хүрэлцэхгүй байгаа. Шүүх хуралдааны танхим хүрэлцэхгүй. Дээрээс нь байгаа шүүх хуралдаанд хэн, аль нь хуулийн дагуу оролцох боломж нь хязгаарлалттай байгаа учраас олон нийт энэ шүүх хуралдааныг нээлттэй явуулах ажиллагаанд бас төдийлөн оролцох боломжгүй байгаа.

Хэрвээ энэ боломж нь хангагдаад, хэн аль сонирхсон хуулийн дагуу саяхан нэмэлт өөрчлөлтөөр орсон процессын хуулийн хүрээнд сурвалжлагч, сэтгүүлчид оролцох, хөндлөнгийн бусад этгээдүүд оролцох боломжийг эрх зүйн хувьд орчныг нь бүрдүүлээд өгчихсөн байгаа.

Гагцхүү одоо өнөөгийн байдлын хүрээнд бэрхшээл байгаа.

Энэ бэрхшээлийг шийдвэрлэх юм бол хэнд ч энэ ажиллагаа нээлттэй хянах боломжтой байгаа.

Түүнчлэн ард иргэдэд Улсын Их Хурлын гишүүн Та бүхэн бас зөв зүйтэй шүүхийн талаарх ойлголтыг бас өгөөсэй гэж хүсэж байна.

Шүүх өөрийнхөө хэмжээгээр шударгаар хэрэг маргааныг шийдвэрлэж байгаа гэж миний хувьд үзэж байгаа.

2023 оны байдлаар шүүх 106 мянган хэргийг хянан шийдвэрлэсэн байгаа. Үүнээс 10 хүрэхгүй хувь нь давж заалдах гомдол гаргадаг.

Тэгэхээр 90 хувийг олон нийт.../минут дуусав/

Х.Булгантуяа: Л.Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя гэж байна.

Л.Мөнхбаясгалан: Асуултыг маань ойлгосонгүй юу? Байшин, барилга нь хүртээмжтэй юу, үгүй юу? Шүүгч шүүх хурал нь нээлттэй явдаг уу, явдаггүй юу? Жилд хэдэн хэрэг шийдсэн бэ гэдгийг асуугаагүй.

Шүүх нэр хүнд муутай байгаа нь үнэн шүү дээ. Үүнийг Та хүлээн зөвшөөрөх үү? Бид яг өөртэй чинь холбогдуулж асуугаагүй.

Үүнийг Та хүлээн зөвшөөрч байна уу, зөвшөөрөхгүй байна уу?

Шүүх үнэхээр шударга юм уу, эсвэл нэр хүнд нь ард түмний дунд уначхаад байгаа юм уу? Үүний төлөө юу хийх вэ? Ямар үзэл бодолтой явдаг вэ?

Шүүхээс ял авсан, оргож зугтаагаад явчихсан шүүгч нар байгаа шүү дээ.

Одоо хүртэл эрэн сурвалжлагдаж байгаа. Салбар ийм байхад салбарыг өнөөдөр энд өмөөрөөд өөр юм яриад байж болохгүй гэж бодож байна.

Тэгээд Улсын Их Хурал шүүхийн нэр хүндийг сэргээх үүрэггүй л дээ. Бид Та бүхний нэр хүндийг сэргээж, олон түмэнд сурталчлах үүрэггүй.

Би тэгэхээр танаас ингэж л асуугаад байгаа юм. Дахиад асуултаа тавья. Шүүхийн нэр хүнд унасан.../минут дуусав/

Х.Булгантуяа: Их тодорхой асууж байна.

Шүүхийн нэр хүнд унаад байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгаа та энэ талаар юу хийх вэ гэдэг асуултыг асуугаад байгаа юм.

Тэгэхээр Их Хурлын гишүүд ард түмний төлөөлөгчийн хувьд иргэдийн дунд ийм ойлголт байгаад байна. Энэ асуултад тодорхой хариулж өгнө үү гэж Л.Мөнхбаясгалан гишүүн асууж байна. Тийм ээ.

Э.Золзаяа: Шүүхийн нэр хүндийн асуудлын хүрээнд одоо энэ шүүхийн талаарх мэдээлэл ард иргэдэд үнэн зөв, бодитой, тэнцвэртэй байдлаар хүргэгдэх ёстой.

Энэ тал дээр анхаарч ажиллана.

Шүүх одоо өнөөдөр ч гэсэн анхаарч ажиллаж байгаа.

510 шүүгч байгаа. Энэ дотор бусдын л адил тийм ээ уулын мод урттай богинотой гэгчээр ганц нэг хүн ийм зөрчил, хэрэгт холбогдсон байхад 510 шударгаар ажиллаж байгаа бусад шүүгчдэд нялзаамааргүй байна.

Мэдээлэл нь үнэн зөв, нээлттэй бодитой байхын хүрээнд шүүхийн тухай хуульд тойм бичих. Өөрөөр хэлбэл энгийн ойлгомжтой байдлаар илэрхийлдэг, тайлбарладаг болж байгаа.

Миний хувьд шүүхийн шийдвэрийг бичих, хууль зүйн тайлбар

гаргах тал дээр чанарыг дээшлүүлэх талаар ажиллана гэж бодож байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат.

С.Эрдэнэбат: Шүүхээр шийдэгдэж байгаа хэргийн 30-аад хувь нь хөдөлмөрийн харилцаатай холбоотой, ажил албатай холбоотой, цалин хөлстэй холбоотой хэргүүд байдаг.

Зарим хэргүүд нь маш их удаан шийдэгддэг. Мөн зарим томоохон хэргүүд 5, 6 жил болдог.

Үндсэндээ бараг шүүхэд өгчихвөл энэ хэргээ 5, 6 жил бүх өөртөө ашигтайгаар эргүүлж болох гэдэг нэг ийм юм яваад байгаа.

Тэгэхээр энэ яг хуульдаа байна уу, эсвэл шүүхийн өөрийнх нь таны түрүүний ярьдаг шүүхийн хүртээмж, байр сав, ийм зүйлүүд байна уу гэдэг дээр Та юу гэж боддог вэ?

Мөн шүүхэд итгэх итгэлийн бас нэг зүйл нь шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болчхоод түүнийг.

Яах вэ, өөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа бас зарим талаар их уддаг.

Шүүхийн гарчихсан шийдвэрүүдийг хэрэгжүүлэх гэж бас дахиад 2, 3 жил, 4, 5 жил болдог.

Ялангуяа зөвхөн цалин хөлсөөрөө ажиллаж амьдарч байгаа хүмүүс шүүхийн энэ удаан процессыг 2, 3 жил хүлээнэ гэдэг бол үр хүүхдээ тэжээх, наад захын өөрийнхөө амьжиргааг авч явах, амьд явах гэдэг энэ эрхүүд нь ингээд зөрчигддөг.

Тэгэхээр энэ тал дээр таны хийхээр боддог зүйл юу вэ. Та анхан болон дунд шатад ажиллаж байсан туршлагатай шүүгчийн хувьд энэ тал дээр яаж ажиллах вэ гэдэг ийм асуулт асууя.

Х.Булгантуяа: Нэр дэвшигч Э.Золзаяа.

Э.Золзаяа: С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулья.

Хөдөлмөрийн эрх зүйн маргаан нийт шийдвэрлэгдэж байгаа иргэний хэргийн 10-аад хувийг эзэлдэг.

Түүнээс давж заалдах гомдол гаргаж байгаа хувь байгаа. Дийлэнх хэргийг мөн өмнө нь хариулсан шиг зөв шийдвэрлэгдэж байгаа.

Дуулиантай хэргүүд буюу томоохон хэргүүд гэж сая хэлээд байгаа. Цөөн тооны хэргүүд удааширч байгаа байдал байгаа.

Хөдөлмөрийн эрх зүйн маргааныг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн процессын хүрээнд хянан шийдвэрлэдэг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль маань 2002 онд батлагдаж хэрэгжиж байгаа. Ер нь хамгийн өөрчлөлт ороогүй хууль мөн.

Энэ удааширч байгаа шалтгаан нь шүүх хуралдааныг хойшлуулж байгаа байдалтай холбож тайлбарлана.

Шүүх хуралдаан хойшлуулж байгаа үндэслэл шалтгааныггааныг жил бүр Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхүүд судалж гаргадаг.

Шүүх хуралдаан хойшлуулж байгаа явдал шүүгч болон шүүхийн ажилтны үйл ажиллагаанаас хамаарч ер нь нэг их хойшилдоггүй байгаа. Хэргийн оролцогчоос холбоотой хойшилдог.

Энэ нь хуульд нь байна уу, хуулийн хэрэгжилт нь байна уу гэдэг энэ асуудлын хүрээнд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд одоо нэг өөрчлөлт оруулаад өгөөч гэж хүсмээр байдаг юм. Шүүгч нар.

Энэ нь ямар өөрчлөлт юм бэ гэхээр урьдчилсан шүүх хуралдаантай болгоод өгөөч ээ. Урьдчилсан шүүх хуралдаантай болгоод өгөхийн ач холбогдол нь юу юм бэ гэхээр урьдчилсан шүүх хуралдаан дээр хэргийн оролцогч нотлох баримтуудаа үндсэн хуралдаанд оруулах бүх нотлох баримтуудаа тохиролцоод авчихдаг юм.

Үндсэн хуралдаанд орох нотлох баримтуудаа тохиролцоод авчихсан тохиолдолд үндсэн шүүх хуралдаан хойшлуулах асуудал яригдахгүй.

Тэгэхээр процессын ийм өөрчлөлт хийгээд өгөөч гэж шүүгч нар бас хүсэж байгаа.

Тэгэхээр шүүхийн зүгээс шүүх хуралдааныг хойшлуулаад шүүгч өвдөөд янз бүрийн байдлаар ажлаа таслаад яваад ингээд шүүх хурал нь хойшилсон ийм тохиолдол байдаггүй юм. Гагцхүү шүүх хуралдааны оролцогчийн зүгээс шүүх хуралдаан дээр нотлох баримт гаргаж өгөх, тэр нь ач холбогдолтой байгаад авах юм бол нөгөө талд нь танилцуулах, шүүх дээр өмгөөлөгч авах, итгэмжлэгдсэн төлөөлөгчөө солих ийм үндэслэлүүдээр шүүх хуралдааныг хойшлуулаад байдаг юм.

Тэгэхээр шүүх хэрэг маргаанаа шийдвэрлэж байгаа оролцогчдын эрхийг хангах үүднээс шүүх хуралдаан хойшлуулж энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширдаг ийм явдлууд байгаа. Тэгэхдээ цөөн тооных шүү.

Одоо нөгөө томоохон хэргүүд дээр л ингэж анхаарал хандуулаад байгаа болохоос биш дийлэнх хэргүүд нь зөв голдирлоороо л явж байгаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага шүүхийн шийдвэрийг биелүүлнэ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага Хууль зүйн яамны харьяа байгууллага.

Нэгэнт шүүхийн шийдвэр гарсан. Энэ нь биелэгдэх учиртай.

Тийм учраас эдгээр байгууллага.../минут дуусав/

Х.Булгантуяа: О.Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Э.Золзаяа шүүгчид юуны түрүүнд амжилт хүсье.

Манай яг энэ шүүхийн системд байгаа нэр цэвэр их ховорхон хүмүүсийн нэг ингээд нэр дэвшээд ороод ирсэнд хуульч хүнийхээ хувьд баяртай байна.

Тэгэхдээ түрүүний Л.Мөнхбаясгалан гишүүний хэлсэн үгийг бодох ёстой.

Өнөөдөр шүүхийн нэр хүнд тааруу байгаа нь үнэн. Шүүхэд захиа даалгавар өгдөг, дээрээс нь нөлөөлдөг, хараат бус байдалд нь халддаг явдал байгаа нь үнэн. Бүгд мэдэж байгаа.

Шударга бусын хонгил гэдэг нэртэй. Тэр хонгилынх нь үзүүрт нь шүүгч, шүүх байдаг.

Үүгээр юу хэлэх гээд байгаа юм гэхээр Та иргэний хэрэг маргаан шийдвэрлэж, яг энэ Эрүүгийн хуулиас хүний эрх, эрх чөлөө, гэмт хэрэгтэй холбоотой асуудлаас ангид явж байсан байна. Таны намтрыг харахад.

Тэгэхдээ Улсын дээд шүүхийн шүүгч гэдэг бол шүүх юм оргил албан тушаал.

Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар маш олон асуудал шийдвэрлэдэг.

Энэ дунд дагнасан шүүх байгуулах. Тэгээд Үндсэн хуулийн цэцэд Монгол Улсын Ерөнхийлөгч, тэгээд тодорхой албан тушаалтнуудын хууль зөрчсөн байж болзошгүй ийм гомдол мэдээллийг гаргадаг, Улсын Ерөнхий прокуророос ирүүлсэн олон асуудлуудад дүгнэлт хийдэг маш чухал үүрэгтэй ийм бүтэц байдаг. Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан гэдэг бол.

Ер нь Улсын Дээд шүүхийн дагнасан танхимууд тэр чиглэлийнхээ бодлогыг тодорхойлж явдаг.

Тэгэхээр би танд захиалсан шинжтэй зүйл хэлэх гээд байгаа юм.

Энэ Улсын дээд шүүхийн шүүгчийн үүргийг гүйцэтгэхдээ зөвхөн шүүн таслах ажиллагаанаас бусдаар шүүхийнхээ нэр хүндийг өндөрт өргөх, хараат бус байдлыг бэхжүүлэх, шүүхийг шударга байлгах энэ үйлсэд сэтгэл санаагаа чилээж, саналаа өгч ажиллаарай.

Маш олон хүмүүс шүүхийн талаар сөрөг ойлголттой байгаа. Шүүхийн нэр хүнд муу байгаа. Энэ зөвхөн Таны саяын хэлж байгаа шиг шүүхийн үйл ажиллагааг бусдад ойлгуулаагүй гэдгээс биш, бас нэлээн олон дутагдал байгаа шүү.

Засгийн газрын зүгээс таны ярьж байгаа иргэний процесс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, энэ бүх зүйлийг боловсронгуй болгох чиглэлээр ажиллана.

Гагцхүү Та Улсын Дээд шүүхийн шүүгч хэмээх нэр хүндтэй албанд ажиллахдаа Монгол Улсын шүүн таслах ажиллагааны нэр хүнд, хууль шүүхийн өмнө эрх тэгш байх Үндсэн хуулийн зарчим, энэ зүйлүүдээ хуульч хүний хувьд, шүүгч хүний хувьд ёс зүй зарчмаа өндөрт өргөж ажиллаарай гэж захъя. Баярлалаа.

Х.Булгантуяа: ОАлтангэрэл сайд үг хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг.

П.Сайнзориг: Баярлалаа. Өнөөдөр холбогдох хууль тогтоомжийн дагуу Улсын дээд шүүхэд нэр дэвшигчтэй бид танилцаж байна.

Тэр дундаа иргэний чиглэлээр буюу хувийн эрх зүйгээр мэргэшсэн хуульч Улсын дээд шүүхэд нэр дэвшиж байгаад юун түрүүнд талархалтай байгаа.

Тэгээд олон гишүүд маань хэлж байх шиг байна. Ер нь шүүхийн нэр хүнд.

Тэгэхээр үүнийг бид жоохон үйлчилгээ талаас нь анхаарч, шүүхийн үйл ажиллагааг сайжруулах, энэ

чиглэлийнх нь хөрөнгө оруулалтын асуудлуудыг Улсын Их Хурал бид ойлгож дэмжиж өгөх ёстой юм.

Өөрөөр хэлэх юм бол энэ шүүхээр үйлчлүүлж байгаа иргэдийн нөхцөл байдлыг анхаарч, шүүхийн барилга, байгууламжийн асуудлыг. Тэнд зөвхөн шүүгч, шүүхийн захиргааны ажилтан гэдэг утгаараа биш, түүгээр үйлчлүүлж байгаа иргэдийн нөхцөл байдлыг бид тооцож энэ шүүхэд өгөх энэ хөрөнгө оруулалтын асуудлуудыг цаашдаа анхаарах зайлшгүй шаардлага нэгдүгээрт байна гэж үзэж байгаа.

Хоёрдугаарт, би нэр дэвшигчээс асуух хоёр асуултынхаа өмнө нэг хэлмээр байна.

Өнөөдөр хуульч бэлтгэх тогтолцоогоо бид эргэж харахгүй болохоо байсан.

Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг хийж чадахгүйгээс өнөөдөр бакалаврын түвшинд төгсөж байгаа хүүхдүүд ерөөсөө нийт үзсэн хичээлийн 20-хон хувь нь бизнесийн хичээлүүд үзэж байгаа. Бизнесийн эрх зүйгээр үзэж байгаа.

Тийм учраас өнөөдөр хуульчид бид бизнес гэдэг юм уу, энэ чиглэлийнхээ үүргийг гүйцэтгэж чадахгүй, нийгэмдээ зохих хэмжээний энэ чиглэлийнхээ үүргийг гүйцэтгэж чадахгүй, хялбарчилж чадахгүй, харилцааг засаж чадахгүй ийм зүйлүүд байна.

Тийм ч учраас иргэний маргаанууд удааширдаг. Энэ чиглэлдээ ойлголтгүй хүмүүс нь Эрүүгийн шүүхээр явах, хандах гэдэг юм уу ийм зүйлүүд байгаа.

Тэгэхээр бид таны бодлыг асууя гэж бодож байна.

Ер нь арилжааны бие даасан хуулиудыг боловсруулах ажил өнгөрсөн хугацаанд явж байсан. Энэ дээр та ямар байр суурьтай байдаг вэ?

Ялангуяа “business to business” буюу “B2B” харилцаан дээр арай ялгамжтай байдлаар бичмэл хууль гэхээсээ илүүтэй бизнесийн тэр үйл ажиллагаанд явагдаж байгаа бизнесийн практикийг үндэслэж тэр бичмэл хуулийн шаардлагаас зарим тохиолдолд эрх ашиг нь хөндөгдөхгүй бол бизнесийн маргаан шийдээд өгдөг баймаар байна.

Тэгэхгүй хууль дээр ингэж бичсэн байна гээд өгсөн авснаа буцаа ч гэдэг юм уу ингээд бизнесийн харилцааг ор тас анхан болон давж заалдах шатны шүүх дээр ингээд гацаачхаад байх юм

Хоёрдугаарт нь, мэдээж дампуурлын эрх зүйн орчин, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын асуудал байгаа.

Тэгэхээр энэ дээр Та бас байр сууриа хэлээч.

Ер нь иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэл, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тогтолцооны хувьд Та ямархуу бодолтой байдаг байдаг вэ? Яаж сайжруулах гэдэг юм уу, энэ зүйлээсээ байр суурь байгаа юу?

Хоёрдугаарт, яах вэ, мэдээж Улсын дээд шүүхийн нэг том үүрэг бол энэ хууль тогтоомжийн нэгдмэл байдал байгаа. Энэ дээр мэдээж томоохон судлаачид, судалгааны арга зүйтэй хүмүүс очиж байгаад би баяртай байна.

Тэгэхээр энэ дээр цаашдаа ахицууд гарах байх гэж бодож байгаа юм.

Тэгэхээр та ер нь зүгээр арилжааны хууль болон энэ “business to business”, “B2B” харилцаан дээрх ялгамжтай байдлаар зохицуулах энэ харилцааг юу гэж боддог вэ?

Хоёрдугаарт, ер нь дампуурал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулиудын асуудал дээр хувийн байр суурь. Энэ дээр ямар асуудлууд тулгамдаж байгаа вэ гэдэг зүйлийг бас хэлээч?

Ер нь бид энэ “**процессын эрх зүй**”-г нь сайжруулж өгөхгүйгээр энэ шүүхийн нэр хүндийг өсгөж чадахгүй.

Өнөөдөр гурван иргэний хэргийн нэг нь бизнесийн маргаан байдаг мөртөө яг иргэний юу гэдэг юм өдөр тутмын маргаан шиг ийм зууралдсан процесстой учраас ерөөсөө маргаан Иргэний шүүхээр шийдэгдэхгүй байгаа.

Хоёр чихнээс өөр авах юмгүй болчихсон хойно нь шийдвэр гарч байгаа учраас шүүхийн шийдвэр биелэхгүй байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ дээр дампуурал буюу төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг анхнаас нь бодож, бас хууль эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгөх энэ ажил чухал байгаа юм.

Тэгэхээр гишүүд маань ч гэсэн энэ чиглэлдээ анхаараасай гэдэг зүйлийг би хүсэж байгаа юм.

Тэгээд нэр дэвшигчээс хариулах бололцоотой бол дээрх хоёр асуултад хариулт өгнө үү гэж хүсэж байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Э.Золзаяа нэр дэвшигчийн микрофоныг өгье.

Э.Золзаяа: П.Сайнзориг гишүүний асуултад хариулья.

Хуульч бэлдэх тогтолцоог эргэж харах болсон гэдэг энэ асуудал дээр би адилхан байр суурьтай байгаа.

Хуульч бэлдэх тогтолцооны хүрээнд хуулийн сургуулиуд 5 жилийн сургалтыг явуулдаг.

Энэ дээр сүүлийн үед ажиглагдаад байгаа зүйл нь энэ эхний 2 жилийн сургалтад ерөнхий эрдэм оруулаад байна. Анагаахын сургуульд 6 жил, 7 жил суралцахдаа цэвэр яг анагаахынхаа чиглэлийн мэдлэгийг эзэмшдэг бол хуулийн сургуульд мөн адил нийгмийн эмчийнхээ хувьд яг 5 жил яг хуулийнхаа мэргэжлийн хичээлүүдийг үзэж явах нь зүйтэй гэдэг ийм байр суурьтай байдаг.

Тийм учраас ерөнхий эрдмийг 2 жил оруулаад байгаа байдал дээр анхаарч өгнө үү.

Тэгэхээр хуульч бэлдэх тогтолцоон дээр энэ нөлөөлөөд байгаа нь харагддаг. Миний бие Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн Практик судлалын танхимд цагийн багшаар ажилладаг.

Тэгэхээр яг энэ системд шилжээд ирсний дараа оюутнуудын мэдлэг нь арай бага болоод ирсэн. Тийм юм ажиглагдаж байгаа.

Тийм учраас яалт ч үгүй хуульч бэлдэх тогтолцоог эргэж харах, түүний суралцаж байгаа тэр эрдмийн хичээлүүдийнх нь бизнесийн эрх зүйн

чиглэлийн хичээлүүдийг ахиу оруулах гэдэг дээр санал нэг байгаа.

Арилжааны тухай хууль дээр арилжааны эрх зүй хөгжиж байгаа. Арилжааны тухай хуулийг шинээр батлахтай холбоотой хуулийн төслүүд явагдаж байгаа. Арилжааны бие даасан хуультай байх уу, эсвэл иргэний хууль дээрээ өөрчлөлт оруулах уу гэдэг энэ шийдлийг Улсын Их Хурал өөрийнхөө эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх байх.

Одоо яагаад энэ арилжааны “B2B” хэлцэл шүүх дээр удаад байна вэ гэдэг асуудлын хүрээнд иргэний хууль дээр байгаа дутмагшил нь юу гэхээр арилжааны хэрэг маргааныг шийдвэрлэх энэ эрэмбийг зөв тогтоогоод өгөөч л гэдэг асуудлууд байна.

Тэгэхээр эрэмбийг зөв тогтоогоод өгөх юм бол энэ хууль хэрэглээн дээр ингээд өөрчлөлтүүд орчихно.

Өөрөөр хэлбэл ямар эрэмбэ. Ердийн хэрэг маргаан шийдвэрлэх **“C2C”** [customer-to-customer] хэлцэл, **“B2C”** [business-to-consumer] хэлцэл шийдвэрлэдэг.

Энэ зарчмаар “B2B” хэлцлүүдийг шийдвэрлэх боломжгүй.

Тэгээд түргэн шуурхай байдалтай холбоотойгоор энэ өөрчлөлтийг иргэний хуульд оруулах эрэмбэ тогтоох замаар, эсвэл арилжааны бие даасан хууль батлах замаар шийдвэрлэх боломжтой.

Миний бие яг хувь судлаачийнхаа хувьд эхний удаа арилжааны бие даасан хуультай байгаасай гэж ерөнхийдөө хүсдэг. Судлаачийн хувьд хариулж байгаа.

Учир нь гэвэл манайх зах зээлд оролцоод.../минут дуусав/

Х.Булгантуяа: П.Сайнзориг гишүүн тодруулга.

П.Сайнзориг: Би Улсын Дээд Шүүхэд ийм дэвшилтэт бодлоготой хүн дэвшиж байгаад таатай байна.

Өнөөдөр бид энэ “B2B” буюу мөнгөний эргэлтийг дэмжсэн энэ харилцааг хууль эрх зүйн болон шүүхийн процессын хувьд дэмжиж өгч байж Монгол Улсад хөрөнгө оруулалт болон бизнесийн харилцаа эрүүлжих бодлого явах юм.

Тэгэхээр энэ дээр арилжааны бие даасан хуультай байх энэ асуудлыг Улсын Дээд шүүх болон бусад судалгааны байгууллагууд чухал үүрэг рольтой байгаа. Энэ хууль хэрэглээний нэгдмэл байдлын хүрээнд өнөөдөр бизнесийн маргааныг захиргааны эрх зүйгээр шийдэж байгаа энэ байдлыг хууль хэрэглээний нэгдмэл байдлын хүрээнд засаж залруулах арга хэмжээг авахыг Танаас би хүсэж байна.

Өнөөдөр хоёр хувьцаа эзэмшигчдийн маргааныг өмгөөлөгч нь гүйж очоод эхлээд улсын бүртгэлийн маргааныг нь захиргааны шүүхэд өгөөд ямар ч тэр бүртгэлийг хүчингүй болгосноороо хоёр хувьцаа эзэмшигчдийн маргаан хэрэггүй болж байгаа байхгүй юу.

Иргэний шүүх дээр маргалдаад л байдаг. Гарсан шийдвэр нь аль хэзээний үр дагаврын хувьд ойлгомжгүй болчихсон.

Тэгэхээр энэ бодлогуудыг үргэлжлүүлэхэд Та идэвхтэй ажиллаарай

гэдэг зүйлийг хүсье. Тэгээд амжилт хүсье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат.

Д.Ганбат: Тэгээд ерөнхийдөө анхан шатад ажиллаж байсан, давж заалдах шатад ажиллаж байсан шүүгч хүн Улсын Дээд Шүүхэд ирж байгаа. Тэр тусмаа эмэгтэй хүн ирж байгаад, 50 гаран насны хүн бололтой. Талархалтай хандаж байна.

Тэгээд анх эхлээд сурч байсан мэргэжил нь хуулийн ч мэргэжил биш байсан юм байна.

Тэгээд дараа нь бакалавр, тэгээд магистр энэ бүх юмыг эзэмшээд явсан ийм хүн байна гэж бодож байна.

Шүүхэд би маш хүндэтгэлтэй ханддаг. Ер нь бүгд тэгж хандах ч ёстой.

Нөгөө талаар шударга шүүхээр шүүлгэх эрх гэж байна. Хүний өөрийн үндсэн жам ёсны эрх нь.

Тэгээд шударга шүүх маань байна уу? Манайд. Үүнээс гадна хараат бус шүүх яг хуулийнхаа дагуу ажиллаж чадаж байгаа юу?

Би хэд хэдэн зүйлийг тодруулмаар байна.

Анхан шат, давах энэ тэр бол бас боломжийн ажиллаад байгаа. Янз бүрийн алдаа дутагдал байдаг байх.

Улсын Дээд Шүүх маань бас нэг намын дарга **LIVE** хийгээд шүүмжилж байна лээ.

Тэгэхээр шүүхийн эцсийн шийдвэр гараагүй болохоор тэд нарыг яг тийм ийм гэж би хэлж чадахгүй л дээ.

Гэхдээ ямар нэгэн байдлаар тийм хариу өгөөгүй ээ. Тэнд одоо бараг л хамааралтай хүмүүс байдаг бололтой л юм яриад л. Ямар нэгэн юманд гэмт хэрэгт оролцчихсон бололтой л зүйлүүдийг ярина лээ.

Энэ тийм юм уу, биш юм уу?

Нөгөө талаар хонгил. Хонгилоор чирэгдлээ. Хонгил үүсгэж чадаад байна гэдэг. Тэр нь ч бас батлагдаж, нотлогдсон.

Өмгөөлөгч нэг нөхөр шүүгч нартай холбогдоод мөнгө төгрөг өгөөд ингээд хамгийн сүүлд л ер нь шүүх дээр л очно шүү дээ.

Шүүх л шударга ёсыг сэргээнэ. Шүүх л хараат бус ажиллана. Энэ юмаа Улсын Дээд шүүх чинь хийж чадах уу? Энд ер нь юу саад болоод байдаг юм бэ?

Нөгөө талаар уг нь хуулиараа энэ шүүхийн төсөв. Нэлээн олон хуулиудыг бид гаргасан л даа. Өнгөрсөн 4 жилд. Чадан ядан юмаа сайжруулах гээд л яваад байгаа. Энэ процесс тасралтгүй явна л даа.

Тэр тусмаа бид 30 жил л жинхэнэ тийм ажиллах ёстой шүүхийнхээ тэр байдалд орж байгаа шүү дээ. Намын харьяалалгүй. Одоо ч тэгж хэлэхэд хэцүү. Гэхдээ бид явж л байна. Туулах ёстой юмаа туулаад.

Шүүгчийн төсвийг Улсын Их Хурал байнгынхаа мэргэжлийн хороогоор ярилцаад л тэгээд ямар нэгэн байдлаар Сангийн яам, Төсвийн байнгын

хороо хасаж саатуулахгүйгээр л явуулах ёстой.

Зүгээр тэрийг нь үзэж хараад л. Гэтэл энэ юм алдагдсан гээд байх шиг байна.

Энэ алдаагаа бид энэ төсвийнхөө ярилцаж байгаа үедээ засаад явна гэж ойлгож байна.

Би ганц нэг хүмүүсээс асуусан. Байнгын хороон дарга нартайгаа ирж уулзсан. Үүнийг засах нь зүйтэй гэж байх шиг байна лээ.

Тэр талаар бас энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга ойлголтоо өгөөрэй. Ямар учиртай юу яаж авах юм бэ?

Бид бас боломжийн мөнгө төгрөгийг нь тавиад ажиллуулах ёстой. Гэхдээ тийм боломжтой мөнгө төгрөг Монгол Улсын хувьд хэцүү байна. Яагаад гэвэл хулгайч луйварчид бүгдийг нь идэж ууж байна. Энэ дээр тэр “Ногоон автобус”, тэр “Хөгжлийн банкны асуудал”. Эцсийн эцэст шүүх дээр л очдог.

Тэгээд та нарын ажиллаж байгаа байдал чинь ийм байна шүү дээ. Энэ хүмүүсийн цалин пүнлүүг нэмүүлэх, энэ бүх юман дээр энэ шударга шүүх чинь, хараат бус шүүх чинь ажиллаад байна уу, ажиллахгүй байна уу? Энэ дээр л ард түмэн хараад бас учир дутагдалтай байна гэж яриад байна.

Үүнийг сайжруулах, яг тэр хууль номд нь нийцүүлж ажиллуулахлаар Та бүхэн маань юу бодож байдаг юм бэ дээ.

Х.Булгантуяа: Нэр дэвшигч Э.Золзаяа.

Э.Золзаяа: Шүүх Үндсэн хуульд нийцүүлэн шийдвэр гаргаж байгаа.

Хүний эрх, жам ёсны эрхүүд хамгаалагдаж байгаа гэж миний зүгээс үзэж байгаа.

Тодорхой хэрэг маргааны хувьд болохоор хариулт өгөх боломжгүй ээ. Улсын Дээд шүүх хариу өгөөгүй гэдгийн талаар одоохондоо миний хувьд болохоор ийм мэдээлэл байхгүй учраас хэлж хариулж мэдэхгүй байна.

“Хонгил” гэдэг энэ нэрийг шүүхээс өгөөгүй. Энэ бол олон нийтийн сүлжээнд тархсан нэр томъёо байгаа.

Тэгэхээр энэ тал дээр хонгил байгаа эсэх гээд хариулт өгөх боломжгүй.

Миний хувьд болохоор Үндсэн хуульд нийцүүлэн үйл ажиллагаагаа эрхэлдэг.

Хараат бус байх, бие даасан байх энэ шаардлагуудыг хангаж ажилладаг.

Цаашид ч гэсэн хангаж ажиллана.

Шүүхийн төсвийн хүрээнд Ерөнхий зөвлөлийн дарга хариулт өгөх үү?

Х.Булгантуяа: 3 номерын микрофон.

Л.Энхбилэг: Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Шүүхийн төсөв жилээс жилд өсөж байгаа.

2021 оны 12 сарын 09-нд 2021 оны 3 сараас эхэлж ажилласан. Шүүхийн

тухай хууль батлагдсантай холбогдуулаад 2021 оны 12 сарын 09-нөөс Шүүхийн ерөнхий зөвлөл бүрэн бүрэлдэхүүнээр 10 гишүүнтэй ажилласан. Үндсэн хуулийн байгууллага болж. Шүүхийн захиргааны төв байгууллага.

Бид анх ирэхэд 74.0 тэрбум төгрөгийн төсөв хүлээж авсан.

2023 онд 90.0 тэрбум болсон.

2024 онд 165.0 тэрбум болсон.

Энд ямар нэгэн хөрөнгө оруулалтын зардал байхгүй. Бүгд урсгал зардал.

2024 онд 19.0 тэрбум хөрөнгө оруулалтын зардлыг тавьж өгсөн. Энэ нь цахимжилттай холбоотой. Нэг барилгажих ажилтай холбоотой.

Х.Булгантуяа: Нэмж гүйцээн хариулахад минут өгье. 3 номерын микрофон.

Л.Энхбилэг: Баярлалаа. Бусад зардал дандаа урсгал зардал. Өөрөөр хэлбэл цалин хөлс л байдаг.

Шүүхийн бие даасан шүүгчийн хараат бус байдлыг хангахад яг энэ санхүү, хөрөнгө оруулалт, төсөв маш чухал.

2013 оноос хойш нэг ч хөрөнгө оруулалт байхгүй.

Одоо бид 2025 оныхоо төсөвтөө хөрөнгө оруулалтын зардлаа тавьж өгч байгаа. Шүүхэд нэг ч стандартын барилга байхгүй. Ихэнх шүүхэд дандаа түрээсийн байранд ашиглалтын зардал төлж байдаг ийм байруудтай. Өөрийн гэсэн 8 л

байртай. Яг үндсэн хөрөнгийн бүртгэлтэй.

Тэгэхээр стандарт бус байранд иргэд маань шүүхийн үйлчилгээ авч байгаа учраас маш их бухимдалтай. Шүүхэд итгэх итгэл үүнтэй бас холбоотой.

Хуралдааны танхимгүйгээс болж хурлууд маш их хойшилдог, хугацаа хэтэрдэг, ажилчид маань тогтворгүй байдаг. Нэн ялангуяа захиргааны албан хаагчид. Сүүлийн үед энэ ихэссэн.

Тэгэхээр гишүүд маань төсөв мөнгөн дээр анхаараад өгнө гэдэгт итгэлтэй байна.

Ерөнхий зөвлөл дунд хугацааны хөгжлийн бодлогоо батлуулсан.

Энэ бол төсөв хөрөнгөтэй, эзэнтэй, хариуцах эзэнтэй, үр дүнтэй, гүйцэтгэлтэй ийм хөгжлийн бодлогыг баталсан.

Бид энэ ажлыг хийнэ гэж хичээж зүтгэж ажиллаж байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн. Тодруулах уу? Тэгье. Д.Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Тэр хонгил энэ тэрийг мэдэхгүй гээд байх юм. Жоохон тийм юм санагдчихлаа.

Энэ чинь тэгээд юу яасан шүү дээ. Гурван шатын шүүхийн шийдвэр нь гараад л ингэдэг. Дараа нь тэгээд л буруу, зөв болоод л ингээд буцдаг иймэрхүү зүйлүүд байгаа байхгүй юу. Танай дээр.

Шүүхийн шийдвэр эцсийнх л байх ёстой шүү дээ. Гурван шатынх явчихсан байхад.

Ямар үедээ яагаад тэгчихдэг юм гэх мэтчилэнгийн. Энэ одоо яагаад ингээд юу оролцоод байдаг юм гэсэн.

Тэр хонгилыг би ярилаа. Бүр яг бодитойгоор ковидын үед ямаршуухан байдалтай байсан бэ энэ тэр гээд олон нийтийн сүлжээгээр бүр бичлэгтэйгээ явж байсан шүү дээ.

Тэр шүүгч нарын оролцож байгаа асуудал. Дараа нь юу болоод дууссан нь.

Ер нь шүүгч нарыг хэн нь шалгаж хянадаг юм? Шүүгч нар хэрэг гаргалаа гэхэд Сахилгын хороо, мэдээж хэрэг Шүүхийн ерөнхий зөвлөл байдаг л байх.

Гэхдээ яг одоо гэмт хэрэг үйлдвэл тэрийг нь хэн шалгаж хянадаг юм. Бүх хуулийн байгууллагуудыг нэг л газар шалгаад байна уу?

Х.Булгантуяа: Э.Золзаяа нэр дэвшигчээс асууж байна уу? Тийм ээ.

Нэр дэвшигч Э.Золзаяа.

Э.Золзаяа: Тийм ээ тийм. Тийм. Бичлэг байгаа гэсэн. Тийм ээ. Сахилгын хороо энэ асуудлыг шалгаад хэргийг хэрэгсэхгүй болгоод шийдвэрлэхсэн байгаа.

Сахилгын хороо яагаад ийм шийдвэр гаргаснаа өөрөө тайлбарлах байх.

Тийм учраас Сахилгын хорооны өмнөөс би хариулт өгч чадахгүй байна.

Гурван шатын шүүх шийдвэр гаргадаг, буцдаг гэдэг асуудал нэг хэрэг дээр гарсан.

Хэргийн талаар би Шүүхийн тухай хуульд зааснаар тайлбар өгөх боломжгүй байна.

Х.Булгантуяа: Уг нь манай хэд хэдэн гишүүдээс ялангуяа шүүхэд иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд, шударга болгоход юу хийх ёстой вэ. Та Улсын Дээд шүүхэд нэр дэвшиж байгаа хүний хувьд.

Хууль нь болохгүй байна уу, хөрөнгө төсөв нь болохгүй байна уу, хүний нөөц нь болохгүй байна уу. Бид яаж дэмжих вэ гээд асуугаад байхаар Та ерөөсөө хонгил гэж байхгүй ээ. Би мэдэхгүй. Хариулт өгч чадахгүй. Энэ бол сошиалын л өгсөн нэр. 510 шүүгч байгаа. Уулын мод урттай богинотой. Нэг их асуудал ер нь байхгүй дээ гэсэн байдлаар хариулаад байгаад л түрүүн Л.Мөнхбаясгалан гишүүн, сая Д.Ганбат гишүүн, С.Эрдэнэбат гишүүн нэлээн олон гишүүдүүд дахин дахин тодруулж асуугаад байна л даа.

Дараагийн асуулт дээрээ Та нэмээд хариулаад явчхаарай.

О.Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Шүүхэд болоод шүүх тогтолцоонд иргэдийн итгэх итгэл гэдэг асуудал байнга л яригддаг.

Зөвхөн ингээд яригдах төдийгүй, сая би олон улсын индексийг нь үзэж байна л даа.

Хуулийн засаглалын индекс гээд. “Rule of Law” гээд индекс байдаг юм байна. Үүгээр 142 орноос манайх 2016

онд 55 дугаар байранд 0.54 оноогоор орж байж, 2020 онд 57 дугаар байр болж ухарч, 2023 онд 64 дүгээр байранд орж ухарч.

Тэгэхээр зөвхөн бидний ярьдаг зүйл, социал дээр ярьдаг зүйл төдийгүй энэ хуулийн засаглалын үзүүлэлт чинь олон улсын хараат бус байгууллагын үнэлгээгээр Монгол Улсыг 142 орноос ингээд жил бүхэн. Сүүлийн 2016 оноос гэхээр сүүлийн 8 жилд үндсэндээ жил бүхэн байр ухарсан байна л даа.

Тэгэхээр үүнийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн төлөөллийг таныг бас энэ дээр тодорхой мэдээлэл өгөөч?

Энэ ямар үзүүлэлт. Шүүхэд иргэдийн итгэх байдал гэдэг чинь зөвхөн бидний санаа бодол биш яг индексээрээ ингээд. Энд ямар дүгнэлттэй байдаг юм? Аль үзүүлэлтүүд нь хойш татаад байдаг юм? Юун дээр нь яаж анхаарч байгаа юм?

Тэр тусмаа бид шударга ёс, авлига гэж ярьсан сүүлийн жилүүдэд чинь бүр илүү дордчихож байна.

Тэгэхээр энэ дээр нэг хариулт өгөөч.

Нэр дэвшигч өөрөө шүүгчээсээ гадна багш байсан хүн учраас би энэ талын статистик талаас нь асуух гээд байна.

Дахиад энэ шүүхэд иргэдийн итгэх итгэлтэй холбоотойгоор анхан шатан дээр хэчнээн хэрэг шийдэгддэг юм? Энэ нь ингээд давдаг. Давахад шийдвэр магадгүй зарим нь батлагдаж гараад, зарим нь эсрэгээрээ гардаг байх.

Дахиад Дээд шүүхэд очиход бас тодорхой хэмжээгээр өөрчлөгддөг байх.

Энэ үзүүлэлтүүдийг бид ер нь юу гэж эндээс дүгнэж болох ёстой вэ? Батлагдаад байгааг нь шүүх шударга шийдээд байна гэх юм уу, эсрэг гараад анхан шатын шүүхийг давах шүүх дээр очоод нөгөө талд нь шийдэхийг бас үүнийг шударга гэж хэлэх нэг хэсэг байна.

Нөгөөдөх нь захиалгаар шүүчихлээ. Яагаад гэвэл яг энэ шүүх тогтолцоо чинь нэг хуулийг хоёр өөр янзаар ингэж унших уу, хууль хоёр өөр янзаар ашиглах уу гэдэг зүйл, заалт гээд олон зүйлүүд үүний цаана яригдана. Үүний цаана чинь дахиад тэр нөгөө шүүхэд иргэдийн үл итгэх итгэл, олон олон зүйлүүд үүний цаана явдаг байх.

Тэгэхээр нэр дэвшигч та яг энэ тоо статистикуудыг дурдаад, үүн дээр ер нь ямар дүгнэлт эндээс бид хийж болох юм? Мэдээж үүний цаана шүүгчийн хараат бус байдал, бие даасан байдал олон зүйл байдаг байх л даа. Мэдээж байдаг байх.

Тэгэхдээ л энэ чинь бас нэг тоо баримт, энэ статистик чинь нэг тоо баримт харуулж илэрхийлэх байх л даа.

Тэгэхээр энэ дээр нэр дэвшигчийг байр сууриа илэрхийлж өгөөч. Мэдээлэл өгөөч ээ гэж хүсэж байна.

Х.Булгантуяа: Э.Золзаяа нэр дэвшигчийн микрофоныг өгье. 5 номер.

2023 оны шүүхийн статистикийн хүрээнд иргэний хэрэг 63 мянга 407 хэрэг шийдвэрлэгдсэн. Нийт шийдвэрлэгдсэн хэргийн 60 хувийг эзэлдэг.

Үүнээс 3110 хэрэг давж заалдах шатын шүүх хуралдаанаар орж шийдвэрлэгдсэн. Энэ нь иргэний хэргийн 4.9 хувийг давж заалдах гомдол гаргасан.

Тэгэхээр 95.1 хувьд давж заалдах гомдол гаргаагүй. Шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн.

Хяналтын журмаар энэ 3111 магадлалыг давж заалдах шатын шүүхийн шийдвэрийг магадлал гэж нэрлэдэг. 244 нь хяналтын шатын шүүхээр хэлэлцэгдсэн байгаа.

Тэгэхээр энэ тоон үзүүлэлтээс 3110-аас 244-ийг хасах юм бол 2600 гаруй хэрэгт хяналтын журмаар гомдол гаргаагүй.

Эрүүгийн хэргийн хувьд 2023 онд 14 мянга 202 хэрэг шийдвэрлэгдсэн.

Энэ нь нийт хэргийн 13 хувийг эзэлж байгаа.

Давж заалдах шатын гомдол болох 2215 гомдол гаргасан. Энэ хэргийг давж заалдах журмаар шийдвэрлэсэн. Нийт эрүүгийн хэргийн шийдвэрлэсний 15 хувьд нь давж заалдах гомдол гаргажээ.

Өөрөөр хэлбэл 85.0 хувьд нь гомдол гаргаагүй ээ. Шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ ээ.

Энэ 2215 магадлалаас 164 магадлал Улсын дээд шүүхийн хяналтын шатын шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн байгаа.

Захиргааны хэргийн хувьд 2023 онд 2371 хэрэг шийдвэрлэсэн. Энэ нийт хэргийг нь 2 хувьд эзэлдэг.

Давж заалдах журмаар энэ 2371 хэргээс 1677 хэрэг буюу 70.0 хувь нь гомдол гаргаж захиргааны давж заалдах шатны хэрэг шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн.

Энэ магадлалаас 100 нь хяналтын журмаар хэлэлцэгдсэн байгаа.

Саяын тоо хэмжээнээс Та нар дүгнэлт хийх боломжтой гэж үзэж байна. Үүнд зөрчлийн буюу хуучин хэллэгээр захиргааны хариуцлагын хэрэг 26 мянга 248 хэрэг шийдвэрлэгдсэн. Нийт хэргийн 25 хувь байгаа.

Үүнээс эс зөвшөөрч 723 гомдол гарсан. 723 зөрчлийн хэргийг давж заалдахны шүүх шийдвэрлэсэн. Энэ нь нийт зөрчлийн хэргийн 2.7 хувь.

Тэгэхээр 97.3 хувьд нь гомдол гаргаагүй гэж. Тоон үзүүлэлт ийм байна.

Олон улсын индекс бол энэ судалгаа. Судалгааны хүрээнд доогуур байна. Энэ доогуур байгаа нь шүүхэд иргэдийн итгэх итгэл доогуур байгаа гэж хэлж байгаатай Та бүхэнтэй санал нэг байна.

Үүнийг яаж сайжруулах вэ гээд. Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж Улсын Их Хурал баталсан байгаа.

Өнөөгийн байдлаар зарим хэргийг бодитоор шууд дамжуулж байгаа. 2025 оны.../минут дуусав/

Х.Булгантуяа: О.Цогтгэрэл гишүүн нэмж тодруулъя.

О.Цогтгэрэл: Би зөвхөн саяын статистикуудаас нэг ийм зүйлийг л таныг илүү тодотгож хэлээсэй гэж хүсэж байна л даа.

Жишээ нь, иргэний хэрэг дээр 3 мянган гомдол давж заалдсан байна шүү дээ. Энэ 3 мянган гомдол өмнөх анхан шатын шийдвэрээсээ баталж гарсан юм уу, эсрэг гарсан юм уу?

Энэ 3 мянгаас 244 нь хяналтын шатаар орсон юм байна шүү дээ. Энэ чинь одоо бүгдийг нь авахгүй. Дээд шүүх чинь өөрөө бас өөр болчихсон байх.

Энэ нь өөрөө баталж гарсан юм уу, эсрэг гарсан юм уу? Энэ чинь өөрөө бас тийм нөхцөл байдлыг хууль хэрэглээ, аль эсвэл хуулийг захиалгаар ажиллаж байна гээд олон зүйлүүдийг үүний цаана илэрхийлэх ёстой байх гэж. Энэ дээр нэг тодотгол хэлээч.

Тэгээд тэр индекс дээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн төлөөллөөс тэрийгээ хариулж өгөөч ээ гэж.

Х.Булгантуяа: Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг хариулах уу?

Л.Энхбилэг: Монгол Улсын шүүхийн шүүхэд итгэх иргэдийн итгэлтэй холбоотой олон улсын индекс байдаг.

Үүгээрээ манайх жил бүр байр доошилсон байдалтай.

Шүүхийн ерөнхий зөвлөл өөрөө жил бүр бас шүүхэд итгэх иргэдийн итгэлийн судалгааг хийдэг. Хоёр янзаар хийж байгаа.

Шүүхээр үйлчлүүлсэн иргэдээс. Мөн шүүхээр үйлчлүүлээгүй иргэдээс гээд.

Тэгэхээр шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн хувьд 64.1 хувь нь шүүхэд итгэдэг. Шүүхийн шийдвэр үндэслэлтэй гарсан гэдэг. Мөн “Нээлттэй нийгэм форум”-аас жил болгон ийм судалгаа авдаг. Энэ судалгаа нэлээн өргөн хүрээтэй хийгддэг.

Энэ дээр хамгийн сүүлийн 2022 оны 54.7 гэсэн. Иргэд шүүхэд 54.7 хувьтай итгэж байна. Шүүхийн шийдвэр үндэслэлтэй гарч байна гэсэн ийм индекс байдаг.

Х.Булгантуяа: Нэмэлт хариулт авах уу? О.Цогтгэрэл гишүүн. Минут нэмж өгөх үү?

Нэр дэвшигчээс нэмж маш тодорхой хариулмаар байна.

Э.Золзаяа: 2023 оны байдлаар иргэний 3111 хэрэг давж заалдах шатын журмаар хянан шийдвэрлэгдсэн байгаа.

Одоо яг процентыг нь би шууд санахгүй байна.

Тэгэхдээ 35 орчим хувь нь хэвээр үлддэг. Хууль хэрэглээний болон тооцооллын өөрчлөлт орж байгаа хэргүүд нь бас нэг 35 хавьцаа.

Тэгэхээр 30 орчим хэргийг процессын зөрчилтэй гээд дахин шийдвэрлүүлэхээр буцаасан ийм ойролцоо тоо хэлье дээ.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн, Шадар сайд С.Амарсайхан.

С.Амарсайхан: Гишүүд нэр дэвшигч болон Шүүхийн ерөнхий зөвлөлөөс маш тодорхой асуултууд,

хүлээлтүүдийг хүсээд байна л гэж ойлгож байна.

Тухайлах юм бол ер нь энэ шүүхийн шинэчлэлийн үйл явцад шүүгчдийн үүрэг хариуцлага маш чухал шүү гэдгийг. Өөрөөр хэлбэл шүүхийн шинэчлэл өөрөө хууль дүрэм журмын өөрчлөлтөөс гадна шүүгчдийн өөрсдийнх нь хандлага, харилцаа, ёс зүй, ажил үүргийн арга барил, шүүхийн шатанд яваа хэрэг маргааныг шийдвэрлэх явцад ил тод байдлыг хангах чиг үүрэгтэй шүү гэдгийг.

Тухайлах юм бол яг одоо хэрэг маргааныг шийдвэрлэх үедээ үнэн зөвийг эрхэмлэж чадаж байна уу. Нөгөө бидний хүсээд байдаг шударга ёсоо сахиж чадаж байна уу, олон нийтийн хүлээгээд байдаг нөгөө ёс зүйн хэм хэмжээгээ баримталж чадаж байна уу, чандлан сахиж байна уу, олон нийтийн итгэлийг хүлээхүйц үйл ажиллагаагаа ил тод явуулж байна уу гэдэг ийм асуудлыг л илүү их тод тодорхой асуугаад байна гэж бодоод байна.

Тэгээд шүүхийн шинэчлэл харьцангуй бодитой хийгдэж байгаа.

Зарим нэг асуудлууд анхаарал шуугиан дэгдээсэн зүйлүүд байгаа.

Гэхдээ үүний хажуугаар шударга, ажлаа хариуцлагатай, нэр төртэй хийж байгаа олон зуун шүүгчид байгаа гэдэгт би эргэлздэггүй.

Хэд хэдэн зүйл дээр манай Шүүхийн ерөнхий зөвлөл цаашаа анхаарах, дээрээс нь зохион байгуулалтаа хийх зайлшгүй шаардлага байна гэж харж байна.

Яагаад ийм асуултууд ирээд байна. Яагаад олон нийт, улс төрчдөөсөө эхлээд эргэлзээд байна гэдэг.

Би шүүхийн байгууллага хуульд нийцүүлэн, нотлох баримтад үндэслэн аливаа улс төр, хөндлөнгийн дарамт шахалт, эсвэл нөлөөллөөс ангид үйл ажиллагаагаа явуулах ийм боломж нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө аль шатдаа шүүхийнхэн анхаарч байгаа, ахиц дэвшиц гарч байгаа гэж үзэж байгаа.

Ганцхан энэ дээр шүүгчид маань юун дээр анхаарах ёстой байна гэхээр энэ хэрэг маргааныг шийдвэрлэх явцынхаа ил тод, нээлттэй байдлыг хангах, тайлагнах үүргээ жоохон дутуу хийгээд байна уу даа.

Энэ тайлагналын хариуцлага гэдэг энэ тогтолцоогоо шүүхийн шинэчлэлийн хүрээнд өөрсдөө хийгээгүй. Дээрээс нь өөрсдийнхөө шүүгчдийн дунд туршлага солилцож байгаа, хэрэг шийдвэрлэх сайн арга туршлагаа ярилцдаг боловч олон нийтийн хүрээнд мэдээ мэдээлэл дутуу хүргээд байна уу даа.

Тэр хэрээрээ энэ шүүхийн нэр хүнд унаж байгаа. Тэр дунд нь бас далимдуулсан цөөхөн хэдэн шүүгчдийн ашиг сонирхлын асуудал байдаг учраас тэр нь анхаарал татсан хэвээр байна гэж хараад байгаа юм.

Тийм учраас энэ тайлагнах үүргээ, манай шүүгчид хуулиар хүлээсэн үүргүүд ч бий, ёс суртахууны хувьд хүлээсэн үүргүүд ч бий.

Ойлгомжтой. Гаргасан шийдвэрээ ойлгомжтой бөгөөд ил тод, нээлттэй шаардлагатай үед нь тайлагнаж, эргэлзээг нь тайлахгүй цахим дээрээ тавиад

орхичихдог учраас бас ийм асуудлууд гараад байгаа байх.

Хоёрдугаарт, энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийг ажил үүрэгээ бүрэн гүйцэтгэх талаас нь төсөв, санхүүгийнх нь талаас бид анхаарахгүй бол байр саваар нь хангаж, сандал ширээгээр нь хангаж бүрдүүлж өгөөгүй байж бас шударга ёсыг биелүүл гэж шахах эрх нь, үүрэг нь байгаа боловч нөгөө талаараа бүтээмжийг бий болгох тэр боломжийг нь бүрдүүлж өгч чадахгүй байгаа.

Улсын Их Хурал дээр орж ирдэг төсөв нь хасагддаг.

Хуульд байна шүү дээ. Ер нь орж ирсэн төсвийг хэвээр нь батлах ёстой гээд.

Энэ үүргээ ч гэсэн манай Их Хурлын эрх, үүргийн хүрээнд анхаарах ёстой гэж бодож байгаа.

Гуравдугаарт, энэ шүүхийн цахимжилтын асуудал.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. /алх цохив/

Улсын Их Хурал Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчидтэй танилцлаа. /алх цохив/

Баярлалаа. Дараагийн асуудалд оръё.

**Зургаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн
2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай
хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл
/Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэх асуудал. Зургаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын

хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тилеуханы Аубакир танилцуулна.

Индэрт урьж байна.

Т.Аубакир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны

төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх үед

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Г.Тэмүүлэн нар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан төсвийн тусгай шаардлагын зохицуулалт болон хуулийг дагаж мөрдөх, хэрэгжүүлэхтэй холбоотой заалттай хэрхэн уялдаж байгаа талаар, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх хуулийн шаардлагатай нийцэж

байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед эдгээр хуулийн төслүүдийг Байнгын хороо нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгээс нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг бууруулах замаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 2025-2026 онуудад 2 хувь хэвээр байх нь зүйтэй гэж үзэн холбогдох тооцооллын хийж, эдийн засгийн зарим үзүүлэлтэд өөрчлөлт оруулан нийт 6 зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Харин Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Б.Жаргалан нар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах, Ардчилсан намын бүлгээс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3-д заасан тусгай шаардлагыг өөрчлөхгүй хэвээр үлдээх нь зүйтэй гэсэн зарчмын зөрүүтэй санал тус тус гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар хууль зүйн дүгнэлт гаргуулахаар Төсвийн байнгын хорооноос Улсын Их Хурлын Тамгын газарт 2024 оны 8 дугаар сарын 19-ний өдөр хүсэлт гаргасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэр томъёоны тодорхойлолт нэмсэн, өөрчлөн найруулахаар заасан нь тухайн хуулийн зарим заалтад нэр томъёоны зөрчил үүсгэхээр байгаа талаар хууль зүйн дүгнэлт гаргасан байна.

Уг хууль зүйн дүгнэлттэй Байнгын хорооны хуралдаан дээр танилцан нийцүүлэх арга хэмжээг авсан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Лувсаннъямын Гантөмөр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Равсалын Ринчинбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн Засгийн газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Очиржанцангийн Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.
/алх цохив/

Хоёр намын бүлгээс нэрс ирсэн байгаа.

Гэхдээ энэ удаа нэрс ирүүлэхдээ хуульд заасны дагуу хугацаандаа хоёулаа багтаж ирүүлээгүй.

Тэгээд энэ удаадаа Их Хурлын даргын зүгээс намын бүлгүүдэд сануулга болгож хэлж байгаа.

Өмнөх өдрийн 16.00 цагаас өмнө асуулт асуух, үг хэлэх гишүүдийн нэрсийг ирүүлэх учиртай.

Дараагийн удаа цагаасаа хоцорсон намын бүлгийн нэрийг хүлээж авах боломжгүй гэдгийг албан ёсоор хэлье.

Тэгээд өнөөдөр сануулга өгсөн учраас ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлүүлье, асуулт асуулгая.

Ирсэн нэрсийн дагуу ирсэн ирцээрээ Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууна.

Ж.Баярмаа: Би энэ юун дээр өгөөгүй юм. Энэ андуурал болсон байх шиг байна.

Д.Амарбаясгалан: Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан макро эдийн засгийн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал үндэслэж боловсруулах ёстой гээд хуульдаа заачихсан байгаа.

Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдээс асуух асуулт байгаа нь, энэ удаагийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөлөл нь Та бүхний

гаргаж өгсөн макро эдийн засгийн үзүүлэлт, суурь дээр үндэслэсэн үү? Энэ дээр зөрүүтэй асуудал байгаа юу гэж тодруулмаар байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт ерөнхийдөө Баялгийн сангаас Хуримтлалын сан бүрдүүлнэ гээд заачихсан байгаа.

Тэгэхээр 2025, 2026 оны төсвийн төсөөлөл дээр “хүн бүрт нийгмийн даатгалын хуримтлалын санг бүрдүүлнэ” гэж заасан байгаа. Эндээсээ эрүүл мэнд, боловсрол, орон сууцын чиглэлээр тодорхой зарцуулах боломжтой байхаар тусгачихсан байгаа.

Тэгэхээр 2025, 2026 оны төсвийн төсөөлөл дээр энэ талаар ямар дүнгээр тусгасан байгаа вэ? Энэ тал дээр мэдээлэл өгөөч гэж Сангийн яамнаас асуумаар байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ажлын хэсгийн 8 дугаар микрофон.

Ж.Дэлгэрсайхан: Улсын Их Хурлын эрхэм гишүүд Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Саяын асуулт бол яг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн энэ 2025 оны төсвийн жилээс хэрэгжих эрх, үүрэгтэй холбоотой асуултыг асуулаа.

Бид яг энэ 2024 оны 01 сард орон тооны болж томилогдсон.

Тэгээд 2023 оны 7 сарын 07-нд орсон төсвийн тогтвортой байдлын тухай

хуулийн төсвийн эрх зүйн орчны өөрчлөлтөөр бид саяын гишүүний асуусан макро эдийн засгийн таамаглалыг гаргаж өгөх ийм үүргийг хүлээсэн байгаа.

Энэ үүргийнхээ дагуу бид 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026, 2027 оны төсвийн төсөөллийн талаарх макро эдийн засгийн мэдээллийг 3 сарын 15-нд Эдийн засаг, хөгжлийн яаманд хүлээлгэж өгсөн.

Тэр бол 2025 онтой хамааралтай асуудал.

Яг одоо орж ирж байгаа төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл нь 2024, 2025, 2026 онтой холбоотой учраас яг тэр макро эдийн засгийн төсөөллийг баримжаалах ёстой ийм төсвийн хүрээний мэдэгдэл одоо орж ирээгүй байгаа гэдгийг тодруулж хэлье.

Тийм учраас 2025, 2026, 2027 оны бидний гаргаж өгсөн мэдээлэлтэй шууд нийцэх албатай ийм төсвийн хүрээний мэдэгдлийг одоогоор бид хэлэлцээгүй байгаа гэж бидний зүгээс үзэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сангийн яам хоёр дахь асуултад хариулт өгье.

Төсвийн бодлогын газрын дарга М.Санжаадорж. 2 дугаар индрээс хариулт өгнө.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. Л.Соронзонболд гишүүний асуултад хариулъя.

2024 оны хувьд хуримтлалын санд 499.0 тэрбум төгрөг төлөхөөр тусгасан байгаа.

Энэ сан түрүүн таны дурдсанчлан боловсрол, эрүүл мэнд, орон сууцын чиглэлд зарцуулахаар хуульчилсан байдаг.

Ирэх оны хувьд энэ дүн одоогийн байдлаар 197.0 тэрбум төгрөгийн санхүүжилт гэсэн тооцоо “Эрдэнэс Монгол” компаниас урьдчилсан байдлаар ирээд байгаа.

Төсвийн хүрээний мэдэгдэлд бас энэ дүнгээр ингээд тусаж байгаа. Мөн түүний дараа жилд бас тэгж тусаж явж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан:

Л.Соронзонболд гишүүн. Тодруулга.

Л.Соронзонболд:

Тэгвэл одоогийн орж ирж байгаа төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн таамаглалыг Эдийн засаг, хөгжлийн яам гаргасан уу, эсвэл Сангийн яам өөрсдөө гаргасан уу гэдэг асуулт байна.

Д.Амарбаясгалан: 2 дугаар индэр. М.Санжаадорж хариулъя.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж.

Одоогийн Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар макро эдийн засгийн бодлогын төлөвлөлт асуудал Эдийн засаг, хөгжлийн яамны эрхлэх асуудалд хүргэж байгаа.

Мөн Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн тоог үндэслэж макро эдийн засгийн тооцооллыг хийж, энэ тооцооллынх нь

дагуу Засгийн газарт уг асуудлыг Эдийн засаг, хөгжлийн яамнаас танилцуулахаар байгаа.

Сангийн яамнаас энэ тоон дээр ирсэн тоон дээр нь үндэслэж нийт орлого, нийт зарлага, мөн тэнцлийн тоогоо энэ тооцоон дээрээс өмчилж гаргадаг. Баярлалаа.

Д.Амарбаясгалан:

Жаргалсайханы Золжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Золжаргал: Энэ дээр нэр андуурч өгсөн байна.

Р.Батболд гишүүн асуултаа асууя. Алга байна. Г.Лувсанжамц гишүүн асуултаа асууя.

Г.Лувсанжамц: Төсвийн тодотгол, тогтвортой байдлын хуулийн өөрчлөлтийн талаар анхааралтай уншиж танилцсан бөгөөд зарчмын хувьд дэмжиж байгаа.

Манай улс албан ёсоор дунджаас доош орлоготой улсаас дунджаас дээш орлоготой руу шилжээд ер нь хөгжлийн ангилал ахиж байгаа.

Одоогийн төсвийн дүрмүүд нь танилцуулгыг харахад 2010 онд дөнгөж уул уурхайн эдийн засаг эхэлж байх үед гарсан.

Тэгээд түүнээс хойш 14 жил өнгөрчихсөн байгаа болохоор одоо энэ Засгийн газрын хөтөлбөрт байгаа хөгжлийн бодлоготойгоо уялдуулаад, шинэчлээд боловсронгуй болгоод явах нь зүйтэй гэж бодож байгаа.

Нөгөө талаас “газрын тос боловсруулах үйлдвэр”,

“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц”, “нийслэлийн төв цэвэрлэх байгууламж” гээд хөгжлийн томоохон төслүүдийг хурдан хэрэгжүүлж дуусгахад одоогийн төсвийн хязгаарлалтад тулаад хүндрэл учраад байна гэж ойлгосон.

Тиймээс эдгээр асуудлуудыг шийдэх нь зүйтэй гэж бодож байна.

Сангийн яамны мэргэжлийн баг өөрсдөө бас ийм төсвийн сахилга батыг сулруулах, эдийн засаг төсвийн тогтворгүй байдлыг үүсгэх ийм төсөл барьж орж ирэхгүй байх гэж бодож байна.

Энэ дээр Сангийн яам байр сууриа илэрхийлэхийг хүсэж байна.

Тэгээд хоёр асуулт байна.

Эхнийх нь, төсвийн дүрмүүдийн шинэчлэл нь олон улсын жишигт ер нь хэр нийцэж байгаа юм бол оо?

Бусад улс улс орны туршлага ямар байдаг талаар ингээд харьцуулаад хариулж өгөөсэй, ойлгуулж өгөөсэй гэж хүсэж байна.

Хоёрдугаар асуулт нь, нэгдсэн тэнцэл гээд 2 хувиар жил болгон ингээд хураагаад түүнийгээ зээлээ төлөөд эргээд явна гэсэн тийм байдалтай байгаа нь надад их зөв зүйтэй заалт шиг санагдсан.

Тэгээд энэ долоо хоногийн эхээр хэлэлцэх эсэх дээр зарим гишүүд төсвийн хяналтыг сулруулаад байна гээд хэлж байсан.

Үнэхээр ийм сахилга батыг сулруулж байгаа зүйл байгаа юм уу? Эсвэл илүү сайн хяналттай болоод байгаа

юм уу? Энэ талаар нийт гишүүддээ ойлголт өгөөсэй гэхийг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Хэн хариулт өгөх вэ?

Төсвийн байнгын хорооны дарга, ажлын хэсгийн дарга Ц.Даваасүрэн гишүүн хаана байна. Хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Төсвийн тогтвортой байдлын хуульд байгаа төсвийн шалгуурууд дотор хоёр өөрчлөлт хийж байгаа.

6.1.2-ын тэнцвэржүүлсэн тэнцлийг суурь тэнцэл.

Мөн 6.1.3-т байгаа нөгөө уул уурхайн бус бүтээгдэхүүний дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувьтай харьцуулсан харьцаа гэсэн ийм өөрчлөлтийг төсвийн урсгал зардал дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй гэсэн ийм хоёр шалгуур үзүүлэлтээр өөрчилж байгаа юм.

Тэгээд тэр суурь тэнцэл гэдэгт төсвийн зарлагад одоо байгаа зээлээр санхүүжиж байгаа зардлыг тусгахгүй байя гэдэг л ийм ойлголт л доо. Зээлээр санхүүжиж байгаа зардлыг.

Тэгэхээр зээлээр санхүүжиж байгаа зардал яг одоохондоо мэдээж эрсдэл үүсэхгүй. Ирээдүйд зээл, өрийн дарамт үүсгэхгүй л гэдэг асуудал юм.

Тийм учраас бид шалгуур үзүүлэлтэд 4 дэх шалгуур болж байгаа өрийн нэрлэсэн дүнгээрх хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй гэдэг шалгуур байгаа учраас энэ дээр баригдана л гэж үзэж байгаа юм. Энэ дээр баригдана.

Тэгэхдээ энэ дээр нэг зүйлийг бид нэлээн харгалзаж үзсэн юм. Одоо ингээд бидэнд зээлээр хийх ёстой “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц”, мөн одоо энэ “Солонго I, II хороолол”, хамгийн гол юм “нефтийн үйлдвэр” байгаа юм.

Нефтийн үйлдвэртэй байх уу, үгүй юу гэдэг асуудал. Нефтийн үйлдвэрийг одоо ингээд барина гэвэл тэр чинь 1 тэрбум гаруй долларын санхүүжилт орж ирэх гэж байгаа учраас зээлийн ашиглалт өсөөд явчихна.

Тэгэхээр өндөр хэмжээний зээлийн ашиглаад тавиад ирэхээр нөгөө төсвийн тэнцэл чинь алдагдах гээд байгаа учраас тэр зардал талд зээлээр санхүүжиж гарч байгаа зардлыг тусгахгүй л явъя гэсэн санаа.

Тийм учраас бид юу гэж үзсэн гэвэл нэгдүгээрт өрийн дүн бол дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй. Эндээ баригдах юм байна.

Хоёрдугаарт, ер нь Монгол тэгээд нефть бүтээгдэхүүнтэй байх ёстой л гэдэг асуудал. Өөрөө үйлдвэрлэдэг байх ёстой.

Хэрвээ бид яг энэ өрийн хязгаартаа баригдах юм бол зээлийн ашиглалт нь нөгөө жилдээ 100 сая, 200 сая гээд ингээд явж өгөхгүй. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц явж өгөхгүй нэг ийм дүрд хүрэх л харагдсан учраас яах вэ, үүнийг хэрэглэж болох юм.

Тэгэхдээ бид уг нь түр хугацаагаар байвал яасан юм гэж ярьсан болов ч тэгээд одоогоор шийдэж чадаагүй.

Уг нь 3 жил юм уу, 4 жилээр энэ үзүүлэлтээр явбал яасан юм бэ гэсэн тийм байр суурьтай байсан.

Тэгэхдээ ажлын хэсэг дээр ярьж байгаад юу ч гэсэн хоёр үзүүлэлтээр нь явчихъя. Тэнцвэржүүлсэн тэнцэл нь ч байгаа, суурь тэнцэл нь ч байгаа гэж ингэж шийдсэн байгаа.

Гол юм зээлийг тооцохгүй байгаа боловч ирээдүйд үүсэх өрийн дарамт нь тэр дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулсан 60 хувийн харьцаандаа хянагдаад явна л гэж үзэж байгаа.

Д.Амарбаясгалан:

Г.Лувсанжамц гишүүн тодруулга.

Г.Лувсанжамц: Нөгөө бусад орны жишигтэй харьцуулж яаж байгаа гэдгийг нь тайлбарлаж өгсөн нь зүгээр болов уу гэж бодож байна.

Ер нь өөр улсад ямар байгаа юм бол?

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Г.Лувсанжамц гишүүний асуултад нэмж хариулъя.

Ер нь улс орон болгон өөр өөрийн онцлогт таарсан ийм хязгаар дүрмийг ашигладаг.

Олон Улсын Валютын Сангийн веб сайт руу ороод харах юм бол одоогоор 75 улс төсвийн янз янзын ийм хязгаар тавьчихсан ийм дүрэмтэй.

Хамгийн багадаа 2 хязгаар байна. Хамгийн өндөр нь 6 хязгаартай байх жишээтэй.

Ер нь томоохон эдийн засгууд, Америк, Европ, Англи, Япон. Эдгээр орнууд төсвийн хязгаарууд нь нэлээн тийм либерал, нэлээн тийм маневр хийдэг ийм нэлээн өсөлтөө дэмжиж явдаг ийм байдаг.

Хөгжиж буй орнуудын хувьд нэлээн төсвийн сахилга баттай явъя гэдэг ийм шаардлагыг ч Олон Улсын Валютын Сан, Дэлхийн банкнаас, олон улсын санхүүгийн байгууллагуудаас тавьдаг.

Тиймдээ ч нэлээн хязгаартай, нэлээн сахилга баттай явъя гэдэг ийм зарчим барь гэж байгаа юм.

Харин энэ ковидоос хойш.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуултаа асууя.

М.Нарантуяа-Нара: Сангийн яамны мэргэжилтнээс тодруулж асуумаар байгаа зүйл байна.

Тэгээд түрүүн хэллээ. Энэ жилийн хувьд 499.0 тэрбумыг орон сууц, боловсрол, эрүүл мэндэд зориулалттай. Ийм 3 зүйлд зориулалттай байгаа гэсэн.

Эндээс Эрүүл мэндийн яамыг чадавхжаад 4-өөс 5 жил хүртэл тийм ээ, бүх төрлийн өвчнийг Монголдоо эмчилдэг болох хүртэл хүүхдийн эрүүл мэндийн асуудал сох хаягдчихаад байгаа.

Яг одоо өвдчихсөн байгаа. Яг одоо эмчилгээний зардал хайж байгаа энэ хүүхдүүдэд энэ 499.0 тэрбумаас тийм ээ, эрүүл мэндийн эмчилгээний зардлыг гаргах ийм боломж бололцоо байна уу гэж асуумаар байгаа юм.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. М.Санжаадорж дарга хариулъя. Индрийн 2 дугаар микрофон.

М.Санжаадорж: Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 4 сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталсан.

Ингэхдээ Үндэсний баялгийн сан нь дотроо гурван сантай байхаар.

Ирээдүй сан, Хуримтлалын сан. Мөн хөрөнгө оруулалтын сан байхаар хуульчилсан.

Ингээд гурван сангууд маань бүгдээрээ тус тусдаа өөрийн гэсэн орлогын эх үүсвэртэй. Ямар тохиолдолд ямар байдлаар орлого орох вэ гэдгийг хуульчлан тогтоосон байгаа.

Яг таны асууж байгаа Хуримтлалын сангийн хувьд орлого нь өөрөө стратегийн ордуудтай холбоотой, манай улсын эзэмшиж байгаа, төрийн эзэмшиж байгаа эзэмшлийн компаниудын ногдол ашигтай холбоотой орлогоос бүрдэхээр заасан байдаг.

Энэ орлогоор гурван төрлийн зардлыг ерөнхийлөн гаргаж болно гэсэн заалттай байдаг.

Энэ нь эрүүл мэндийн чиглэлээр, боловсролын чиглэлээр, мөн орон сууцжуулалтын чиглэлээр гэж заасан байдаг.

Энэ жилийн хувьд Засгийн газраас энэ хуримтлагдаж байгаа зардлыг орон сууцжуулалттай холбоотойгоор зарцуулахаар шийдвэрлэгдсэн байгаа.

Одоогоор яг эрүүл мэндтэй холбоотойгоор зарцуулах тийм журам

одоогоор батлагдаж гараагүй. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, одоо бид Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль болон Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн тухай хуулиар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ямар ямар үйлчилгээг нь ямар ямар сангаас, эсвэл ямар эх үүсвэрээс санхүүжүүлэх вэ гэдгийг тусгайлан заасан байдаг.

Тэгэхээр одоо бид хэрвээ дахиж тусад нь эх үүсвэр оруулж ирж байгаа тохиолдолд үүнийгээ журамлахдаа илүү юу гэдэг юм таны яг хэлсэн агуулгаар илүү бидний орхигдуулсан тэр эмчилгээ, үйлчилгээ, тусламж, үйлчилгээний чиглэлээр, магадгүй юу гэдэг юм шинэ технологи нэвтрүүлэх чиглэлээр зарцуулах боломж нь байгаа.

Цаашдаа энэ чиглэлээр Эрүүл мэндийн яамны саналыг бид үндэслээд Засгийн газар дээрээ энэ асуудлыг яриад оруулж ирэх боломжтой гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн нэмж хариулъя.

Ц.Даваасүрэн: М.Нарантуяа-Нара гишүүний асуулт дээр тодруулаад өгчихье.

Тэр хүүхэдтэй холбогдолтой гадаадад эмчилгээнд явбал зардлыг яаж санхүүжүүлэх вэ гэж асуугаад байна шүү дээ. Тийм үү.

Тэгвэл Монголд эмчлэгддэг үү гэдэг юм уу, Монголд тэр чиглэлийн эмчилгээ байхгүй тодорхой өвчин дээр 20 билүү? Хэд байгаа билээ? Б.Жавхлан.

Одоо чинь төсөв дээр. Аан? Тийм. 50 хувийг нь гаргахад хэд байгаа вэ? Дүн нь хэд байгаа юм?

Тийм. Тодорхой эх үүсвэр одоо төсөв дээр байгаа.

Тэр үүсвэрээс тухайн өвчинд гарсан зардлынхаа 50 хувийг санхүүжүүлэх ийм бололцоо байгаа. Тэр сангаас гадна. Хуримтлалын сангаас гадна.

Монголд эмчлэгддэггүй ийм өвчний хувьд хүүхэд тэр сангаас гарсан зардлынхаа 50 хувийг авах эрхтэй. Тийм. Том хүн 20 хувь. Өнгөрсөн хавар ингэж эх үүсвэр баталж өгсөн байгаа шүү.

Д.Амарбаясгалан: Доржзовдын Энхтуяа гишүүн асуултаа асууя.

Д.Энхтуяа: Бид Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулаад, парламентын шинэ тогтолцоог сонгоод, тэгээд 126 гишүүнтэй энэ парламент үйл ажиллагаагаа эхлээд гол чухал асуудлуудаа хэлэлцэж байна.

Тэгэхээр парламентын гол үндсэн үүрэг хууль тогтоомж батлах, хэрэгжилтэд хяналт тавих. Мөн дунд болон урт хугацаандаа Монгол Улсын нэгдсэн төсвийг бид батлах, хянах гэсэн ийм үндсэн чиг үүргээ бид хэрэгжүүлж байна.

Тэгэхээр одоо бид хамгийн гол асуудлаа хэлэлцээд явж байна.

Тэгэхээр энэ дээр хоёр асуулт байгаа юм.

Тэгэхээр Монгол Улс 2010 онд Төсвийн тогтвортой байдлын тухай

хуулийг батлаад, 2013 оноос энэ хуулийг хэрэгжүүлж эхэлсэн.

Тэгэхээр энэ хуулийн хамгийн чухал гол концепц нь төсвийн тогтвортой байдлыг хангах зарчим байгаа юм.

Хоёрт нь, төсвийн тогтвортой байдлыг хангах.

Энэ тогтвортой байдлыг хангахын тулд тусгай шаардлагыг хуульчилж өгсөн байдаг.

Тэгэхээр “тусгай шаардлага” гэдэг нь юу юм бэ гэхээр төсвийн зарлагын өсөлтийг уул уурхайн бус, бусад салбарын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувьд тохируулан хязгаарлах гэсэн нэг ийм заалт байгаа юм.

Мөн Засгийн газрын өрийн хязгаарыг тогтоох замаар зохист хэмжээнд байлгах, төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах гэсэн ийм чухал заалтууд байгаа юм.

Тэгэхээр өнөөдрийн бидний энэ хэлэлцэж байгаа Засгийн газраас орж ирсэн төсөл дээр энэ тусгай шаардлагыг үгүй болгох ийм зүйл орж ирсэн юм болов уу гэж миний хувьд харж байгаа юм.

Тэгээд эндээс үүдэлтэйгээр би хоёр асуулт асууя.

Нэгдүгээр асуулт нь. Энэ асуултад би яг энэ төсвийг яг үндэслэлтэй гардаж боловсруулсан Сангийн яамны, мөн дээрээс нь төрийн албан хаагчийн тангараг өргөсөн Сангийн яамны мэргэжилтнүүдээс асууя. Улс төрчдөөс, сайд нараас асуугаагүй шүү.

Тэгэхээр 2024 онд хүлээгдэж байгаа биелэлтээр дотоодын нийт бүтээгдэхүүн хэдэн их наяд төгрөг болох юм бэ?

Энэ бол өнгөрсөн 2023 онтой харьцуулахад яг хэдэн хувийн өсөлт байна вэ гэсэн нэгдүгээр асуулт байна.

Энэхүү өсөлтийн чухам яг хэдэн хувь нь эрдэс баялгийн салбараас орж ирж байгаа юм бэ?

Хоёрдугаар асуулт. Төсвийн зарлагын талаар. 2024 онд өмнөх оноос яг хэдэн хувиар өссөн ийм өсөлттэй гараад байгаа юм бэ?

Цаашдаа 2025, 2026 онуудад энэ төсвийн зарлага дотоодын нийт бүтээгдэхүүний хэдэн хувьд байж яг хэдэн хувиар өсөхөөр төсөөлөгдсөн ийм төсвийн төсөөллийг Та бүхэн бодож боловсруулж орж ирсэн бэ?

Д.Амарбаясгалан: Хэн хариулах вэ? Сангийн яам. 2 дугаар индэр дээрээс.

Г.Золбоо: Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо гишүүний асуултад хариулья.

2010 онд Монгол Улс анх Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг батлаад 4 тусгай шаардлагыг 2013 оноос бүрэн мөрдөж эхэлсэн.

Ер нь олон улсад төсвийн дүрэм гэдэг нь төсвийн тогтвортой байдлыг хангах, цаашдаа ирээдүйд эдийн засгийн хязгаарлагдмал нөөцөөр эдийн засгийг дэмжих.

Үүн дээрээ төсвийн бодлогоор тогтвортой дэмжих. Цаашид өрийн дарамтаас хязгаарлах гэсэн үндсэн зарчмын хүрээнд төсвийн дүрмүүдийг улс орнууд хэрэглэж явдаг.

Үүнээс хамгийн түгээмэл хэрэглэгддэг нь өрийн болон тэнцлийн дүрэм байгаа.

Монгол Улс дэлхий дээр өнөөдрийн байдлаар 106 улс төсвийн дүрмийг ямарваа нэгэн байдлаар ашиглаж байгаагийн

- ▷ орлогын,
- ▷ зарлагын,
- ▷ тэнцлийн,
- ▷ өрийн

4 тусгай шаардлагыг дөрвүүлэнг нь ашиглаж байгаа 5 орны нэг юм.

Тэгээд өнөөдрийг хүртэл бидний баримталж ирсэн энэ тусгай шаардлага 10 жилийн хугацаанд тодорхой хэмжээнд эдийн засгийг дэмжиж тогтвортой байлгах, уул уурхайн савлагаанаас хамгаалах тал дээр үүргээ гүйцэтгэсэн гэж үзэж байгаа.

Тэгээд олон улсад хөгжлийнхөө үе шатад, эдийн засгийнхаа онцлогт тохируулаад төсвийн тусгай шаардлагуудыг байнга сайжруулж явдаг.

Тийм учраас бид Сангийн яамнаас энэ олон улсад байдаг нийтлэг жишгийг судалж байгаад энэ төсвийн тусгай шаардлагуудыг үгүй болгоогүй. Харин илүү сайжруулах чиглэлд оруулж ирсэн.

Үүн дээр урсгал зардлыг 30 хувиар хязгаарлах. Түүнчлэн суурь

тэнцлийн ашгаар өр төлөх гэдэг 2 том концепцыг оруулж ирсэн байгаа.

Өмнөх Тогтвортой байдлын тухай хууль дээр өрийг ямар арга замаар төлөх вэ гэдгийг тодорхой зааж өгөөгүй байдаг байсан бол одоо бид жил болгон суурь тэнцлийн ашиг болох дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиар өрийг төлж, цаашдаа өрийн дарамтаас сэргийлэх гэдэг үндсэн том зарчмын сайжруулалтыг хийж оруулж ирсэн байгаа юм.

Тэгээд 2024 оны анх бид төсвийн төслийг батлах үед дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 74 их наяд төгрөгөөр байсан бол өнөөдрийн төсвийн тодотголоор эдийн засаг сүүлийн хагас жилийн байдлаар хүлээгдэж байгаа гүйцэтгэл 79 их наяд төгрөгт хүрэхээр байна гэсэн тооцоон дээр төсвийн тодотголыг болон төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж орж ирсэн байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Индрийн микрофонд нэмэлт хариулт.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж.

2023 оны дотоодын нийт бүтээгдэхүүн гүйцэтгэлээрээ 70.4 их наяд төгрөг, 2024 оны дотоодын нийт бүтээгдэхүүн 79.2 их наяд төгрөг. Зөрүү нь 8.8 их наяд төгрөг байна.

Яг уул уурхайн бус дотоодын нийт бүтээгдэхүүнийг нь аваад үзэх юм бол 2023 оны гүйцэтгэлээр 49.4 их наяд төгрөг, 2024 онд уул уурхайн бус дотоодын нийт бүтээгдэхүүн 56.4 их наяд төгрөг байна. Зөрүү нь 18 орчим их наяд төгрөг байна. Тийм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Доржзовдын Энхтуяа гишүүн тодруулга.

Д.Энхтуяа: Баярлалаа.

Яах вэ, ер нь ирээдүйгээ өөдрөгөөр төсөөлж орох орлогоо улс орныхоо хөгжил цэцэглэлтэд зарцуулна гэдгийг ойлгож байна. Өөдрөгөөр төсөөлж байгааг ойлгож байна.

Гэхдээ яг энэ орж ирсэн төсвийг ингээд харахад төсвийн зарлага санаанд багтахааргүй өсөх ийм дүр зураг харагдаж байна.

Мөн Засгийн газрын өр ч гэсэн хяналтгүй байх вий гэсэн ийм эмзэглэл байна.

Мөн Засгийн газрын өрийг төлөх хязгаарлагдмал ийм байдал үүсэх вий. Үүнээс улбаалаад Монгол Улсын эдийн засгийн хөгжил, Монгол Улсын төсөвт маш хүнд дарамт орж, эрсдэлд орох вий гэсэн ийм болгоомжлол надад байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя.

Б.Жаргалан: Оройн мэнд хүргэе.

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль тогтвортой байхдаа л үүргээ гүйцэтгэдэг. Тэгээд ер нь гол нь тогтвортой байдал нь чухал гэж ойлгож байгаа.

Гэтэл харамсалтай нь бид өнгөрсөн хугацаанд төсвийнхөө тогтвортой байдлын тухай хуулийг туйлын тогтворгүй хууль болгож хувиргалаа.

Тэгээд энэ хуулийн өнөөдөр бидний хэлэлцэж байгаа асуудал дээр ингэж өөрчилснөөр төсвийн зардал замбараагүй өсөж байна.

Ердөө хоёрхон жилийн өмнө 2023 оны төсвийн зарлагыг 20 их наядын босго давж баталлаа гээд л бид тухайн үед гайхаж байсан.

Тэгвэл ерөөсөө одоо ингээд л өнөөдөр бид 30 их наядын босгыг давах гэж байна. Энэ тодотголоор одоо ингээд 3.1 их наядар зарлага нэмэгдэж байгаа.

Тэгээд хоёрхон жилийн дотор одоо ингээд 10 их наядар төсөв маань нэмэгдчихлээ.

Тэгээд хоёрхон жил биш нэгхэн жилийн дотор шүү. Тэгээд энэ бол ерөөсөө л бидний нүүрсний мөнгө. Тийм ээ. Нүүрсний мөнгөн дээр л бид бүгдээрээ найрлаад байна. Тэгээд төсвөө нэмэгдүүлээд байна. Зарлагаа нэмэгдүүлээд байна. Дарга ангийн тансаглалыг нэмэгдүүлээд байна.

Тэгээд энэ жил 60 сая тонн нүүрс гаргана гэсэн бол одоо энэ тоо 80 сая болж өөрчлөгдөх гэж байна гээд тодотгол хийж байна.

Тэгэхийн тулд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиараа оролдож байна.

Тэгээд өнгөрсөн 10 орчим жилийн хугацаанд бид 300 гаруй сая тонн нүүрс экспортолчихсон байж байгаа.

Энэ нүүрснээс орж ирсэн мөнгөөр жишээлбэл нүдэнд харагдаж, гарт баригдах тийм бүтээн байгуулалт, ард иргэдийн амьжиргаанд нөлөөлөх зүйл

ерөөсөө хийгдсэнгүй. Бид зарлагаа л нэмээд байгаа.

Тэгэхээр энэ дээр гишүүд маш анхааралтай хандаж, тогтож шийдвэр гаргахыг хүсэж байна.

Тэгээд асуултын тухайд гэх юм бол нэгдүгээрт Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асууя.

Зөвлөлийн дүгнэлтэд төсвийн зарлагыг тэлэх нөхцөл бүрдүүлж, төсвийн зарлагын хэмжээ 2024 онд 3.1 их наяд, 2025 онд 3.6 их наяд, 2026 онд 4.9 их наяд төгрөгөөр өсөж, 3 жилийн хугацаанд төсвийн зарлагын хэмжээ 11.6 их наяд төгрөгөөр өсөхөөр байна гэж байна.

Энэ нь манай макро эдийн засгийн үзүүлэлт, төгрөгийн ханшид хэрхэн яаж нөлөөлөх вэ гэдэг асуулт байна.

Хоёрдугаарт, Сангийн яам бид өнгөрсөн 10 жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар бий болсон тусгай шаардлагууд түүхэн үүргээ гүйцэтгэсэн л гэж яриад байгаа юм.

Тэгээд яг өнгөрсөн 10 жилийн хугацаанд тэгвэл Сангийн яам энэ тусгай шаардлагуудыг хэдэн онд нь биелүүлж байсан бэ?

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульдаа өөрчлөлт оруулахгүй, төсвийн хүрээний мэдэгдэлдээ өөрчлөлт оруулахгүй хуулиа баталж байсан он жилүүдээ нэрлэнэ үү гэж Сангийн яамнаас хүсэх байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Эхний асуултад Л.Гантөмөр дарга хариулах уу? Тогтвортой байдлын зөвлөл. Ажлын хэсгийн 8 дугаар микрофон.

Ж.Дэлгэрсайхан: Гишүүний асуултад хариулья.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан байна.

Бидний хуулиар хүлээсэн үүрэг яах аргагүй төсвийн тогтвортой байдлыг хадгалах. Энэ агуулгаараа бид энэ дүгнэлтийг гаргасан гэдгийг гишүүд маань хүлээн авч ойлгохыг хүсье.

Энэ хүрээнд бид Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагууд болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээс хамаарсан энэхүү өөрчлөлт дээр суурилж гол дүгнэлтээ өгсөн юм.

Эндээс үүсэж болох гол эрсдэл нь өнөөдөр дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, уул уурхайн супер цикл дуусаж байгаа гэсэн энэ үед бид ингэж төсвөө тэлэх нь нэгдүгээрт төсвийн орлогын тасалдалд хүрч томоохон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжихгүй болох үндсэн магадлалтай гэсэн болгоомжлол бидэнд байгаа.

Хоёрдугаарт нь, таны саяын асуусан. Төсөв 3 жилийн дотор 10 гаруй их наяд төгрөгөөр тэлж байгаа байдал нь импортыг дэмжсэн, төлбөрийн тэнцэл дээр дарамт үзүүлж, валютын ханш, инфляцад сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэсэн байдлаар харж байгаа юм.

Тийм учраас бидний энэхүү дүгнэлт бол байж болзошгүй томоохон эрсдэл тулгарвал яах вэ гэдэг энэ суурь нөхцөл дээр суурилж өгсөн дүгнэлт байгаа.

Сангийн яамны маань оруулж ирсэн нөхцөл бол энэхүү төсвийг тэлье, томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлье, эдийн засаг харьцангуй өөдрөг байх боломжтой байна гэсэн ийм нөхцөлөөр харсан гэж бид ойлгосон.

Тийм учраас хэрвээ бид таны хэлээд байгаа нүүрс гэдэг зүйл маань багаар гарвал томоохон энэ төлбөрийн тэнцэл, өрийн дарамтын эрсдэл, валютын ханшийн эрсдэл бий болж болзошгүй гэсэн ийм байр суурьтай байгаа гэдгээ хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сангийн яам. Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулья.

Б.Жавхлан: Б.Жаргалан гишүүний асуултад хариулья.

Болгоомжлол үргэлж байх хэрэгтэй. Тийм ч учраас энэ удаагийн оруулж ирж байгаа өөрчлөлтүүд энэ эрсдэлийг хааж байгаа юм.

Таныг би эдийн засагч хүн. Ойлгох байх гэж найдаж байна.

Суурь тэнцлийг жил бүр нэмэх 2 хувь. Нэмэх 2 хувь шүү. Дотоодын нийт бүтээгдэхүүний.

79 их наядын 2 хувь гэдэг бол 1.6 их наяд. Бид хойтон 1 орчим их наядын өр төлөх ёстой.

Түүнээсээ бараг 1.6 дахин илүү өр төлбөл зохих эх үүсвэрийг бид суллаж гаргаж ирнэ гэсэн үг.

Ингээд явахаар өөрөөр хэлбэл урсгал тэнцэл гэдэг маань одоо таны хэлээд байгаа тэр нүүрснээс орж ирж байгаа орлого маань байнгын ашигтай

байх ёстой. Зардлаа нөхөөд. Алдагдалтай биш.

Тэгэхээр түүнээс хамааралтай зардал өсөх гэдэг, зардлаа бид алдах гэдэг тийм айдас байхгүй болно гэсэн үг. Хуульчилчхаж байгаа учраас.

Тийм учраас тийм эрсдэл ингээд байхгүй болно гэсэн үг. /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут.

Б.Жавхлан: Б.Жаргалан гишүүн ээ, төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг бол ийм тусгай шаардлага, хязгаар биш. Тусгай шаардлага биш.

Дараа жил эдийн засаг маань ер нь ямархуу хэмжээтэй байх нь вэ гэдгийг л зарлаж байгаа юм.

Тэр дотор чинь 3 багана байдаг. Хойтон жилийнх. Тэрний дараагийн 2 жилийнх гээд.

Тэрний дараагийн жил нь нөгөө 2 дугаар багана нь 1 дүгээр багана руугаа шилжиж орж ирээд дахиад өөрчлөгдөөд явдаг ийм хуультай. Шинэчлээд. Жил болгон шинэчилдэг байхгүй юу. Төсвийн үнийн мэдэгдлийг.

Тусгай шаардлагыг бид сүүлийн 5 жил. Би өөрийнхөө байсан үеийн түүхийг л хэлье. Бусад хүмүүсийнхийг мэдэхгүй. Та заримыг нь мэдэх байх гэж найдаж байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд бид нэлээн хүнд сорилтуудыг давж ирсэн.

Гэсэн хэдий ч Улсын Их Хурлаар батлагдсан тусгай шаардлагуудыг бид яг таг хангаж ирсэн байгаа.

Түүн дотроос бүр хамгийн гол энэ өрийн хязгаарыг бид маш сайн сахилга баттай ирж, анх хэдэн жил үү. Арваад жилийн өмнө 85 хувьд хүргэж байсан тэр зээлийн өрийн хязгаарыг өнөөдөр 39 хувь болгочихсон байна.

Алдагдал 8.8 хувиас.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Хуульч хүн болохоор Та хэдийн төсөвтэй холбоотой энэ яриа жаахан харь сонсогдоод байгаа.

Бодвол иргэдэд маань ч гэсэндээ зарим зүйл ойлгомжгүй байж магадгүй.

Тэгэхээр аль болох Та хэдийг нөгөө энгийн байдлаар тайлбарлаж, зарим нэг асуултад маань хариулаасай гэж хүсэж байна.

Тэгээд миний ойлголтоор манай Сангийн яам маш их томоохон хэмжээний худалдан авалт хийх гээд. Одоо айл гэрээр бол нөхөр нь нэг том машин авах гээд л. Эхнэр нь яах гээд байгаа юм бэ, наадхыг чинь төлж чадах юм уу л гэдэг байдалтай байх шиг байна гэж ойлгоод байгаа.

Тэгээд нөгөө талаас эхнэр болох Төсвийн тогтвортой байдлын зөвлөл маань яг л гэрийнхээ санхүүг нэг ийм тогтвортой байлгачих гээд л хараад л хянаад байна гэж би хувьдаа ойлгож байна.

Энэ нь өөрөө нөгөө Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль тогтоомжид хэрвээ өөрчлөлт оруулах гэж

байгаа бол бас тодорхой хэмжээний шаардлага тавьж байгаа. Тийм ээ. Хууль тогтоомжийн тухай хуулиар.

Эргээд би Хууль тогтоомжийн тухай хуулиа харахаар энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль одоо нөгөө юу гэдэг юм, энэ хуульд тавигдах тэр шаардлагад хамаарахаар харагдаад байна. Хамаарахаар. Тийм ээ.

Тэгэхээр маш их судалгаанууд хийгдсэн байх ёстой. Үр нөлөөнүүд хийгдсэн байх ёстой гээд нэлээн хэдэн ийм үечлэлүүд, шаардлагууд харагдаад байна.

Тэгэхээр энэ Хууль тогтоомжийн тухай хуульд хэрвээ заасан энэ шаардлага Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд хамаардаг юм уу, хамаардаггүй юм уу? Хамаардаг бол холбогдох судалгаанууд нь энэ удаа яагаад хийгдээгүй юм бэ? Бодвол тодотгол гээд хийгдээгүй гэдэг тайлбар өгөхгүй байх.

Яагаад гэвэл хууль дээр тийм хүндэтгэн үзэх шалтгаан байхгүй байна.

Тэгэхээр үүнд Сангийн яам хариулж өгөөч ээ.

Хоёрдугаарт, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс би нэг зүйл асуумаар байна. Би үүнийг аягүй шинэ механизм гэж ойлгож байгаа. Манай хуулийн салбараар Хүний эрхийн Үндэсний Комисс шиг ийм хяналтын маш том чухал механизм бий болж байгаа гэж ойлгож байгаа.

Тэгэхээр би танай байгууллага руу мэйл бичсэн. Сангийн яамны энэ өнгөрсөн хугацаанд саяын энэ анхны чуулганаас хойш өгч байгаа тайлбартай холбоотой нэмээд энэ дүгнэлт,

зөвлөмждөө засвар оруулдаг юм уу, эсвэл энэ Сангийн яамны хэлээд байгаа тайлбартай холбоотойгоор нэмэлт тайлбар мэдээллээр ингэж хангаж өгөөч ээ гэдэг имэйл биччихсэн байгаа.

Тэгээд уг нь үүнд хариулчихсан бол бид хэдийн ойлголцол илүү хялбар байх байсан болов уу.

Тэгээд энэ дээр Сангийн яамны энэ хариулаад байгаа хариунд та хэд маань яг нэг тайлбар өгөөдхөөч гэдэг ийм хоёр дахь асуулт байна.

Гурав дахь нь, өчигдөр би санаандгүй Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны хурал дээр ороход Их Хурлын хуулийн газраас энэ хуулийн дүгнэлт гаргасан байсан.

Тэгэхээр тэр дүгнэлтийг энэ чуулган дээр танилцуулдаггүй юм шиг байна. Тийм ээ. Тэр уг нь танилцчихсан бол бас ингээд нэг ийм хоёр тийшээ харчихсан байгаа байгууллагын хайнааг хагалахад тэр дүгнэлт их хэрэгтэй дүгнэлт байх байлаа.

Тэгэхээр тэр чухам танилцуулж болдог юм уу, болдоггүй юм уу? Гишүүдэд тарааж болдог юм уу, болдоггүй юм уу? Хэн хариулах юм бол доо гэдэг нэг ийм асуулт байна.

Тэгээд гуравт нь тэр томоохон зээлээр томоохон хөрөнгө оруулалтыг санхүүжүүлж байгаа тохиолдолд тэрийг өр төлбөр гэсэн хэсэгт бичихгүй л гэж би хувьдаа ойлгоод байна.

Тэгээд манай өрхийн өр гэсэн хэсэгт орохгүй л гэж ойлгох гээд байна л даа. Тийм юм байж болдог юм уу? Үүнийг эсвэл би буруу ойлгоод байна уу гэдэг дээр тайлбар хүсэх гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Засгийн газраас оруулж ирж байгаа тодотголыг дэмжиж өгөөч ээ гэдэг хоёр шалтгаан байгаа юм.

Нэгдүгээрт, ер нь бид засаж янзлах юм гарч ирчхээд байгаа юм. Зарим гишүүд их эмзэг хүлээж аваад байх шиг байна.

Гарцаагүй л ийм юм болчихсон юм чинь одоо үүнийг бид хөндөхөөс яах юм бэ.

Би дараа нь аягүй бол худлаа яриад бай гэж магадгүй. Би үүнийг бүр уншаад өгье. Энэ хууль дээр байгаа зүйлийг нь.

Өнгөрсөн 6 сарын 05-нд орсон нэмэлт, өөрчлөлт байгаа юм.

6.4.энэ хуулийн 6.1.2 тусгай шаардлагыг 2025 оны төсвийн жил хүртэл. Өөрөөр хэлбэл 2024 оны 12 сарын 31 хүртэл гэсэн.

6.1.4-г заасан тусгай шаардлагыг 2025 оны төсвийн жилээс хэрэгжүүлнэ гээд.

6.1.2 гэдэг нь алдагдлын хязгаар.

6.1.4 гэдэг нь өрийн хязгаар. Өөрөөр хэлбэл бид 01 сарын 01-нээс эхлээд алдагдлын хязгааргүй болно. Өнөөдөр бид өрийн хязгааргүй явж байгаа.

Үүнийг бид өөрчлөхгүй бол болохгүй.

Тийм учраас үүнийг засаж сайжруулж орж ирж байгаа гэж ойлгож болно.

Хоёрдугаарт, өдөр манай Тэргүүн Шадар сайд хэлсэн дээ. Би тэр үгийг давтаж хэлье гэж бодож байна.

Хамтарсан Засгийн газрын энэ өнгөн дээр ер нь нэг жоохон урагшилчихъя. Бүтээн байгуулалтуудаа хийчихье гэж байгаа.

Ер нь яах вэ, хүний өөрийнгүй л үүнийг эсэргүүцэж байгаа, таалагдахгүй байгаа хүмүүс байх шиг байгаа юм.

Гэхдээ эд нарт одоо бид нарын хариулт өнөөдөр энд олон юм ярих биш. Ер нь нэг цаг хугацааны дараа бид үр дүнд хүрсэн байх ёстой, юм хийсэн байх ёстой. Энэ үйл хэргээрээ л харуулах ёстой байгаа юм.

Тэгэхээр энэ талаас нь хараад дэмжээд өгөөч ээ гэж байгаа юм.

Х.Баасанжаргал гишүүн ээ, Та буруу ойлгосон байна.

Энэ бүртгэлийн асуудал биш. Зээл гэдэг өр төлбөр дээрээ байдгаараа л байна. Баланс дээр харагддагаараа л харна.

Харин бид хязгаар тооцохдоо бид арай өөрөөр харъя. Арай өөрөөр харъя.

Зээл авчхаад хэрэглэж чадахгүй байгаа 10 их наяд төгрөг байгаа байхгүй юу. Энэ сүүлийн 30 жилийн хугацаанд авчихсан. Авбал зохих гэрээгээ хийчихсэн. Аваад эхэлчихсэн. Тэгээд хэрэглэж чадахгүй байгаа 10 их наяд төгрөг байгаа.

Энэ дотор хамгийн том нь гэх юм бол түрүүн Ц.Даваасүрэн дарга хэллээ.

Нефть боловсруулах үйлдвэр байна. Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламж байна. Удахгүй эхлэх Эрдэнэбүрэн байна гээд. Гэх мэт.

Эдгээр санхүүжилтүүдээ бид хийхгүй ийм боломжгүй хязгаарт очоод байгаа юм.

Гэхдээ энэ ашиглалт нөгөө 60 хувь гэдэг хязгаар дотроо баригдана. Дээрээс нь нэрлэсэн үнэ гэхээр энэ асуудлууд чинь их нарийн хяналттай, хязгаартай болоод ирнэ.

Дээрээс нь та тэр гэр бүл ярилаа. Уг нь эсрэгээрээ л дээ. Тэр эхнэр, нөхөр хоёрын асуудал нь. Жил бүр 2 хувийн ашигтай тэнцэлтэй гараад. Энэ эх үүсвэрээрээ өрөө төлөөд явна шүү, жил бүр.

Тэгэхээр бид авсан зээл. Авч байгаад шинэ зээлээ ашиглах болон өмнө нь ашиглачихсан зээлүүдээ ингээд яг балансыг нь бариад явчих юм байгаа юм. Үүнийгээ бүүр хуульчилчхаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр улам их сайжирч байна гэсэн үг. Та нэг жилийн дараа хараарай, 2 жилийн дараа хараарай. Энэ хуулийн дагуу өр нэмэгдэх нь үү, багасчихсан байх нь уу.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт болсон уу? Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуултаа асууя.

Уучлаарай. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нэмж хариулах юм байна. Тийм ээ. 8 дугаар микрофон. Ажлын хэсгийн.

Ж.Дэлгэрсайхан: Гишүүний асуултад хариулья.

Энд яах вэ, Сангийн яам ингээд хоёр тийшээ харчихсан юм байхгүй.

Учир нь бидний хуулиар хүлээсэн үүрэг нь яах аргагүй л энэ тогтвортой байдлыг хадгалах ёстой.

Бидний үзэж байгаагаар яг энэ өөрчлөлтүүдийг хийж орж ирснээр урсгал зардал нэлээн дээшээ явчхаж болзошгүй байна.

Одоогийн байдлаар нэрлэсэн үнээр тооцоход 44 хувьтай байгаа өр 60 луу явах юм бол төсвийн огцом тэлэлт үүснэ.

Эдийн засаг дээр сөрөг нөлөөлөл орж ирэх юм бол гарцаагүй эрсдэл үүсэж болзошгүй гэдэг байдлаар нь энэ тусгай шаардлага, энэ зүйлсээ хэвээр хадгалах нь зүйтэй юм байна гэсэн ийм саналтай байгаа.

Таны имэйлийн талаар би мэдээлэл аваагүй байна. Албан ёсны хариу өгье.

Д.Амарбаясгалан: Х.Баасанжаргал гишүүн тодруулга.

Х.Баасанжаргал: Б.Жавхлан сайд аа, дэмжихгүй гэдэг утгаараа асууж байгаа юм биш л дээ. Ойлгох гэж. Ер нь яг юу болоод байна. Энэ кнопыг чинь дарахын тулд их л хариуцлагатай л дарах ёстой байлгүй дээ. Тийм ээ. Ойлгож ухамсарлаж байж.

Тэгэхээр төсөв гэдгийг л ойлгох гэж хичээж байгаа л оролдлого байгаа юм.

Тэгээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс бүх гишүүдэд зориулаад урьдчилаад үүнээс өмнө бид нарт бүгдээрэнд нь имэйл ирүүлсэн.

Энэ төсвийн тогтвортой байдал гэдэг чинь юу юм бэ, өнгөрсөн хугацаанд бид юу туулав гэдэг маш ийм энгийн байдлаар бэлдэж ирсэн мэдээлэл урьдчилаад бид нарт өгчихсөн байсан учраас энэ бүхнийг нэг арай өөрөөр харахад их нэмэртэй байсан гэж хэлэх гээд байгаа юм.

Хоёрдугаарт, цаашид төсвийг бид жендэрийн мэдрэмжтэй төсөв, хүний эрхийг баталгаажуулахад хэр үр нөлөөтэй байгаа төсөв бэ ч гэдэг юм уу ийм аргачлалуудыг нэвтрүүлээсэй гэж хүсэж байна.

Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл шинэ институц учраас энэ институц өөрөө маш их чухал институц гэж би хувьдаа харж байгаа учраас ийм шинэ аргачлал, шинэ зүйлүүдийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуултаа асууя.

Б.Мөнхсоёл: Оройн мэнд.

Миний хувьд өмнө нь **“Нээлттэй нийгэм форум”**-д ажиллахдаа улсын төсвийн анализыг олон жил хийж байсан хүн байгаа юм.

Тэгээд олон улсад **“International Budget Partnership”** гэж байгууллага байдаг. **“Олон улсын төсвийн түншлэл”** гээд.

Тэгээд улс орнуудыг төсвийн нээлттэй байдлаар нь жагсаадаг.

Монгол Улс сүүлийн үед ерөнхийдөө ухрах маягтай байгаа.

Тэгэхээр энэ олон үзүүлэлтээс шалтгаалдаг ийм том индекс л дээ.

Тэгээд нэг нь зөвхөн нээлттэй байдал биш. Одоо төсвийг хэлэлцэхдээ, ярилцахдаа иргэдээ, судлаачдаа хэрхэн сонсдог юм бэ. Тэд нарын санаа бодлыг хэрхэн тусгадаг юм бэ гэдэг хүртэл ордог.

Тэгэхээр энэ байдал, ялангуяа одоо бид Х.Баасанжаргал хуульчийн хэлж байгаагаар маш их хариуцлагатай, өндөр үүрэгтэй. Бид иргэдийн төлөөлөл шүү дээ.

Тэр утгаараа энэ асуудлыг дахин дахин нухацтай яриад байхад гэмгүй сэдэв. Өөрөөр хэлэх юм бол бид боломж олдвол аль болохоор яаралтай горимоор биш ердийн горимоор авч хэлэлцэж байх ёстой асуудал байгаа юм.

Тэгэхээр гол асуудал юун дээр бид яриад байгаа вэ гэхээр нөгөө л Төсвийн тогтвортой байдлын хууль буюу өмнө нь манай Б.Жаргалан гишүүний хэлсэнчлэн тогтвортой байдлыг бий болгох биш, бодит амьдрал дээрээ төсвийн сахилга батгүй байчхаад, түүндээ тохируулаад эргээд Төсвийн тогтвортой байдлынхаа хуулийг өөрчлөөд, тэр тусмаа бүр 17 удаа өөрчилчихсэн учраас өнөөдөр бид энэ асуудлыг нухацтай яриад байгаа юм.

Тэгэхээр одоо бүгдээрээ. Яах вэ олон дахин хэлэлцээр байгаад тэр төсвийн тогтвортой байдлын 6.1.2-ыг өөрчлөөд тэр суурь зарлага, орлого энэ тэр гээд яриад байна.

Гэхдээ миний мэргэжлийн хүний хувьд ядаж протоколдоо үлдээмээр байна.

Энэ үзүүлэлтийг эргэж харах, энэ төсвийн алдагдлыг маш нухацтайгаар хязгаарыг байлгах ер нь шаардлага өндөр байдаг шүү л гэдгийг хэлмээр байгаа юм.

Тэгээд бид эргэж санах хэрэгтэй. Нөгөө Олон Улсын Валютын Сангийн хөтөлбөрт 2017 онд орсон юм шүү дээ. Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр.

Түүн дээр яагаад орлоо. Тэнд гол тэдний өгсөн олон зөвлөмжийн нэг нь өөрөө бас төсвөөс гадуур бүртгэлтэй санхүүжилт аюултай, эрсдэлтэй буюу нөгөө Хөгжлийн банкны асуудал, нөгөө Монголбанкны хэрэгжүүлсэн моргейжийн ч гэдэг юм уу иймэрхүү асуудлууд байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ мөнгө, санхүүтэй холбоотой асуудал дээр нухацтай хандахаас өөр аргагүй.

Тэгээд Сангийн сайд маань хэлж байгаа, энэ бусад хүмүүс хэлж байгаа тэр өр төлбөр босгосон 10 их наядын энэ зээл, гаднаас боссон энэ мөнгөө гол нь мега төслүүддээ зарцуулаад, хэрэгжүүлээд, эргээд эдийн засгаа өдөөмөөр байна, Ажлын байр бий болгомоор байна, өгөөжийг нь авмаар байна гэж байгаа.

Тэгэхдээ үүнийг хэрэгжүүлэхдээ гол нь төлбөрийн тэнцлийг хэрхэн тооцсон бэ?

Тэгээд эдийн засаг дээр халалт хэр авчрах вэ? Эдийн засгийн шингээх чадвараа давхар тооцсон уу? Эргээд нөгөө нэг хүнд ноогдох дотоодын нийт

бүтээгдэхүүн маань 10 мянган доллар гэж тооцсон байна лээ.

Хэрэв энэ тооцоолол ирэх 4 жилд зөв хийгдсэн бол 10 мянгаас ч илүү байхаар харагдаж байна шүү дээ. 14 мега төсөл.

Энэ нь өөрөө эргээд асуудалтай хэрэгжээд явах юм бол харин ч магадгүй 10 мянган доллароос ч бага болох магадлалтай. Яагаад гэвэл бид ханшийн эрсдэл байна, инфляцын эрсдэлүүд гээд ингээд бусад эрсдэлүүдээ тооцох хэрэгтэй.

Тэгэхээр энэ асуултыг ерөнхийд нь асуучихъя гэж бодож байна.

Ингээд товчхондоо 16 секунд үлдсэн байна. Баярлалаа.

Би нэгхэн юмыг хэлчихье. 2014 байна уу. Нөгөө Төсвийн тогтвортой байдлын зөвлөл үүсэхэд би өөрөө байгалийн баялгийн засаглалын институцийн захиалгаар.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Б.Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя.

Энэ удаагийн өөрчлөлтөөр цоо шинэ хязгаар, зохицуулалтын харилцаа орж ирж байгаа гэж түрүүн манай мэргэжилтэн хэлсэн. Та анзаарсан болов уу гэж ингэж бодож байна.

Урсгал зардлаа 30 хувиар ингээд хязгаарлачхаж байгаа юм. Өмнө нь бид 30 хувиас давж байсан он жилүүд ч байгаа.

Тийм учраас одоо бол 25 орчим хувь дээр байна. Үүнийг 30 хувиар хязгаарлана. Нэг.

Хоёрдугаарт, суурь тэнцлээ байнга 2 хувийн ашигтай байна. 2-оос доошгүй. Дотоодын нийт бүтээгдэхүүний шүү.

Одоо хойтон 2025 онд дотоодын нийт бүтээгдэхүүн бүр 95 их наяд хүрэх шинжтэй байна.

Үүний 2 хувь гэдэг 2 их наяд. 2 их наядаар бид тухайн жилийнхээ үндсэн өрийг хангалттай төлөөд, дээрээс нь бондуудаа ч хүртэл “buyback” хийх боломжтой ийм хэмжээ байхгүй юу.

Энэ маш чухал нэг ийм түүчээ орж ирж байгаа юм.

Яг өнөөдрийн хувьд байхгүй болчхоод байгаа шүү. Нөгөө 60 хувийн хязгаар маань. Үүнийгээ буцааж оруулж ирж байгаа.

Ийм үндсэн гурван шалгуур дотор бид өөрийнхөө менежментийг, стратегиа бариад явна.

Дээрээс нь өр нэмэгдэх үү гэж байгаа. Өр нэмэх эсэхийг Их Хурал шийднэ. Нэг доллароор ч нэмэгдэхийг. Ямар өр авах вэ, ямар зээл авах вэ гэдгийг та энд шийдэх байхгүй юу.

Тийм учраас Засгийн газар дангаараа шийддэг асуудал биш. Засгийн газар ашиглалтаа л шийднэ.

Ашиглалтаа шийдэхдээ яг саяын таны хэлж байгаа төлбөрийн тэнцлээ бид уншиж цаашаага төсөөллөө, мөнгөний бодлого болон төсвийн бодлогын орчинд хүндрэл, эрсдэл гарахгүй байхаар алхмаа тааруулаад явна гэсэн үг.

Эхлээд ямар ч байсан бид. Одоо юу юугүй ийм өөрчлөлтүүд ороод үүнийг чинь тултал тултал нь ингээд хэрэглээд явна гэсэн асуудал биш л дээ.

Ямар ч байсан боломж дүрмүүдээ өөрчлөлт орууллаа. Тэгээд цаашаага яг таны хэлж байгаагаар төлбөрийн тэнцлээ уншаад эндээ ямар нэгэн эрсдэл гарахгүйгээр алхмаа тааруулаад явах. Энэ нь өөрөө төсвийн бодлого, нөгөө мөнгөний бодлого хоёроо уялдуулна гэдэг нь энэ байгаа юм. Тийм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн нэмж хариулья.

Ц.Даваасүрэн: Тийм. Би Б.Мөнхсоёл гишүүний хэлсэнтэй санал нэг байна.

Ер нь яах вэ энэ гишүүдийн хэлээд байгаа энэ тогтвортой байх ёстой шүү, сахилга баттай байх ёстой шүү гэдэг энэ үндэслэлээр анх бид 2000-аад оны эхэн үед Олон Улсын Валютын Сантай энэ төсвийн хүрээний мэдэгдэл энд тавих дээд хязгаарыг тохирч гаргаж ирсэн нь ерөөсөө тэр. Яагаад гэвэл та нар хэтэрхий үрэлгэн байна, зардал чинь их хурдацтай өсөж байна гэснээс болж төсвийн хүрээний мэдэгдэл бий болоод, дараа нь энэ Төсвийн тогтвортой байдлын хууль бий болоод ингээд явсан.

Тийм учраас сая бид ингээд хэлэлцэж байх явцдаа жишээлбэл төсвийн тэр тэнцвэржүүлсэн тэнцлийг үлдээчихсэн байгаа. 19.9 нь хэвээрээ үлдчихсэн байгаа. Тэр байхгүй болчихсон биш. Тэрийг манай Б.Жавхлан сайд буруу тайлбарлаад байгаа юм.

Тэр 6.4-өөр 2025 он хүртэл гэж байж байгаа мөртөө 19.9-өөр 2025 оноос хойш хасах 2 хувиас хэтрэхгүй шүү гэдэг заалт нь үлдчихсэн байгаа.

Тийм учраас төсвийн тэнцлийн тэр хязгаар нь байж байгаа.

Зүгээр хоёр л шалгуур үзүүлэлтийг өөрчилсөн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Батбаатар: Төсвөө ярихаар нэг тийм, төсвийн хүрээний мэдэгдэл гээд ярихаар хүрээ хязгаар, тэгээд нөгөө өрийн тааз, энэ бүх зүйлүүд яригддаг.

Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх нөгөө тоглоомын дүрэм зохиогч буюу түрүүн нэг центийн өрийг ч гэсэн Их Хурал нэмэх, хасах зээлийг шийднэ гэж байгаатай адилхан.

Тэгэхээр Их Хурлын онцгой эрх одоо энд байж байдаг. Энэ төсвийн хүрээний мэдэгдэл, энэ бүх зүйл дээр хараад байхаар зарим нэг зүйл дээр жаахан эргэлзээ төрөөд байгаа юм.

Их Хурал эрхээ эдэлж чадахгүй болох юм биш биз дээ гэдэг. Засгийн газраас төсөв төсөл ороод ирдэг. Их Хурал ингээд дагаад батлагч үүрэг гүйцэтгэдэг.

Өнөөдөр Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр зарчмын зөрүүтэй санал Их Хурлын гишүүд, Байнгын хороо ажилласан саналууд зөндөө олон унаж л байна лээ.

Ерөнхийдөө тэнд унах тусмаа Их Хурлын ажил унаад л, Засгийн газрын

ажил босож ирээд л яваад байна гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр Их хурлын гишүүд маань энэ эрхээ эдэлж чадахгүй болдог.

Өнөөдрийн тэр Г.Тэмүүлэн гишүүний яриад байдаг шиг тодорхой хэмжээнд мэдээлэл дутагдаад.

Төсвийн байнгын хорооны дүгнэлт дөнгөж энэ асуудлыг хэлэлцэж байх үед ч байдаг юм уу, энэ мэдээллүүд нь цагийг нь тулгаж орж ирээд уншиж, судалж, мэдэж амжаагүй гишүүд зүгээр кнопчны үүрэг гүйцэтгээд байх вий.

Бид алдаа гаргавал энэ бол 3 сая монголчуудын 30 мянга, 300 мянга, 3 мянган хүний амьдрал дээр буудаг хүнд шийдвэр болно.

Тийм учраас энэ мэдээллийгээ их сайн өгөх тал дээр анхаарахгүй бол хэтэрхий яаравчлаад. Өдрийн цайны цаггүй, шөнийн оройны цаггүй ингээд үргэлжлээд батлаад яваад байдаг чинь их олон зүйл ардаа дагуулж байгаа шүү гэдгийг хэлмээр байгаад байгаа юм.

Мөнгөний нийлүүлэлт 42 их наяд, түүний 30 их наяд нь төсвөөр дамжиж байна.

Тэгэхээр мөнгөний нийлүүлэлтийн 10 их наяд нь л бодит эдийн засаг буюу хүмүүсийн орлого, бараа, ажил үйлчилгээ, үйлдвэрлэлээс бий болж байна.

Энэ тохиолдолд төсөв ингэж нийт мөнгөний нийлүүлэлтийн дөрөвний гурвыг эзэлж байгаа тохиолдолд Монголбанк мөнгөний бодлогоо хатууруулахаас өөр замгүй болно.

Бизнес эрхэлж байгаа, ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүст санхүүгийн эх үүсвэр олдохгүй болно.

Хатуу мөнгөний бодлоготой байна гэдэг чинь тэр иргэдийн амьдрал ахуйд хатуугаар тусна. Үүнийгээ тэр Улсын Их Хурал, Монголбанк, Засгийн газрын нэгдмэл эдийн засгийн бид нарын хүсээд хийх гээд зориод байгаа юм бол олон том төслүүд байна.

Тэгэхдээ тэд нарыг яах гээд хийгээд байгаа юм бэ гэдэг бол ард түмнийг ядууралгүй л амьдруулах шүү дээ. Хамгийн анхан шатын суурь нь ядууралгүй байх.

Ядуурал хамгийн бага хэмжээнд байгаа. Дотоодын нийт бүтээгдэхүүн өсөөд байдаг, өсөөд байдаг. Иргэдэд наалдаж байгаа зүйл байхгүй. Баян хоосны ялгаа гараад байдаг.

Том төслүүдийн эрсдэлийг суурь эрсдэл, одоо энэ эрсдэлийн тооцоо үнэлгээг хийсэн үү? Энэ 14 төсөл гэнэ үү, хэд гэнэ вэ? Тэр олон ТЭЗҮ. Эрсдэлийн үнэлгээ хийсэн зүйл байгаа юу, үгүй юу?

Дунд хугацаа, урт хугацаандаа өрийн дарамт ямар байх юм? Эдийн засгийн гадаад, дотоод шокийн асуудлыг энэ төсвийн хүрээний мэдэгдэлтэй бодож байгаа юу?

Өнөөдөр энд энэ тухай яриад ямар нэг шок дарамт учрахгүй. Бид энэ зүйлийг ядуурал буурна гээд ингээд яриад гарвал дараа нь жилийн дараа асуу.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан хариулна.

Б.Жавхлан: Б.Батбаатар гишүүний асуултад хариулъя.

Яах вэ, ерөнхий онолын талын л асуулт тавьчихлаа гэж ойлголоо.

Аливаа өсөлт тэлэлт эрсдэл дагуулдаг. Эрсдэл дагуулна. Үнийн өсөлт дагуулна, төлбөрийн тэнцэл дээр эрсдэл гарна. Яг таны ярьж байгаа мөнгөний бодлогын зөөлрүүлэх орон зай тэр хэмжээгээр багасаж ирдэг.

Тэглээ гээд бид өсөлтийг хязгаарлаж зугтааж болохгүй. Хамгийн гол нь өсөлт маань өөрөө бодит өсөлт нь эерэг байх хэрэгтэй.

Өөрөөр хэлбэл инфляц байна. Нэмэгдэнэ. Өсөлт нь түүнээсээ давсан эерэг л байх хэрэгтэй.

Үүнийгээ л бид их зөв тооцоолж мөнгөний бодлого, энэ төсвийн бодлого хоёроо их сайн уялдуулж. Эцэст нь бид хөгжих боломжоо тавьж өгөх нь л их чухал юм гэж ингэж харж байгаа.

Энэ удаагийн бидний төсөв бол мөн л энэ рүүгээ харсан энэ 4 жилийн эхлэл. Магадгүй томоохон бүтээн байгуулалт, хөгжлийн дараагийн 30 жилийн циклийн эхлэлийг ч тавьж байгааг үгүйсгэхгүй.

Энд бид хуулийн боломжуудаа эхэлж тавьж өгч байна гэж харах хэрэгтэй.

Цаашдаа алхмаа яаж удирдах нь Засгийн газар, Төв банк үүрэг. Энд хяналт тавих, хууль эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгөх, стратегийг нь баталж өгөх, түүндээ хяналт тавих нь Их Хурлын бүрэн эрх байдаг.

Тэгээд энэ хүрээнд хэдүүлээ хамтраад ажиллаад явахад болохгүй зүйл байхгүй. Илүү амжилтад хүрэх боломж бидэнд байна гэж харж байна.

Төсвийн хүрээний мэдэгдэл маань одоо байгаа хуулиараа Эдийн засаг, хөгжлийн яам гаргадаг юм шүү. Эдийн засаг, хөгжлийн яам. Өөрөөр хэлбэл Эдийн засаг, хөгжлийн яам маань бидний хөгжлийн загварын хязгаарыг нь тавьж өгдөг. Ер нь чиглүүлдэг гэсэн үг байгаа юм.

Тэгэхээр төсвийн хүрээний мэдэгдлийг бас хүмүүс энэ тусгай шаардлагатай бас андуураад байх шиг байдаг юм. Төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилж болно. Энэ чинь эдийн засаг өөрчлөгдөх бүрд төсвийн хүрээний мэдэгдэл өөрчлөгдөнө.

Жил бүр батлуулдаг тоо шүү дээ. Жил бүр батлуулдаг тоо. Нэг удаа батлуулаад 3 жил үүнийгээ хараад суудаг зүйл биш байгаа юм. Жил болгон өөрчлөгдөнө, жил болгон шинэчлэгдээд явдаг ийм зүйл юм байгаа юм шүү.

Тэгээд мэдээж манай Эдийн засаг, хөгжлийн яам улам л цаашдаа би чадавхажна гэдэгтээ эргэлзэхгүй байна.

Тэгээд гадаад, дотоод бүхий л шокийг зөв тооцоолж оруулж ирсэн байгаа. Тийм.

Д.Амарбаясгалан:

Бямбадоржийн Пунсалмаа гишүүн асуултаа асууя.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу? Би гурван асуулт асууя.

Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл их өөдрөг тавигдсан

байгаа. Энэ жил 5.6, дараа жил 8 хувь гээд.

Гэтэл уурхайн бүтээгдэхүүний үнэ ханш, гадаад эрэлт буураад байна. Тийм ээ.

Тийм учраас энэ төсөөлөлдөө хүрэх боломж бололцоо юу байна? Эсвэл уул уурхайн бус дотоодын эрэлт хэрэгцээгээрээ бид төсвийн төсөөлөлдөө хүрэх боломж бололцоог юу гэж харж байгаа вэ? Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаарт нь, энэ том мега төслүүдээ дэд бүтэц, эрчим хүч. Тийм ээ. Энэ төслүүдээ бид хөдөлгөх хэрэгтэй байна.

Үүнийг хөдөлгөхийн тулд бид Төсвийн тогтвортой байдлынхаа тухай хуульд өөрчлөлт хийх шаардлагатай байгаа. Энэ өөрчлөлтийг дэмжиж байгаа.

Дэмжиж байгаа боловч бид цаашдаа томоохон төслүүдтэй холбогдолтой гадаадын том зээл, тусламж орж ирэх тухай бүрд нь Улсын Их Хурлын гишүүд хяналтаа тавьж, эдийн засаг судлаачдын санал, дүгнэлтийг нь сонсож шийдвэрээ гаргаж явах энэ боломж бололцоог юу гэж харж байгаа вэ?

Гишүүд ер нь эндээ байнгын хяналт, тухай бүрд нь хяналтаа тавьж байх нь хэрэгтэй гэж хэлэх гэсэн юм.

Гуравдугаарт нь, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн урсгал зардал нь дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй гэж энэ удаа өөрчлөлт оруулж ирэх гэж байгаа юм билээ.

Зардлын дээд таазыг тодорхойлж өгч байгаа юм шиг боловч одоо байгаа бидний дотоодын нийт бүтээгдэхүүний урсгал зардал нь 26, 27 хувьтай л байдаг. Тийм болохоор энэ өөрчлөлтөөрөө урсгал зардал өсөх гээд байгаа юм.

Тэгэхээр бид заавал ингэж урсгал зардлыг өсгөх шаардлагатай юм уу? Энэ төрийн захиргааны албаны ажил, үүргийн давхардлыг бууруулах, магадгүй мэргэжлийн холбоодоор зарим ажил, үүргийг шилжүүлэх боломж бололцоо юу байна?

Тэгээд үлдэж байгаа гурав, дөрвөн дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ хувийг төрийн үйлчилгээний энэ олон эмч, багш нарынхаа цалин хөлсийг нэмэгдүүлэхэд зарцуулах, Эс бөгөөс дотоодын нийт бүтээгдэхүүний зардлыг заавал өсгөхгүйгээр 26, 27 хувь дээр нь барьчих энэ боломж бололцоогоо юу гэж харж байдаг юм болоо гээд. Ийм гурван асуултыг асууя.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Б.Пунсалмаа гишүүнд баярлалаа. Дэмжиж үг хэлсэнд.

Сүүлийнхээс нь эхэлье. Урсгал зардал маань 30 хувийн. Энэ бол хязгаар шүү. Өөрөөр хэлбэл 30 хувиас давж болохгүй шүү л гэж байгаа юм.

Тэгэхээр үүнийг өөрөөр хэлбэл маргааш шууд 30 хувьд тултал нь бид ашиглана гэсэн зүйл огт биш шүү.

Бид аль болох мэдээж нөгөө 2 хувийн ашигтай байх ёстой гэдэг нөгөө талынхаа түгжээндээ баригдаад урсгал зардал маань хязгаарлагдаад явна гэсэн үг.

- Орлогодоо хязгаарлагдана.
- 30 хувьдаа хязгаарлагдана.

Гэхдээ нэмэх 2 хувь байх ёстой гэдгийг үүнийгээ бариад явна.

Түрүүн Б.Мөнхсоёл гишүүн гишүүн бас хэлж байсан. 100 хувь санал нийлж байна.

Энэ дээр бид бодлогын мэтгэлцээн байнга хийж байх болно. Нээлттэй бид ажиллана. Судлаачид, эрдэмтэд, мэргэжилтэн экспертүүдтэй аль болох л нээлттэй бид ажиллана. Тийм.

Гадаад эрэлтийн хувьд одоо бидэнд 10-аас 15 жилийн л хугацаа байна. Нүүрс дээр.

Бид ерөөсөө ганцхан зах зээлтэй. Урд талын.

Хятадууд маань жилд 3.5 тэрбум тонн нүүрс хэрэглэдэг. 3.5 тэрбум.

Бид 80-хан саяыг л нийлүүлдэг.

Аваад ир, аваад ир, хэчнээнийг л авчирна, хэчнээнийг л хил гаргаад шиднэ бид авна л гэдэг.

Тэгээд бидний зөөж чадаж байгаа хүчин чадал, ухаж гаргаж байгаа хүчин чадал маань 80 орчим байна л гэсэн үг байгаа юм.

Тэгэхээр энэ ёстой нөгөө үүлэн чөлөө гэдэг шиг бид 10-аас 15 жилийн энэ хугацаандаа бид тултал нь экспортлоод авах хэрэгтэй.

Харин энэ хооронд энэ нүүрснээс үл хамааралтай бид дэд бүтэц, эдийн

засгаа солонгоруулах энэ ажлаа хийж амжих хэрэгтэй байгаа юм.

Дотоодын үйлдвэрлэл, төрөлжүүлэх гээд байгаа нь.

Түүний төлөө бид энэ дэд бүтцүүдээ, одоо энэ өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчээ хангаж авах, энэ бүтээн байгуулалтууд, зам харгуй гээд. Үүнийгээ л бид энэ ойрын жилүүдэд хийгээд авъя л гээд байгаа юм шүү дээ.

Бидний гол санаа маань энэ юм байгаа юм. Хамтарсан Засгийн газрын үед.

Сандал, ширээгээ жоохон хойш нь тавьж байгаад энэ дэд бүтцүүдээ хийгээд авъя л гэж байгаа юм шүү.

Тэгээд үүнийг маань дэмжиж өгөөрэй л гэж хүсээд байгаа юм. Тийм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Банзрагчийн Түвшин гишүүн асуултаа асууя.

Б.Түвшин: Хэдүүлээ сүүлийн хэд хоног энэ төсвийн тухай л нэлээн мэтгэлцэж ярьж л байна.

Ер нь Улсын Их Хурлын гишүүд гэдэг төрөл бүрийн мэргэжлийн хүмүүс.

Тэгэхдээ бүгдээрээ бүгдийг мэддэг гэсэн үг биш.

Цөөхөн хэдхэн шийдвэр гаргахдаа мэргэжлийнхээ судлаачдын олон жилийн дүгнэлтийг харж шийдвэр гаргах зүйлүүдийн нэг бол энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн өөрчлөлт юм.

Бусад юмыг мэдрэмжээрээ ч юм уу, өөрийнхөө мэдлэгт суурилж болох л юм.

Яагаад гэвэл эндээс гарах үр дүн ирээдүйн Монголчуудын 5, 10 жилийн амьдралын дүр төрхийг харуулах учраас. Энд уг нь суурьтай хандья л гэж байгаа юм.

Түүнээс биш нэг хэсэг газар нь идэж уух гээд бөөн тоо толгой оруулж ирээд, нөгөөдөх нь түүнээс нь харамлаад суугаад байгаа ч юм биш.

Энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг өөрчлөхгүй ээ гэж үзээд байгаа шалтгаан нь мэргэжлийн суурь судлаачид ороогүй, маш богино хугацаанд гаргаж байгаа шийдвэр.

Гуравдугаарт, энэ дээр үзэл баримтлалын зөрүүтэй байгаа учраас л мэтгэлцээн өрнүүлээд гурав, дөрөв хоног л мэтгэлцлээ.

Дээрээс нь энэ чинь дандаа ирээдүйн таамаглалын тухай ярьж байгаа учраас тэр ирээдүйн таамаглалыг гадна дотнын мэргэжилтнүүд, судлаачдаасаа авч байгаад явуулбал уг нь бид илүү тогтвортой шийдвэр гаргах байсан юм л даа.

Энэ “тэнцвэржүүлсэн тэнцэл” гэдэг аргыг “суурь тэнцэл” гэдэг арга руу шилжүүлж орж ирж байна.

Байдаг л арга. Олон улсад аль альныг нь сольж болдог.

Гэхдээ солихын тулд энэ уг нь их цаг шаарддаг. Ялангуяа тэр өрийн дээд хязгаар 60 гээд байгаа нь байж л байгаа. Гэхдээ өрийг тэнцэлтэй нь, орлоготой, зардалтай нь уг нь хослуульж байж

барьдаг энэ аргыг л энэ тэнцвэржүүлсэн тэнцэл гээд байгаа юм л даа.

Нэг ёсондоо одоо манайх өр хязгааргүй ч юм шиг. 60 хувьтай гээд аль нь ч байсан одоо мөнгөө гаргах гэхээр орж байгаа бүх орлогоо урсгал зардалдаа ихэнх зарчхаж байгаа байхгүй юу.

Тэгээд тэр урсгал зардлаа багасгаж байгаа тэр хэмжээгээрээ зээл авах эрх нь Засгийн газарт байгаа. Гэтэл Засгийн газар богино хугацаанд урсгал зардлаа багасгаж чадахгүй учраас тэр гадаад, дотоодоос авч байгаа зардлаа л, цулыг нь хасаж тооцож байгаад оруулья гэж хэлж байгаа юм.

Үүний эрсдэл нь болохоор нөгөө өрийн тэнцлийн орлогын зарлагын балансжуулдаг арга байхгүй. Одоо бид яаж байна вэ гэхээрээ төсвийнхөө бүх орлогыг урсгал зардал руу болгоод 2 хувийн ашигтай гаргаж байна.

Магадгүй дотоодын нийт бүтээгдэхүүний ч гэдэг юм уу, төсвийн орлого нь ч гэдэг ч юм уу 60 хүртэл хувийн зээлтэй болно.

Тэгэхээр энэ бол ирээдүйд эрсдэлтэй байж магадгүй л гэдэг нэг талын үзэл баримтлал. Хэтэрхий богино хугацаанд мэргэжлийн бус байдлаар сэтгэл хөдлөлөөр, эмоциор хандаж хоёр талын мэтгэлцээн өрнөж байна л гэдэг дээр л мэргэжлийн маргаад яваад байгаа.

Тэгээд энэ маргааныг би ажлын хэсэг дээр болон Төсвийн байнгын хороон дээр өмнөх чуулганы хурлууд дээр байнга илэрхийлсэн учраас давтаад яах вэ.

Хоёр, гуравхан асуултыг асууя.

Өнөөдөр манай Монгол Улсын гадаад дотоодоос авсан зээлийн хүү манай төсвийн орлогын хэдэн хувийг эзэлж байгаа вэ?

Хоёрдугаарт, манай ирээдүйд авч магадгүй, ялангуяа дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ буюу тэр өрийн дээд хязгаараар авсан зээл нь манай төсвийн орлогын хэдэн хувийг эзлэх вэ?

Дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьтай тэнцэх хэмжээний ашиг гарна гээд байгаа энэ ашиг нь, өөрөөр хэлбэл ирээдүйн 5-аас 8 жилийн уул уурхайн орлогын хэлбэлзэлтэй хэдэн хувийн хэлбэлзлийг бид давж гарах вэ?

Энэ дээрээс эцэст нь дүгнэж хэлэхэд бид энэ хэлбэлзлийг л ер нь бууруулж болох юм байгаа юм.

Ер нь манай Монгол Улс гадаад дотоодын валютын эрсдэлийн хэлбэлзлийн эрсдэлд орох уу? Уул уурхайн эрсдэлд орох уу? Ойрын 5-аас 10 жилийн прогнозуудыг хэлж өгөөч ээ гэсэн ийм л суурь хэдэн асуултыг энэ удаа асууя гэж бодож байна.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж хариулна.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. Б.Түвшин гишүүний асуултад хариулья.

Яах вэ, тусгай шаардлагыг өөрчилж байгаа хэд хэдэн шалтгаан байгаа. Үүний хамгийн чухал бидний оруулж ирсэн шалтгаан бол өнөөдөр олж байгаа орлогоо бүгдийг нь цалин, тэтгэвэр, халамж тавиад, бүтээн

байгуулалт хийхгүйгээр дуусгачихгүй ээ гэдэг зүйл л хэлж байгаа юм.

Үүний тулд урсгал зарлага 30 хувиар хязгаарлах хязгаарлалт орж ирсэн байгаа.

Хоёрт нь, одоо олж байгаа орлогоосоо орлого ахиухан олж байгаа дээрээ өрөө төлье өө л гэж байгаа юм.

Энэ нь тусгай шаардлагаар бас дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиар заавал өр төл гэдэг тусгай шаардлага орж ирж байгаа.

Гуравт нь, олж байгаа орлого дээрээсээ тусгайлан орон зай гаргаад бүтээн байгуулалт хийе ээ гэдэг ийм гурван логик л орж ирж байгаа.

Энэ гурван логиктой холбоотой байгаа.

Тоонуудын хувьд бид гаднаас авч байгаа зээлийг бид орлого тооцож авдаггүй. Одоо өөрчлөөд байгаа нөгөө тэнцвэржүүлсэн тэнцлийг бид суурь тэнцэл гэдэг тусгай шаардлагаар өөрчлөх гээд байгаа ерөөсөө шалтгаан нь тэр.

Өөрөөр хэлбэл бид олж байгаа татварын орлогоороо нийт орлого гэж үзээд нийт гарч байгаа зарлагадаа зээлийн ашиглалтаа оруулаад ингээд эндээсээ тэнцлээ боддог л ийм л манай арга болчхоод байгаа юм.

Энэ агуулгаараа бид бүтээн байгуулалтаа хийж чадахгүй. Өнөөдрийн бидний үүсээд байгаа нөхцөл энэ болчхоод байгаа юм.

Хүүгийн төлбөрийн талаар асууж байсан. 2024 оны хувьд хүүгийн зардал 1 их наяд 173.0 тэрбум төгрөг байгаа.

Бид тооцооллын хоёр янзын өөр аргаар өрийн дарамтыг тооцож үзсэн.

Одоо яг Сангийн яамны оруулж өгсөн энэ тусгай шаардлагаар баталж өгсөн тохиолдолд 2029 он хүртэл хоёр аргаар хоёулангаар нь үзэхэд бид өрийн дарамтад орохгүйгээр өнөөдрийн байгаа өрийн түвшин хэвээр хадгалагдахаар, хүүгийн зардал бас хэвээр хадгалагдахаар, арай бага зэргээр буухаар ийм тооцоо гарч ирээд байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдаваа асуултаа асууя.

Б.Пүрэвдаваа: Оройн мэндийг хүргэе.

Тогтвортой байдлын зөвлөлөөс асуулт байна.

Танайх дүгнэлт гаргахдаа эрсдэлтэй байна. Энэ хуульд өөрчлөлт оруулах нь эрсдэл дагуулах бас боломжтой гэдэг ийм дүгнэлт гаргасан. Сүүлийн 3 өдөр Байнгын хорооны хурал болон ажлын хэсгийн хурлууд дээр энэ танин мэдэхүйн шинжтэй онол талын мэдээллүүд нэлээн яригдлаа.

Тэгэхээр зөвлөл эрсдэл гарах юм яг аж ахуйн нэгжүүдэд, иргэдэд ямар үзүүлэлтүүд нь голлох эрсдэлийг дагуулах юм бэ? Жишээгээр үнийн өсөлт, ажилгүйдэл, ядуурал, аж ахуйн нэгжүүд голчлон дарамт болж байгаа нийгмийн даатгалын шимтгэл, НӨАТ-ын төлөлтийн асуудал дээр ямар нөлөө үзүүлэх вэ?

Дээрээс нь тодорхойгүй байдал үүсээд байгаа зүйл нь энэ улс төрийн нөхцөл байдлыг Та бүхэн бас нэг мэргэжлийн улсууд, дээрээс нь хараат

бус дүгнэлт гаргадаг байгууллагын хувьд жишээгээр Б.Түвшин гишүүн бол Ардчилсан намын төлөөлөл.

Ардчилсан намын бүлгийн санал Төсвийн байнгын хороон дээр эсрэг байр суурьтай саналыг илэрхийлсэн.

Г.Тэмүүлэн гишүүн бол Монгол Ардын намын бүлгийн төлөөлөл. Өмнө нь Төсвийн байнгын хорооны дарга хийж байсан хүн. Мөн эсрэг байр суурьтай байгаа.

Гэтэл энэ өөрчлөлтийг Засгийн газар оруулж ирэхдээ гурван намын хамтарсан мөрийн хөтөлбөрийн гол зүйл юм гэдгийг хурал болгон дээр тайлбарлаад байгаа юм.

Тэгэхээр зөвлөл яг иргэддээ зориулаад ойлгомжтой байдлаар энэ тодорхойгүй байдлыг.

Ямар эрсдэл байна вэ гэдгийг ойлгомжтойгоор нэг тайлбарлаад тоон мэдээллээр нэг хэлээд өгвөл болох уу л гэж асуумаар байгаа юм.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн. Ажлын хэсгийн 8 дугаар микрофон.

Ж.Дэлгэрсайхан: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан. Б.Пүрэвдаваа гишүүний асуултад хариулья.

Бид энэ хавар томилогдсон гэдгээ түүрүүн хэлсэн.

Тэгээд 3 сарын 15-нд бид 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-

2027 оны төсвийн төсөөллийн талаарх макро эдийн засгийн тоонуудыг Эдийн засгийн хөгжлийн яаманд гаргаж өгсөн байдаг.

Тэр хүрээнд бидний гол олж харсан зүйл бол эдийн засгийн өсөлт гэдэг зүйл ойрын нэг, хоёр жилдээ харьцангуй өндөр байж болох боловч цаашдаа эдийн засаг дээр цохилт, ялангуяа уурхайн салбараас ирсэн цохилт үүсэж болзошгүй юм байна гэсэн ийм макро эдийн засгийн таамаглал гаргасан.

Тэр хүрээнд бидний гаргасан таамаглалын хувьдаа бид төсвийн дунд хугацааны хүрээний мэдэгдлийн тоонуудыг анх удаагаа дээд, доод хязгаартай эрсдэлээс хамгаалсан тоонууд гаргаж өгсөн юм.

Тэр тоонуудын хувьд бид эдийн засгийн өсөлтийн хувьд энэ жилдээ бид 5-аас 6 хувьтай. Дараа жилд харьцангуй өндөр. Түүнээс цаашаа буурч болзошгүй юм байна гэсэн ийм дүгнэлт гаргаад төсвийн зарлагын хувьд 2025 онд бүр яг энэ 2024 оныхоо хувьд түвшинд хадгалаад, түүнээс цааш 3 орчим их наядын өсөлттэйгөөр явж болох юм байна гэсэн ийм төсвийн зарлагын таамаглал, тэрхүү эдийн засгийн таамаглалдаа тулгуурлаад гаргасан.

Бидний гол эрсдэл гээд байгаа зүйлийг, бидний хуулиар хүлээсэн үүргийнхээ хүрээнд бид “төсвийн тогтвортой байдал” гэдгийг нэгдүгээрт эдийн засгийн нөхцөл байдалд тохирсон зарлагын өсөлтийг хязгаарласан дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн зардлын хувь хэмжээг хязгаарласан ийм байдлаар явах нь зүйтэй гэсэн энэ төсвийн тусгай шаардлагынхаа хүрээнд нэгдүгээрт харсан.

Хоёрдугаарт нь, бидний харсан өнцөг бол хэрвээ төсвийн тэлэлт үргэлжлэх юм бол Монгол Улсын эдийн засагт харьцангуй сөрөг үр дагавар гарах юм бол яах вэ гэдэг ийм байдлаар тооцсон юм.

Энэ өнгөрсөн арван хэдэн жилийн эдийн засгийн нөхцөл байдлыг тооцвол Монгол Улсын эдийн засаг үнэхээр хэлбэлзэлтэй байсан гэдгийг Та бүхэн мэднэ.

Тэр хүрээндээ хамгийн гол нь эдийн засаг унах юм бол төсвийн орлого дээр томоохон дарамт ирэх юм байна. Нарийвчилсан таны хэлээд байгаа тоонуудаас илүү бидний гол анхаарсан зүйл бол төсвийн орлого тасалдах юм бол бид эдийн засгийн хувьд энэ томоохон төсөл хөтөлбөр хэрэгжихгүй царцсан төслүүдтэй өрийн дарамтад орсон. Магадгүй 2017 оных шиг тийм хүнд байдал руу орсон ийм нөхцөл байдал үүсэж болзошгүй юм байна гэж өөрсдийнхөө хуулийн хүрээнд эрсдэлээс хамгаалах тэр чиг үүргийнхээ дагуу ийм л дүгнэлтүүдийг хийчхээд байж байгаа юм.

Хэрвээ ийм байдал үүсвэл мэдээж хэрэг иргэд дээр, аж ахуйн нэгжүүд дээр томоохон дарамт болох нь тодорхой.

Учир нь өнөөдөр Монгол Улсын татварын орлого нь өөрөө дотоодын нийт бүтээгдэхүүний 34.0 хувь хүрчихсэн. Өнөөдрийн хөгжиж байгаа Монгол Улсын энэ түвшинтэй харьцуулахад бараг хөгжингүй орнуудын тодорхой түвшинд хүрчихсэн ийм өндөр татварын дарамттай байгаа гэдгийг хэлмээр байна.

Д.Амарбаясгалан:

Б.Пүрэвдаваа гишүүн тодруулга. Кнопоо дарахгүй байж байя. Микрофон өгье.

Б.Пүрэвдаваа:

Таны харж байгаагаар яг бүр тухайлсан, ялангуяа иргэд аж ахуйн нэгжүүдэд эрсдэлтэй нөхцөл эдийн засгийн хямрал боллоо гэж төсөөлье. Хил хаагдъя. Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурлаа гэж бодъё.

Тэр үед ийм ийм эрсдэл тохиох магадлал хамгийн өндөр нь ийм ийм үзүүлэлтүүд байх юм гэдэг дээр нэг бүр тодорхой хэлмээр байна. Өөрсдийнхөө байр суурийг.

Тэндээс гарах ямар арга зам байгаа юм?

Д.Амарбаясгалан:

Нэмж хариулах уу? Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн. Ажлын хэсгийн 8 дугаар микрофон.

Ж.Дэлгэрсайхан:

Тэгэхээр гишүүний асуултад тодруулахыг хичээе.

Түүрүүн бидний тэр тооцсон тооцооллын аргачлалын хувьд бид Монгол Улсын эдийн засаг яг энэ сүүлийн арав гаруй жилд ямар хэмжээний цохилт авч байсан бэ гэдэг дундаж түвшин дээр тулгуурлаж цохилтын тэр нөлөөллийг нь тооцохыг хичээсэн байдаг.

Тэгэхээр тэр хүрээнд харвал хэрвээ нүүрсний экспортын хэмжээ буураад магадгүй үнэ 100-аас доошоо орсон тохиолдолд бидний хувьд төлбөрийн тэнцлийн урсгал алдагдал нэлээд өндөр хэмжээгээр нэмэгдэж, төсвийн алдагдал 2 хувиасаа давах ийм нөхцөл байдал үүсэх юм байна.

Энэ нь Монгол Улсын өрийн дарамтыг илүү их нэмэгдүүлэх ийм боломжтой байна л гэсэн дүгнэлт хийж байсан юм.

Одоогийн орж ирээд байгаа төслийн хүрээнд урсгал зардал 30 хувь болж, өрийн таазыг 60 луу хүргэх юм бол бид бас энэ эрсдэл илүү их нэмэгдэх байх л гэж харж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя. Шадар сайд Тогмидын Доржханд.

Т.Доржханд: Би яг энэ асуулт хариултын төгсгөлд нь бас нэг тодруулга хийх нь зүйтэй юм шиг байна.

Яг энэ Тогтвортой байдлын хуулийг Сангийн яаманд байхдаа оруулж ирж байсан. Энэ маш зөв.

Тэгээд ийм хэлэлцүүлэг болж байгаа нь эрүүл юм. Харин гишүүд нэг тодорхой ойлголттой байгаасай гэж хүсэж байгаа юм.

Бид энэ төсвийн тогтвортой байдлын хуулийг хийхдээ энэ урсгал зардлыг хянах, хязгаарлах байдлаар хийж байсан юм.

Тэгээд төсвийн алдагдал, өр гээд энэ 4 индикатораар ингээд явж байсан.

Одоогийн энэ тэлэлт нь юу хийх гээд байна гэхээр хөрөнгө оруулалт руу мөнгөө суллаж гаргаж ирж байгаа юм. Хуучин манай төсөв чинь дандаа барилга санхүүжүүлдэг байсан байхгүй юу. Байшин, зүгээр соёлын төвүүд, юу байдаг юм. Байшин барих тусмаа л нөгөө урсгал зардлуудад өсөөд байдаг.

Ингээд л төсөв чинь дийлэхээ больчихсон. Халамжийн төсөв болчихсон. Цемент санхүүжүүлдэг төсөв болчихсон. Хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөв биш байсан байхгүй юу.

Тэгвэл одоо энэ нэмэлтүүд чинь дандаа хөрөнгө оруулалтыг шийдье. Өнөөдрийн бидний яриад байгаа энэ бүтээн байгуулалтуудыг шийдье ээ гээд. Үнэн үнэн. Эдийн засгийн хаалт бол.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт минут өгье. Гүйцээж хариулъя.

Т.Доржханд: Баярлалаа.

Тэгэхээр эдийн засгийн хаалтууд үүснэ. Макро үзүүлэлтүүд өөрчлөгдөнө.

Гэхдээ энэ тохируулгуудыг чинь мөнгөний бодлого, төсвийн бодлогын уялдаагаар хийдэг юм.

Одоо бид юу руу орох гээд байна гэхээр өнөөдөр 4 жилийнхээ хөтөлбөрөөр том том төслүүдээ санхүүжүүлнэ гэдгээ шийдчихлээ. Хувийн хэвшлээр санхүүжүүлнэ шүү дээ.

Тэдний тодорхой хэсгийг нь төсвөөс гаргаж байж, комментмент хийж байж энэ төслүүд чинь цаашаа явах юм.

Тэгэхээр урсгал зардлын санхүүжилт биш, илүү хөрөнгө оруулалт руугаа оруулсан ийм шийдвэр гарч байгаа болохоор энэ нь эргээд нөгөө төсвийн тогтвортой байдалд, макро эдийн засагт хүндрэл учруулах вий.

Дээрээс нь өр хүнд байдалд орох вий гэдэг тийм эрсдэл өндөр биш шүү.

Эсрэгээрээ энэ нэрсэн үнээр өрийн үзүүлэлтээ тооцно гэдэг чинь олон улсын байгууллагуудын харин хүлээж байгаа зүйл юм. Энэ үзүүлэлтээ чангаруулаад байгаа юм. Үүнийг бид буруугаар ойлгож болохгүй шүү.

Харин агуулгын хувьд энэ өөрчлөлтийг хийх үү, үгүй юу гээд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилж ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлнэ.

Индэр дээрээс үг хэлэхээр байгаа. Бадрахын Найдлаа гишүүн 2 дугаар индэр дээрээс үг хэлье. Удахгүй санал хураалт явагдана.

Б.Найдалаа: Баярлалаа.

Ерөнхийдөө одоо орж ирж байгаа хуулийн төсөл, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, энэ өөрчлөлтүүдийг зарчмын хувьд дэмжиж байгаа.

Гурван нам хамтраад том асуудлаа шийдье. Олон жил ужгирчхаад байгаа, гацчихаад байгаа асуудлуудаа шийдье, эдийн засгаа урагшлуулъя гэдэг дээр дэмжиж байгаа.

Гэхдээ бас санаа зовж байгаа зүйлс байна. Тухайлбал, энэ төсвийн дүрмүүд, тогтвортой байдлын тухай хууль. Энэ дүрмийн өөрчлөлт дээр, төсвийнхөө үндсэн дүрмийг өөрчилсөн дээр одоо энэ танхимд ч гэсэн

мэргэжилтнүүдийн хүрээнд, Төсвийн байнгын хорооны дарга ч гэсэн бас цухуйлгаж байна.

Яг нэгдсэн санал байхгүй байгаа байхгүй юу. Төсвийн дүрэм бол урт, дунд хугацаанд үйлчлэх ёстой маш чухал дүрэм. Үүнийг арай хийж баталсан. Монгол Улс.

Хэрэгжүүлж бас бүрэн сураагүй байгаа. Дадаа ч үгүй байгаа.

Үүнийг харин яг энэ төсвийн тодотголтой хамтруулаад ийм богино хугацаанд яаран түргэн оруулж ирж байгаа нь зарчмын хувьд буруу гэж бодож байна.

Тодотголыг бол хийчих. Ойлгомжтой шүү дээ. Засгийн газрын бүтэц өөрчлөгдөж байгаа, зардлууд өөрчлөгдөж байгаа. Дараа нь арай тусад нь байдлаар оруулж ирсэн бол зөв байсан юм.

Тэгээд энэ дээр би бас эргэлзэж байна. Засгийн газрын гишүүд болон Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн яг энэ дүрмээ өөрчилснөөр ямархуу нөхцөл байдал эрсдэлтэй орчин үүсэх вэ гэдгийг маш сайн мэдэж байгаа болов уу гэдгийг би бас эргэлзэж байна.

Төсвийг батлуулаад явах амархан. Дараа нь харин энэ зардал нэмэгдэх, гадаад өр нэмэгдэх, үүнийг тооцохгүй шахуу зардалтай болж байгаа нь бид нарт ямар эрсдэл үүсэх вэ гэхээр яг л магадгүй 2012 оноос 2016 онд байсан нөхцөл байдал давтагдах магадлалтай шүү.

Би үүнийг санаа зовоод хэлж байгаа юм. Яагаад гэвэл төсвийн зарлага нэмэгдүүлэх үүдийг нь нээчих юм бол

Сангийн яам ч, яг энэ танхимд Улсын Их Хурал хянах боломжгүй байхгүй юу.

Ер нь боломжгүй. Гадаад зээлийн өсөлтийг ч гэсэн дээ. Нийслэл ч юм уу, орон нутгийн бонд, зээл тавих бүрэн боломжтой болчхож байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээрээ Засгийн газрын хувьд маш том хариуцлага ирж байна. Тэлэх ёстой. Хөрөнгө оруулалтаа нэмэх ёстой.

Энэ дээр харин хяналтаа яаж тавих юм бэ. Энэ дээр онцгой ажиллах ёстой.

Өмнө нв гарсан эрсдэлийг гаргахгүй байх талаас анхаарах том хариуцлага байна.

Дараагийн нэг зүйл нь, төсвийн тэр цаглавруудыг өөрчилж байгаа дээр бас санал нийлэхгүй байна.

Улсын төсөв дүнгээрээ томорсон. Гишүүдийн тоо олширсон. Хүрээ нь нэмэгдсэн. Үүнийг өмнөх шигээ ийм богино хугацаанд хэлэлцэх юм бол сайн хэлэлцүүлэг болж чадахгүй.

Тэгээд олон нийтэд, Их Хурлын гишүүдэд хугацаа хэрэгтэй.

Тэгэхээр 10 сарын 01 байсныг нь 9 сарын 01 болгосноо буцаагаад 10 сарын 01 болгож байгаа юм байна. Энэ дээр санал нийлэхгүй байна.

Процессын хувьд төсөл боловсруулах, санал гаргах дээр хугацаа хэрэгтэйг би ойлгож байна. Тэгэхдээ үүнийг яаж ийгээд Монгол Улс төсвөө эртхэн хэлэлцдэг, эртхэн олон нийтэд нээдэг, сайн хэлэлцүүлдэг, сайн баталдаг байх ёстой. Энэ дээр бодоосой гэж бодож байна.

Өрийн хязгаар яриад байна. 60.0 хувь. Дотоодын нийт бүтээгдэхүүний.

Хэрвээ өрийнхөө орон зайг нэмэгдүүлж байгаа юм бол энэ 60.0 хувиа багасгах бодлого байна уу? Үүнийгээ 50.0 хувь болгож болно шүү дээ.

Тэгэх юм бол бид нөгөө эрсдэл багасаад явчихна. Тэртээ тэргүй өрөө нэмэх, зээлээ нэмэх орон зай байгаа.

Тэгээд эцэст нь хэлэхэд ХҮН намын зүгээс, ХҮН намын гишүүд бид хэдий хамтарсан засагт орсон, дэмжиж ажиллаж байгаа, төслүүдийг явуулъя, ажил хийе, бүтээе гэж байгаа боловч ямар нэг зарчмын хувьд буруу, мэргэжлийн хувьд буруу, маргаантай зүйл байх юм бол нөхцөл байдлыг үл харгалзан хэлж ярьж, шүүмжилж, шаардлагатай бол зогсоож явна.

Тэгэхээр дахиад хэлэхэд өнөөдрийн Засгийн газарт өмнө нь гарсан эрсдэлийг давтахгүйн төлөө, зардлаа тавьчихгүйн төлөө, макро эдийн засагт тогтвортой байдлаа алдахгүйн төлөө хяналттай сайн ажиллах шаардлага үүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн индрээс үг хэлнэ.

2 дугаар индэр.

М.Нарантуяа-Нара: Давхацсан байгаа тул санал байхгүй.

Д.Амарбаясгалан: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн 1 дүгээр индрээс үгээ хэлнэ. Цаг яваад эхэлсэн байгаа.

Г.Тэмүүлэн: Гишүүддээ бас оройн мэнд хүргэе.

Тэгэхээр төсвийн хүрээний мэдэгдлийг дагалдуулж Төсвийн тогтвортой байдлын тухай хууль орж ирж байгаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг Та бүхэн онцолж сайн уншаарай.

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гэдэг маань үндсэндээ энэ төсвийн тусгай шалгууруудыг хэрэгжүүлэх, мөрдүүлэх зорилго бүхий ийм гол Үндсэн хууль байгаа юм. Тэр дундаа манай төсөв санхүүгийн байгууллагууд болсон Эдийн засаг, хөгжлийн яам Сангийн яамныхан Үндсэн хууль шигээ мөрдөж байх ёстой хууль байгаа юм.

Сая хэлэлцүүлгийн явцад бас нэг тийм ташаа өнгөц мэдээллүүд гарч ирж байна. Би энэ дээр залруулах юмыг хийх ёстой гэж бодоод байгаа юм.

Энэ юу юм бэ гэхээр нэг жилийнхээ төсвийг боловсруулахдаа төсвийнхөө хүрээнийхээ мэдэгдэлтэй нийцүүлж орж ирж байх ёстой. Хуулиараа. Ингээгүй бол хориглоно.

Төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг бол үндсэндээ Монгол Улсын энэ төсвийн бодлогын баримт бичиг байгаа юм. Бодлогын баримт бичиг.

Энэ бодлогын баримт бичгийг боловсруулахдаа бид бүхэн харин төсвийн тусгай шаардлагыг хангасан, нийцүүлж хийж байх ёстой асуудал байгаа юм. Хангаж нийцүүлж хийж байх ёстой асуудал.

Тэгэхээр үндсэндээ нэг талдаа төсвийн тусгай шаардлага гэдэг амин чухал асуудал. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль.

Нөгөө талдаа бид дунд хугацааныхаа төсвийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа тусгай шаардлагаа хангаж, мөн нэг жилийнхээ төсвийг боловсруулж орж ирэхдээ үүндээ ч гэсэн нийцүүлж хийж байх ёстой асуудлууд байгаа юм.

Тэгэхээр энэ үндсэндээ Монгол Улсын Их Хурлаас Засгийн газартаа, төсөв санхүү, эдийн засгийнх нь талаас нь хяналт тавьж, төсөв санхүүгийнхээ аюулгүй байдлыг хангах үндсэн суурь бодлогын баримт бичиг. Суурь Үндсэн хууль гэж би хэлээд байгаа нь энэ байгаа юм.

Тэгэхээр бид үүнийг өнгөрсөн магадгүй энэ хууль батлагдсанаас хойших энэ 15 жилийн хугацаанд, 14 жилийн хугацаанд төсвийнх нь тусгай шаардлагыг нэг ч мөрдөж ирж байгаагүй.

Энэ бол төсвийн тэнцлийн алдагдал 2 хувь, Засгийн газрын өрийн үлдэгдэл 60 хувь.

Ганцхан 2015 онд Засгийн газрын өрийн үлдэгдэл 60.0 хувьдаа ганцхан удаа хүрсэн шүү. 58 байсан.

Түүнээс хойш нэг ч хэрэгжиж байгаагүй. Энэ хууль хэзээ ч хэрэгжиж байгаагүй. Жил болгоны төсвийг оруулж ирж байхад, жил болгоны төсвийн тодотголыг оруулж ирж байхад төсвийн хүрээнийх нь мэдэгдлийг нь буюу төсвийн бодлогын баримт бичгийг нь дандаа өөрчилж орж ирдэг.

Тэрийг өөрчлөхийн тулд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг нь дандаа өөрчилж орж ирж байгаа. Түүнд заасан тусгай шаардлагуудыг нь, хугацааг нь хойшлуулж орж ирж байгаа.

Арга ядсандаа бид Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг цоожлох гэж төсвийн шинэчлэлийн хүрээнд үүнийг цаашид хугацааг нь сунгах, хэмжээг нь өөрчлөхийг нь, бууруулахыг нь хориглоно гэсэн зохицуулалтуудыг хийж өгч байсан асуудал.

Тэгэхээр энэ дээр манай гишүүд бас онцгой анхаарал хандуулж ирээрэй.

Цаашид энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулж байгаа тусгай шаардлагад тооцогддог, хэмжигддэг, төсвийн хүрээний мэдэгдэлд ордог шалгуур үзүүлэлтүүд буюу Засгийн газрын өр, мөн дээрээс нь төсвийн суурь зарлага болон тэнцлүүдийг тооцохдоо эдгээрүүд нь орохгүйгээр тооцож орж ирж байгаа.

Одоо цаашдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хууль байх шаардлагагүй болж гарч ирж байгаа.

Тэр 60.0 хувь байх шаардлагагүй болж таарч ирж байгаа. Тэр 2 хувь байх шаардлагагүй болж таарч ирж байгаа.

Энэ хуулийг бид цаашид мөрдөх ч шаардлагагүй. Улсын Их Хурал цаашид төсвийн хүрээний мэдэгдлийг ч хэлэлцэж нэр төдий нэр зүүх шаардлага байхгүй.

Тэгэхээр энэ хуулийг бид төсвийн хүрээг дагуулж орж ирж байгаа Тогтвортой байдлын хуулийг дэмжихгүй.

Түүнээс томоохон гоё төсөл, хөтөлбөрүүд оруулж ирэхийг дэмжинэ.

Өнөөдөр харин Эдийн засаг, хөгжлийн яам энэ төслүүдийг эрэмбэлж оруулж ирэх хуулийн зохицуулалтыг бид төсвийн шинэчлэлийн хүрээнд оруулж ирсэн.

Аль нь эдийн засгийн үр өгөөжтэй юм, аль нь түрүүлж явах ёстой юм. Эргээд Монгол Улсын нийт төсөвт өр зээлд хэрхэн нөлөөлөх юм гэдгийг тооцож оруулж ирэх ёстой байсан.

Тэгэхээр энэ үүднээс Та бүхэн анхаарч дүгнэж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гишүүд үг хэлж дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй 9 санал байгаа.
/алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41.6-д хуралдаан даргалагч санал хураалт явуулах цагийг урьдчилан товлон зарлах бөгөөд санал хураалт явуулахаас 5 минутын өмнө тусгайлан дохио өгч гишүүдэд мэдэгдэнэ гэж заасан байгаа.

Тэгэхээр 5 минутын дараа санал хураалт явуулна. Бүлгийн дарга нарыг орж ирэхийг урья.

Улсын Их Хурлын гишүүдийг суудлаа эзлэхийг урьж байна. 5 минутын дараа санал хураалт.

Санал хураалтаа эхлүүлье. Эхлээд чуулганд байгаа гишүүдийн ирцийг бүртгэх зорилгоор ирцийн санал хураалтыг явуулъя. Зөвшөөрснөөр санал өгнө. Санал хураалт. /алх цохив/

Миний санал орсонгүй. Өөр санал нь ороогүй гишүүд байна уу? Т.Доржханд гишүүн, Б.Хэрлэн гишүүн. 3 гишүүний санал ороогүй байна.

Ингээд зарчмын зөрүүтэй 9 санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, дэмжсэн болон дэмжээгүй, дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно гэж хуульд заасан байгаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Байнгын хороо дэмжсэн санал.

1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн 3 дахь заалтын “орлогын хэмжээ” гэснийг “орлогын доод хэмжээ” гэж, 9 дэх заалтын “санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ” гэснийг “хуваарилах зардлын дээд хэмжээ” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ч.Анар, А.Ариунзаяа, Д.Батбаяр, Р.Батболд, Э.Болормаа, П.Ганзориг, Х.Ганхуяг, П.Мөнхтулга, Д.Пүрэвдаваа, Б.Пунсалмаа, Б.Түвшин, Б.Уянга, Дав.Цогтбаатар, Ж.Чинбүрэн.

Цаашид “Ажлын хэсэг” гэх. Санал хураалт. /алх цохив/

63.9 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн 4 дэх заалт буюу “Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ” 2025 онд “32,992.0” гэснийг “31,901.6” гэж, 2026 онд “35,849.5” гэснийг “34,967.8” гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2025 онд “34.7” гэснийг “33.6” гэж, 2026 онд “34.2” гэснийг “33.4” гэж, үзүүлэлтийн 5 дахь заалт буюу “Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл” 2025 онд “-2,990.7” гэснийг “-1,900.3” гэж, 2026 онд “-2,975.9” гэснийг “-2,094.1” гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2025 онд “-3.1” гэснийг “-2.0” гэж, 2026 онд “-2.8” гэснийг “-2.0” гэж, үзүүлэлтийн 6 дахь заалт буюу “Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ” 2025 онд “28,101.0” гэснийг “27,010.6” гэж, 2026 онд “30,779.5” гэснийг “29,897.8” гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2025 онд “29.6” гэснийг “28.4” гэж, 2026 онд “29.4” гэснийг “28.6” гэж, үзүүлэлтийн 7 дахь заалт буюу “Нэгдсэн төсвийн суурь тэнцэл” 2025 онд “1,900.3” гэснийг “2,990.7” гэж, 2026 онд “2,094.1” гэснийг “2,975.9” гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2025 онд “2.0” гэснийг “3.1” гэж, 2026 онд “2.0” гэснийг “2.8” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

63.0 хувиар санал дэмжигдлээ.

Миний хурууны хээ таньсангүй. Дэмжсэн саналд бүртгүүлье.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, мөн Д.Энхтүвшин гишүүн, Б.Баярбаатар гишүүн дэмжсэн саналд бүртгүүлж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх.

“5 дугаар зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ч.Анар, А.Ариунзаяа, Д.Батбаяр, Р.Батболд, Э.Болормаа, П.Ганзориг, Х.Ганхуяг, П.Мөнхтулга, Д.Пүрэвдаваа, Б.Пунсалмаа, Б.Түвшин, Б.Уянга, Дав.Цогтбаатар, Ж.Чинбүрэн.

Цаашид “Ажлын хэсэг” гэх. Санал хураалт. /алх цохив/

65.7 хувиар санал дэмжигдлээ.

Б.Пунсалмаа гишүүн дэмжиж санал өгсөн. Төхөөрөмж таньсангүй гэж байна. Дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье гэж байна.

2.Төслийн 3 дугаар зүйлд “, 6.5 дахь хэсгийн “нэмэгдүүлэх, 6.4-г заасан хугацааг сунгахыг” гэснийг “нэмэгдүүлэхийг” гэж,” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.

Хоёр хоёр гишүүн. Дэмжсэн, дэмжээгүй хоёр хоёр санал хэлж болно. Тамгын газар. Тийм ээ. Тамгын газар тайлбар өгөөдөх үү? Ч.Дондогмаа дарга.

Ч.Дондогмаа: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41.5 дахь хэсэгт асуулт, хариулт явсны дараа Байнгын хорооноос санал хураалтаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол тус бүрээр дараах журмаар санал хураалт явуулна.

41.5.1-д хуулийн төслийн талаар Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдалгүй тус бүр хоёр хүртэл гишүүн 4 минутаас илүүгүй хугацаанд үг хэлсний дараа санал хураалт явуулах гэсэн ийм дэг байгаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүн бол тайлбарлаж бас үг хэлж болохоор зохицуулалт байх шиг байна шүү дээ. Тийм ээ.

Алга байна. Дэгээрээ явах уу? Санал хураалт. /алх цохив/

52.8 хувиар санал дэмжигдлээ.

Д.Батлут гишүүн дэмжсэнээр бүртгүүлэх хүсэлт тавьж байна. Протоколд тэмдэглэе.

3.Төслийн 3 дугаар зүйлд “19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “2025” гэснийг “2024” гэж” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлд “19.9 дэх хэсгийн “Энэ хуулийн 6.1.2-т” гэснийг “Энэ хуульд” гэж тус тус” гэж нэмэх.

Улсын Их Хурлын гишүүн
П.Сайнзориг. Горимын санал.

П.Сайнзориг: Дарга аа, энэ саналыг бас ажлын хэсэг дахиж нэг авч үзээд, санал хураахгүйгээр бас гүйцээн боловсруулах чиглэл өгөөд санал хураахгүйгээр буцаачих бололцоо байна уу.

Яагаад гэхээр энэ Төсвийн тогтвортой байдлын хуулиар бид яг тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт минут өгье.

П.Сайнзориг: ... хязгаарлаад хэмнэсэн энэ зүйлээрээ өр төлбөрөө төлнө. Харин хөрөнгө оруулалт талдаа хязгаарлалт байхгүй гэсэн мөртөө яг энэ заалтаар нь болохоор тусгай шаардлагаас хассан тэр хуучин тусгай шаардлага болох төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн нөгөө дотоодын нийт бүтээгдэхүүн хасах 2 хувьтай байна гэснээ хасалгүй үлдээчихээр энэ зөрчлүүд чинь гарах нь. Энэ төсөл, хөтөлбөрүүд чинь явахаа болих юм биш үү гэсэн ийм бодлогын юм харагдаад байх юм.

Тэгэхээр үүнийгээ эргээд ажлын хэсэг дээр нэг яриад эцсийн хэлэлцүүлэг дээрээ гүйцээн боловсруулж орж ирээч ээ гээд ийм саналтай байна.

Тэгэхээр хураалгүйгээр буцаачихъя гэсэн ийм саналтай байна.

Д.Амарбаясгалан: Горимын саналын дагуу 4 дэх саналыг хураалтыг гүйцээн боловсруулах чиглэлийг Байнгын хороонд өгч шилжүүллээ. Эцсийн хэлэлцүүлгээр дахин оруулж ирье.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал.

Энэ одоо түрүүчийн саналын адил дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураах уу?

Улсын Их Хурлын гишүүн
Г.Тэмүүлэн тайлбар.

Г.Тэмүүлэн: Өчигдөр Төсвийн байнгын хорооны хуралдаан дээр зарчмын зөрүүтэй санал гаргасан. Б.Жаргалан гишүүний хамтаар.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг Засгийн газраас санаачилж оруулж ирснийг, нэг талдаа сөргөөр энэ өөрчлөлтүүдийг оруулж ирж байгааг, муу хувилбараар хийх гэж орж ирж байгаа энэ асуудлыг энэ байдлаар өөрчилж болохгүй.

Үүнийг хууль санаачлагчид нь буцаах ёстой.

Нэг талдаа бид бүхний энэ өнгөрсөн 14 жилийн хугацаанд эдийн засаг, төсөв санхүүгийнхээ энэ хүндрэл бэрхшээлтэй холбоотой сорилт,

тулгамдсан асуудлуудтай холбоотой. Бид бүхний магадгүй яагаад сүүлийн 15 жилийн хугацаанд яагаад хөгжөөгүй юм бэ гэдгийг чинь гарц гаргалгаа, шийдэл болсон энэ хуулийг бид 2010 онд анх хийж байсан юм.

Энэ хууль өөрөө сайн хууль. Энэ хуулиар бид энэ төсвийн тогтвортой байдлыг хариуцлагажуулах, төсвийн сахилга бат, хяналтыг бид бүхэн бас шаардах, төсвийн тусгай шаардлага болоод үүнийг тогтоож, хуулийнхаа хүрээнд хэрэгжүүлэхийг Засгийн газраас шаарддаг ийм хэм хэмжээг тогтоосон хууль байгаа.

Энэ бол би ямар сайндаа хэлж байгаа зүйл бол энэ Үндсэн хууль шиг хууль шүү гэж яриад байгаа. Манай Засгийн газарт, Сангийн яамныханд, Эдийн засаг, хөгжлийн яамныханд.

Энэ ч үүднээс би Та бүхнээс бас хичээнгүйлэн гуйж байгаа юм.

Бусад зүйл дээр магадгүй Та бүхэн өөр өөрсдийнхөө өнцгөөр, улс төрийн байр суурьнаас энэ дээр хандаж болно.

Энэ бол Монгол Улсын цаашдын энэ эдийн засгийн чинь аюулгүй байдалтай холбоотой. Магадгүй үүнийг энэ байдлаар өөрчилсний чинь төлөөлсөн нь, хор хохирол нь Монгол Улсын эдийн засаг болно. Бид бүхний ирээдүй болно. Энэ ард түмний чинь аж амьдрал болох гээд байгаа юм.

Тэгэхээр энэ үүднээс би Та бүхнээсээ хичээнгүйлэн гуйж байгаа юм. Кнопдоо битгий хүрээч ээ. Бусад зүйлээрээ Та бүхэн бас өөр өөрчлөлтүүдийг бас хийж болж байна. Ганцхан энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр ингэж

байдлаар муугаар өөрчлөхийг би хэзээ ч хүлээн зөвшөөрөхгүй.

Энэ бол зарчмын хатуу байр суурь юм. Үүний хор хохирлыг бид бүхэн бүгдээрээ ирээдүйгээрээ төлнө. Бид бүгд цаашид хөгжих юм уу, хөгжихгүй юм уу, төсөв санхүү дээрээ хариуцлагатай байх юм уу, байхгүй юм уу, эрсдэлд орох юм уу, орохгүй юм уу гэдгийг чинь зүг чигийг нь заах луужин болсон хууль чинь энэ байгаа юм.

Бид Засгийн газраас, Сангийн яамнаас асуух ёстой хэрэгжүүлж байх ёстой. Хэрэгжүүлж байх ёстой энэ тусгай шаардлагуудыг яагаад 10 жилийн хугацаанд нэг ч хэрэгжүүлж байгаагүй юм бэ?

Энэ 2 хувийн алдагдлыг 60.0 хувийн Засгийн газрын өрийн хязгааруудыг бид шаардах ёстой шүү дээ.

Одоо энэ хуулийг яагаад өөрчилж орж ирж байгааг бид асуух ёстой шүү дээ.

Үүнийг би зарчмын хувьд дэмжихгүй. Та бүхэн маань кнопдоо битгий хүрээрэй. Энэ асуудал улс орны чинь аюулгүй байдалтай шууд хамааралтай асуудал шүү л гэдгийг би хичээнгүйлэн гуйж бас Та бүхэнд хэлж байгаа шүү.

Д.Амарбаясгалан: Дэгээрээ бас тайлбар хэлэх боломжтой. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Г.Тэмүүлэн гишүүн ээ, попорно попорно гэхэд ингэж улс орноороо тоглож попорч болохгүй шүү.

Би нэлээн өөрт чинь тэвчээртэй хандаад байгаа.

Энэ үг хэлээд байгаа энэ нөхрийн өөрийнх нь хийсэн өөрчлөлт нь би түрүүн уншсан. Уншиж сонс. Дахиад унш. Чи чимээгүй байж бай. Би чамайг үг хэлж байхад чинь саад болоогүй шүү.

6.4 буюу энэ хуулийн 6.1.2-т заасан тусгай шаардлагыг буюу алдагдлын хязгаар байна шүү дээ. 2025 оны төсвийн жил хүртэл буюу энэ оны сүүл хүртэл хэрэглэнэ.

6.1.4 буюу өрийн хязгаарыг заасан тусгай шаардлагыг 2025 оны төсвийн жилээс хэрэгжүүлнэ.

Өөрөөр хэлбэл өнөөдөр өрийн хязгааргүй болчихсон явж байгаа. Ийм заалтыг энэ хүн өөрөө хийсэн. Энэ хүн өөрөө хийгээд одоо ийм юм яриад явж байдаг.

Тийм учраас үүнийг би хэлээд байгаа юм биш Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн хэлтсийн дүгнэлт дотор энэ орчихсон байгаа. Ийм хуулийн зөрчил үүссэн байна гээд.

Үүнийг Засгийн газар яаралтай засах ёстой, сайжруулах ёстой гэдэг ийм дүгнэлтийг Улсын Их Хурал Тамгын газар ийм дүгнэлт гаргасан байгаа.

Д.Амарбаясгалан: Г.Тэмүүлэн гишүүн болно. Дэгээрээ явъя.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал.

1.Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, Г.Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

За байз, энэ төхөөрөмж гацчихлаа. Санал хураалтыг хүчингүй болгочихъё.

Санал хураалт. /алх цохив/

47.2 хувиар санал дэмжигдсэнгүй.

Санал хураалт дэмжигдээгүй байна.

Дараагийн санал хураалт гэж. Тэгээд санал хураалгах шаардлагатай юм уу?

3.Төслийн 6.1.3-т заасан төсвийн зарлагын тусгай шаардлагыг өөрчлөхгүй хэвээр үлдээх.

Харин тийм.

Гишүүд байж байгаарай. Одоо нэгэнт санал дэмжигдээгүй учраас буцаах тогтоолын төсөл уншина.

С.Бямбацогт гишүүн горимын санал гаргаж байгаа юм байна.

С.Бямбацогт: Энэ төхөөрөмж ерөөсөө улайчаад дэмжсэн, дэмжээгүй нь мэдэгдэхгүй. Одоо бусдаас мэдлээ шүү дээ.

Төхөөрөмж ажиллаагүй учраас горимын санал гаргаж байна.

Энэ санал хураалтыг хүчингүй болгож дахиж хурааж өгөөч ээ гэсэн байна.

Д.Амарбаясгалан: С.Бямбацогт гишүүн дахин санал хураалгах горимын санал гаргасан байгаа.

Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн асуудал. Санал хураалт явуулах шаардлагатай байгаа гэсэн үг.

Санал хураалт явуулах уу? Л.Мөнхбаатар дарга. Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар гишүүнд микрофон өгье.

Л.Мөнхбаатар: Эрхэм гишүүддээ оройн мэнд хүргэе.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан бүлэг байр сууриа нэгтгэх нэгдсэн ойлголтод хүрэх зайлшгүй шаардлага байгаа учраас уг хэлэлцэж

байгаа асуудлаар Монгол Ардын намын бүлэг завсарлага авч байна.

26-ны 10.00 цаг хүртэл завсарлага өгөх ийм саналыг Их Хурлын даргад гаргаж байна.

8 дугаар сарын 26-ны өдрийн 10.00 цаг хүртэл.

Д.Амарбаясгалан: Тэгвэл Даваа гарагийн 10.00 цаг хүртэл энэ асуудлаар завсарлага өглөө. /алх цохив/

Дараагийн асуудал. Байж байгаарай. Гишүүд сууж байя.

**Долоо.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,
Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд
/Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хоёр дахь хэлэлцүүлэг/**

Хэлэлцэх асуудал. Долоо.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд.

Тийм. Тэгэхээр харин мөн адил энэ асуудлаараа завсарлага авах ёстой.

Өнөөдөр хэлэлцэх асуудалд орчихсон учраас.

Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар.

Л.Мөнхбаатар: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд үйлчлүүлэх тухай хуулийн төсөл дээр Монгол Ардын намын бүлэг завсарлага авсантай холбогдуулан дараагийн хэлэлцэх асуудлаас мөн завсарлага авч байна.

Хугацааны хувьд ирэх долоо хоногийн Даваа гарагийн буюу 26-ны өдрийн 10.00 цаг хүртэл завсарлага авчирна.

Д.Амарбаясгалан: Даваа гарагийн 10.00 цаг хүртэл завсарлага өглөө. /алх цохив/

**Найм.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд
/Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэх асуудал. Найм.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүд.

Наймдугаар асуудал.

Л.Мөнхбаатар дарга. Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар.

Л.Мөнхбаатар: Уг хэлэлцэж байгаа асуудлуудаар Монгол Ардын намын бүлэг бүлгийн байр сууриа нэгтгэх зайлшгүй ийм шаардлага гарсан учраас уг асуудлаас мөн завсарлага авах хүсэлтэй байна.

Уг асуудлыг Улсын Их Хурлын дарга шийдвэрлэж өгнө үү.

Хугацааны хувьд ирэх долоо хоногийн Даваа гараг буюу 26-ны өдрийн 10.00 цаг хүртэл завсарлага өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: Даваа гарагийн 10.00 цаг хүртэл завсарлага өглөө.

Өнөөдрийн чуулганы хуралдаан хаалаа.

Нэг дэх өдрийн 26-ны өдрийн 10.00 цагт нэгдсэн хуралдаан үргэлжилнэ. /алх цохив/

Хуралдаан 12 цаг 03 минут үргэлжилж, 22 цаг 07 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД